

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ISSN: 2313-6170

Түлхүүр үг: Orçuulgazuj

ОРЧУУЛГАЗҮЙ

IX

(Орчуулга дахь хэл соёлын асуудал)

Эрхлэн хэвлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар
2021

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ОРЧУУЛГАЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

№09 (559)

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Ш.Эгшиг (доктор, дэд профессор)

Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)

Э.Равдан (ШУ-ны доктор, профессор)

Го.Аким (доктор, профессор)

С.Эрдэнэмаам (доктор, профессор)

Л.Чулуунбаатар (доктор, профессор)

Г.Буяннэмэх (доктор, профессор)

О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч)

М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)

К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор)

Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор)

В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор)

Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор)

Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн Монгол

судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч: МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн профессорын хамтлаг

Хянан засварласан: Ш.Эгшиг, Г.Элдэв-Очир

Хуудасны хэмжээ: А4

Хэвлэлийнхуудас: 14,2 хх

Хэвлэсэн тоо: 100 ш

Хэвлэлийнгазар: “Удам соёл” ХХК

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

ISSN: 2313-6170

Key title: Орчуулгазүж

TRANSLATION STUDIES

IX

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar
2021

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

TRANSLATION STUDIES

RESEARCH SERIES №09 (559)

Editor: Egshig.Sh (National University of Mongolia, Mongolia)

Secretary: Eldev-Ochir.G (National University of Mongolia, Mongolia)

Editorial Boards:

Ravdan.E (National University of Mongolia, Mongolia)

Akim.G (Ph.D, Professor, Mongolia)

Erdenemaam.S (Mongolian State University of Education, Mongolia)

Chuluunbaatar.L (National University of Mongolia, Mongolia)

Buyannemekh.G (National University of Mongolia, Mongolia)

Chinbayar.O (President of the Mongolian Translators Union, Mongolia)

Chimedtseye.M (National University of Mongolia, Mongolia)

Okada.K (Tokyo University of Foreign Studies, Japan)

Bayarmend.B (Inner Mongolia University, P.R.China)

Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical University, Russia)

Marie-Dominique Even (French National Center for Scientific Research, France)

Hou Wanzhuang (Center of Mongolian studies of Peking University, P.R.China)

Founder:

Professors Team for Translation Studies, Division of Humanities, School of Arts and Science,
National University of Mongolia

Edited by: Eldev-Ochir.G

Paper size: A4

Number of pages: 14,2

Number of prints: 100

Press: “Udam soyol” printing

ГАРЧИГ

Өмнөтгөл үг	9
-------------	---

ХЭЛ ШИНЖЛЭЛ

Ш.Эгшиг	Монгол хэлний бусад хэлд нөлөөлсөн тухайд /XVIII-XX зуун/	12
Т.Мягмарсүрэн	Үсэгчлэн галиглах арга, түүнийг хэрэглэхтэй холбоотой зарим асуудал	18
Б.Жигжидсүрэн, Сана	Монгол хэлний халх болон цахар аялгууны үгсийн сангийн зарим онцлог, ялгаа	26
Ц.Мөнхтуяа	Монгол-англи хэлний [eI], [OI] хос эгшгийн акустикийн задлалын зэрэгцүүлсэн судалгаа	30

ОРЧУУЛГАЗҮЙ

Ч.Золзаяа, Б.Энхзул	Техник технологийн дискурс дэх метафорын судалгаа	40
Л.Чулуунбаатар	Англи хэлний “to be” үйл үгийн орчуулгын тухай	46
Г.Элдэв-Очир, Р.Оргил	Монгол хэлний хэлц хэллэгийг хятад хэлнээ орчуулсан байдал	51
Д.Долгорсүрэн	Соёл ба үнэт зүйлийг үл хэрэгссэнээс үүдэн орчуулгад гарч ирэх гажуудал	55
Б.Батчимэг, У.Лхагвасүрэн	Даяаршил –интернэт – орчуулга	60
Г.Элдэв-Очир, Мициг	Хятад хэлний цээр үгийг орчуулах арга	66
Д.Алтантуяа	“Гологдсон хүүхэн” зохиолын “авах” нийлэмж үг хийгээд түүний хятад орчуулгын асуудалд	70
П.Энхжаргал, Д.Маралмаа	Япон хэлний өвөрмөц хэлцийн орчуулгын тухайд /“ki” (気) гэх үг бүхий хэлцийн жишээгээр/	77
О.Мөнхчимэг	Улс төрийн илтгэлийн орчуулга дахь соёлын нөлөө	87

НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГА

Н.Мөнхцэцэг	Англи хэлний адилтгал нэр томьёог орчуулах асуудалд	94
С.Дугармаа, Ц.Одончимэг	Усны барилга байгууламжийн нэр томьёог хуулбарлан орчуулах нь	110
Б.Төмөрхуяг	Анагаахын нэр томьёоны орчуулгын асуудалд	116
Д.Баярмаа	Хуулбарлан орчуулсан нэр томьёоны утгазүйн судалгааны асуудалд	123

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ

Г.Эрдэнэчимэг	Модон бар уу? төмөр бар уу?	130
Б.Нэргүйжаргал, Гэгээнзул	“Тунгалаг Тамир” романы хятад орчуулгын алдаан дээр хийсэн судалгаа	135

Д.Отгонтуяа, А.Сүхмаа, Г.Энхбаяр П.Уянга, Б.Хавар	“Дүблинчүүд” зохиолын орчуулгад хийсэн зарим ажиглалт Лү Шюний “А-Кюгийн үнэн түүх” зохиолын гурван монгол орчуулгыг харьцуулах нь	139 147
Д.Будсүрэн	Р.Х.Брайдын хайкү шүлгийн орчуулгын тухай	154

ОРЧУУЛГЫН САН ХӨМРӨГ

Г.Эрдэнэчимэг	Чосөнъ-ий хэвлэл мэдлэгийн үйлдвэрлэлийг монопольчилсон нь	164
---------------	---	-----

CONTENTS

Preface	9
---------	---

LINGUISTICS

Sh. Egshig	The influence of the mongolian language on other languages in the 18 th -20 th centuries	12
T.Myagmarsuren	Transliteration and some issues of its usage	18
B.Jigjidsuren, Sana	Mongolian khalkha and chakhar dialect differences in vocabulary	26
Ts.Munkhtuya	A constrative acoustic analysis of mongolian and english diphthongs as [ɐI], [ɔI]	30

TRANSLATION STUDIES

Ch.Zolzaya, B.Enkhzul	Metaphors in Technical Discourse	40
L.Chuluunbaatar	The english verb to be	46
G.Eldev-Ochir, R.Orgil	Translation methods of Mongolian idioms into Chinese Language	51
D.Dolgorsuren	Perversion in translation due to ignoring culture and values	55
B.Batchimeg,		
U.Lkhagvasuren	Globalization- internet- translation	60
G.Eldev-Ochir, Muqier	Translation methods of Chinese taboo	66
D.Altantuya	A study on collocation words with 'take', and their chinese translation	70
P.Enkhjargal, D.Maralmaa	Translation of Japanese idioms: focus on "ki (気)" idiom of operation	77
O.Munkhchimeg	Influences of culture in translating political speeches	87

TRANSLATION OF TERMINOLOGY

N.Munkhtsetseg	On the Translation Issues of English Metaphor Terms	94
S.Dugarmaa,		
Ts.Odonchimeg	Using Loan Translation for Hydraulic Structure Engineering Terminology	110
B.Tumurkhuyag	Translation of medical terms	116
D.Bayarmaa	Study on semantic aspects of calque translated terms	123

TRANSLATION CRITICISM

G.Erdenechimeg	Is Block Printing Uses Wood or Iron?	130
B.Nerguijargal,		
Gegan Zhula	Analysis in the translation errors of (Novel) "Tungalag Tamir"	135

D.Otgontuya, A.Sukhmaa, G.Enkhbayar	Some analysis in the mongolian translation of “Dubliners”	139
P.Uyanga, B.Khavar	Comparison of three Mongolian translations of Lu Xun's “True Story of Ah Q”	147
D.Budsuren	R.H.Blyth’s translation of haiku	154

TRANSLATION ANTHOLOGY

G.Erdenechimeg	Chosun's edition Monopolization of knowledge production	164
----------------	---	-----

ӨМНӨТГӨЛ ҮГ

“Орчуулга нь бусдын соёлыг тэр чигт нь нь тодруулан ойлгуулж өгдөг зүйл болохоос бус, зүгээр нэг үгийн тухай асуудал төдий биш” хэмээн Английн зохиолч Энтони Бургес (Anthony Burgess) өнгөрсөн зуунд хэлж байжээ. Италийн нэрт орчуулагч Анна Рускони (Anna Rusconi) “Ертөнцийг хаа ч хүргэдэг хөтөч нь орчуулагч юм” гэж хэлсэн нь орчуулагчийн нэгэн үүргийг мөн тодорхойлсон мэт санагдана. Энэ хоёр үгээр орчуулга бол соёлын хөтөч, бусдын соёлыг таниулан тайлбарлаж өгдөг хэрэгсэл гэж ойлгож болохоор байна. Чингэхээр энэ жил хэл соёлын харилцаа хамаарал хэрхэн орчуулгад тусдаг болохыг судалдаг, соёлыг орчуулах ухаан (соёлын орчуулгазүй)-ыг сэдэв болгон дэвшүүлж, энэ дугаараа гаргахаар зорьсон билээ.

2012 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн МУИС-ийн Орчуулгазүйн эрдэм шинжилгээний есдүгээр бага хурал энэ жил “Орчуулга дахь хэл соёлын асуудал” сэдэвтэйгээр цахим орчинд амжилттай зохион байгуулагдлаа. 2021 оны 3 сарын 12-нд хоёр салбар хуралдаантай болсон уг цахим хуралд МУИС-ийн доктор Г.Элдэв-Очир, доктор Г.Эрдэнэчимэг, доктор Ш.Эгшиг, доктор Л.Дорждэрэм, доктор Д.Отгонтуяа, доктор Г.Эрдэнэнаран, доктор П.Энхжаргал, магистр Б.Батчимэг, У.Лхагвасүрэн, Д.Сарантуяа, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн доктор Н.Мөнхцэцэг, ШУТИС-ийн профессор С.Дугармаа, доктор Д.Баярмаа, доктор Ч.Золзаяа, докторант Б.Энхзул, докторант Ц.Одончимэг, АШУҮИС-ийн доктор Б.Төмөрхуяг, ОУУБИС-ийн доктор Т.Мягмарсүрэн, доктор Б.Жигжидсүрэн, докторант Н.Ууганцэцэг, БНХАУ-ын Хөлөнбуйрын их сургуулийн доктор Хуан Дуншөн, Дорнод Их сургуулийн докторант Д.Алтантуяа нарын эрдэмтэн судлаачид илтгэлээ хэлэлцүүлж, орчуулгазүйн олон асуудлаар чөлөөт хэлэлцүүлэг өрнөж, олон нийтэд чиглэсэн санал зөвлөмжийг гаргав. Гарсан саналыг багцлан авч үзвэл, нэгдүгээрт, нэр томьёо оноох нь шинжлэх ухааны салбар ухаан бүрд жигд хийж цэгцлэх ёстой нэг чухал асуудал болох, хоёрдугаарт, монгол хэлээ сайн эзэмшсэн мэргэжилтний хэрэгцээ шаардлага их байгааг харгалзан, их дээд сургууль мэргэжлийн сургалтын хөтөлбөртөө монгол хэлийг оруулж, салбар ухаантай уялдуулан эх хэлийг заадаг байх, гуравдугаарт, залуусын эх хэлний боловсролд анхаарах зайлшгүй шаардлага үүссэн нь гадаад хэл заадаг, орчуулга хийдэг мэргэжилтнүүдийн нийгмийн үүрэг хариуцлага болсныг хуралд оролцсон эрдэмтэд хүлээн зөвшөөрч, эдгээр чиглэлд хамтран ажиллах боломж байгааг илэрхийлсэн юм.

Олон улсын орчуулгын өдрийн ээлжит их хэлэлцүүлгийг МУИС, ШУА-ийн Хэл Зохиолын Хүрээлэнтэй хамтран “Хэлний философи” сэдвээр хийж, Хэл зохиолын хүрээлэнгийн доктор Э.Пүрэвжав Судар бичгийн хүрээлэнгийн 100 жилийн ойд зориулсан “Монгол хэл шинжлэлд Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтдийн оруулсан хувь нэмэр”, доктор С.Энхжаргал “Монгол хэлний хэвшмэл хэллэгийн утгыг танин мэдэхүйтэй холбох нь”, доктор Н.Мөнхцэцэг “Нэр томьёо ахуйн сургаалтай холбогдох нь”, МУИС-ийн профессор, доктор (Sc.D) Ц.Гомбосүрэн “Людвиг Витгенштейний боловсруулсан хэлний философи”, доктор Ш.Эгшиг “Орчуулгазүйн тайлбарламж хандлага” сэдвээр тус тус илтгэв. Энэ эрдмийн хэлэлцүүлгээр орчуулгазүйг шинжлэх

ухааны бусад салбар ухаантай холбогдох талаас нь эхлүүлсэн анхны эрдмийн индэр болсныг энд тэмдэглэж байна.

Манай орчуулгын судалгаанд орчуулгын шүүмж судалгаа давамгайлж, орчуулгын харьцуулсан, зэрэгцүүлсэн судалгаа голдуу хийж байгаа юм. Судалгааны аргазүй, аргачлал олон байдаг ч, эрдэмтдийн хийж буй судалгаа нэг хүрээнээс халихгүй, давтагдсан сэдэвт судалгаа хийсээр ирлээ гэхэд хилсдэхгүй биз ээ. Гадаад ертөнцөд энэ хандлага бараг үгүй болж, алив судалгааг хүрээ хязгаараас нь гаргаж, бүхий л харилцаа хамааралд нь судлах хандлага бий болсон, шинжлэх ухааны салбар ухаан олон дэд чиглэлээр гүнзгийрэн хөгжиж эхэлснээс гадна, өөр хоорондын салбар дундын ухаан хөгжиж байна. Нийгмийн ухааны асуудлыг хэл шинжлэлийн үүднээс, хэл шинжлэлийг тархи судлал, сэтгэл судлалтай холбох, эсвэл, хэлийг биологийн ухааны үүднээс тайлбарлах, хэлийг цахим хэрэглээнд оруулах зэргээр хүний нийгмийн хөгжил хурдассантай холбоотой хэлшинжлэлийн салбар ухаан үүсч, ирээдүйд ч мөн энэ маягаар дундын олон ухаан үүсэх нь гарцаагүй болж байна. Анх шинжлэх ухаан үүсэхдээ алив нэг зүйлийг судлах задлаг аргыг боловсруулан ихээхэн хөгжил дэвшилд хүрч, хэрэглээнд нэвтрэн орж байсан ч тэдгээр нь хангалтгүй болж, эдүгээ нийлэг болгох аргазүй, аргачлалд шилжиж буй үйл явц өрнөж байна. Энэ байдал манай өнөөгийн судлаачдын судалгаанд үгүйлэгдэж байна. Мөн орчуулга судлалын сүүлийн үеийн онолын бүтээлд суурилан хийсэн судалгаа ч үгүйлэгдэж байна. Бидний энэ жилийн зорьсон ажлын үр дүнд сэтгүүлийн булан нэмэгдэх хандлагатай байгаа юм. Судлаачид орчуулгын ухааныг хэл шинжлэл рүү нь илүү хандуулах, угсаа хэлшинжлэл, нийгэм хэлшинжлэлийн чиглэлд хөгжүүлэх, нэр томьёо судлалтай холбох байдал ажиглагдаж эхэллээ.



“Орчуулгазүй” сэтгүүлийн ес дэх дугаар ийнхүү мэндэлж байна. Бид сэтгүүлийг анх үүсгэн хэвлүүлж эхэлснээс хойш тогтмол гаргасаар ирлээ. Энэ дугаар Хэл шинжлэл, Орчуулгазүй, Нэр томьёоны орчуулга, Орчуулгын шүүмж судлал, Орчуулгын сан хөмрөг булангуудтай гарч байна. Дугаарын онцлог бол орчуулгазүйн чиглэлийн янз бүрийн байгууллагын эрдэмтэн судлаачдын өгүүлэл шалгаран хэвлэгдэж буй явдал юм. Энэ нь судлаач эрдэмтэд төдийгүй нийгмийн хүрээний төлөөлөл болсон олон хүн орчуулгын үүрэг, ач холбогдлыг сайтар ойлгон, ухамсарлаж байгаагийн илрэл болно. Ер нь эрдэм шинжилгээний сэтгүүлээр тогтохгүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ч орчуулгын талаар асуудал хөндөх нь олширч байгаа юм. Манай сэтгүүлийн бодлого бол Монгол дахь орчуулгазүйн чиг хандлагыг тодорхойлж, тулгамдаж буй асуудлыг шийдэх эрдмийн индэр болох явдал билээ.

Цаашид эрдэмтэн судлаачид, номын садан, уншигч түмнээс сэтгүүлийн талаархи санал, шүүмж, зөвлөгөө хийгээд бүтээл туурвилаа байнга ирүүлж байна гэдэгт итгэж байна.



Орчуулга бол дэлхийн олон соёлын уулзвар, үндэстэн хооронд бие биеэ танин мэдэх хөтөч нь юм. Энэ сэтгүүлийн уншигч, дэмжигчдийн эрдэм оюуны гэгээн цагаан мөр ямагт дурайж байх болтугай.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар
“Гадаад хэлний орчуулга” хөтөлбөр

Таргуд Шагдарсүрэнгийн Эгшиг (Ph.D)



ХЭЛ ШИНЖЛЭЛ





THE INFLUENCE OF THE MONGOLIAN LANGUAGE ON OTHER LANGUAGES IN THE 18th-20th CENTURIES

Sh.Egshig¹

Хураангуй: Торгоны зам болон Цайны замын судлалд үндэстэн угсаатны бүлгийн соёл хоорондын харилцаа үүсэх, соёл нэвчих, уусах боломжийг бий болгодог нийгэм соёлын өргөн хүрээний ойлголт багтана. Монгол хүн Алтайн хязгаар, Байгаль орчмын Сибирийн хэсэг, Шинжаан, Хойд Хятадын олон угсаатан, ястантай хэл соёлоор нягт харилцан, аж төрсөөр иржээ. Ялангуяа хязгаар нутгийн харуул хийгээд суурьшигчдын хооронд бие биеийнхээ хэлийг сурч, Хиагт, Маймаачин, Хаалган зэрэг хил орчмын худалдааны төвлөрсөн суурин газарт олон үндэстний худалдаачдын дундын хэл үүсэхэд монгол хэл ихээхэн нөлөөтэй байв. Олон угсаатны дундын холимог хэл (пиджин хэл) үүсэхэд монгол хэл ямар үүрэг нөлөөтэй байсан талаар энэ өгүүлэлд дурдан, монгол хэлний үгийн сан, өгүүлбэрзүйн түвшиний онцлог нь уг дундын холимог хэлд яаж туссан тухай товч авч үзлээ.

Key words: Mongolian language, pidgin, Tea Road, Yakhta trade pidgin

Tea Road was a flourishing trade route that span around 10,000 kilometers from China through the Mongolian Steppe, the Far East, Siberia, and the Urals to St. Petersburg of Russia in the 18th to 20th centuries. The Tea Road is a multi-national trade route similar to the Silk Road, provided an opportunity for cultural exchanges between different nationals and ethnic groups that habited along the route, as well as formed new multi-national trade hubs. The cultural exchanges along the route were so extensive, that even in places where one ethnic group was dominant, the influence of other cultures on that group were clearly evident. One of these nations were the Mongols.

Mongolian language development has been passed down through the proto mongolian, the ancient mongolian, the middle mongolian and the modern mongolian language². It is clear from the written records and the works of mongolian and foreign mongolists who have studied the mongolian language, it has coexisted among the mongolian dialects for the last 500 years, thus the mongolian language has remained stable³ in its nature.

The Mongols have been nomadic pastoralists for centuries⁴. Mongols are one of the few ethnic groups in the world that still maintain a nomadic lifestyle to date. Despite being nomadic, throughout

¹ Associate professor, Faculty of Humanities, School of Arts and Sciences, National University of Mongolia

² Б.Түвшинтөгс, О.Шинэбаяр 2012, Монгол хэлний түүхийн судалгааны тойм, Монгол хэл ба монгол хэлүүд, Хэл шинжлэл Соёмбо нэвтэрхий толь, Соёмбо Пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 316-312 тал.

³ Kalm'ĭckisches Wŕterbuch von G.J.Ramstedt, Helsinki, 1935.

Ш.Лувсанвандан 1959, Монгол хэл аялгууны учир, Studia Mongolica, Том I, Улаанбаатар, 26-27 тал.

Б.Ринчен 1969, Монгол Ард Улсын хамниган аялгуу, ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар хот.

Х.Нямбуу 1992, Монгол угсаатны хэлний бүрэлдэхүүн, БНМАУ-ын хүн ардын хэл аялгууны ангилал, "Монгол Улсын Угсаатны зүй" Удиртгал Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн газар, Улаанбаатар.

Roberte N.Hamayon, M.L. Beffa 1984, Les Langues Mongoles, Ŗtudes mongoles et sibiŖiennes, 14, pp.121-169

⁴ Jeong, Su-il. 2019. SILK ROAD The Photographic Silk Road-Steppe Road, Seoul: Gyeongangbuk-Do, Korea Institute of Civilizational Exchanges.

its history Mongolians have adapted to various forms of government and economic systems. In the Middle Ages, the Mongols had a warlike military system, with units based on a principle of Ten. Even the civilians had a semi-military organization and advanced administrative functions⁵.

During the second revival of the Silk Road in the Middle Ages, the Mongols set up guards along the Silk Road, perfected the horse relay station economy, and developed expedited long-distance messaging system. Later, when the Mongols came under Manchu rule in the 18th to 20th centuries they were divided into small administrative units, scattered throughout the country and engaged in livestock husbandry. During this period, the Russian Empire commissioned many expeditions to conduct various geographic and ethnographic studies as part of their strategy to conquer Siberia⁶ and further expand its territory to the east. As a result, they have reached the borders of Mongols.

Mongols have always had close ethnic and linguistic ties with the many ethnic groups living in Siberia, which enabled them to form easy communications and relationships with the Russians⁷. The Mongols were also one of the five major ethnic groups in the Manchu dynasty, and as an early ally of the Manchus, they lived for almost two hundred years with the privilege of preserving their native way of life.

In fact, it was at this time that there was a historic opportunity to move from north to south, south to north, to run a transportation business to carry large loads of weight of commodities for merchants. In the Mongolian Gobi Desert and steppes, only Mongols could load camels and carry weights, and only Mongol herders knew the state of the Mongolian land⁸. In connection with all this, the use of the mongolian language, especially the vocabulary, has undergone certain changes. Mongolian language has also begun to influence other languages. Many historical records can be found that noted the fluency of northwestern Mongols in Russian language. The advantage of language enabled Mongols to receive Russian ambassadors, exchange goods of Mongol origin, and act as middleman in introducing Chinese goods to Russia from the middle of the 17th century.

*"In 1618 the Golden Khan of Khotgoid⁹ invited Russian envoys to Uvs Lake and served them tea for the first time; and sent 200 packets of tea as a gift to the Russian tsar, an introduction of tea to Russian elite. At that time, the Russians were looking for ways to establish relations with China (the Manchus) and gathered information about China through their good neighbors, the Mongols. China which were under Manchu rule and Russia, did not know each other; and were geographically distant without direct route."*¹⁰

There are reports that Mongols carrying heavy loads of weight along the Tea Road reach the Kalgan to the south, and even right up to the Great Wall and Peking; to the north via Kyakhta, or through western Mongolia, through Khovd to Tsagaan Nuur Tashant, and even further to Biysk. The movement

⁵ Concerning the city of Cambaluc, and its great traffic and population, Excerpt from The Book of Ser Marco Polo: The Venetian Concerning Kingdoms and Marvels of the East Volume1, Book Second, part 1, chapter XXII. translated and edited by Colonel Sir Henry Yule (London: John Murray, 1903) p.2.

Chinggis khan's four great legacies, Key figures in Mongol history, The Mongols in World history. http://afc.casia.columbia.edu/mongols/figures/figu_geng_legacy.htm

⁶ Gibson, J. 1980. Russian Expansion in Siberia and America. *Geographical Review*, 70 (2), pp.127-136.

⁷ Д.О.Лоевский 2005, Русско-Китайские отношения в XVII в.: Отечественная историография, Документ, Архив, История, Современность. Выпуск 5, Издательство Уральского Федерального Университета, Екатеринбург, стр.277-286.

В.С.Мясников, Н.В.Шепелева 1980, Империя Цин и Русское государство в XVII в. Москва

⁸ Эгшиг Ш, Гэрэлтөв Д, Сүхбаатар О, Бадрал Ё. 2016. Цайны зам, Улаанбаатар: Мөнхийн үсэг.

⁹ Ш.Б.Чимитдоржиев, *Взаимоотношения Монголии и России в XYII-XYIII вв.*, Издательство «Наука» Москва, 1978, стр.36.

¹⁰ Ш.Эгшиг "Ази Европыг холбосон "Цайны зам" ба Монгол" Euroasian network, Past, Present and Future, 2014 Korea-Mongolia International Conference, 2014.10.10, Ulaanbaatar, pp.91-107.

of goods by the Mongols brought them to the crossroads of many cultures. The Mongols were well versed in the eastern Manchu, Chinese, and Tibetan languages, and were in constant contact with the people of the northern region around Lake Baikal, listening to and conversing in their many dialects. At the time, there were few Chinese-Manchu speakers in Russia. Official relations between the Russian Empire and the Manchu Dynasty began only in the 18th century. In 1727, the Bura Protocol established the Russian-Manchu border, and in 1728 the Kyakhta Treaty was established, after of which the trade relations started between the Russians and Manchus.

Kyakhta and Tsurkhait were designated as trading points, but at the time Kyakhta flourished as the world's largest trading city¹¹. Guards were deployed along the Mongolian Khalkha border, which required border guards to communicate with other ethnic groups that lived along the border. This led to learning each other's languages between the guards and settlers, and trade expansions in border settlements such as Kyakhta along with development of merchants' 'pidgin language'.

According to some scholars, the Bura Protocol and Kyakhta treaty facilitated trade between Tsarist Russia and the Manchus, transporting goods such as tea, silk, and porcelain from the depths of Manchu-dominated southern China to Europe, and the trade route was later renamed as the Tea Road. As a result, a form of pidgin language of the merchants appeared at every node of the Tea Road station¹² such as the Kyakhta merchant pidgin, the Maimaachin merchant pidgin, Urga merchant pidgin and the Kalgan merchant pidgin. In Siberia, many new settlements sprang up from this trade route, and many dialects flourished. There is historical evidence that the pidgin language of the merchant, which was formed at the national border station of the Tea Road, was used not only as a spoken language but also as a sign language. However, there is currently no evidence that the tea trader's 'pidgin' has evolved into a 'creole' language¹³.

The location of Mongolia as a gasket between Russian-occupied and Manchu territories often served as a common language in Russian-Manchu relations. Envoys from Russia were allowed to the Manchu government through the Ministry of Foreign Affairs of Mongolia.

There are many reports where the Manchu envoys passing through Mongolia on their way to Russia, recorded various Mongolian words of respect and the eloquent speech forms used to address kings and officials from foreign countries. There are several examples of this in the research works¹⁴ supervised by Sayana Namsaraeva, a Buryat scholar at Cambridge University. The Manchu king was called the "Bogd Khan" by the Russians, the Russian king as "White Khan", the Great Wall as "Wall", Kalgan (Zhangjiakou) as "Door". The border node city between China and Mongolia is called "Khaalgan" (Kalgan). The names of the Mongolian places such as Tagna Uriankhai, Il Tarvagatai were spelled as per Mongolian pronunciation. In addition to using the Mongolian word in its full pronunciation, it was also used in conjunction with words in other languages. Examples of conjunctions were: Tsar Bogdoi/Prince Bogdoi, and sentences were: Адали иностранец? (Adali inostranets?) (Are you a foreigner?)¹⁵.

In general, a structure, consisting of a mixture of Russian and Mongolian words, tended to be predominant in the pidgin language of the Kyakhta merchant. The example of Sayana Namsarayeva also

¹¹ Александр Жиров 2000, Чайный путь и Кяхта, Журнал "Земля Иркутская", стр.67.

¹² Sayana Namsaraeva 2014, Border Language/Chinese Pidgin Russian with a Mongolian 'Accent', Inner Asia 16, Koninklijke Brill NV, Leiden, University of Cambridge 122 p.
Dieter Stern 2005, Myths and facts about the Kyakhta trade pidgin, Journal of Pidgin and Creole languages, Volume 20, Issue 1, pp.175-187.

¹³ Sarah G.Thomason 1997, Contact languages I. Pidgins and Creoles, Chapt.7, Amsterdam: John Benjamins.

¹⁴ Also see there, pp.116-138.

¹⁵ Also see there, 124 p.

shows that it was common for Mongolian verbs to be formed by suffixes on the basis of Russian verbs. *Пить-пыху (drink), кушать-кушаху (eat) спать-спиху (sleep)*¹⁶.

It is evident that there are words of the Buryat dialect of the Mongolian language, such as “шипкошанга” - “shipkoshanga” (very loud, louder) that combine Russian and Mongolian words to form a single word. According to Russian scholars, this combined language is the dialect of Transbaikalia. For example, the following Mongolian words are included in the vocabulary of this dialect: Аршан (mineral water), Архихахит (drink alcohol), Ганзушка (pipe for tobacco), Затуран (pulp tea), Обмалахаться (to marry *малаха* - hat in Mongolian)¹⁷. Examples from the research of Russian scholars Sayana Namsaraeva, S. Cherepanov, A. Y. Musorin¹⁸ and K. Federova¹⁹ show that the Mongolian word plays an important role in the formation of the Russian-Mongolian border dialect or merchant pidgin. However, it is common for Russian and Mongolian words to be used in conjunction with Russian, Mongolian, Manchu, and Chinese words in a single sentence. Many dialects of the Mongolian language, such as Khalkha (Mongolian central dialect) and Buryat dialects (Buryat dialect, one of the Mongolian dialects of the Baikal Basin), are predominantly used in Kyakhta merchants' pidgin language. Also, in Kyakhta merchants' pidgin it has been observed that words such as Russian, Mongolian, and Chinese are often used in the form of Mongolian verbs.

The use of predominant number of Russian-Mongolian and relatively smaller proportion of Chinese and Manchu words, which are mostly nouns indicate this that the merchants' pidgins may be based on the Mongolian language.

The position of the members of a sentence tends to be dominated by SOV-structured sentences. In other words, it follows the sentence structure of the Altaic root languages, or more precisely, the position of the member of the Mongolian sentence, and preserved by the Chinese-Russian pidgin language. In Chinese and Russian languages, the position of the members of the sentence is usually according to SVO and OVS-structured sentences.

Between the 18th and 20th centuries, the Mongolian language had a significant influence on the pidgin language of merchants, which was formed in Kyakhta, the border node city (and other similar trade stations such as Kalgan, Khuree, Khovd, Uliastai, Bugat and Huhhot which were centralized in the depths of Mongolia) located on the Tea Road. The lexicon and grammar of the Mongolian language have greatly influenced this format, which makes the subject matter interesting. There is a need for further research of the notes of scholars that recorded the use of Mongolian verbs formed by suffixes, and the position of sentence members that preserve the structure of Mongolian sentences in these common languages.

It is concluded that during the historical period of the Tea Road trade in the 18th and 20th centuries, a Mongolian-based derivative pidgin language was formed. Here we only discuss the Kyakhta merchants' pidgin, and there is an example of a Mongolian-based Chinese pidgin at another station on the Tea Road in the modern Chinese city of Kalgan to the south of Mongolia. Scholars who have studied pidgin and the Atlas of Pidgin and Creole Language Structures (APiCS: The Atlas of Pidgin and Creole Language Structures) have written "Chinese pidgin Russian" and "Chinese pidgin Russian with Mongolian 'accent'." Since the verb is formed by the verb structure of the Mongolian language, we

¹⁶ Also see there, 124 p.

¹⁷ Sayana Namsaraeva 2014, Border Language/Chinese Pidgin Russian with a Mongolian 'Accent', Inner Asia 16, Koninklijke Brill NV, Leiden, University of Cambridge 125 p.

¹⁸ А.Ю.Мусорин 2004, Лексика Кяхтинского пиджина, Функциональный анализ языковых единиц, Новосибирск. ст. 79-86.

¹⁹ Kapitolina Fedorova Language Contacts on the Russian-Chinese Border: The 'Second birth' of Russian-Chinese Trade Pidgin Chapter 7, pp.72-84.

suggest that another pidgin language called “mongolian pidgin Russian” should co-exist. We consider studying next whether “mongolian pidgin Chinese” existed.

In the 1990s, Mongolia transitioned to a market economy. Free trade began to flourish. At that time, not only mongolian but also russian and chinese traders were involved in trade, and mongolian traders traded wherever possible to obtain goods in high demand through border crossings. Re-formation of a common language among traders began again. This is a study field to clarify the features of the common language (pidgin) of modern traders and to study the influence of the Mongolian language as well.

References

In Mongolian:

1. Ш.Лувсанвандан 1959, Монгол хэл аялгууны учир, *Studia Mongolica*, Том I, Улаанбаатар.
2. Х.Нямбуу 1992, Монгол угсаатны хэлний бүрэлдэхүүн, БНМАУ-ын хүн ардын хэл аялгууны ангилал, “Монгол Улсын Угсаатны зүй” Удиртгал / Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн газар, Улаанбаатар.
3. Б.Ринчен 1969, Монгол Ард Улсын хамниган аялгуу, ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.
4. Б.Түвшинтөгс, О.Шинэбаяр 2012, Монгол хэлний түүхийн судалгааны тойм, Монгол хэл ба монгол хэлүүд, Хэл шинжлэл Соёмбо нэвтэрхий толь, Соёмбо Пресс хэвлэлийн газар, Улаанбаатар.
5. Ш.Эгшиг “Ази Европыг холбосон “Цайны зам” ба Монгол” Euroasian network, Past, Present and Future, 2014 Korea-Mongolia International Conference, 2014.10.10, Ulaanbaatar
6. Ш.Эгшиг Ш, Д.Гэрэлтөв, О.Сүхбаатар, Ё.Бадрал. 2016. Цайны зам, Улаанбаатар: Мөнхийн үсэг.

In English:

1. Avery, Martha. 2003. The Tea Road, China and Russia meet across the steppe. Beijing: China Intercontinental Press.
2. Concerning the city of Cambaluc, and its great traffic and population, Excerpt from The Book of Ser Marco Polo: The Venetian Concerning Kingdoms and Marvels of the East Volume1, Book Second, part 1, chapter XXII. translated and edited by Colonel Sir Henry Yule (London: John Murray, 1903)
3. Dieter Stern 2005, Myths and facts about the Kyakhta trade pidgin, *Journal of Pidgin and Creole languages*, Volume 20, Issue 1.
4. Gaby Bamana 2008, On the tea road, A journey into Mongolian life and Culture
5. Gibson, J. 1980. Russian Expansion in Siberia and America. *Geographical Review*, 70 (2)
6. How the Kaan’s posts and runners are sped through many lands and provinces, Excerpt from The Book of Sir Marco Polo: The Venetian Concerning Kingdoms and Marvels of the East Volume1, translated and edited by Colonel Sir Henry Yule (London: John Murray, 1903)
7. Jeong, Su-il. 2019. SILK ROAD The Photographic Silk Road-Steppe Road, Seoul: Gyeongangbuk-Do, Korea Institute of Civilizational Exchanges.
8. Kapitolina Fedorova Language Contacts on the Russian-Chinese Border: The ‘Second birth’ of Russian-Chinese Trade Pidgin Chapter 7.
9. Sarah G.Thomason 1997, Contact languages I. Pidgins and Creoles, Chapt.7, Amsterdam: John Benjamins.
10. Sayana Namsaraeva 2014, Border Language/Chinese Pidgin Russian with a Mongolian ‘Accent’, Inner Asia 16, Koninklijke Brill NV, Leiden, University of Cambridge.

In Russian:

1. Александр Жиров 2000, Чайный путь и Кяхта, Журнал “Земля Иркутская”.
2. Записка С.И.Черепанова 1853, X. Кяхтинское китайское наречие русского языка, Известия второго отделения Императорского Академия.
3. Лоевский Д.О. 2005, Русско-Китайские отношения в XVII в.: Отечественная историография, Документ, Архив, История, Современность. Выпуск 5, Издательство Уральского Федерального Университета, Екатеринбург.
4. Мусорин А.Ю. 2004, Лексика Кяхтинского пиджина, Функциональный анализ языковых единиц, Новосибирск.
5. Мясников В.С., Н.В.Шепелева 1980, Империя Цин и Русское государство в XVII в. Москва
6. Чимитдоржиев Ш.Б. 1978, *Взаимоотношения Монголии и России в XVII-XVIII вв.*, Издательство «Наука» Москва.

In other languages:

1. Kalmückisches Wörterbuch von G.J.Ramstedt, Helsinki, 1935.
2. Roberte N.Hamayon, M.L. Beffa 1984, Les Langues Mongoles, Études mongoles et sibériennes, 14.



ҮСЭГЧЛЭН ГАЛИГЛАХ АРГА, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ АСУУДАЛ

Т. Мягмарсүрэн²⁰

Abstract: This study was carried out to identify current situation and issues of transliteration of Mongolian words into Latin scripts. According to the purpose, we conducted a survey to investigate whether people are facing with a problem in connection with the transliteration of Cyrillic Mongolian characters into Latin characters and if so, why it is happening and what characters are difficult to make them converted. In this survey, four types of groups, “Mongol messenger” (an English language newspaper), “Chingis Khaan” (a book translated from Mongolian to English), Mobicom and Unitel companies (telecommunications service providers) and social media users were involved. The social media users in the survey were randomly selected. The result of the survey showed that 1) There is a problem in the process of transferring a word from the alphabet of Mongolian Cyrillic language to Latin alphabet. 2) The transliteration of four Mongolian Cyrillic characters such as “ө”, “ү”, “х”, and “в” into Latin characters are confusing and those characters are being used in a mixing way. 3) Therefore, individuals and organizations haven't been completely complied with the MNS5217:2012 standard, transliteration of Mongolian even it had been approved in 2012. 4) However, the standard is somewhat limited to the computer and other mobile devices and it causes mistransliteration.

Түлхүүр үг: үсэг, хэрэглэгч, алдаа, стандарт

Оршил

Дэлхийн цөөн хэдхэн улстай хамтын ажиллагаатай байсан манай улсын гадаад харилцааны салбар үсрэнгүй хурдацтай хөгжиж олон улс оронтой улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал гэх мэт чиглэл бүрээр харилцаагаа өргөжүүлэх болсон тэр цаг үеэс хойш өдгөө хорь гаруй жил болжээ. Хөгжлийн ийм таатай орчин бүрдсэн нь бидэнд чамгүй үр шимийг хүртэх боломжийг бий болгож өгсөн юм.

Бид улс улсын хэлийг эзэмших, тэр дундаа олон улсын харилцааны голлох хэл болсон англи хэлийг эзэмших хэрэгтэй болж, энэ талаар төрийн бодлого, шийдвэртээ ч цаг алдалгүй тусгаж, тодорхой зорилтот хөтөлбөр, арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн. Англи хэл нь нэгэнтээ дэлхий нийтийн соёл, шинжлэх ухаан, батлан хамгаалах, цэрэг армийн салбараас авахуулаад энгийн иргэдийн өдөр тутмын харилцаанд түгээмэл хэрэглэгдэх боллоо. Ийнхүү англи хэлнээс монгол хэлнээ, монгол хэлнээс англи хэлнээ орчуулах ажил мэргэжлийн орчуулагчийн хүрээнээс халж, хүмүүс өөрсдийн хичээл сургууль, хөгжил төлөвшил, аялал жуулчлал, хэрэгцээтэй мэдээ мэдээлэл хүртэх замаар орчуулах болсон нь хувь хүний хувьд үр өгөөжтэй хэдий ч үүний цаана хэл шинжлэлийн болон орчуулга зүйн тодорхой ойлголт, мэдлэг дутмагийн улмаас орчуулгын хэл найруулга, утга санаа, соёл сэтгэлгээний ялгаа гэх мэт орчуулах арга зүйтэй холбоотойгоор төрөлх хэл болон гадаад хэлэнд нөлөөлсөн зарим нэгэн таагүй үр нөлөөг бий болгосоор байна.

²⁰Доктор /Ph.D/, ОУУБИС, Англи хэлний тэнхим

Ялангуяа өнөөгийн мэдээлэл технологийн өндөр хөгжил нь хэлэнд сайн, саар үр дагаврын аль алиныг нь үзүүлж байгаа бөгөөд саар нэгэн нөлөө нь одоо энд дурдах гэж буй монгол үгийг англиар галиглахтай холбогдож байгаа билээ. Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээ мэдээлэл хүргэх, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах, таниулах, радио телевизүүд гадаадын кино, нэвтрүүлэг үзүүлэх, байгууллага, иргэд хувийн ба албаны захиа захидал бичих гэх зэргээр бараг хүн бүр монгол үгийг латин үсгээр галиглаж байгаа билээ.

Монгол улс 2003 онд анх монгол үгийг латин үсгээр хөрвүүлэх стандартыг албан ёсоор батлан хэрэгжүүлж эхэлсэн юм. 2012 онд уг стандартыг хүчингүй болгож нэмэлт засвар оруулаад өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжүүлж байна. Гэвч бид стандартыг дагаж мөрдөхдөө зарим талаар дутагдалтай, өөрсдийн дур зоргоороо монгол үгээ англиар галиглаж байгаа нь өнөөгийн бидний аливаа хууль журмаа хэр хэмжээнд дагаж мөрдөх болсныг төдийгүй хуулийг боловсруулагчид нь, сахиулагчид нь ч мөн хэр зэрэг дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлж байгааг харуулж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор зарим нэгэн үсгийн галигийн тэмдэглэл цахим хэрэгслийн боломжид хязгаарлагдаж байгааг, улмаар түүнийг шийдвэрлэх арга замыг, ер нь аливаа туурга тусгаар улс эх хэлээ хэрхэн хамгаалах талаар судлаачид санал дэвшүүлж байгаа ч ажил хэрэг болж жигдрэх нь хангалтгүй байна.

Үндсэн хэсэг

Монголчууд бид хэл соёлын баялаг өв сантай гэдгээ олон баримтаар нотолдог. Түүний нэг нь монгол үгийг галиглах юм. Анх Алтан хаан “Ганжуур” судрыг орчуулах зарлиг буулгаснаар 1587 онд Харчины Аюуш гүүш “Али Гали” хэмээх гадаад үгийг монгол бичгээр тэмдэглэх галиг үсгийн тогтолцоог боловсруулж монголын хэл шинжлэлийн хэрэглээний эргэлтэд оруулжээ. Али гэдэг нь эгшиг, гали гэдэг нь гийгүүлэгч гэсэн утгатай самгарди үг юм. Аюуш гүүш санскрит хэлний 16 эгшиг, 34 гийгүүлэгч, төвд хэлний 4 эгшиг, 30 гийгүүлэгч үсгийг монгол бичгээр бичих галигийг зохиохдоо монгол бичгийн авиазүй, үсэгзүй, санскрит, төвд хэлний авиазүйн онцлогийг тун нарийн ажиглан шинжилсэн гэж хэл шинжлэлийн эрдэмтэн судлаачид дүгнэдэг.

Үг хэллэгийн бичигт уг эх шинжээр нь буулгах тогтолцоог галиг үсэг гэдэг. (Санжаа, 2008) Монгол үгийг англи хэлээр галиглахдаа латин цагаан толгойн үсгээр тэмдэглэх бөгөөд үсэгчлэх болон авиачлах гэсэн хоёр аргаар буулгадаг.

Зураг 1. Галиглан орчуулах арга

Үсэгчлэн галиглах (Transliteration)	Авиачлан галиглах (Transcription)
- Нэг хэлний цагаан толгойн үсгийг нөгөө хэлний нийцэх цагаан толгойн үсгээр хөрвүүлнэ. - Тухайлбал, Грек - Кирилл: ⟨α⟩ → ⟨а⟩	- Авианы галиг нь үсгийн галигаа бодвол үгийн бичлэгийг гэхээсээ илүү дуудлагад тулгуурлан нэг хэлний цагаан толгойн үсгийн нөгөө хэлний цагаан толгойн үсгээр хөрвүүлнэ. - Тухайлбал, Кирилл - Англи: ⟨г⟩ → ⟨gh⟩

Нэг үсгийг өөр нэг үсгээр хувиргахдаа зөв бичих болон дуудах зүйн онцлогийг харгалзах шаардлагатай. Ингэж үгийг үсэгчлэн ба авиачлан галиглахдаа тухайн үгийн тухайн хэлэндээ хэрхэн дуудагдаж, бичигдэж байгаа яг тэр байдлаар нь нөгөө хэлний авиа, бичлэгт аль болох нийцүүлэн буулгахад анхаарах юм.

Жишээлбэл, англи хэлний “facebook” гэсэн үгийн дуудлага нь [feisābuk]. Үүнийг монголоор “фэйсбүүк” гэж дуудах бөгөөд бид энэ үгийн дуудлагыг нь алдаагүйгээр зөв дуудан хэрэглэж байна. Өөр нэгэн жишээ бол “iphone”. Англи дуудлага нь [aiāfəwn]. Монголоор “айфөүн” гэж дуудна. Гэхдээ бид “айфон, айпон” тэр битгий хэл “ааяпан, ааяпон” ч гэж дууддаг. Ерөнхийдөө латин цагаан толгойн үсэгтэй гадаад үгийг дуудахдаа бидний гаргадаг нэг түгээмэл

алдаа бол хоёр хэлний үсгийн хэлбэр талыг нь бодолцох гээд байдаг нэг зуршилтай. Энд “iphone” гэх энэ англи хэлний үгэнд орсон “o” үсгийг монгол хэлнийхээ “o” үсгийн хэлбэр ижил байдлаар нь шууд дуудаж, цаад хэлэндээ хэрхэн дуудагддагийг үл анзаарна. Англи хэлний нэг үетэй үгэнд орсон эгшиг үсгийг дуудах дөрвөн тохиолдол байх бөгөөд үүний нэг хэлбэр болох задгай үед буюу “ГЭГ, ГЭГГ” бүтэцтэй үед “o” үсгийг монгол хэлний “o” үсэгтэй ижил дуудлагаар дууддаг. Жишээ нь: “hot”, “song” г.м. Магадгүй энэ нь ч зарим нэг алдаанд нөлөөлдөг байж болох юм. Мөн бид өөрсдөө монгол хэлэндээ нэг үсгийг нэг л дуудлагаар дууддаг тул үүн шигээ адилхан дуудах хандлагатай байдаг.

Монгол үгийг англи хэлнээ галиглахад энэ мэт бичлэг, дуудлагыг мөн ялгаагүй анхаарах нь чухал. Монгол хэлний “дээл” гэсэн үгийг англиар “deel”, “тоорцог”-ийг “toortsog” гэх мэтээр үсэгчлэн галиглаж байгаа нь латин цагаан толгойгоор зөв тэмдэглэж байгаа юм. Дуудлага нь ч монгол хэлээр хэлж байгаагаас онц гойд зөрөхгүй. Цаад хэлэндээ өргөлтийг яаж авахаас хамаараад бага зэрэг өөр сонсогдох талтай. Гэхдээ монгол хэлнээс англи хэлнээ үгийг галиглахад зарим үсгийн бичлэг нь таарах ч дуудлага нь зөрдөг. Энэ талаар хэл шинжлэлийн ухааны доктор (Sc.D) Ц.Шагдарсүрэн багшийн “Монгол үг, нэр томъёог латин үсгээр тэмдэглэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлдээ авсан нэгэн тодорхой жишээг шууд эш татаж тайлбарлая. Монгол үгийг англи хэлний үсгээр тэмдэглэхэд юуг анхаарах, ямар зарчим баримтлах талаар ингэж бичжээ.

“Нэгэнт аль нэгэн гадаад хэлээр бичиж байгаа, хоёрт, монгол хэл мэдэхгүй хүмүүст зориулсан гэдгээр хэмжүүр болгож буй тул нэр томъёог өөр хэлээр бичихэд тэр хэлтний зөв бичихзүйг нь харгалзах шаардлага гарна. Монголчууд өөр хоорондоо латин галигаар бичихэд Selen(g)ge, Ger гэж тэмдэглэж болох боловч англиар бичих тохиолдолд тэр хэвээр нь бичих аргагүй, өөрөөр хэлбэл тухайн хэлний зөв бичихзүй, тухайн ер нийтийн зөв дуудахзүйн шаардлагад нь нийцүүлэн англи хэлээр Сэлэнжэ, жэр гэж дуудуулахгүйн тулд Selenghe, Gher ~ Selengue, Guer гэх мэтээр үсэгзүйн боломжийг хэрэглэн зохистой тэмдэглэх ёстой гэсэн үг. Ингээж гэмээ нь монгол хэл мэдэхгүй нийт англи хэлтэн монгол үгийг англи маягаар биш, монголоор шууд зөв дуудах болно. Үсэгзүй (Graphics)-н ухаанд үүргийн талаас нь, дуудлагагүй үсэг (Non-functional grapheme/letter) гэдэг нэр томъёо бүхий тухай ойлголт байдаг бөгөөд энэ нь Сэлэнгэ, гэр хэмээх дээрх хоёр үгийн жишээнд -g- гийгүүлэгчийн ард -e- эгшигийн өмнө жийрэглэн орсон -h-, -и- үсэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ хоёр нь өөрөө бие даасан дуудлагагүй, утга ялгах чадваргүй боловч тухайн үгийг англи хэлний маягаар Сэлэнжэ, жэр гэж дуудахгүй, Сэлэнгэ, гэр хэмээн дуудаарай гэсэн “тэмдэг” мэт үүрэгтэй.” (Шагдарсүрэн, 2010) Англи хэлний “g” үсэг нь хоёр янзаар дуудагддаг бөгөөд “g” үсгийн ард “e”, “i”, “u” эгшиг орвол цагаан толгойн дуудлагаараа [dʒi:] буюу монгол хэлний “ж” үсэг мэт дуудлагатай болдог. Жишээ нь: gerund [dʒɛlənd], ginger [dʒɪndʒə], gym [dʒɪm]. Харин “a”, “o”, “u” үсгүүд ард нь орсон тохиолдолд [g], монгол хэлний “г” үсэг адилаар дуудагдана. Жишээ нь: go [gɔ:], gather [ˈgædə], gum [gʌm] г.м. Англи хэлэнд ийм үсэг хэд хэд бий. Бид энэ ялгааг нь анхаарч үсэгчлэн галиглавал монгол үгийг гадаад хүн зөв дуудаж, эргээд ямар монгол үг хэлж байгааг нь бид ойлгоно.

Монгол үгийг латин цагаан толгой бүхий гадаад хэлээр тэмдэглэхдээ бичих дуудах хоёрын аль алиных нь зарчмыг баримталж тэмдэглэх нь тухайн зорилгод илүү нийцтэй юу эсвэл дан бичлэг болон дуудлагад тулгуурлах нь илүү чухал уу гэдгээ бодолцох нь зүйтэй. Чингис хааны нэрийг гадаадынхан “Genghis Khan” гэж галигласан байдаг. (Wikipedia) Харин бид үүнийг “Жэнгис хан” гэж уншина. Мэдээж их хааны нэрийг зөв бичих зүй, зөв дуудах зүйн аль алиныг баримталж галиглах ёстой. Тиймээс “Chingis Khaan” гэж латинаар тэмдэглэвэл “Чингис хаан” гэж уншина. Ер нь гадны мэдээллийн эх үүсвэрт монголын түүхэн хүмүүс болон ханлиг улс, газар орны нэрийг янз янзаар тэмдэглэснийг монголоор уншихад өөр үг болж дуудагдан гайхаж буудилдаг.

Гадаад үгийг монгол хэлэнд буулгахдаа аль болох тухайн эх хэлнээс галиглах нь зүйтэй ажээ. Төрийн шагналт, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хэл шинжлэлийн ухааны доктор, (Sc.D) Ц.Шагдарсүрэн “Гадаад нэр томъёог монголоор тэмдэглэхдээ аль нэгэн хоёрдогч буюу гуравдагч хэлээр дамжуулалгүй, уг хэлэнд нь ойртуулан тэмдэглэх зарчмыг баримталбал зохино. Үүнд бас учир дагавар буй. Тухайлбал, бичилгэ дуудалга хоёрын алий нь барих вэ гэдэг зовлонтой зүйл тулгардаг. Бичилгийг нь голлон баримтлах бөгөөс эргэж сэргээхэд хялбар боловч олон тохиолдолд дуудалгаасаа зөрөх нь бий. Дуудалгыг нь голлон баримтлах бөгөөс бичилгийг эргэн сэргээхэд төвөгтэй болдог. Жишээ нь: герман хэлнээ -ei- хослолыг [-ай-] гэж дуудаг тул *Heine* гэдэг нэрийг монголчилбол үсэгчлэн *Хейне* гэж буулгах уу (ингээж гэмээ нь эргүүлэн үсэгчлэн сэргээхэд зовлонгүй)? дуудалгаар нь *Хайне* гэж тэмдэглэх үү (ингээж гэмээ нь эргэж үсэгчлэн сэргээхэд хэцүү) гээд нэлээд зовлон гардаг тул нарийн судалгааны дүнд шийдэх энэ мэт зүйл олон бий.” Өнөөгийн залуучууд бид мэдээллийг гол төлөв нийгмийн сүлжээнээс олж үзэж байдаг ч, энэ мэт хэрэгтэй мэдээлэл нь тэнд биш зохиогчийн ном бүтээл дотор байж байдаг тул олж унших нь ховор. Энэ нь бид өнөөдөр нэг нэгэндээ гар утас, компьютер зэргээрээ мэдээ мэдээлэл, санал сэтгэгдэл бичихдээ байнга гаргаж байгаа алдаанаас илэрхий байгаа юм. Байгууллагууд, ном зохиол, сонин сэтгүүлийн зохиогч гээд бараг л бүгд монгол үгийг латин үсгээр галиглахдаа жигдэрсэн нэг тогтолцоо барьдаггүй.

Манай улс 1945 оноос хойш кирилл үсгийг албан ёсоор хэрэглэж эхэлсэн бөгөөд кирилл цагаан толгойн үсгийг латинаар галиглах MNS5217:2012 стандартыг 2012 оны 02 дугаар сарын 16-нд батлан хэрэгжүүлж байна.

**Хүснэгт 1. Монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсэгт хөрвүүлэх
MNS5217:2012 стандарт**

№	Кирилл үсэг	Латин үсэг	№	Кирилл үсэг	Латин үсэг
1.	А	A	19	Р	R
2.	Б	B	20	С	S
3.	В	V	21	Т	T
4.	Г	G	22	У	U
5.	Д	D	23	Ү	Y
6.	Е	Ye	24	Ф	F
7.	Ё	Yo	25	Х	H, Kh
8.	Ж	J	26	Ц	Ts
9.	З	Z	27	Ч	Ch
10.	И	I	28	Ш	Sh
11.	Й	I	29	Щ	Shch
12.	К	K	30	Ъ	'
13.	Л	L	31	Ы	Y
14.	М	M	32	Ь	'
15.	Н	N	33	Э	E
16.	О	O	34	Ю	Yu
17.	Ө	§	35	Я	Ya
18.	П	P			

Монгол улсын стандарт хэмжил зүйн газраас гаргасан энэ стандарт нь “ISO 9:1995, Information and documentation-Transliteration of Cyrillic characters into Latin characters-Slavic and non-Slavic Languages” стандарттай бүрэн нийцдэг байна. Монгол үгийг латин үсгээр галиглах тогтсон загвар, дагаж мөрдөх стандарт байгаа хэдий ч бид монгол үгийг латин үсгээр хөрвүүлэхдээ энэ стандартаа нийтээр дагаж хэвшихгүй байна. Нийтээр жигд дагаж мөрдөхгүй байгаа нь боловсруулсан энэ стандартдаа байна уу?, эсвэл хэрэглэгчдэдээ байна уу? Монгол улсын стандарт, хэмжил зүйн газраас албан ёсоор монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсэгт хөрвүүлэх стандартыг анх 2003 онд батлан хэрэгжүүлснээс хойш үүний хэрэглээ,


галигийн тэмдэглэгээтэй холбоотой асуудлаар Ш.Лувсанвандан (2008), Ц.Шагдарсүрэн (2008, 2010), Б.Батбаяр (2012), Б.Сүхбаатар (2012) болон бусад эрдэмтэн судлаачид, нийтлэлчид асуудал хэлэлцэж, санал дэвшүүлсэн байдаг.

Судалгааны хэсэг

Энэхүү өгүүллээр монгол үгийг латин үсгээр галиглаж байгаа өнөөгийн байдлыг буюу монгол хэлнээс англи хэлэнд үгийг хэрхэн хөрвүүлэн хэрэглэж байгааг тодруулсан болно. Энэ зорилгодоо хүрэхийн тулд монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсгээр галиглахад ямар бэрхшээл байгааг, ямар ямар үсэг галиглаж болохгүй байгааг тодорхойлохоор хэрэглэгчийн судалгаа авлаа.

Зураг 2. Хэрэглэгчийн судалгаа


Монгол үгийг латин үсгээр галиглахад хоёр асуудал тулгарч байна. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын дийлэх нь буюу 60% нь цахим хэрэгсэл дээр тохирох тэмдэгт нь байдаггүй гэж үзсэн бол үлдсэн 35% нь бусдыг дагаад хамаагүй бичиж байна.



Хүмүүс хувийн ба албан захидал бичих, эрдэм шинжилгээний илтгэл тавих, өгүүлэл бичих, ном бүтээл орчуулах, сонин сэтгүүл гаргах гэх зэргээр цахим хэрэгслээр монгол үгийг латин үсгээр үсэгчлэн галиглаж байгаа бөгөөд монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсгээр хөрвүүлэхэд дараах үсгүүдийг хамгийн бэрхшээлтэй гэж үзлээ.

Зураг 3. Үсэгчлэн галиглахад бэрхшээлтэй үсэг

Монгол хэлний кирилл цагаан толгойн 35 үсгийг латин 25 үсэгт хөрвүүлэхэд бэрхшээлтэй байдаг үсгүүдийг сонгуулахад Ө, Ү, Х, В-г нэрлэлээ. Ө, Ү үсгийг нөгөө хоёр үсгээсээ илүү бэрхшээлтэй гэж үзэж байгаа нь эдгээрийн эгшиг үсэг гэдэгтэй нь холбоотой болов уу. Судалгаанд оролцогчид цахим хэрэгслээр Ө, Ү үсгийг О, У үсэгтэй хольж хэрэглэдэг, гэхдээ үүнийгээ хоорондоо ойлголцдог гэж хариулав. Иргэд Ө, Ү, Х, В үсгийг латинаар хоёроос гурван үсгээр тэмдэглэж байна.



Дээрх нэг латин үсгээр монгол хэд хэдэн үсэг тэмдэглэж байгаа, нэг монгол үсгийг хэд хэдэн латин үсгээр хэрхэн тэмдэглэж байгааг дараах жишээгээр үзүүлье.

Хүснэгт 2. Галиглахад бэрхшээлтэй монгол ба латин үсгийн тэмдэглэл ба түүний дуудлага


Үсэг	Монгол үг	Латин үсгээр хөрвүүлсэн байдал	Нэг үсгийг нөгөө хэлний хэд хэдэн үсгээр хольж хэрэглэж байгаа байдал	Галигласан үгийн дуудлага
Ө	Өгөөдэй	Ogodei	Ө→O	Огодэй
Ө	Өлзий	Ulzii	Ө→U	Улзий, Үлзий
Ө, Ү	Н. Төмөрхүү	N. Tomorkhuu	Ө→O Ү→U	Томорхуу Томорхүү
Ү	Пүүжээ	Puyjee	Ү→Y	Пийзий
В	Говь	Gowi	В→W	

B	Идэвхжүүлэх	Idevhjuulch	B→V	
X	Халаалт	Halaalt	X→H	
X	Харах	Xarax	X→X	

Өгөөдэй, Өлзий, Төмөрхүү гэх мэт “ө” үсэг орсон хүний нэрийг англиар галиглахдаа “o”, “u” үсгийг авч ашиглаж байна. Галигласан үгийг эргээд монгол хэлэнд буулгахад Огодэй, Улзий, эсвэл, Үлзий гэж уншиж болно, мөн Томорхуу, эсвэл, Томорхүү гэх байдлаар уншиж байна. “Y” үсгийн будлианыг харвал Пүүжээ гэсэн нэрийг “Руужее” гэхээд, уншихаар “Пийзий” гэх дуудлагатай болж байна. Монгол хэлний “B” үсгийг латины “V”, “W” үсгээр тэмдэглэж байгаа нь “Gowi”, “idevhjuulch” үсгийн жишээнээс харагдаж байна. Энд жишээ татаж авсан “Төмөрхүү”, “идэвхжүүлэх”, “халаалт”, “харах” гэсэн монгол үгэнд орсон “х” үсгийг латинаар “Tomorkhuu”, “idevhjuulch”, “halaalt”, “xarax” гэж галигласан байгааг харвал “х” үсгийг латинаар “h”, “kh”, “x” гэсэн гурван үсгээр тэмдэглэжээ. Энэ нь хэрэглэгчдийн цахим хэрэгсэлд тэмдэгт нь байхгүй, бусдыг дагаад бичдэг гэсэн хариулт үнэн болохыг харуулж байна.


Судалгаанд оролцогчдын бэрхшээлтэй гэж үзсэн дээрх Ө, Y, X, B гэсэн дөрвөн үсгийг энгийн иргэд, сонин сэтгүүл, орчуулгын зохиол бүтээл, албан байгууллагууд хэрхэн ашиглаж байгааг цааш тодруулсан бөгөөд судалгаанд “Монгол мессенжер” сонин, “Чингис хаан” орчуулгын ном, үүрэн холбооны үйлчилгээ явуулдаг Мобиком, Юнител компаниуд болон цахим сүлжээний хэрэглэгчдийн төлөөллийг хамрууллаа.

Зураг 4. Монгол үгийг латин үсгээр хөрвүүлсэн байдал (Ө, Y)



Англи хэлээр орчуулан гардаг “Монгол мессенжер” сонины 2 өдрийн дугаараас хүний болон газар орны оноосон нэрийг үсэгчлэн галигласан 40 үгийг түүвэрлэсэн бөгөөд “ө”, “ү” үсгийг стандартад зааснаас өөрөөр буюу аль алиныг нь ижилхэн латин “u” гэсэн нэг үсгээр тэмдэглэжээ. Монгол хэлнээс англи хэлэнд орчуулсан “Чингис хаан” номоос 30 үг түүвэрлэн авсан бөгөөд эдгээр нь Arik Boke, Yesugen, Guchlug, Khukh-nuur, Jurkin гэх мэт оноосон нэр бөгөөд “Монгол мессенжер” сонины адил “ө”, “ү” үсгийг латин “u” үсгээр галигласан байна. Сонин сэтгүүл, ном зохиол нь нэг хэлнээс нөгөө хэлэнд хийсэн орчуулгын бүтээл тул голдуу нэр томъёог үсэгчлэн галиглажээ.

Зураг 5. Зураг 4. Монгол үгийг латинаар үсгээр хөрвүүлсэн байдал (Ө, Ү, Х, В)



Мобиком, Юнител гэх мэт үүрэн холбооны үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжүүд хэрэглэгчдэдээ мэдээ мэдээллээ хүргэх, энгийн иргэд хоорондоо захиа захидал цахим хэрэгслээр бичихдээ монгол үг бүрийг үсэгчлэн галигладгаараа ном, сониноос ялгаатай. Энэ нь “ө”, “ү” хоёр үсгийг биш энд яригдаж байгаа дөрвөн үсгийг дөрвүүлэнг нь хольж, сольж, нэг монгол үсгийг хоёр латин үсгээр тэмдэглэсэн байгаагаас харагдаж байна. Тэр дундаа эдгээр эх үүсвэрт “ү” үсгийн галиг бусад үсгээсээ илүү хувиар стандартаас зөрүүтэй тэмдэглэгдэж байна. Өмнөх ном, сонин дээр ч ийм үр дүн гарсан. Жишээ нь: “ү” үсгийг “u”, “v” хоёр латин үсгээр тэмдэглэж байна. Энэ нь стандартад заасан “Ӯ” латин үсэг нь цахим хэрэгсэлд байдаггүйтэй холбоотой. “Ө” үсгийг ч мөн стандартад зааснаас өөрөөр “ö” биш, “ү” үсэгтэй ижилхэн “Ӯ” гэсэн нэг латин үсгээр бичиж байгаа нь цахим хэрэгслийн боломжид хязгаарлагдсаных юм.

“Х” үсгийг өнөөгийн мөрдөж буй стандартад “kh”, “h” гэсэн хоёр хувилбараар тэмдэглэхээр тусгасан байдаг. Эдгээр үсгүүдийн хувьд цахим хэрэгсэлд байдаг үсгүүд. Гэхдээ үүнээс өөрөөр бас латин “x” үсгээр галиглаж байгаа нь дээр дурдсанаар нэгд, бусдыг дуурайх, хоёрт монгол хэлний “х” үсэгтэй хэлбэр ижлээр нь орлуулж байна. Англи хэлний “х” үсгийн цагаан толгойн дуудлага нь монгол хэлнийхээс огт ондоо [eks] буюу “(э)кс” тул монгол хэлний “х” үсэгтэй нийцэхгүй юм. Иймд англи хэлний энэ үсгээр монгол хэлний “х” үсэг орсон үгийг үсэгчлэн, авиачлан галиглахад тухайн монгол үг зөв дуудагдахгүй.

Монгол үгийг латин үсгээр галиглахад бэрхшээлтэй гэж үзэж байгаа өөр нэг үсэг бол монгол хэлний “в”. Энэ үсгийг бэрхшээлтэй гэж нэрлэхээсээ илүү бид өөрсдийгөө бодлогогүй, хайхрамжгүй, замбараагүй гэвэл ононо. Учир нь иргэд энэ үсгийг судалгаанд хамрагдсан нөгөө гурван бүлгээсээ илүү хувиар алдаж тэмдэглэж байгаа юм. Монгол хэлний “в” үсгийг тэмдэглэх латин “v” үсэг нь цахим хэрэгсэлд бэлэн байдаг.

Дүгнэлт, санал

Монгол үгийг латин үсгээр үсэгчлэн болон авиачлан галиглахад бага зэрэг бэрхшээл байна. Бэрхшээл нь кирилл цагаан толгойн үсгийг латинаар галиглах MNS5217:2012 стандартад ч байна, иргэд бидэнд ч байна. Хэрэглэгчийн судалгаагаар бэрхшээлтэй гэж үзсэн Ө, Ү, Х, В үсгийг хэрхэн бичиж тэмдэглэж байгааг албан ба албан бус дөрвөн бүлгийн төлөөллийг хамруулан

судалж үзэхэд, Ө, Ү үсгийн хувьд стандартад заасан латин үсэг “Y”, “ö” нь хэрэглээний цахим хэрэгсэлд байдаггүй учраас латин “u” үсгээр адилхан галиглах нь түгээмэл байна. Түүнчлэн монгол хэлний “Y” үсгийг латин “Y”, “V”, “O” үсгээр, “Ө” үсгийг латин “O” үсгээр ч “дөхүүлэн” тэмдэглэж байна. Х, В үсгийг латин үсгээр галиглахад цахим хэрэгслийн талаас бэрхшээл байхгүй, зөвхөн бид замбараагүй, дур зоргоороо бичиж байна.

Монгол үгээ латин үсгээр буруу галиглахад нэгд, дагаж мөрдөх стандарт байсаар атал бид өөрсдөө хувь хувьдаа галиглах хувилбарыг бий болгосон. Хоёрт, нэг хэсэг нь яаж галиглахаа огт мэдэхгүй тул бусдыг дагаад хамаагүй бичдэг. Гуравт, хэрэгжүүлж буй стандартад заасан зарим латин үсгээр монгол үгийг тэмдэглэхэд цахим хэрэгслийн боломж нь байхгүй байгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Буруу галиглаж байгаагийн уршгаар гадаад үгийг монголоор буруу дуудаж бусдын зүйлд хүндэтгэлгүй хандаж эвгүй байдалд орох, монгол үгээ латин үсгээр буруу галигласнаас, өөрсдөө эргээд нөгөө монгол үгээ танихгүй болох, гадаадынханд буруу зөрүү ойлголт төрүүлж будилуулах, тэр байтугай бид өөрсдөө ч дотроо овог нэрээ буруу галиглаж бичээд төрийн үйлчилгээ авах, гадаадад явах, захидал харилцаа үүсгэхдээ үл ойлголцож өөртөө болон бусдадаа төвөг учруулж байна.

Иймд цаашид монгол үгийг латин үсгээр галиглах MNS5217:2012 стандартаа нийтээр хэрэглэж хэвших, тус стандартыг хэрэглэхтэй холбоотой гарч байгаа алдаа дутагдлыг холбогдох мэргэжилтнүүд нь хянаж үзээд боломжит хувилбарыг дэвшүүлэх нь зүйтэй.

Ном зүй

1. Батбаяр, Б. (2012). *Монгол бичигт латин үсэг ингээж хэрэглэе*. Улаанбаатар.
2. Лувсанвандан, Ш. (2008). *Монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсэгт хөрвүүлэх тэмдэглэгээ*. Улаанбаатар.
3. Санжаа, Ж. (2008). *Монгол хэлний авиа зүй ба авиалбарзүй*. Улаанбаатар.
4. Сүхбаатар, Б. (2012). *Монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсэгт хөрвүүлэх нь*. Улаанбаатар.
5. Төмөртоогоо, Д. ба бусад. (2004). *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар.
6. Шагдарсүрэн, Ц. (2010). *Монгол үг, нэр томъёог латин үсгээр тэмдэглэх нь*. Улаанбаатар.
7. Шагдарсүрэн, Ц. (2008). *Монгол хэлний кирилл цагаан толгойн үсгийг латин үсэгт хөрвүүлэхдээ болзон тэмдэглэх нь*. Улаанбаатар.
8. Wikipedia. (n.d.). *Genghis Khan-Wikipedia*.



МОНГОЛ ХЭЛНИЙ ХАЛХ БОЛОН ЦАХАР АЯЛГУУНЫ
ҮГСИЙН САНГИЙН ЗАРИМ ОНЦЛОГ, ЯЛГАА

Б.Жигжидсүрэн²¹, Сана²²

Abstract: The research is intended to examine vocabulary differences and distinguishing features of Khalkha and Chakhar dialects of Mongolian language. It shows comparisons of some different words and expressions, and it is concluded the results of the comparison. Mongolian language radio programs of the Khulunbuir Radio and Television Committee were selected, and the words and expressions with different local dialects was sampled and compared in the research.

Түлхүүр үг: үгийн сан, хэлц, хэллэг, аялгуу, Халх аялгуу, Цахар аялгуу

Аливаа хэлний аялгууг ялгах нэг гол хүчин зүйл бол хэл шинжлэлийн талаас авиазүйн онцлог, ялгаа байдаг ч үгийг сангийн ялгаа ч мөн адил чухал нөлөөтэй байдаг. Түүхэн хэл шинжлэл судлаачид тодорхой бүс нутаг, тэр дундаа хөдөө орон нутгийн аялга, аялгууны өөрчлөлтийг ажиглан судлах болсноор нутгийн аялгуу судлал зууны тэртээ Европт үүсэн бий болжээ. Хожим нь Нутгийн аялгуу судлал нь үг зүйн ялгааг судлах болсон.” (О’Грейди, Добровольский, 1987:346)

Тус судалгаанд нэр үг, үйл үг, тэмдэг нэр гэх мэт хэл зүйн айн талаас нь гэхээсээ илүү Халх болон Цахар аялгууг тодотгон ялгаж буй үг хэллэг буюу үгийн сангийн үүднээс харьцуулан судалсан байдаг. Судалгааны явцад “сүжи” (дарга), “кадр” (дарга) гэх мэт зээлбэр үг, “мануус” (бид), “хамжилцаа” (тусламж) гэх мэт нэр үг, “шингээх” (дуу/дүрс бичүүлэх), “тунгалагших” (цэлмэх) гэх мэт нэр үг, “хүчир” (хэцүү), “бүр сайн” (маш сайн) гэх мэт тэмдэг нэр, “дуугийг” (дууг), “баяжлыг” (баяжих) гэх мэт дагавар төдийгүй “хамжилцааг чангатгах” (харилцааг чангатгах), “уур амьсгалын хувиралт” (уур амьсгалын өөрчлөлт), “сүлжээний амар түвшинг хамгаалах” (сүлжээний аюулгүй байдлыг хамгаалах) гэх мэт үг хэллэгийн онцлог ялгаанууд байгааг олж илрүүлжээ.

“Монгол хэл үгсийн сангаар маш баялаг төдийгүй үгсийн сангийн найруулга бүрэлдэхүүний хувьд олон янз байдаг. Үгийн санд хуучирсан үг, шинэ үг, нутгийн аялгууны үг, нэр томьёо, этгээд аялгууны үг, ном бичгийн болон энгийн ярианы үг зэрэг багтах боловч эдгээр нь утга зохиолын хэлний хэм хэмжээнд тэр бүр тохирдоггүй юм” (Надмид, Санжаа, 1993:15) гэснээс үзвэл Халх болон Цахар аялгуу нь үгийн сангийн ялгаа бүхий хэлц хэллэг олон байгааг баталж байна. “Аливаа хэлний үгийн сан бол байгаль нийгэмд гарч байгаа өөрчлөлт, шинэ юм, үзэгдлийг даган шинэ үг хэллэг, нэр томьёогоор баяжиж байхад зарим нь хуучирч хэрэгцээнээс гарах, эсвэл эсвэл зарим хуучин үг хэллэгийг сэргээн хэрэглэх зэргээр хэлний бусад үзэгдлийг бодвол ихэд хөдөлгөөнтэй байдаг гэжээ”. (Надмид, Санжаа, 1993:15) гэсэнтэй санал нэг байна.

²¹ ОУУБИС, Англи хэлний тэнхимийн багш, доктор

²² БНХАУ, Хөлөнбуйр ИС, ГХС, Англи хэлний тэнхимийн багш

Тухайлбал, Монгол хэлний Цахар аялгуунд үг зээлбэрлэх болон шинээр зохиох байдлаар шинэ үг хэллэгээр үгийн сан нь нэмэгдэж байна.

“Утга зохиолын хэл нь суурь болсон аялгуунаасаа зонхилж, авиазүй, хэлзүйн онцлогийг авах бөгөөд иймээс ч халх аялгууны гол гол онцлог утга зохиолын хэлтэй үндсэндээ тохирч гол баримжаа болдог. Харин бусад аялгуунаас ихэвчлэн үгийн сангаа баяжуулж байдаг бөгөөд тухайлбал ойрд аялгууны *цэрд*, буриад аялгууны *баавгай*, *заядуул* зэрэг үг аль хэдийн утга зохиолын хэлний үгийн санд нэвтрэн оржээ.” (Надмид, Санжаа, 1993:7) гэснээс үзвэл Халх болон Цахар аялгуу нь харилцан зээлбэрлэн авч үгийн сангаа баяжуулсан гэх жишээ судалгаанд хамруулсан 11 нэвтрүүлгээс төдийлөн ажиглагдсангүй.

“Хэмнэлийн утга тухайн хэлээр яригч хүний ой ухаанд хадагдсан утгыг ялгах, түүнийг өөр хооронд нь эсрэгцүүлэн тавих чухаг тодорхойлолт мөн. Үгийн нийлцийн харьцаа аман яриа, бичвэрт шууд илэрдэг бол хэмнэлийн харьцааг үгийн сангийн нэгжүүдийн төстэй ба ялгаатай талыг тогтоох өвөрмөц задаргааны аргаар үгийн нийлэмжийн харьцаанаас гаргаж авдаг байна.” (Равдан, 2000:65) гэсэн нь Халх болон Цахар аялгуугаар яригч хүмүүсийн ой ухаанд хэлний онцлог хэлц хэллэг нь бүрэн хадгалагдсан, үгийн сангийн энэхүү ялгаатай байдал нь харьцангуй тогтвортой байна. “Тухайн нэг хэлний хэл шинжлэлийн онцлог ялгаа нь тухайн хэлээр харилцан ярилцагчийн хэл ярианы найруулгаас шалтгаалдаг. Тэрхүү хэл ярианы найруулга нь ерөнхийдөө яригчийн сэтгэлийн байдал, тухайн үеийн нөхцөл байдлыг илэрхийлдэг. Энэ хүчин зүйл нь аялга, аялгууны байдлаас ялгаатай. Аялгуу нь тухайн нийгмийн хүрээнд олон хүмүүсийн дунд тодорхой тогтсон байдаг бол, ярианы найруулга нь нэг хүний өөр өөр нөхцөлд үүсч буй ярианы хэл юм.” (Хамид Бехраван, р.17) гэснээс үзвэл хэл яриа нь тухайн яригч хүний ямар үг сонгон ярьж байгаагаар буюу түүний бодол санаагаа илэрхийлж буй дахин давтагдашгүй онцлог ялгаагаар тодорхойлогдож болох юм. Мөн түүнчлэн тухайн радио нэвтрүүлгийг бэлтгэсэн сэтгүүлч, нийтлэгч, редактор, нэвтрүүлэгчийн ямар яс үндэстэй, ямар аялгуугаар ярьдаг эсэхээс шалтгаалан ялгаатай үг хэллэг үүссэн байж болно.

“Америк, Их Британийн хүмүүс уулзахдаа хамгийн тод ялгаа нь тэдний аялга дуудлагад оршиж байна. Гэхдээ илүү гүнзгий эсвэл мэдэгдэхүйц бага түвшинд үгийн сангийн зөрүү нь энэ хоёр аялгууг тэс өөр хэл мэт болгож байна. Тухайлбал, Америк аялгуунд “railroad tie”, Британи аялгуунд “railway sweeper” гэх мэтийг ижил нэг юм заасан үгсийг өөрөөр нэрлэдэг. Мөн түүнчлэн хоёр өөр үг боловч Америк аялгаар “luggage”, Британи аялгаар “baggage” гэх мэтийн утга ижил үгс байдаг. Нэг газар түгээмэл хэрэглэгддэг зарим үгс нөгөө газар түгээмэл биш байна. Тухайлбал, “soppy” эсвэл “row” гэх мэт үгс Америкийн толь бичигт байх боловч ярианд нь түгээмэл биш харин Их Британид түгээмэл хэрэглэгддэг байна. Их Британид хадгалагдаж үлдсэн “fortnight”, “constable” гэх мэт үгс Америкчуудын хувьд орхигдож, харин Британид хэрэглэгддэггүй “mad” (in the sense of angry), “fall”, “sick” гэх мэт олон үгсийг Америкт илүү хэрэглэж байна.” (Giuseppina Scotto Di Carlo, 2012:4) Үүний адил Халх болон Цахар аялгууны ялгаатай үг, хэллэг ч мөн нилээд байна. Жишээ нь: Цахар аялгууны “сүүдэрлэн шинэчлэх”, “хундага мөрийцөх уралдаан”, “ухуулан туушлуулахыг түргэтгэх” гэх мэт үгс шууд хүлээн авч ойлгоход төвөгтэй байна. Мөн “дүнчүүр”, “түм”, “гацаа”, “балгас”, “жин” гэсэн үг хэллэг Цахар аялгуунд хадгалан авч үлдсэн байхад Халх аялгуунд эдгээр үгсийг төдийлөн хэрэглэдэггүй.

“Газар нутгийн тусгаарлалт нь аялгуу хоорондын ялгааг үүсгэх нэг гол хүчин зүйл болдог бөгөөд зарим аялгуу нь байгалийн жамаар тусгаарлагдсан газарзүйн онцлог шинжээс шалтгаалан тусгаарлагддаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан нөлөөллөөс гадна Их Британид гарч буй Америкийн кино илүүтэйгээр нөлөөлж байж болох юм” (Giuseppina Scotto Di Carlo, 2012:5) гэснээс үзвэл газар зүйн тусгаарлагдмал байдал нь Халх болон Цахар аялгууг өөр өөрийн онцлогоо хадгалан хөгжихөд мэдээж нөлөөлжээ. Харин мэдээлэл технологи өндөр хөгжсөн өнөө

үед мэдээ мэдээлэл болон урлаг соёлын харилцаагаар дамжин тодорхой хэмжээнд харилцан нөлөөлөх хандлага байна.

Хөлөнбуйрын радио телевиз хорооны Монгол хэлний ерөнхийлсөн радиогийн 11 нэвтрүүлгийг сонгон авч нутгийн аялгууны онцлог ялгаатай үг, хэллэгүүдийг түүвэрлэн авч харьцуулан судаллаа.

Тус судалгаанд хамруулсан радио нэвтрүүлэг 1 минутад ойролцоогоор хэдэн үг хэлэгдэж, мөн хэдэн ялгаатай үг, хэллэг байгааг илрүүлэв. Радиогийн нэвтрүүлгүүд нь 1 минутад хамгийн багадаа 100 үг, хамгийн их нь 140 үг хэлэгдэж байсан учир дунджаар 1 минутад 120 үгээр тооцон судалгаанд ашигласан.

Хүснэгт 1. Радио нэвтрүүлгүүдийн харьцуулсан үзүүлэлтүүд

№	Радио нэвтрүүлгийн нэр	Нэвтрүүлгийн хугацаа /минут/	Нийт үгийн тоо /ойролцоогоор/	Хэлц, хэллэгийн тоо	Эзлэх хувь
1	Сонин мэдээ	10:00	1200	10	0.833
2	Талын цуурай	28:37	3360	14	0.416
3	Бүх улсын мэдээ	30:37	3600	13	0.361
4	Мэдээ мөрдлөгө	14:50	1960	4	0.204
5	Тулгуур товчоон	14:56	1680	7	0.416
6	Сонин мэдээ	10:03	1200	4	0.333
7	Малжих орон	19:52	2280	3	0.131
8	Радио туужис	25:23	3000	5	0.166
9	Цаг уурын мэдээ	03:27	360	4	1.111
10	Хуулийн тавцан	07:53	840	2	0.238
11	Өвөр Монголын мэдээ	16:56	1920	12	0.625
	Нийт		21400	78	0,34 /дундаж/

Судалгаанаас авч үзвэл “Малжих орон” нэвтрүүлэгт 0,13% (хамгийн бага), “Цаг уурын мэдээ” нэвтрүүлэгт 1,11% (хамгийн их)-ийг нутгийн аялгууны ялгаатай үг, хэллэг эзэлж байна. Нийт 11 нэвтрүүлгийн дунджаар авч үзвэл 0,34%-ийг эзэлж байгаа нь нутгийн аялгууны ялгаатай үг, хэллэг маш бага хувийг эзэлж байна. Иймд Халх болон Цахар аялгуугаар ярилцагч хүмүүс бүрэн чөлөөтэй харилцан ойлголцох боломжтой байна. Харин хааяа тохиолдох нутгийн аялгууны үг, хэллэг Халх аялгуугаар ярилцагч хүмүүст ойлгомжгүй байгаа нь тус хоёр аялгууг ялгах гол хүчин зүйл болж байна.

Дүгнэлт

Халх аялгуунд төдийлөн хэрэглэгдэхээ больсон хуучин үг, хэллэгийг Цахар аялгуунд идэвхтэй хэрэглэж байгаа нь үгийн сангийн ялгааг үүсгэхэд голлох нөлөөтэй байгаа төдийгүй тус хоёр аялгууг тодотгож байна.

Судалгаанд хамруулсан нэвтрүүлгүүдэд нутгийн аялгууны ялгаатай үг, хэллэг дунджаар 0,34%-ийг эзэлж байгаа нь Монгол хэлний Халх болон Цахар аялгуугаар ярилцагч хүмүүсийн хувьд харилцан ойлгоход төдийлөн хүндрэл бэрхшээл учруулахуйц хэмжээнд биш байгаа ч аялгууг ялгарах нэгэн онцлог нөхцөл болж байна.

Халх болон Цахар аялгуугаар ярилцагч хүмүүс бүрэн чөлөөтэй харилцан ойлголцох боломжтой байна. Харин хааяа тохиолдох нутгийн аялгууны үг, хэллэг Халх аялгуугаар ярилцагч хүмүүст ойлгомжгүй байгаа нь тус хоёр аялгууг ялгах гол хүчин зүйл гэж дүгнэж байна.

Ном зүй

I. Монгол хэлээр

Равдан. Э., (2000). Бүтэц хэл шинжлэл, Улаанбаатар

Надмид. Ж., Санжаа. Ж., (1993). Орчин цагийн монгол хэлний авиа зүй, Улаанбаатар

II. Гадаад хэлээр

O'Grady, Dobrovolsky, Contemporary linguistic analysis, Toronto, Ontario, Canada, 1987

Hamid Behravan, (2012). Dialect and Accent Recognition, Master's Thesis, School of Computing, University of Eastern Finland

III. Цахим эх сурвалж

http://www.cs.joensuu.fi/sipu/2012_MSc_Behravan_Hamid.pdf (Hamid Behravan. December, 2012, Dialect and Accent Recognition, Master's Thesis, University of Eastern Finland, School of Computing)

http://elies.rediris.es/Language_Design/LD15/LD15_03_Scotto_di_Carlo.pdf (Lexical Differences between American and British English: a Survey Study, Giuseppina Scotto Di Carlo, *Università degli Studi di Napoli 'Federico II' Italy*)



МОНГОЛ-АНГЛИ ХЭЛНИЙ [vi], [ɔi] ХОС ЭГШГИЙН АКУСТИКИЙН ЗАДЛАЛЫН ЗЭРЭГЦҮҮЛСЭН СУДАЛГАА

Ц.Мөнхтуяа²³

Abstract: This paper contrasts acoustic analysis of 60 words with Mongolian diphthongs as [vi], [ɔi] in the first and second syllables produced by Mongolian female and male participants and compared to acoustic studies of English diphthongs as [vi], [ɔi]. Four Mongolian native speakers were recruited to produce for 30 words. A contrastive acoustic analysis of Mongolian and English diphthongs as [vi], [ɔi] measured and analyzed formant one (F₁) and formant two (F₂) values, spectrogram and durations. Results show that Mongolian - English diphthongs as [vi], [ɔi] by native speakers are different and similar acoustic properties in syllables.

1. Presentation of the diphthongs as [vi], [ɔi] acoustic qualities of comparison between Mongolian and English Languages by female and male in syllables.

2. The Comparative and contrastive acoustic differences and similarities of the Mongolian - English diphthongs as [vi], [ɔi] qualities in other syllables.

Түлхүүр үг: эгшиг, хос эгшиг, акустик анализ, формант, уртач, Прат программ, спектрограмм

УДИРТГАЛ

Эрдэмтэн Ж. Санжаа, Ж. Надмид нар (Ж. Санжаа, Ж. Надмид, 2008) хос эгшиг гэдэг өгүүлэх эрхтний үйл ажиллагаа аажмаар нэг эгшгийг хэлэх байдлаас нөгөө эгшгийг хэлэх байдалд шилжин орохыг хэлнэ гэж тодорхойлжээ. Орчин цагийн монгол хэлэнд хос эгшгийн тухай, мөн зарим хос эгшгийг авиалбарын тоонд оруулах эсэх талаар эрдэмтдийн санал олон янз байна. Монгол хэлний хос эгшгийг нилээд нарийвчлан судалсан эрдэмтэд болох Б.Я.Владимирцов, Г.Д.Санжеев, Г.И.Рамстедт, Ш.Лувсанвандан, С.Мөөмөө, Ш.Барайшир нар монгол хэлэнд ай, ой, уй, үй гэсэн дөрвөн уруудах хос эгшиг авиа байна гэсэн нэгдмэл саналтай. Монгол хэлний эй хос эгшгийг сунжруулан уртаар хэлдэг учир арын эгшгээсээ хүчдэлээр ялгарч үе бүтээдэггүй. Академич Ш.Лувсанвандан (Ш.Лувсанвандан, 1976) халх аялгууны хос урт эгшгийг уруудах хос эгшиг, өгсөх урт эгшиг гэж ангилжээ.

Монгол хэлний халх аялгууны хос эгшгийн туршилтын авиа зүйн Ж.О.Свантессон тагнайшсан эгшгийг авиалбар гэж авч үзээгүйгээс гадна [ai], [oi], [ui], [ɔi] 4 хос эгшиг байна гэсэн бол, С.Булгантамир (2017) [ɛi:], [əi:], [oɪ:], [ɯi:] 4 хос эгшиг авиатай байна гэсэн судалгааг үндэс болгов.

А.Холбрук, Г.Фэрбанк (Holbrook & Fairbanks, 1962) ба И.Лихэсте, Г.И.Петерсон (Lehiste & Peterson, 1961), Л.Маддисон (Maddieson L, 2009), П.Рөүч (Roach.P), Л.Сунбок (Sungbok L, 2014) нарын эрдэмтэд хос эгшгийн талаарх туршилт авиазүйн анхны судалгааг англи хэлний жишээгээр хийжээ. 1) хоёр эгшгийн өнгө, 2) эхний эгшиг ба спектрийн өөрчлөлтийн хувь, 3) эхний эгшиг ба өөрчлөлтийн чиглэл хос эгшгийг тодорхойлоход илүү чухал үүрэг гүйцэтгэж байна гэжээ. Эгшиг авиаг олон янзын өнгөөр хэлж болох боловч тэдгээрийг бие биенээс ялгадаг гол шинж чанар нь хэлбэлзлийн давтамж буюу формант (П. Ладефогед, 1993) юм.

²³ ӨМИС-ийн докторант, АШУҮИС-ийн ЭС-ийн багш

Өгөгдлийн сан: Монгол хэлний халх аялгууны өгөгдлийн сангаас [ai], [ɔi] хос эгшиг авиа орсон 60 үгийг түүвэрлэн 2 эрэгтэй, 2 эмэгтэй авиалагчаар АШУҮИС-ийн Е-хичээлийн танхимд уншуулж долгионы хэлбэлжлийн тоон үзүүлэлтийг спектрографаар²⁴ судалж тодорхойлохдоо бид тухайн авиаг Praat²⁵ программаар задаллаа. Үр дүнг SpecPraat²⁶ программаар тооцоолсон.

Авиалагчдын тухай мэдээлэл


№	Авиалагчийн нэр	Хүйс	Нас	Оршин хаяг	суугаа	Мэргэжил	Мэддэг гадаад хэл
1	Т. Лхамсүрэн	23	Эм	Улаанбаатар	Оюутан	Англи хэл	
2	Т. Мөнхжаргал	35	Эм	Улаанбаатар	Багш	Англи хэл	
3	Р. Эрдэмтөгс	21	Эр	Улаанбаатар	Оюутан	Англи хэл	
4	Ц. Пүрэвсүрэн	34	Эр	Улаанбаатар	Багш	Англи хэл	

Монгол хэлний журамласан толины төлөөлөх чадвартай хамгийн идэвхтэй хэрэглээний [ai], [ɔi] хос эгшиг авиа орсон 60 үгийг түүвэрлэн 2 эрэгтэй, 2 эмэгтэй авиалагчаар тус тус уншуулж англи хэлний [ai], [ɔi] хос эгшиг авиа акустикийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулсан болно.

Монгол, анги хэлний [ei], [ɔi] хос эгшиг авианы спектр, формантын хэмжигдэхүүн, шилжилтийг задлан шинжлэхэд уруудах хос эгшиг болох нь илэрхий байна. Солонгон бичлэг буюу спектрограм нь [ei], [ɔi] хос эгшиг авианы шинж чанарыг илэрхийлдэг ба хэвтээ тэнхлэг нь хугацаа, босоо тэнхлэгт давтамж, голын хар хэсэг нь энерги болон хэлбэлзлийн давтамжийн бүрэлдэхүүн буюу формантыг илтгэдэг. Монгол хэл 4 хос эгшигтэй, англи хэл нь 8 хос эгшигтэй бид энэ удаад хоёр хэлэнд хоёуланд нь байгаа [ei], [ɔi] хос эгшигийг сонгон авч судаллаа.

Хүснэгт 1. Монгол – англи хэлний хэлний [ei], [ɔi] хос эгшиг авианы формантын задлал

	Монгол хэл		Англи хэл (Sungbok L, 2014)	
	F1	F2	F1	F2
[ei]	758	1634	735	1560
[ɔi]	626	1466	628	1680



²⁴ Спектрограмм дээр авианы өнгөний үндсэн илтгэлцүүр формант F1, F2, F3, F4, өнө, хүчдэл, өндөр нам, үе, авианы бүтэх арга, байр, амьсгалын түрэлт, хамаршилт, хэлний өргөгдөх хэмжээ төдийгүй уруулын хэлбэр, дууны замын бусад өөрчлөлт, үзэгдлийг таних, тодорхойлох олон талын давуу талтай.

²⁵ Boersma et Weenink, 1993-2014

Хүснэгт 2. Монгол – англи хэлний хэлний [vi], [ɔi] хос эгшиг авианы онцлог шинж

	Монгол хэлний хос эгшиг авианы шинж	Англи хэлний хэлний хос эгшиг авианы шинж
[vi]	Уруулын бус, хэлний урдуурх, агуу дунд ба дэд агуу, хос эгшиг авиа.	Уруулын бус, хэлний урдуурх, уйтан, хос эгшиг авиа.
[ɔi]	Уруулын, хэлний дундуурх, дунд, хос эгшиг.	Уруулын, хэлний дундуурх, дунд, хос эгшиг.

Англи хэлний [iə], [eə], [ʊə], [ei], [ai], [ɔ:i], [əʊ], [aʊ] 8 хос эгшигтэй (Sungbok L, 2014). Харин бид энэхүү судалгааг хийхдээ монгол хэлний [vi], [ɔi] хос эгшиг англи хэлний [vi], [ɔi] хос эгшиг авиатай харьцуулан физик шинжийг тодорхойллоо.


Хоёр хэлний хувьд [ci] хос эгшиг монгол тэргүүн бус үед бичгийн хэлэнд тохиолдсон боловч ярианы хэлэнд их хувьсал гарч өөр эгшиг авиа болон хувирсан нь туршилтаар батлагдсан учир монгол хэлэнд [ci] хос эгшиг байхгүй гэж үзлээ. Цааш судалгаагаа хоёр хэлний [vi], [ɔi] хос эгшгийн акустик онцлогт хандуулан хийлээ.

Хүснэгт 3. Монгол хэлний тэргүүн үеийн [vi], [ɔi] хос эгшгийн формантын харьцуулал (эрэгтэй, эмэгтэйгээр)


Авиа	Үг	Эрэгтэй		Эмэгтэй	
		F ₁	F ₂	F ₁	F ₂
[vi]	sein	758	1634	930	1914
[ɔi]	oilkox	626	1466	787	1849

Хүснэгт 4. Англи хэлний тэргүүн үеийн [vi], [ɔi] хос эгшгийн формантын харьцуулал (Sungbok L, 2014), (эрэгтэй, эмэгтэйгээр)


		Эрэгтэй		Эмэгтэй	
		F ₁	F ₂	F ₁	F ₂
[vi]	Eye	728	1560	830	1870
[ɔi]	Boy	480	1498	522	1720



Зураг 2. Монгол – англи хэлний тэргүүн үеийн [vi], [ɔi] хос эгшгийн авиалагчдын зэрэгцүүлэл



Зураг 3. Монгол хэлний аймаг[ε:], англи хэлний сус[vi]үгийн хос эгшгийн спектрограммын зураг.




Зураг 4. Монгол хэлний ОЙЛГОХ [œ], англи хэлний BOY [ɔi]хос эгшгийн спектрограммын зураг.

Хүснэгт 5. Монгол хэлний тэргүүн бус үеийн [vi], [ɔi] хос эгшгийн формантын харьцуулал (эрэгтэй, эмэгтэйгээр)


Авиа	Үг	Эрэгтэй		Эмэгтэй	
		F ₁	F ₂	F ₁	F ₂
[vi]	ᠣхви	746	1586	969	1980
[ɔi]	ᠠᠨᠲᠤᠭᠤᠢ	662	1382	639	1665

Хүснэгт 6. Англи хэлний тэргүүн бус үеийн [vi], [ɔi] хос эгшгийн формантын харьцуулал (Sungbok L, 2014) (эрэгтэй, эмэгтэйгээр).


	Эрэгтэй		Эмэгтэй	
	F ₁	F ₂	F ₁	F ₂
[vi]	600	1455	760	1689
[ɔi]	410	1399	522	1590



Зураг 5. Монгол – англи хэлний тэргүүн бус үеийн [vi], [ɔi] хос эгшгийн авиалагчдын зэрэгцүүлэл



Зураг 6. Монгол хэлний **ТУУЛАЙ**[tʰyɮai], англи хэлний **JULY**[dʒʌli] үгийн хос эгшгийн спектрограммын зураг.




Зураг 7. Монгол хэлний **нохой** [noɣɔi], англи хэлний **destroy** [dɪstrɔi] үгийн хос эгшгийн спектрограммын зураг.

Хоёр эгшиг нийлж үеийн цөм болохыг хос эгшиг хэмээн тодорхойлдог. Англи хэлний [ɪ], [ɔi] хос эгшиг а, о богино эгшгүүд и эгшгийн хоорондох авианы хөдөлгөөний шилжилт(гулсалт) явагдсанаар үүсч байна (Roach, P 1989:18). Хүчтэй эгшгээр эхлээд, сул эгшгээр төгссөн бол уруудах, сул эгшгээр эхлээд хүчтэй эгшгээр төгссөн хос эгшгийг өгсөх хос эгшиг гэнэ (Ж. Цолоо, 2008:82-83) Монгол хэлний [ɪ], [ɔi] хос эгшиг нь уруудах хос эгшиг, англи хэлний [ɪ], [ɔi] хос эгшиг нь өгсөх хос эгшиг юм. Учир нь [i] хүчтэй хэлэгдэж байна.

Хүснэгт 7. Монгол –англи хэлний тэргүүн үеийн [ɪ], [ɔi] хос эгшгийн өнө.

Эгшигавиа	Үнэмлэхүй дундаж өнө мсек. (Монгол хэл)	Үнэмлэхүй дундаж өнө мсек.(Англи хэл) (Holbrook & Fairbanks, 1962)
[ɪ]	196	173
[ɔi]	169	186
Дундаж	180	172

Өнийн уртын харьцаагаар хос эгшгүүдийг харуулбал:




Зураг 8. Монгол – англи хэлний тэргүүн бус үеийн хос эгшгийн өнийн харьцуулал

Хүснэгт 8. Монгол – англи хэлний тэргүүн бус үеийн хос эгшгийн өнө.

Эгшиг авиа	Үнэмлэхүй дундаж өнө	Үнэмлэхүй дундаж өнө (Holbrook & Fairbanks, 1962)
[vi]	260	193
[ɔi]	223	163
Дундаж	205	173

Үүнийг өнийн уртын харьцаагаар харуулбал:





Зураг 9. Монгол – англи хэлний тэргүүн бус үеийн хос эгшгийн өнийн харьцуулал.

Үгийн бүтэц дэх үеийн тоо нэмэгдэх тусам тэргүүн үеийн хос эгшгийн өнө богино эгшгийн нэгэн адил багасч байна.

Монгол хэлний [vi] нь Тэргүүн үед [ɛ:] авиалбарын хувилбартай, тэргүүн бус үед ч мөн [vɛ], [ɛ:] авиалбарын хувилбартай тохиолдож буй нь харагдаж байна.


[vi]- 6 ɛ:m²g kɛ:xamʃiktʰei		F ₁	F ₂	F ₁	F ₂		[vi] - 8 tuulʊɛ/xar ɛ:x
	[ɛ:]	580	1533	458	1632	[vɛ]	
				520	1510	[ɛ:]	



Зураг 10. Тэргүүн ба тэргүүн бус үеийн [ɛ:] авиалбарын шилжилтийн зураг

Монгол хэлний [ɔi] нь ярианд хэлний байр урагшилсан. Тэргүүн үед [ɔœ] авиалбарын хувилбартай, тэргүүн бус үед [ɔi] урагшилсан, урт эгшиг авиа [œ:] болж хувирчээ. [ɔœ], [œ:] авиалбарын хувилбартай тохиолдож буй нь харагдаж байна. Доор хүснэгтэд англи хэлний тэргүүн үеийн [ɔi] ярианд хувиралттай байна. Тэргүүн бус үед [ɔœ] хэлний байр нь урагшилж хэлний урдуур хэлэгдэх онцлогтой байна.

[ɔi] -5 noir		F ₁	F ₂	F ₁	F ₂		[ɔi] - 4 ɔœ: noxœœ
	[ɔœ]	566	1406	453	1310	[ɔœ]	
				480	1208	[œ:]	



Зураг 11. Тэргүүн ба тэргүүн бус үеийн [э:] авиалбарын шилжилтийн зураг

Монгол хэлний хос эгшгийг биеэ даасан авиалбар болно гэж ихэнх эрдэмтэд үздэг билээ. Эхний эгшгийн акустик шинж нь үл мэдэг алдарч, хоёр дахь буюу и эгшгийн формант бүрэн хэлбэржээгүй балархай шинжтэй байгаа тул бид ай [eɪ:], ой [oɪ:] гэж олон улсын галигийг баримтлан тэмдэглэв (С.Булгантамир, 2016). Монгол хэлний [eɪ], [oɪ] хос эгшиг нь тэргүүн үед [ε:], [эе] хувилбартай ба тэргүүн бус үед [eε], [ε:], [эе], [оо:] авиалбарын хувилбартай гэдгийг туршилтаар баталлаа. Хоёр дахь эгшгийн өнгөнөөс илүүтэйгээр нэг дэх эгшгийн өнгө, түүний спектрийн өөрчлөлт хос эгшгийг тодорхойлоход гол үүрэгтэй гэж (Т. М. Нейрей, П. Ф. Ассман, 1986) үзжээ. Монгол хэлний [eɪ], [oɪ] хос эгшиг хэлний байраар урагшилж, [ε:] урт эгшиг авиа болсон (аймаг, гайхах, байх гэдэг үгэнд илэрч байна.) байна.



Дүгнэлт

1. Монгол хэлний [i] эгшиг F1 буурч, [e] эгшгийн F2 нь ихэссэн ингэснээр [i] эгшгийн байр хойшилж, [e] эгшгийн байр урагшилсан байна. Монгол хэлний [eɪ] нь [ε:] урт эгшиг болон хувирч байна. Монгол хэлний [eɪ], [oɪ] хос эгшиг нь тэргүүн үед урт эгшиг болон хувирч байна.
2. Монгол хэлний [eɪ], [oɪ] хос эгшиг нь уруудах хос эгшиг бол, англи хэлний [eɪ], [oɪ] хос эгшиг нь өгсөх хос эгшиг болно.
3. Англи хэлний [oɪ] хос эгшиг нь тэргүүн бус үед [ə:] урт эгшиг [i] эгшиг хойшилж [e] шилжин [oɪ] хувирч [эе] болж хувирч байна.
4. Англи хэлний тэргүүн үеийн [eɪ] хос эгшиг нь харьцангуй [e:] илүү урт, [i] –гийн шилжилт нь маш тод буй спектрограммын зургаас харж болно. Англи хэлний [eɪ], [oɪ] хос эгшгийн шилжилтийн зураг тод харагдаж байна.
5. Хоёр хэлний авиалагчдын ялгаа байна. Эмэгтэй авиалагчдын формант 1 эрэгтэй авиалагчдаас илүү их байна.



Ном зүй

1. Батдорж, Ц. (2014), Халх аялгууны авианы акустик задлал, диссертац, ӨМИС
2. Баярмэнд, Б (1997). Баарин аман аялгууны судлал. Хөх хот.
3. Bolinger D. Intonation and its parts. Palo Alto. CA: Stanford University Press.
4. Буяннэмэх, Г. (2012). ОЦМХ-ний халх аялгууны урт болон хос эгшгийг туршилт авиазүйн аргаар судалсан дүнгээс. *Оюуны хэлхээ*, 2012, I (08): 169-173.
5. Булгантамир, С. (2016). “Монгол, франц хэлний эгшгийн акустик авиазүй зэрэгцүүлсэн судалгаа”. МУИС.2017

6. Владимирцов, Б. Я. (1989). Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Введение и фонетика, Издание 2-е, Москва.
7. Gay, (1968). "Effects of speaking rate on diphthong formant movements," J. Acoust. Soc. Am. 44, 1570–1573
8. Gay, T, (1970). "A perceptual study of American English diphthongs," Language Speech 13, 65–88
9. Holbrook and Fairbanks, G. (1962). "Diphthong formants and their movements," J. Speech Hear. Res. 5, 38–58
10. Lehiste and G. E. Peterson, (1961). "Transition, glides, and diphthongs," J. Acoust. Soc. Am. 33, 268–277
11. Ladefoged, P. (2011). A course in phonetics. Orlando. FL: Harcourt Brace & Company. 1993.
12. Ladefoged, P. (1984) Phonetic Data Analysis. blackwell Publication.
13. Ladefoged, P and Ian Maddieson, (1996). The Sounds of the World's Languages, Oxford, х.321.
14. Лувсанвандан, Ш. (1976). Авиа, авиалбар хоёр. УБ хот
15. Miller, D and Meyer, D. J, (1993). "Three approaches to the classification of American English diphthongs," J. Phonetics 21, 205–229



ОРЧУУЛГАЗҮЙ





ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДИСКУРС ДЭХ МЕТАФОРЫН СУДАЛГАА

Ч. Золзаяа²⁷, Б.Энхзул²⁸

Abstract: The purpose of this research is to study how metaphors in technical discourse appear in English and how they are translated into Mongolian in the context of cognitive semantics. Metaphor and discourse are closely related to each other and they cannot be considered in separable. Scholars have studied metaphors in many different contexts. In this work, we observed how English metaphors appear in the field of technics and technology as well as their translation in Mongolian. In addition, the study has also shown that metaphors can be translated by substituting with their equivalences or substituting for other metaphors. As defined by the scientist Douglas Battler (1986), the metaphor of the technical field is 1) naming parts and parts and space; 2) highlight actions and timing; In this paper, we unanimously support the definition that it is used to describe properties rather than time and space, and 4) to emphasize both time and space in modeling.

Түлхүүр үг: концептуаль метафор, эх үүсвэр, бай хүрээ, хэл шинжлэл, когнитив, хэл соёл

I. Оршил

Мэдээлэл, техник технологийн асар хурдацтай орчин үеийн нийгэмд хүний мэдлэгийг илэрхийлэх, тайлбарлах гол тулгуур онол болох танихуйн хэл шинжлэлийг дискурсын хүрээнд нарийвчлан судлах нь зөвхөн нийгмийн сэтгэл судлал, гадаад хэл заах аргазүй, боловсрол судлал, орчуулгын онол гэх мэт олон шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой. Түүнчлэн аливаа үндэстний танин мэдэхүй оюун ухааны илрэл болсон мэдлэгийг бүтээх олон талаас нь илэрхийлэх, тайлбарлах мөн чанарыг тодорхойлох тулгуур ойлголт болох дискурсын судалгаа нь хэл шинжлэлийн төдийгүй мэдлэгийн олон салбарыг хамарсан судалгаа юм.

Хэл бол сэтгэл судлал, харилцаа, үүрэг, соёлын хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэлийг илэрхийлдэг танин мэдэхүй, хүний мэдлэгтэй салшгүй холбоотой учир танихуйн хэл шинжлэлийг цогцоор нь авч үзэх нь чухал юм. Танихуйн хэл шинжлэл нь учир зүй болон хэлний утгазүй, сэтгэл судлал, мэдлэгийн онолын зааг дээр хүн хэлээрээ мэдээлэл хүлээн авах, боловсруулах мэдлэг бүтээж хэлээр илэрхийлэхийг мөн хэлний сэтгэлгээний асуудлыг судалдаг. Энэхүү судалгааны ажил нь дискурс дэх метафор ба тэдгээрийн хоорондын уялдаа холбоог ойлгоход маш чухал ач холбогдолтой. Судалгааны ажил нь оршил, онолын хэсэг буюу дискурс, концептуаль метафорын талаарх эрдэмтдийн үзэл, баримтлал, өнөөгийн чиг хандлага, ажлын үр дүн, санал, дүн шинжилгээ гэсэн үндсэн бүлгүүдээс бүрдсэн юм.

II. Судалгааны ажлын онолын үндэслэл

Дискурс нь логик баримтлал, өргөн гүн хийсвэрлэл, сэтгэхүйн үйлдлүүд, харилцааны хэлбэрүүдийг хэлтэй холбон тайлбарладаг өргөн хүрээтэй салбар юм гэж Элизабетт Имс (2015)

²⁷ ШУТИС, ГХС, Ph.D

²⁸ ШУТИС, ГХС, докторант

онцлон тэмдэглэсэн байна. Анх XX зууны 50-иад оны үед францын эрдэмтэн Эмиль Бенвенист (1950) ярианы тухай онолоо боловсруулж байхдаа франц хэлний “discours” гэсэн үгийг “яригч этгээдийн юу ярьж байгааг” тодорхойлох гол шинж гэсэн шинэ утгаар хэрэглэсэн бол, эрдэмтэн Зелиг Харрисс 1952 онд “Discourse analysis” хэмээх бүтээлээ туурвисан. Ийнхүү тэд *дискурс* гэдэг ухагдахууныг өөр өөрийнхөөрөө тайлбарлан хэл шинжлэлд оруулж ирсэн түүхтэй. *Дискурс* нь нэг талаас хэлээр сэтгэх үйл явц, нөгөө талаас түүний үр дүн болох бичвэр хоёрыг нэгэн зэрэг багтаан авч үздэг. 1970-аад оноос дискурсыг олон өнцгөөс судалж иржээ. Тухайлбал, социологийн үүднээс Сакс Шелоф, Жеферсон нар 1974 онд, угсаатны зүйн үүднээс Хаймес 1996 онд, сэтгэл судлалын үүднээс Кинц 1998 онд, Гернбачер 1990 онд тус тус судалсан байна. Мөн эрдэмтэн Ван Дейк 1985 онд дискурсын тухай дөрвөн боть бүтээл гаргасан байна. Оросын эрдэмтдээс И.Р.Гальперин, З.Я.Тураева, О.И.Москальская, нар уламжлалт бүтэц-утга зүйг голлон судалж байсан бол, эрдэмтэн Т.М.Дризде, Н.Д.Арутюнова нар нийгэм хэл шинжлэл, сэтгэл судлалын онолын үүднээс судалсан байдаг.

Монголын үе үеийн нэртэй эрдэмтэн, судлаачид тухайлбал, Ш.Лувсанвандан, Б.Ринчен, А.Лувсандэндэв, Ш.Гаадамба, Д.Дашдаваа, Ж.Төмөрцэрэн, Д.Бадамдорж, Ц.Сүхбаатар, Б.Пүрэв-очир, Г.Томтогтох, Ж.Баянсан нар дискурсийг үгийн сан, найруулга зүй, орчуулга судлалын хүрээнд судалсан бол, сүүлийн 10 жил дискурсийн судалгаанд танихуйн хэл шинжлэлийн чиглэлээр ихээхэн хувь нэмэр оруулсан эрдэмтэн Б.Чулуундорж, Ч.Зэгиймаа нар болон тэдний удирдлагын дор залуу эрдэмтэд судалгааны ажил хийж байна. Дискурсыг харилцааны үзэгдэл, хэрэглээ болон дискурсын тусгай төрөл, эсвэл нийгмийн аль нэг салбарт харьяалагддагаар нь “эмнэлгийн дискурс”, “улс төрийн дискурс”, “шинжлэх ухааны дискурс”, “соёл урлагийн дискурс” гэж ангилан авч үздэг. Жишээ нь: 2001 онд доктор Д.Хонгорзул “Сонины мэдээллийн дискурсийн үгийн санг регистрийн үүднээс зэрэгцүүлэн судлах нь” сэдвээр эрдмийн бүтээлээ туурвижээ. 2003 онд эрдэмтэн З.Ганчимэг “Шинжлэх ухааны хялбаршуулсан дискурсыг танихуйн хэлшинжлэлийн үүднээс зэрэгцүүлэн судлах нь”, 2004 онд эрдэмтэн Б.Дагиймаа “Улс төрийн дискурсыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь” судалгаандаа монгол хэлийг төрөл бус хэл болох англи хэлтэй зэрэгцүүлэн судлахдаа улс төрийн дискурсыг макро болон микро түвшинд зэрэгцүүлэн судалсан байна. Мөн 2009 онд доктор Т.Туяа “Эмчийн харилцахуйн онцлогийг монгол, англи хэлний эмнэлгийн дискурсын хүрээнд судалсан нь”, Т.Төмөрхуяг “Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь” (монгол, орос, англи хэлний жишээн дээр) зэрэг орчин цагийн монгол эрдэмтэд дискурсийг олон салбар чиглэлээр судалжээ.

Түүнчлэн энэ судалгааны ажлаар концептуаль метафорын /source, target domain/ домайн (цаашид эх үүсвэр ба бай хүрээ гэх) хоорондын концептуаль интеграцийн үзэл, уялдаа холбоо болон англи хэлэнд хэрхэн илэрч байгааг тухайн хэлний жишээгээр батлан харуулж, онолын үндэслэлтэй тайлбарласан.

“Metaphor” гэдэг үг нь “metaphora” гэх грек үгнээс үүсэлтэй. Когнитив хэл шинжлэлийн ухаан хөгжихөөс өмнө метафорыг зөвхөн утга зохиолын уран яруу хэлбэр хэмээн үздэг байсан. Метафор нь философи, түүх соёл, улс үндэстний сэтгэлгээний онцлог зэргийг харуулж байдаг учраас судлаачдын хувьд маш чухал судалгааны сэдэв болсоор байна. Концептуаль метафорын сонгодог онолыг анх Ж.Лакофф, М.Жонсон (1980) нар дэвшүүлэн гаргасан. Концептуаль метафорын сонгодог онол, концептын тухай ойлголт, метафор загварын тухай үзэл баримтлалын талаар бид америкийн эрдэмтэн судлаачид Ж.Лакофф, М.Жонсон (1980) нарын “Metaphors we live by” бүтээлээс харж болно. Эдгээр бүтээл нь концептуаль метафорын онолын хөгжилд чухал хувь нэмэр оруулсан.

Когнитив хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл, метафорыг эх үүсвэр /source domain/ болон бай /target domain/ хүрээнүүдийн хоорондын харьцаанд хамааруулан авч үзнэ. Метафор нь үгийн

сан, хэл зүй, утга зүй болон найруулга зүйд асар их үүрэгтэй. Метафорыг ойлгоход эхийн хүрээнээс байн хүрээнд шилжүүлэн ойлгодог. Концептуаль метафор нь “тухайн хэл эзэмшигчдийн соёлын парадигмийн салшгүй хэсэг” (Ж.Лакофф, 1993:210) болсон байдаг тул хүмүүс метафор хэмээн ухамсарладаггүй байна. Мөн Лакофф, Жонсоны (1993:203) когнитив үзлээр бол метафор нь концептуаль систем дэх эх хүрээнүүдийн хоорондын оноолт юм. Хэл шинжлэлд концептуаль метафорыг том үсгээр бичиж тухайн хэлний концептыг илэрхийлдэг. Ковесесс З.,(2005) “метафор нь олон талт үзэгдэл бөгөөд, аливаа хэлэнд байх төдийгүй, концептийн систем, түүнчлэн нийгэм соёлын бүтэц, сэтгэлгээ болон хүмүүсийн үйл байдалд хүртэл оршин байдаг” гэжээ. Техник технологийн эрин эрчимтэй хөгжихийн зэрэгцээ 1980 оноос хойш корпус хэл шинжлэлийн судалгаа эрчимтэй хөгжиж, метафорыг судлахад чухал нөлөөтэй болж ирсэн. Дегнан 2005 онд метафорыг судлан илрүүлэхэд корпусыг хэрхэн ашиглах арга зүйн чиг хандлагыг гаргаж өгсөн нь судлаачдад нэг том алхам болсон юм.

III. Судалгааны арга зүй

Судалгааны ажлын үр дүнд техник технологийн салбарын метафор англи хэлэнд хэрхэн илэрч байгааг олж тогтоох явдал байв. Англи хэлний жишээг когнитив хэл шинжлэлийн хүрээнд концептуаль метафорын судалгаа хийсэн судлаачдын бүтээл, толь бичиг, COCA корпус судалгаанаас түүвэрлэлээ. COCA (Corpus of Contemporary American English) нь 520 сая үгийн сантай хэл шинжлэлийн судалгаа хийхэд өргөн цар хүрээтэй, төрөл бүрийн мэдээллийн сан агуулсан электрон файл юм. Энэ сан нь 1990-2015 оны англи хэлний (American English) төрөл бүрийн эх үүсвэрээс авсан мэдээллийг багтаасан тул өргөтгөсөн дискурс, контекстийн хүрээнд анализ хийж үзэх боломжтой.

Судалгааны ажлын явцад метафорыг илрүүлэхдээ Стин, Праглежаз /1999/ нарын метафор илрүүлэх MIP аргыг ашигласан болно. Энэ арга нь практикт тулгуурласан, системтэй арга барил юм. MIP арга дараах үе шатаар метафор илрүүлдэг (Steen, 1999). Үүнд: 1. Төрөл бүрийн эх текст уншиж тухайн хэлний метафорыг олж түүвэрлэх 2. Дискурс дэх метафорт анализ хийж сэтгэл хөдлөл заасан зүйрлэл мөн эсэхийг тогтоох 3. Тухайн дискурс дэх утга нь үгийн үндсэн утгаас ялгаатай эсэхийг шалгах 4. Үгийн контекстийн утга, үндсэн утгын хоорондын хамаарал болон эх үүсвэр хүрээ, бай хүрээнүүдийн хамаарал, төсөөтэй шинжийг тогтоох, шалгах 5. Тухайн метафорийг тэмдэглэх, бүртгэх

IV. Судалгааны ажлын үр дүн

Судалгааны явцад шинжлэх ухааны зарим салбарын метафор нь англи хэлэнд хэрхэн илэрч байгаа түүний эх болон бай хүрээний хоорондын танин мэдэхүйн зураглалыг авч үзлээ. Жорж Лакофф (2004) улс төрийн дэвшилтэт хөтөлбөрийг сурталчлахын тулд зүйрлэл, “хүрээ-frame” ашиглах санааг дэлгэрүүлжээ. Фрейм гэдэг нь давтамж уялдаа холбооны хэлбэр, слотуудын илэрхийлж буй утгын нэгжид үндэслэгдсэн схемийн протикал хувилбар юм. Слотууд нь утгын дарааллаар зохион байгуулагдсан байдаг ба филлэртэй байж болно. Метафор нь хоёр когнитив бүтцийн тодорхой нэгэн схем харилцаа холбооны тогтвортой давтамжтай алгоритмаар илэрдэг. Энэхүү алгоритм буюу зүй тогтлыг “метафор загвар” гэж нэрлэж болно. Тодорхой фрэйм ба слотуудын нийлбэрээр илэрхийлэгдэх эгнээ давтамжтай метафоруудыг тодорхойлоход метафор загварыг хэрэглэнэ. Фрэймүүд нь слотуудын тусламжтайгаар дотоод зохион байгуулалтаа бий болгох бөгөөд тэдний үндсийг концептууд бий болгоно гэж танихуйн онолоор тайлбарладаг. Хүснэгт 1-д техник технологийн салбарын метафорыг үзүүлж байна.

Хүснэгт 1. Техник технологийн салбарын дискурс дэх метафор

Эх сурвалж	Фрэйм	Метафор илэрхийлэл	Орчуулга	Салбар
BODY Бие	Human body Хүний бие	Transfer arm	Авто үйлдэвч	Уул уурхай
CLOTH Хувцас	Clothing Хувцас	Suspension shoe	Дүүжин углаас	Барилгын салбар
	Part of cloth Хувцасны хэсэг	Sleeve of a jack	Үүрний бортого	Эрчим хүчний
	Part of cloth	Wall pocket	Дамнуурын нүх	Уул уурхай
BODY Бие	Part of human body хүний бие	Nail head	Хадаасны толгой	Барилгын салбар
	Animal body Амьтны бие	Rat tail burner	Нэг садралтай ноцоолгуур	Уул уурхай

Эдгээр жишээнээс харахад, техник технологийн дискурс дэх метафор нь маш өвөрмөц байдлаар илэрч байгаа нь харагдаж байна. “Transfer arm” гэсэн энэ зүйрлэл нь монгол хэлнээ *авто үйлдэвч* гэж орчуулагдсан байна. Хүний *гар* “arm” хэмээх эрхтний үүрэг нь тухайн техникийн эд ангийн үүрэг ижил тул ийнхүү нэрлэсэн байна. Метафор нь тухайн эх ба бай хүрээний хоорондох хамаарлын хүрээнд ойлгогдох ба тухайн зүйлийн ижил төсөөтэй шинж дээр тулгуурлан адилтган зүйрлэдэг.

Доуглэс Батлер 1986 онд техникийн салбарын метафор нь дөрвөн гол үүргээр хэрэглэгддэг гэж тодорхойлсон. Үүнд: Техникийн метафор нь 1) хэсгүүд болон эд анги, орон зайг нэрлэх 2) үйлдэл, цаг хугацааг онцлон тэмдэглэх 3) цаг хугацаа, орон зайг бус, харин шинж чанарыг илэрхийлэх 4) цаг хугацаа, орон зайг хоёуланг нь онцолж загвар гаргах гэж тодорхойлсон байна. Судалгааны ажлын үр дүнгээс харахад, эдгээр ангиллын хувьд ихэнх хэсгүүд болон эд анги нь метафороор нэрлэгдсэн нь ажиглагдаж байна.

2017 онд Шармини Абдулах техникийн салбарын метафорыг орчуулгын талаас нь судалсан. Жишээ нь: “Chemical engineers process **raw** materials” гэсэн өгүүлбэрт байгаа метафорыг авч үзье. Энэхүү өгүүлбэрийн “Raw” гэсэн метафор нь “*uncooked, as articles of food*” буюу *түүхий болгоогүй хоол хүнс, чанаж боловсруулаагүй хоол хүнс* гэсэн утга илэрхийлдэг. Харин энэ өгүүлбэрт “*raw materials*” буюу утга шилжин хэрэглэгдэж байна. Мөн “Engineering technologists **bridge** the gap between engineering and management” (Sharmini Abdullah, 2017:128) жишээг авч үзье. Энэ өгүүлбэрт “bridge” гэсэн үгийн үндсэн утга нь “*a structure spanning and providing passage over a river, chasm, road, or the like*” Гол, ангал, зам гэх мэт зүйлийг дайран өнгөрч, дамжин өнгөрөх байгууламж” гэсэн утгатай. Гэтэл энэ өгүүлбэрт үндсэн утгаар биш “*a connecting, transitional, or intermediate route or phase between two adjacent elements, activities, conditions, or the like*” буюу “*холбож өгөх*” гэсэн утгаар орж байна. Дээрх хоёр жишээг авч үзвэл, энэ хоёр зүйлийн ижил төсөөтэй шинж дээр тулгуурлан хийсвэр ухагдахууныг бай хүрээнд илэрхийлж байна.

IV. Метафорын орчуулгын тухайд хийсэн ажиглалт

Р.Гүрбазар (1996) “Адилтгал, зүйрлэлийг орчуулахдаа түүгээр илэрхийлсэн далд санааг илрүүлж олох нь хамгийн чухал бөгөөд жинхэнэ утгыг олсон үед цөөн тохиолдолд үгчлэн орчуулж болох ба гол төлөв боломжийн үг хэллэгээр орлуулах нь үр дүнтэй” гэжээ. Эрдэмтэн В.Н.Комиссаров (2001) “Өвөрмөц хэллэгийг бүрэн дүүрэн орчуулах арга нь нэг хэлний өвөрмөц хэллэгийг нөгөө хэлний өвөрмөц хэллэгээр буулгах юм. Ингэснээр *утга санааг* бүрэн илэрхийлээд зогсохгүй *уран дүрслэл, сэтгэл хөдлөлийг* илэрхийлнэ. Лакофф, Жонсон (1980)

нарын дэвшүүлсэн концептуаль метафорын онол метафорыг хэлний чимэглэх бус бодитойгоос хийсвэр, танин мэдэхүйгээс үйл таних руу чиглэх танин мэдэхүйн үзэгдэл юм гэсэн санааг дэвшүүлсэн. Энэ үзэгдэл нь метафорын орчуулгын үед ихээхэн илэрдэг. Англи, монгол ард түмэн танин мэдэхүй, соёл сэтгэлгээний онцлогоос үүдэн хүний зан чанар, байдлыг таньж мэдэхдээ өөр өөрийн онцлогтой байгаа нь метафорын орчуулгаас харагдаж байгаа юм.

Метафор утга шилжүүлэлтийг шилжих чиглэлээр нь дараах байдлаар тоймлон үзүүлж болох юм. Үүнд: 1) Амьд бус зүйлийн шинжийг амьд бус зүйлд шилжүүлэх (*техникийн салбарт*) 2) Амьд зүйлийн шинжийг өөр амьд бус зүйлд шилжүүлэх гэх мэт.

Кристина Скафер (2003) метафорын орчуулгатай холбоотойгоор энэ сэдвийн хүрээнд хэд хэдэн орчуулгын арга барил байдаг гэж үзсэн байна. Тэрээр орлуулан орчуулах (нэг метафорыг нөгөө метафороор орлуулан орчуулах), метафорыг өөр үгээр тайлбарлан буулгах, эсвэл, бүр орчуулахгүй орхих гэх мэт хэмээн үзжээ. Метафорыг хэрхэн орчуулах орчуулгын хэм хэмжээг тодорхойлсон загвар ба дүрслэн харуулсан хэмээх хоёр загварт энэ талаар тодорхой тайлбарлан үзнэ гэсэн байна.

Орчуулгын онолын нэг гол тулгуур арга болох дүйцэл нь орчуулгын чанарын маш чухал ойлголт юм. Судлаач Ц.Магсар (2018:39) дүйцүүлэн орчуулах гэдэг нь утгын найруулгын, бүтцийн, үүргийн, ойлголцох байдлын дүйцэл, хэрэглэх байдлын дүйцэл, бүрэн дүйцэл, хагас дүйцэл гэх мэтээр ангилж болно гэж үзсэн байна. Хүснэгт-2-т үзүүлсэн жишээг ажиглан үзье.

Хүснэгт 2. Техник технологийн салбарын дискурс дэх метафор

<i>Метафор илэрхийлэл</i>	<i>Англи тайлбар</i>	<i>Монгол орчуулга</i>	<i>Салбар</i>
<i>Face of crystal</i>	<i>side of crystal</i>	<i>Кристалын талст</i>	<i>Уул уурхай</i>
<i>Bed of brick</i>	<i>Bricks' bottom</i>	<i>Тоосгоны доод тал</i>	<i>Барилгын салбарт</i>
<i>Hot bus</i>	<i>Energized with power</i>	<i>Цахилгаан дамжиж буй утас</i>	<i>Эрчим хүчний</i>
<i>Gripping jaw</i>	<i>Gripping mouth</i>	<i>Хамагч</i>	<i>Уул уурхай</i>
<i>Pipe elbow</i>	<i>An elbow is installed between two lengths of pipe</i>	<i>Дамжуулах хоолойн өвдгөвч</i>	<i>Эрчим хүч</i>

Метафор утга шилжүүлэлтийг харуулахдаа амьд бус зүйлийн шинжийг амьд бус зүйлд шилжүүлсэн байдлыг “*bed of brick-тоосгоны доод тал*”, “*hot bus-цахилгаан дамжуулж буй утас*” гэх мэтээр харуулжээ. Энэхүү жишээнээс харахад, шинжлэх ухааны төрөл бүрийн салбарт, ялангуяа техник технологийн салбар нь маш өвөрмөц метафороор баялаг бөгөөд энэ нь тухайн салбарын хувьд хэвшсэн байна. Жишээ нь “*pipe elbow – дамжуулах хоолойн өвдгөвч*” *elbow* буюу *тохой* гэсэн хүний бие эрхтэн заасан нэр үг нь механизмын жийргэвчийн үүргээр хэрэглэгдэж байна. “*Bed of brick – тоосгоны доод тал*” хүний унтдаг ор - *Bed* гэсэн нэр үг утга шилжиж юмны доод талыг зааж байгаа метафороор хэрэглэгдэж байна. Техник технологийн салбарын метафорын орчуулгыг түүвэрлэсэн жишээний хүрээнд авч үзвэл монгол хэлэнд байгаа дүйцэх үгээр нь орчуулсан метафорууд байна. Мөн англи хэлний “*suspension shoe-дүүжин углаас, sleeve of a jack- үүрний бортого, nail head-хадаасны толгой*” гэх мэт маш өвөрмөц байдлаар адилтган зүйрлэн орчуулсан нь ажиглагдаж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажил нь техник технологийн дискурсийн метафорыг танихуйн утга зүйн хүрээнд судалсан ач холбогдолтой ажил боллоо. Техник технологийн салбарын метафор нь англи хэлэнд маш түгээмэл өвөрмөц байдлаар илэрч байна. Мөн энэ салбарын метафор нь монгол хэлнээ хэрхэн орчуулагдаж байгааг түүвэрлэсэн жишээний хүрээнд судлан үзэхэд метафорыг дүйцүүлэх болон өөр метафороор орлуулан орчуулсан байдал ажиглагдаж байна. Түүнчлэн эрдэмтэн судлаачид метафорыг олон салбарын хүрээнд харьцуулан авч үзсэн боловч яг шинжлэх ухаан техник технологийн салбарын метафорыг тусгайлан англи хэлний метафорыг энэ чиглэлээр зэрэгцүүлэн судалсан судалгаа одоогоор байхгүй байгаа тул цаашид хоёр хэлэнд хэрхэн илэрч байгааг судлан түгээмэл ба онцлог шинжийг нь авч үзэн судлах шаардлагатай хэмээн дүгнэж байна.

Ном зүй

1. Ганчимэг, З. (2003) “Шинжлэх ухааны хялбаршуулсан дискурсыг когнитив хэлшинжлэлийн үүднээс зэрэгцүүлэн судлах нь”, УБ
2. Доуглэс, Батлер. (1986) The function of Metaphor in Technical Discourse, *Research article*, Retrieved from <https://journals.sagepub.com/doi/abs/10.2190/KQGM-7H0C-K1KK-RUCV>
3. Золзаяа, Ч. (2014) “Emotion Metaphors in English and Mongolian: With Special Reference to Anger, Love, Happiness and Sadness” (pp. 257). GNU, Korea
4. Хонгорзул, Д. (2004) “Сонины мэдээллийн дискурсийн үгийн санг регистрийн үүднээс зэрэгцүүлэн судлах нь”, УБ
5. Дагиймаа, Б. (2004) “Улс төрийн дискурсыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь” (монгол, орос, англи хэлний жишээн дээр), УБ
6. Туяа, Т (2009) “Эмчийн харилцахуйн онцлогийг монгол, англи хэлний эмнэлэгийн дискурсын хүрээнд судалсан нь”, УБ
7. Төмөрхуяг, Т. (2011) “Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь” (монгол, орос, англи хэлний жишээн дээр), УБ
8. Lakoff, George and Mark Johnson (1980) “Metaphors We Live By” Chicago Press. pp.242
9. Zoltan Kovecses (2005) “Metaphor and Culture” pp.64.
10. Christina Schffner, (2003). *Metaphor and translation, Some Implications of a Cognitive Approach, Journal of Pragmatics, Volume 36, Issue 7, July 2004, Pages 1253-1269* Retrieved from <https://research.aston.ac.uk/en/publications/metaphor-and-translation-some-implications-of-a-cognitive-approach>

Ашигласан толь бичиг

1. Алтангэрэл, Д. (2001) “Орчин цагийн монгол англи толь”, УБ
2. Батхуяг, С. Зундуйсүрэн, Ч. (1987) “Эрчим хүчний нэр томъёоны тайлбар толь”
3. Батсүрэн, Б. (1986) “Барилгын арван хоёр хэлний толь”, УБ
4. Ган-Очир, З. (1991) “Инженерийн технологийн нэвтэрхий толь бичиг”, УБ
5. Содномдорж, Д. (2018) “Цахилгаан системийн нэр томъёоны хураангуй тайлбар толь”, УБ



АНГЛИ ХЭЛНИЙ “TO BE” ҮЙЛ ҮГИЙН ОРЧУУЛГЫН ТУХАЙ

Л.Чулуунбаатар²⁹

Abstract: Among the English verb *to be* is used so many and it seems that simple when it is applied, but it is very difficult verb. So, when teaching this verb to the students need to properly explain and to show correct examples English and Mongolian. In the sentence *to be* verb is used by different forms and so English people themselves said that *to be* cannot be guess and it is as like *protean*. The word *Protean* was originated from the word *Proteus* which was an early prophetic sea-god or god of rivers and oceanic bodies in Greek mythology. Also, while English language includes in Indo-European language group and it is compound language, but Mongolian includes in Altai language group and it is agglutinative language. Therefore, sentence's structure is different and thought is not the same. In the first step it is hard to understand. In active voice the verb *to be* are used by 9 forms and in passive voice by 10 forms and it shows different time situation and so students need to understand those differences of usage.

Түлхүүр үг: *to be, am, is, are, was, were, being, been*

Монгол Улсын их, дээд сургуулийн англи хэл судлалын анги болон бусад ангиудад янз бүрийн түвшний оюутнууд жил болгон элсэн орох бөгөөд зарим нэг нь анхан шатны мэдлэгтэй байх ба бүр зарим нь анхан шатны мэдлэггүй ч байх тул тэдэнд англи хэлийг эхнээс нь сайтар зааж, тайлбарлан ойлгуулах хэрэгтэй болдог билээ. Англи хэлний үйл үгийн дотроос хамгийн их хэрэглэгддэг хийгээд амархан юм шиг мөртлөө хамгийн адармаатай үйл үг бол “*to be*” юм. *To be* үйл үг нь байнга өөрчлөгдөн хувирч байдаг болохоор англи хэлний хамгийн таагдашгүй зүйл буюу *protean* хэмээн англичууд өөрсдөө хэлэлцдэг байна. *Protean* хэмээх энэ үг Грекийн далайн бурхан *Proteus*-аас үүсэлтэй билээ.



Зураг 1. Грекийн далайн бурхан *Proteus*




Зураг 2. Далайн амьтан *proteus*

Учир нь далайн бурхан Протейс бол арслан, зэрлэг гахай, могой, мод, урсаж байгаа горхи зэрэг түмэн зүйлийн янзаар хувирч чаддаг тул үнэн төрхий нь олж мэдэхэд хэцүү байдаг байна.

²⁹ МҮИС, ОУХС, доктор, профессор

Монгол ойлголтоор энэ нь лусын хаан бөгөөд үлгэрт олон янзаар хувирч чаддаг хэмээн гардаг билээ. Орчин үед далайд орших олон хөлтэй наймаалж маягийн амьтныг ч **protein** гэх бөгөөд далайн усан дотор өнгөний байдалтай зохицон өнгөө хувиргадаг байна.

Тэгвэл **to be** үйл үг өөрөөсөө гадна **am, is, are, was, were, been, being** хэмээх 7 янзын хэлбэртэй болдог бөгөөд хэлзүйн гурван бие дээр гурвуулан дээр нь хувирч чаддаг цорын ганц үйл үг бөгөөд идэвхитэй хэв буюу active voice-ийн 16 цагийн 9-д нь, идэвхгүй хэв буюу passive voice-ийн 10 цагийн арвууланд нь орж цагийн ялгааг үзүүлэн жинхэнэ утга болон туслах үйл үгийн утгаар нэн дэлгэр ордог үйл үг юм. Түүнээс гадна, бие даасан үйл үгийн үүргээр орохоос гадна, өөр үйл үгтэй хоршиж утга ялган туслах үйл үгийн үүрэг гүйцэтгэн, мөн бас баймж үйл үг, өвөрмөц хэлцийн утга ялгах үг нийлэмжээр орох тул утгыг аван саван тэр дор нь ухахад бэрхшээлтэй байдаг билээ. Анхан шатны оюутнуудад **to be** хэмээх үйл үгийг тахиа хэмээн бодвол бусад 7 нь түүнээс гарах өндөг бөгөөд **am, are, is**-ыг одоо цагт идэх хэрэгтэй бөгөөд **am**-ыг нь гагц **I** хэмээх 1-р биеийн төлөөний үгтэй, **is**-ыг **he, she, it** хэмээх 2-р биеийн төлөөний үгтэй, **are** хэмээхийг нь **you, we, they** хэмээх 2-р биеийн олон тооны төлөөний үгтэй тус тус хамт идэх буюу хэрэглэх болно хэмээх мэтээр тайлбарлан тохирох жишээнүүдийг дагалдуулан тайлбарлахад ойлгох нь илүү байдаг.



Зураг 3. *To be* үйл үгийн хувилбар, Зохиогчийн эвлүүлсэн зураг

Нөгөө талаар англи хэл бол Энэтхэг-европ хэлний бүлэгт багтдаг угсармал хэл байхад, монгол хэл бол Алтай овгийн хэлний бүлэгт багтдаг залгамал хэл байх тул өгүүлбэрийн гишүүдийн байрлал эрс ондоо байрлаж, сэтгэхүйн хоорондын зөрүү их гардаг тул эхэн шатанд ойлгоход бэрхшээл гардаг нь тэр болой. Жишээлбэл: **I am a student** хэмээсэн өгүүлбэрийг монголоор “Би бол оюутан байна. Би бол оюутан, Би оюутан” гэх мэтээр орчуулан ойлгож болно. Хэдэн жилийн өмнө “Англи хэл заах арга зүйн эрдэм шинжилгээний хурал” дээр МУИС-ийн Геологи, газар зүйн факультетын багш О.Батхуяг “**to be** үйл үгийг хэрхэн заах тухайд” хэмээх илтгэл тавьсан нь энэ адармаатай үйл үгийг заахдаа бэрхшээлтэй ихээхэн тулгардаг хийгээд оюутанд үүнийг хэрхэн ойлгуулах вэ хэмээн санаа зовж явдаг багш хүний чин сэтгэлийн бодол саналаа гарган энэ өгүүлийг бичсэн нь тун сайшаалтай байгаа юм. Гэхдээ “**Be** үйл үг нь монгол хэл рүү орчуулахад орчуулагддаггүй байж болно” хэмээх тодорхойлоод **I am a doctor**, Би эмч хэмээн жишээ авсан байна. Энэхүү өгүүлбэрийг “Би эмч хэмээн орчуулснаас Би бол эмч буюу Би бол эмч болой, Би эмч хийдэг юм” гэх мэтээр орчуулж, чухамхүү тэр олон эмч нарын нэг, онцлох ёстой хүн би шүү гэдэг санаа илэрснийг гаргаж байгаа бөгөөд “Би эмч” гэж орчууллаа ч эмч гэдэг үгийнх нь ард утгын тэг хувилбар байгаа гэдгийг тайлбарлаагүйгээс буруу ухаарахаар болж тайлбарын иймэрхүү алдаа гарсан байна. Мөн орчуулах явцад тэрхүү **to be** хам сэдвээсээ шалтгаалан янз бүрийн баймж утга гаргахыг огт үгүйсгэж болохгүй юм. Жишээлбэл: Би эмч л дээ, Би эмч юм шүү дээ гэх мэт. Яагаад гэвэл, өнгөрсөн цагийн хувилбартай нь харьцуулбал

энэхүү утгын тэг хувилбар аяндаа мэдэгдэх болно. *To be*-гийн өнгөрсөн цагийн хувилбар нь *was, were* хоёр бөгөөд *was* нь *I, he, she, it* хэмээх биеийн төлөөний үгтэй хамт орж, *were* нь *you, we, they* хэмээх биеийн төлөөний үгтэй хамт орох болой. *I was a student* өгүүлбэрийг “Би оюутан байсан, Би оюутан байлаа, Би оюутан байсан болой” хэмээсэн утга илтгэж, орчуулагдах бөгөөд өнгөрсөн үед оюутан байсан гэдэг мэдээг чухалчлан нэвтрүүлж байгаа бөгөөд *I am a student* нь болохоор одоо оюутан байгаа нь чухал зүйл хэмээсэн мэдээллийг дамжуулж байгаагаараа байгаа, байна хэмээсэн оршин байхын утга тэнд тодорхой харагдаж байгаагаас мэдэгдэх юм. Тийм болохоор “монгол хэл рүү орчуулагдахгүй байж болно” гэдэг тодорхойлолт илэрхий буруу гэдэг нь аяндаа харагдаж байна. *To be* орсон өгүүлбэр хэлбэр нь одоо цаг боловч өнгөрсөн цагийн утга илтгэнэ. Жишээлбэл: *Where are you from?* хэмээн асуухад ихэнх тохиолдолд *“I am from Mongolia”* хэмээн хариулах бөгөөд монгол утга нь “Би Монголоос ирсэн” гэсэн өнгөрсөн цагийн утга илтгэх бөгөөд энэ монгол өгүүлбэрийг оюутнуудаар эргүүлээд орчуулуулахад ихэнх тохиолдолд *“I came from Mongolia”* хэмээн англиар орчуулдаг болой. Энэ нь хоёр өөр сэтгэхүйн тод ялгааг харуулж байгаа хэрэг юм. *To be* –тэй өгүүлбэрийг асуух үг болгоход *to be*-гийг нь өмнө гаргаж асуух өгүүлбэр болгодог нь асуух үггүй тохиолдолд асуух сул үгээр өгүүлбэр төгсгөж асуух өгүүлбэр бүтээдэг монгол хэлнийхээс тэс өөр учир оюутны гайхлыг их төрүүлдэг юм. Жишээлбэл: *Your brother is taller than you* хэмээх өгүүлбэрийг “Ах тань танаас өндөр байна, Ах тань танаас өндөр болой” хэмээн орчуулах бөгөөд монгол оюутны хувьд *Is your brother taller than you?* хэмээсэн өгүүлбэрийг “Болой ах тань танаас өндөр” гэсэн шиг сэтгэгдэх талтай байдаг. Гэтэл энэ нь Ах чинь чамаас өндөр үү? гэсэн утгатай өгүүлбэр байдаг. Үүний учрыг дахин дахин тайлбарлан дасгал олныг хийж сэтгэхүйг нь дадуулах ажил хийх хэрэгтэй болдог. Зарим асуултын хариу нь ирээдүй цагаар хариулах ёстой байтал одоо цагаар хариулах нь монгол оюутны гайхшийг төрүүлнэ. *Who is going to the movies with me?* Хэн надтай кинонд явах гэж байна вэ? хэмээн асуухад *I am* Би явна хэмээн хариулах нь утга нь ирээдүй цагт боловч хариулт нь одоо цагт байгаад нь оюутнууд гайхаад байдаг. Үүний баталгаа бол Би явна гэхийг англиар шууд орчуулгахад *I will go* хэмээн орчуулж ирээдүй цагаар сэтгэх монгол сэтгэхүйн тод жишээг харуулдаг. Нэмж хэлэхэд дээрх жишээнд гарсан *Who* гэх мэтийн тусгайлан асуух үг орох бол өмнө нь эхэнд нь бичдэгийг анхаарах хэрэгтэй юм. Нөгөө талаар лавдуулан болон бататган асуух, асуух өгүүлбэр өмнөх өгүүлбэртээ батлах байвал хойдох өгүүлбэртээ үгүйсгэх, өмнөхдөө үгүйсгэх байвал хойноо батлах байдаг нь ийм хэлбэр зөвхөн ярианд цөөхөн хэрэглэгддэг болохоор оюутнуудад сонин санагдаад байдаг. *We are late, aren't we?* Бид нар хоцорчхов уу, үгүй юү? Учир нь монголоор орчуулахад үгүйсгэх үг болон асуух сул үг орж үйл үг орохгүй байгаад байгаа юм. *To be* үйл үг бие даасан үгийн хувьд дараах шинжийг агуулдаг.

1. Мэдээлэл өгч ажил мэргэжлийг үзүүлдэг. *She is a student. We are teachers.*
2. Биеийн болон сэтгэл санааны байдлыг үзүүлдэг. *I am ill. I am tired.*
3. Нас, хүйс хэлэхэд хэрэглэнэ. *He is twenty years old. He is a boy.*
4. Өнгө зүс, хэлбэр хэмжээ үзүүлэхэд хэрэглэнэ. *It is yellow. She is slim and beautiful.*
5. Байршил заадаг. *Dorj is in the classroom.*
6. Юмны үнэ, цаг хугацаа, сар өдөр, хэмжээ зэргийг үзүүлэхэд орно. *It is 3 o'clock. It is \$10.*
7. There is, there are хэмээх хэлхэцтэй хэрэглэгдэнэ. *There is a pen on the table. There are many shops in our city.*
8. Эзэн биегүй өгүүлбэрт хэрэглэгдэнэ. *It is cold today.*

Дээр дурдсан шинжүүдээс *there is, there are* хэмээх одоо цагийн хэлбэр, *there was, there were* хэмээсэн өнгөрсөн цагийн бүтцийг *to be* хэмээх үйл үг маань *there* хэмээх үгтэй нийлж нэг цул утгыг илтгэж, хам бүтцээр нь орчуулах ёстойг тайлбарлахгүй бол *there*-г нэг орчуулаад *is*-ийг бас салгаж орчуулж ойлгох гээд байдаг болой. 1984 онд МУИС-д багшилж асан англи хэлний багш, доктор Ц.Гомбосүрэн “*There* хэмээх туслах үйл үг бүхий англи өгүүлбэрийг монгол хэлнээ

орчуулах тухай” хэмээх өгүүлэл бичиж МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлж байсан билээ. Түүндээ “Ийм бүтэцтэй өгүүлбэрийг орчуулахад нэлээд бэрхшээлтэй байдаг. Хэцүү байдгийн шалтгаан нь төстэй үг хэллэг монгол хэлэнд байхгүй” хэмээн онцолсон байдаг. Мөн цааш нь “**there + be + n** гэж үүссэн хам бүтэц байр болон цаг заасан байцтай орж, нэг тодорхой газар (байранд) тодорхой бус ямар нэг юм оршиж байна, уг байр сулгүй гэсэн утга илэрхийлдэг” хэмээн нэмж онцолсон байна. **There are many people in the room** гэвэл өрөө сулгүй, хүнтэй байна гэсэн санаа. Тийм болохоор өрөө хэрэгтэй болохоос дотор байгаа улсыг сонирхоогүй гэсэн үг юм. **The book is on the table** гэсэн өгүүлбэр бол Нөгөө ном ширээн дээр байна гэсэн утгатай байхад **There is a book on the table** гэвэл Ширээн дээр нэг ном байна хэмээсэн өөр өөр утгаар орчуулах ёстой болно. Учир нь эхний өгүүлбэрт эрж байсан юм уу сураглаж, ярьж байсан ном энэ байна гэсэн утгыг илтгэж байхад дараагийн өгүүлбэр бол хэний ч юм бүү мэд нэг ном байна гэсэн хайхарамжгүй санааны угаас мэдээлж байгаа утга гарч байна. Тийм болохоор онцлоогүй ерөнхийд нь мэдээлэх үед голдуу дээр дурдсан бүтцийг хэрэглэх бөгөөд **there be** оруулсан үгтэй өгүүлбэрийн өгүүлэхүүнийг монгол хэлнээ “байх”, “орших” хэмээн үйл үгээр орчуулах боловч энэ утгыг илэрхийлж чадах өөр үг, хэллэг, өгүүлбэрээр орчуулж болно гэсэн үг юм. Туслах үйл үг болохынхоо хувьд үргэлжлэх цагийн бүлгийг илэрхийлэхэд ордог байна.

To be V+ing гэсэн бүтцээр орох бөгөөд энэ **to be** нь бие даасан үгийн утгаа алдаж зөвхөн туслах үйл үгийн үүргээр ордог. Жишээлбэл: **I am writing a letter** гэхэд “Би захиа бичиж байна” хэмээсэн одоо үргэлжлэн байгаа цагийг үзүүлдэг байна. Хоёр **to be** ороход оюутан гайхдаг билээ. Жишээлбэл: **I am being here** гэхэд “Би энд байсаар байна, Би энд байж л байна” гэсэн санаанууд гарах бөгөөд эхний **to be** нь туслах үйл үгийн утгаар хоёр дахь нь “байсаар байна, байж л байна” гэсэн гол утгаа үзүүлж байгаа ч хоёулаа нийлж одоо үргэлжлэн байгаа тэр утгыг гаргадаг хэмээхийг сайтар тайлбарлан таниулбал зохилтой байдаг. Мөн туслах үгийн хувьд идэвхгүй хэвийг үзүүлэхэд ордог. Англи хэлэнд, ер англиар барахгүй нийт энэтхэг европын хэлэнд **Passive voice** буюу идэвхгүй хэвийг их хэрэглэдэг. Ялангуяа англи хэлэнд захаас аваад л ямар ч ном зохиолын зүйлийг үзэхэд үйл үгийн гол зонхи нь идэвхгүй хэвд байдаг. Монгол хэлний хувьд тэр идэвхгүй хэв байдаг боловч төдийлөн их хэрэглээд байдаггүй. Тийм болохоор оюутан ойлгоход бэрхшээл гардаг. Жишээлбэл: **I am invited every week** гэхэд Би долоо хоног болгон уригддаг юм уу Намайг долоо хоног болгон урьдаг хэмээх өгүүлбэр болно. Харин **I invited every week** гэвэл Би долоо хоног болгон урьсан хэмээх өгүүлбэр болно. Сүүлийн өгүүлбэр нь идэвхтэй хэвийн өнгөрсөн цагийг үзүүлж байхад эхнийх нь жирийн одоо цагийн идэхгүй хэвийг үзүүлж байгаа учраас өөрөө биш өөр хүнээр уриулдаг үйл явц гарч байгаа нь тэр болой. Идэвхтэй хэвийн тусагдахуун болох зүйлийг идэхгүй хэвд өгүүлэгдэхүүний байранд аваачиж тавьдаг. Зарим жишээ үзье.

- **This house was built a hundred years ago.** Энэ байшин зуун жилийн өмнө баригдсан.

- **I have been invited twice in this week.** Би энэ долоо хоногт хоёр удаа уригдчихаад байна.

- **This problem will have been solved by 2011.** Энэ асуудал 2011 он гэхэд шийдэгдчихнэ эсвэл Энэ асуудлыг 2011 он гэхэд шийдчихнэ хэмээн орчуулах хэрэгтэй болдог. Эхний өгүүлбэр шиг идэвхгүй хэвээр нь буулгаж болох боловч Энэ асуудлыг 2011 он гэхэд шийдүүлнэ гэвэл илүү аятайхан болно. Энэ нь тэгэгд, ингэгд хэмээн орчуулснаас тэгүүл, ингүүл гэж орчуулсан нь хамаагүй дээр гэсэн үг юм. Тэгэхээр монгол хэлний идэвхгүй хэв бол шинжээрээ англи хэлнийхээс тун өөр юм. Өгүүлбэрийн эцэст үйл хийсэн эзэн буюу цагийн байцыг үзүүлэх он, цаг хугацааг үзүүлэхэд заавал **by** хэмээх утвартай хэрэглэдэг. Энэхүү нарийн учрыг тайлбарлахгүй бол үйлдэхийн тийн ялгалын утгаар ордог **by**-тай андуурагдах талтай байдаг.

To be to гэсэн нийлэмж баймж үйл үг болж хэрэглэгдэнэ. Энэ нь утгаараа төлөвлөгөөг илэрхийлнэ. Жишээлбэл: **He is to come back at 9 o'clock.** Тэр 9 цагт эргэж ирэх учиртай. Тэр 9 цагт эргэж ирэх ёстой, Тэр 9 цагт эргэж ирэх ёстой юмсан хэмээсэн нь өмнө нь ярилцаж тохирсон,

энэ талаар тодорхой мэдэж байгаа зүйлийн тухай ярилцаж байгаа санаа юм. Тэгэхээр энэ баймж утгыг илтгэгч нь **to be to V** гэсэн бүтэц юм гэдгийг ямагт санах нь чухал байдаг. Мөн бас тушаал зааврыг илтгэнэ. Жишээлбэл: **She is to stay at home today** хэмээх өгүүлбэр нь Тэр эмэгтэй өнөөдөр гэртээ үлдэх ёстой. Тэр эмэгтэй өнөөдөр гэртээ үлдэх хэрэгтэй. Тэр эмэгтэй өнөөдөр гэртээ үлдэх учиртай юм гэх мэтээр орчуулах хэрэгтэй болно. Хамгийн сүүлд тайлбарлах зүйл бол **to be** тэмдэг нэр, үйлт нэр болон нэр үгтэй хоршиж өвөрмөц хэлцийн утга илэрхийлдэг. Жишээ нь **be climbing the wall** үхтлээ уйдах хэмээсэн хэлц нь **to be** байхгүй тохиолдолд хананд авирах гэсэн жирийн хэллэг болж хувирна. **Be old hat** үеэ өнгөрөөх хэмээх хэлцийн **to be**-г хасвал жирийн л хуучин малгай гэсэн утгатай болно. **Be on thin ice** аюултай байдалд орох, хэцүүдэх гэсэн хэлцийн **to be** –г хасвал нимгэн мөсөн дээр гэсэн жирийн хэллэг болно. **Be under a cloud** хардагдах, сэрдэгдэх хэмээх хэлцийн **to be**-г хасвал зүгээр л үүлэн доор хэмээсэн жирийн үг болно. Монгол хэлний долоо шархадсан чоно (хашир) гэсэн өвөрмөц хэлцийг долоо шархадсан үнэг гэвэл хэлц болж эс чадна. Учир нь бүх үг нийлж байж нэг цогц утга болох хашир гэдгийг илтгэж байна. Тэгвэл үүн лүгээ адил англи хэлний **be under a cloud** хэмээх хэлц нь бүх үг нэгдэн нийлж хардагдах, сэрдэгдэх хэмээсэн нэг л утгыг илтгэнэ. Оюутнууд хэлц гэж мэдээгүй тохиолдолд шууд үгийн утгаар нь орчуулж алддаг тал олон бий. Ийм л болохоор англи хэлний **to be** нь олон янзаар хувирдаг лусын хаан шиг хэмээсэн нь энэ болой.

Ном зүй

1. Англи хэл заах арга зүйн асуудлууд, УБ., 2009
2. Д.Бадамдорж, Монгол хэлний үгийн сангийн утга зүй, УБ., 2006
3. Д.Гүнүйлс, Ц.Нарангэрэл, Англ хэлний үг зүй, УБ., 2007
4. Чой.Лувсанжав, Англи хэл өөрөө сурах, УБ., 1972
5. Ю.Мөнх-Амгалан, Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, УБ., 1998
6. Н.Нансалмаа, Үгийн сан судлал, УБ., 2005
7. Орчуулгын тухай өгүүллүүд, Гадаад хэлнээс орчуулах нь УБ., 1996
8. Ж.Оюунцэцэг, Англ хэлний зүй, УБ., 2007
9. Э.Чинбат, Англи-Монгол өвөрмөц хэллэгийн толь, УБ., 2008
10. Charles Bawden, Mongolian – English dictionary, London, 1997
11. E.Chinbat, English-Mongolian dictionary, UB., 2009
12. The New Penguin English dictionary, London, 2000



“МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЦ ХЭЛЛЭГИЙГ ХЯТАД ХЭЛНЭЭ
ОРЧУУЛСАН БАЙДАЛ”
 (“Тунгалаг Тамир” зохиолын хятад орчуулгын жишээгээр)

Г.Элдэв-Очир³⁰
Р.Оргил³¹

Abstract: Ch. Lodoidamba, the Mongolian famous writer, wrote his creation named “Tungalag Tamir” in 1954, and it is the best Mongolian novel that artistically described the social and political situations, life style, culture and customs of Mongolians, lived in the early of 20th Century. This novel was translated from Mongolian to Chinese language in 1984 by the Chinese translator Wen Zhonghe. In this article, I have studied on how the local idioms, phrases and metaphors on this novel were translated into Chinese.

Түлхүүр үг: Өвөрмөц хэлц, хэвшмэл хэлц, адилтгал зүйрлэл

БНХАУ-ийн орчуулагч Вэнь Жунхө 1985 онд энэхүү зохиолын нэгдүгээр ботийг хятад хэлнээ орчуулсан байдаг боловч хоёрдугаар ботийг өнөө хэр орчуулаагүй бололтой.

“Тунгалаг Тамир” роман нь монгол хэлний өвөрмөц хэлц, хэвшмэл хэлц, адилтгал зүйрлэл зэргээр баялаг агаад эдгээрийг хятад хэлнээ хэрхэн орчуулсан байдалд дүн шинжилгээ хийж, хам сэдвийн хүрээнд харьцуулан утгын алдаатай эсэхэд ажиглалт хийлээ.

1. Өвөрмөц хэллэг

- “Нохойн дуу сонсогдох/ нохойн дуу ойртох”

“...Бид гэгээний авралаар хар цэргийг Хиартал цохиод зарим газраар хэрмэнд ойрхон очсон. Ер нь Бээжингийн **нохойн дуу бараг сонсогдож байсан шүү**. Бид номхон хонь биш, Эзэн Чингисийн угсаа эрэлхэг зоригт Монгол гэдгээ үзүүлсэн шүү...”

“...打得中国军队狼狈不堪。有些部队已经接近了长城，也许还听到了北京城犬吠声。我们不是任人宰割的羔羊。要他们明白，我们是英勇的成吉思汗的蒙古人...”

“Нохойн дуу сонсогдох буюу нохойн дуу ойртох” хэмээх хэлц нь “Монгол хэлний хэлц үгийн тайлбар толь”-д “**Айлд ойртон ирэх, бас нэг өөр утга нь товлосон цаг хугацаа дөхөх**” хэмээх утгаар тайлбарлажээ. Харин уг орчуулгад “听到了犬吠声” буюу үгчилэн орчуулбал “**нохой хуцах чимээ сонсогдох**” гэх ажээ. Гэвч тухайн өвөрмөц хэллэг нь өмнөх өгүүлбэртэй уялдаатай тул нохой хуцах чимээ сонсогдох гэдэгтэй ердөө хамааралгүй билээ. Тухайн зохиолын санааг авч үзвэл, хар цэргийг хиартал цохиод тун удахгүй Бээжинд очиж ялалт байгуулах гэж байна гэсэн далд утгыг агуулж байгаа юм. Харин орчуулагчийн хувьд тухайн утгыг шууд үгчилэн орчуулсан нь зохиолын утга санааг нарийн гаргаагүй байна. Монгол хэлнээ **Айлд ойртон ирэх**,

³⁰ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, доктор

³¹ МУИС, ШУС, ХУС-ын “Гадаад хэл шинжлэл” хөтөлбөрийн докторант

товлосон цаг хугацаа дөхөх зэргийг илтгэдэг “нохойн дуу ойртох” гэсэн өвөрмөц хэлц нь монгол ахуй амьдралтай холбоотой агаад хятад хэлнээ үүнтэй дүйцэх хэлбэрээр илэрхийлдэггүй байна.

- “Хөл алдах”

“...*Чи ч Долгорт хөл алдаж байх шив дээ. Би ч яахав дарлагдаж сурсан хүн. Харин Дулмаа чинь хардаж сүйд болох байх даа гэж сайхан бэлэг авсандаа магнай дүүрэн баярласан Долгорыг гүйн гарахад Должин хэлэв...*”

“...你对都拉格尔**有意**了。我倒没什么，受气惯了。可是，你那个道力玛会打翻醋罐子的。当得到了最好的礼物，满心欢喜的都拉格尔跑出去的时候，道力金这样说道...”

“**Хөл алдах**” хэмээх өвөрмөц хэлц нь “Монгол хэлний хэлц үгийн тайлбар толь”-д “**ихэд хүндэтгэн дайлж цайлах**” хэмээх утгаар тайлбарлажээ. Харин хятад хэлнээ орчуулсан **有意** гэх үгийг үгчилэн орчуулбал “**санаатай, бодолтой, зорилготой**” гэсэн утгыг илэрхийлнэ. Гэхдээ энэ үгэнд “санаатай” гэх нь түүнд сэтгэл алдаж буй утгыг илүү тод илэрхийлэх учраас тухайн зохиолын утгаас тэс өөр уур амьсгалыг бүрдүүлсэн орчуулга болж хувирч байна.

Бидний үзэж буйгаар тухайн өгүүлбэрийн утгыг авч үзвэл Долгорыг их хүндэтгэж таатай хандаж байгаа нь бас өөр нэгэн санаа давхар агуулж байх тул орчуулагч үүнийг илүүтэй анзаарч энэ хүнд ер нь сэтгэлтэй болсон байх магадлалтайг харуулж тухайн үгийг орчуулгадаа ашигласан бололтой.

2. Хэвшмэл хэллэг

- “Амьд хүн аргатай, аргалын гал цогтой”

“...*Явгарсан болохоос үхсэн биш. Амьд хүн аргатай, аргалын гал цогтой доо гэж зуусан шүүднийхээ завсраар шивэгнэн хэлэв...*”

“...这回咱们得步行了，咱们并不是到绝路。活人总会有办法的，点起牛耕火提提神吧，从紧缩的牙缝中挤出了这么几句话...”

“Амьд хүн аргатай, аргалын гал цогтой доо” хэмээх хэвшмэл хэллэгийн үндсэн утга нь “Монгол хэлний их тайлбар толь бичиг”-т “**амьд явбал арга нь олдоно гэсэн санаа**” гэж тайлбарлажээ. Харин хятад орчуулгад “活人总会有办法的，点起牛耕火提提神吧” гэж орчуулсан бөгөөд үүнийг үгчилэн орчуулбал “**амьд хүнд үргэлж нэг арга байж таараа, аргалын гал асаагаад ухаан санаагаа сэргээх**” гэх ажээ. Үүнээс үзэхэд, энэхүү хэвшмэл хэлцийн орчуулгад эхний хэсэг дээр утга нь гарсан боловч арын хэсгийг нэмэх шаардлагатай байсанд эргэлзэж байна. Учир нь Монголчууд аргал түлж ухаан санаагаа сэргээдэг юм шиг ойлголт төрүүлэхээр болсон бөгөөд уг эхийн утгаас эрс ондоо болжээ. Иймд уг хэвшмэл хэлцийг “活人总会有办法的” буюу “амьд хүнд үргэлж нэг арга байж таараа” гээд л орчуулсан бол болмоор санагдаж байна.

- “Бэлхэн тоолох бэлгүй болохоор”

“...*Морь худалдаж авъя гэхэд бэлхэн тоолох бэлгүй болохоор юу ч гэсэн энд хэд хонож хүнтэй уулзан арга зай хайхаас өөр зам байсангүй.*”

“...想买一匹马吧，没有现成的条件。不管怎么样，看来非在这儿住上几天，找到人家，想想办法不可了...”

- “Бэлхэн тоолох бэлгүй болохоор” хэмээх хэвшмэл хэллэгийг “Монгол хэлц үгийн тайлбар толь”-д “**одоо бэлэн гээд байх зүйл байхгүй**” хэмээх утгаар тайлбарлажээ. Харин хятад хэлнээ “没有现成的条件” гэж орчуулсныг үгчилэн орчуулбал “одоо бэлэн гээд байх нөхцөл байхгүй” гэх агаад хүчээр нийцүүлэн утгыг тааруулж орчуулсан гэж үзэж байна. Мэдээж тухайн өгүүлбэрийг хятад хэлнээ дүйцэх, эсвэл, ижил утгатай үгсээр орлуулж орчуулж болох байсан. Гэвч тухайн өгүүлбэрийн орчуулгыг харахад 没有现成的条件 гэсэн хэллэгийг хятад хэлний хувьд хэрэглээний давтамж багатай ажээ. Харин 没有现成的规则 (бэлэн зэлэн ямар нэгэн дүрэм журам байхгүй) гэдгийг илүү түлхүү хэрэглэдэг. Гэвч эх зохиолын утга нь шууд бэлэн тоолоод өгөх мөнгөгүй гэсэн утга байх агаад үүнийг орчуулагч тодорхой гаргаж чадаагүй байна.

- “Далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гарч байдаг”

“...Өдөр өнгөрөх тусам **далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гарч байдаг ба бас тайлбарлаж болиггүй хайр сэтгэлээр Итгэлтийн хийснийг цагаатгаж, амьдрал таван хуруу тэгш биш гэж сэтгэлээ засаж явдаг болжээ...**”

“...日子越长，她就越怕丈夫。丈夫说一是一，说二是二，丈夫指到哪儿，她做到哪儿。她以难分难解的痴情，容忍着丈夫所做的一切。她常说：伸出手来五个指头还不一般齐呢，她以此安慰着自己...”

“Далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гарч байдаг” хэмээх хэвшмэл хэллэгийн утгыг “Монгол хэлний их тайлбар толь”-д тайлбарласнаар “**хүний үгээр, аясаар явах**” гэжээ. Харин хятад хэлэнд “说一是一，说二是二，指到哪儿，做到哪儿” буюу үгчилэн орчуулбал “**нэг гэхэд нэг, хоёр гэхэд хоёр (бүх юм тодорхой) хаашаа заана, тэнд л чи юмаа хийж байх**” гэсэн утгатай агаад дүйцүүлэн орчуулах аргыг ашиглажээ. Тухайн орчуулгын байдлыг харахад эхийн утгыг шууд хятад хэл рүү утгачилан орчуулж уншигчдад ойлгомжтой байх зарчмыг баримталсан байна.

- “Амьдрал таван хуруу тэгш биш”

“...Өдөр өнгөрөх тусам **далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гарч байдаг ба бас тайлбарлаж болиггүй хайр сэтгэлээр Итгэлтийн хийснийг цагаатгаж, амьдрал таван хуруу тэгш биш гэж сэтгэлээ засаж явдаг болжээ...**”

“Амьдрал таван хуруу тэгш биш” хэмээх хэвшмэл хэллэгийн утга нь “**Амьдрал дардан биш, алдаа оноотой байдаг, жаргал зовлон ээлжилдэг**” гэх мэтээр тайлбарласан байна. Үүнийг хятад хэлнээ “伸出手来五个指头还不一般齐呢” гэж орчуулсан бөгөөд үгчилэн орчуулбал “Гараа сунган таван хуруугаа гаргахад хуруунууд нь хоорондоо нийлэхгүй байна” гэсэн утгатай юм. Эх зохиолын хэвшмэл хэллэгийг шууд дүйцүүлж орчуулсан нь тухайн зохиол дахь утга санаа нь бага зэрэг гарсан боловч оновчтой болоогүй байна. Тиймээс уг хэвшмэл хэллэгийн утгатай арай ойр дөхөм “生活之间幸福和悲伤同在一起” гэх хэвшмэл хэллэгээр орчуулах хэрэгтэй байлаа.

3. Зүйрлэл

- “Ишиг шиг чарлахгүй, хурга шиг дуугүй байж байгаад л”

“...Би ч хэлэхгүй, хөнгөлсөн ч хэлэхгүй. **Ишиг шиг чарлахгүй, хурга шиг дуугүй байж байгаад л босоод явчихна...**”

“...我就不说，我也不说，我即不像山羊羔那样咩咩哀叫，也不像绵羊羔那样痛苦地呻吟，我要默默地爬起来跑掉...”

“Ишиг шиг чарлахгүй, хурга шиг дуугүй байж байгаад” гэх зүйрлэлийг хятад хэлнээ шууд үгчилэн орчуулсан байна. Хятад орчуулгад 我即不像山羊羔那样咩咩哀叫，也不像绵羊羔那样痛苦地呻吟 буюу үгчилэн орчуулбал “ишиг шиг майлахгүй, хурга шиг зовж чарлахгүй” гэх утгатай болжээ. Ингэснээр хятад уншигчдад ойлгомжтой байх зарчим ч бас биелэх боломжтой байна.

- “Зурам давхисан ч цочиж, чогчиго дуугарсан ч сэргэлзэн явжээ”

“...Гэнэгүй явж байгаад цохиулчихаж магад гэж зурам давхисан ч цочиж, чогчиго дуугарсан ч сэргэлзэн явжээ...”

“...走在路上，即使跳起一只黄鼠，也会把他吓一跳，黄鹊叫上一声，也会使他毛骨悚然...”

“Зурам давхисан ч цочиж, чогчиго дуугарсан ч сэргэлзэн явах” гэдэг зүйрлэлийн ерөнхий утга нь юм юмнаас маш их айж цочирдож, их сонор сэргэмжтэй явахыг илэрхийлж байна. Харин хятад хэлэнд болохоор “即使跳起一只黄鼠，也会把他吓一跳，黄鹊叫上一声，也会使他毛骨悚然” гэх буюу үгчилэн орчуулбал “зурам үсрэнгүйт айж цочирдоод, шар болжморын дуу чимээнд бие нь зарс хийдэг” гэсэн утгаар орчуулжээ. Энэ өгүүлбэрээс дүгнэхэд маш их айсан гэх утгыг эх зохиолоос нь хуулбарласан боловч чогчиго шувууг шар жижигхэн болжмор шувуугаар төлөөлүүлж орчуулсан байна.

Дүгнэлт

“Тунгалаг Тамир” зохиолын орчуулгад өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэг, зүйрлэл зэргийн заримынх нь утгыг алдагдуулж орчуулсан боловч заримынх нь утгыг дүйцүүлэх болон утгачилан орчуулах аргаар уншигчдад ойлгомжтой байх зарчмыг баримталсан нь харагдаж байна.

Монгол зохиолыг хятад хэлнээ орчуулахдаа ялангуяа хэлц хэллэгийн утгыг туйлын сайн анхаарч, монгол ахуй амьдрал, соёл, сэтгэлгээг хятад уншигчдад зөв оновчтой хүргэх тал дээр орчуулгын олон аргаас уран чадамгай ашиглах шаардлагатай байна.

Номзүй

1. Ч. Лодойдамба . “Тунгалаг Тамир” УБ, 2015
2. Монгол хэлний их тайлбар толь
3. 温中和 清澈的泰米尔河。呼和浩特； 内蒙古人民出版社， 1985



СОЁЛ БА ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ҮЛ ХЭРЭГССЭНЭЭС ҮҮДЭН ОРЧУУЛГАД ГАРЧ ИРЭХ ГАЖУУДАЛ

Д.Долгорсүрэн³²

Abstract: Translation deciphers meaning of the written word from one language to another. Interpreting is a complex and multi-modal, linguistic activity, where the interpreter handles not only the linguistic transfer, but also the whole impact of the context in which the interpreting takes place. Both translation and interpretation enable communication across languages from source to target, and both work with not only the language, but also the culture and values which the speakers of that language respect and adore. Decades of research on translation or interpreting has made it abundantly clear that ignorance or distortions of culture and value in translation leads to a perversion of the truth, that is, such translation can pervert the minds of an audience of hundreds and thousands.

Perversion in translation is not just a quality of something that has been lost in translation, it means that it is not very good as a result of being translated into another language or told in a different way. Essentially, words provide us with a framework for expression, but no two frameworks can express the exact same idea, which means that no words truly translate because each framework in each language has different connotations within its original culture and valuable beliefs of its speakers. According to translation process research, which is into the interpreting process aims to unveil and understand the cognitive actions behind interpreting. The actions part of the process was once described as identifying, decoding, transferring and producing a series of linguistic units from one language to another, but still it must not be perverted.

Keywords: translation, interpreting, perversion, distortion, culture & values

Аливаа орчуулга үнэн зөв байх зарчимд тулгуурладаг бөгөөд хүний бүтээлч үйл ажиллагаа, сэтгэн бодох болон мэргэжлийн ур чадварыг илэрхийлдэг нарийн үйл явц юм. (Gillies, "Translation Practices Explained: Consecutive Interpreting", 2019) Орчуулагч, дуун хөрвүүлэгчид бол аливаа мэдээллийг аман болон бичгийн хэлбэрээр дамжуулагч бөгөөд өөрийн санаа бодол, үгийг бус харин тухайн бичвэрийг, эсвэл, хэлж буй үгийг орчуулж, дамжуулах үүрэгтэй нэгэн билээ. Гэтэл орчуулга хийж буй зарим хүмүүс үүнийг умартаж, өөрийнхөө бодол санааг хольж хутгаж, үг нэмж хасч, эсвэл, итгэл үнэмшил үзэл бодолдоо баригдан нэр томьёо, зарим ойлголтыг гажуудуулж өөрчлөн орчуулах нь орчуулгад гажуудал үүсгэж, орчуулгын онолын зарчмыг зөрчих нь бий.

Орчуулгын онолын зарчмаар, аливаа орчуулгыг хийхэд эх хэлний хэлзүйн онцлог, найруулах ёсыг баримтлахыг чухалчилж, найруулах ёсны олон аргыг хольж хутгалгүй, гол нь эхийн утга санааг хэвээр хадгалж орчуулах нь зүйтэй байдаг. Тайлбарлах шаардлагатай газар нь зүүлт тайлбар хийж, үг хэллэгийг оновчтой сонгон, уншигч сонсогчдын оюуны мэдлэгт тус нэмэр болохуйц мэдээллийг дамжуулах нь орчуулагчийн зорилго юм.

³² МУИС-ийн ШУС-ын ГХТ-ийн ахлах багш

“Бэрх утгыг мэдэн чадваас хурц мөн” хэмээн эртний Энэтхэгийн гүн ухаантан Нагаржуна хэлсэн гэдэг. Эртний Жагарын аугаа их сэтгэгч эл мэргэн дээрх үгийг маш өргөн дэлгэр утгаар айлдсан нь лавтай. Иймд үүнийг орчуулгын ухаанд аваачин хэрэглэхэд үл болох газаргүй мэт. Учир юун хэмээвээс, дуун хөрвүүлээчин гадаад үг, өгүүлбэрийн бэрх утгыг төдийгүй эх хэлнийхээ үг өгүүлбэрийн ч бэрх утгыг тайлдаг ажаам. (Г.Аким, 1990) Аль ч төрлийн орчуулгыг гүйцэтгэхэд доорх үндсэн зарчмыг заавал баримтлах шаардлагатай гэж үздэг болжээ. Үүнд:

А) Тухайн хөрвүүлэг, орчуулгаар уул хэлийг мэдэхгүй хүнд эх зохиол юм уу ярьж байгаа хүний бичсэн, өгүүлснийг аль болохуйц үнэн зөв, хялбар дөхөм байдлаар хүргэх ёстой.

Б) Аливаа орчуулга, хөрвүүлэгт нэг хэлээр бичиж туурвисан, өгүүлсэн, ярьсан зүйлийг нөгөө хэлний хэрэглэгдэхүүнийг оновчтой ашиглан бүрэн төгс илэрхийлэн гаргах ёстой. (Аюушжав, 1996)

Монголын эрдэмтэд, судлаачид төдийгүй гадаадын олон судлаач, орчуулагч, хэл шинжээчид орчуулгын олон аргууд байдаг гэдэг бөгөөд тэдгээр нь сул болон давуу талуудтай байдгийг онцолдог. Үүнд:

1. Үгчилэх арга /Сул тал нь бичвэрийн утга алдагддагт байдаг/
2. Чиглүүлэх арга /Эх бичвэрт байгаатай аль болох төстэй үгийг авч орчуулахыг хэлдэг/
3. Дүйлгэх арга /Утгыг аль болохоор баримталж орчуулах арга бөгөөд үүнийг орчуулгын шилдэг арга гэж үздэг/
4. Утгачлах арга /Орчуулгын нэгж бүрийн уран сайхны илэрхийлэл, хэлбэр агуулгын шүтэлцээг тоон талаас харгалзуулж, санааг яв цав гаргах, эх бичвэрийн үр нөлөө, учир шалтгааныг гол болгодог/
5. Найруулах арга /Санааг нь аваад бүтээлчээр уран найруулах арга юм/
6. Тайлбарлах арга /Эх бичвэр дэх үгийн утгыг шууд баримтлан тайлбарлах арга/
7. Хялбарчлах арга /Санааг гаргадаг боловч ярианы маягаар илэрхийлж, утгын нарийн онцлогийг гажуудуулдаг сул талтай/
8. Нэвтрүүлэх арга /Ухагдахууныг өөр үгээр илэрхийлэхийг гол болгодог, агуулга хэлбэрийн нэгдлийг хадгалан найруулах чадварыг орчуулагчаас шаарддаг/ (Newmark, 1985)

Аливаа орчуулгыг хийхдээ гадаад хэлний үг өгүүлбэрт баригдан, махчилан үсэгчилж хэрхэвч болохгүй гэдгийг их номч Бямбын Ринчен олонтоо сануулсан байдаг. Шууд махчилж орчуулснаас болоод огт өөр эсвэл буруу ойлголт төрүүлсэн байх тохиолдол байна. Жишээлбэл, англи хэлээр яригч ард түмний дунд ихэд дэлгэрсэн “*Amazing Grace*” хэмээх нэгэн дууны нэрийг монгол хэлнээ орчуулахдаа “гайхалтай Грейс” гэсэн байх юм. Уг дуу нь их алдартай дуу бөгөөд бурхны агуу хайрыг магтан дуулсан утгатай ажээ. Англи хэлний *grace* гэсэн үг нь *хайр нигүүлсэл* гэсэн утгатай болохыг сайтар нягтлаагүйн улмаас дээрх дууны нэрийг Грейс гэдэг нэртэй гайхалтай нэг хүний тухай дуу гэж ойлгогдохоор орчуулсан байна. Үүнийг “Гайхамшигт Хайр” гэж орчуулах нь зүйтэй юм.

Орчуулагч, хэлмэрч хүн ямар нэг үг хэллэг, нэр томьёо, ойлголтыг хэрвээ сайн мэдэхгүй байгаа бол мэддэг нэгнээс, эсвэл, найдвартай эх сурвалжаас хайж, асууж,

лавлах нь зүйтэй. Олны хүч оломгүй далай гэдэг мэргэн үг бий. Олны дунд зөв хэлээд, туслаад чиглүүлээд өгөх хэн нэгэн заавал байдаг. Техник технологийн хөгжил дэвшлийн ачаар аливаа мэдээллийг цахим ба цахим бус эх сурвалжаас олж авах, тайлбар болон нэвтэрхий толь бичгээс хайж олох бүрэн боломж байна.

Орчуулга хийж буй хүмүүсийн дунд бусдаас асууж лавлахаас санаа зовж, эсвэл, би багш, орчуулагч хүн тул өөрөө чадна, илүү мэднэ хэмээн муйхарлаж зүтгэх тохиолдол цөөнгүй байдгаас болж орчуулгад алдаа гарах, утгын гажуудал бий болох явдал гардаг. Хэдий онолоо мэддэг ч багш нарын тухайд орчуулга хийх дадлага бага байдаг учраас мэргэжлийн орчуулагч, эсвэл, тухайн салбарын хүмүүсээс мэдэхгүй байгаа зүйлээ асууж тодруулах нь оновчтой зөв орчуулахад тустай. Ер нь асуухаас нэрэлхдэг нь туйлын буруу юм. Орчуулгын аль ч арга дотор эх зохиол, эсвэл, бичвэр доторх гол түлхүүр үг хэллэгийг хасч хаях, эсвэл, өөр утга илэрхийлсэн үгээр солих арга гэж байдаггүй. Гэтэл орчуулга хийхдээ зарим үг хэллэгийг дур мэдэн өөрчилж, үг хасч, нэмж, өөр утгатай болгон орчуулах нь уншигч сонсогчдын, багш нарын хувьд бол оюутнуудынхаа танин мэдэх, сонголт хийх эрх чөлөөнд халдаж буй бүдүүлэг үйлдэл юм. Орчуулгаар дамжуулан авсан аливаа мэдээ мэдээлэл нь олон хүнд нөлөөлж болох учраас үүнийг анхаарах нь маш чухал юм.

“Орчуулга бол аливаа нэгэн хүний үзэл санаанд захирагдах зүйл биш, харин аливаа илэрхийлэл ямар байна тэр илэрхийллийг орчуулах хэлнээ эх хэл дээр байгаа шиг л утга тэнцүү гаргах зүйл гэдгийг хэлэх нь илүүц байж магадгүй.” (Доржготов, 1993) Тэгтэл хувь хүний үзэл бодол, итгэл үнэмшилдээ баригдаж, өргөн хүрээнд сэтгэж ухаарч чадахгүй, хэт туйлшрах явдал орчуулгын чанар үнэлгээнд нөлөөлж байна.

Аливаа хэл нь хүн хоорондын төдийгүй ард түмэн, улс гүрэн хоорондын харилцааны гол хэрэглүүр учраас хэлээр дамжуулан түүх, соёл, үнэт зүйл, үзэл баримтлал, итгэл үнэмшил түгэн дэлгэрч байдаг нь гарцаагүй үзэгдэл бөгөөд боловсрол, шинжлэх ухаан, шашин, гүн ухаан, өдөр тутмын аж амьдралын бүхий л үйл явцыг үг хэлээр илэрхийлж, хэлний ачаар өөр өөр ард түмэн харилцан нэгнээсээ сурч, хөгжиж, боловсорч байдаг. Дэлхийн гол хэл болох англи хэлийг монголчууд ерөнхийдөө гадарлах болж, урьд өмнө орос хэлээр мэдээллийг дамжуулж байсан бол одоо англи хэлнээс ихэнх мэдээллээ авч, англиас монгол хэлнээ орчуулах ном зохиолын тоо нэмэгдсээр байгаа нь сайшаалтай.

Хэл соёл хоёр салшгүй холбоотой тул аливаа хэлээр яригч ард түмний соёл, үнэт зүйл, итгэл үнэмшил нь ном зохиол, оюуны бүтээлд нь шингэж, тусгалаа олж, мөн тэдний хэл яриагаар дамжин үр хойчдоо уламжлагдан өвлөгддөг. Улс орнууд нэг нэгнээсээ харилцан суралцаж, нийт хүн төрөлхтний хувьд юу чухал, юу үнэн, юу сайн сайхан, юу зөв, ямар бүтээл нь цэвэр ёс суртахуун, хүнлэг чанарыг хадгалсан байна түүнийг л өөр өөрийн эх хэлээр дамжуулан харилцан солилцож, сурч, танин мэдэхийг чухалчлан хичээж ирсэн билээ. Хэрэв монголыг судлаач гадаадын эрдэмтэд монгол хэлнээс өөрсдийнхөө хэл рүү аливаа орчуулгыг хийж байхдаа, эсвэл, монгол хэлийг зааж байхдаа, “*би англи, америк, орос, хятад, араб хүн, би уламжлал, ёс заншлаа л баримтална*” хэмээн муйхарлаж, монголчуудын түүх, соёлтой холбоотой материал, ном судрыг жигшин, тэндээс үг өгүүлбэр авахаас айж дургүйцэж байвал тэр хүн яаж монгол хэл соёлыг түгээгч, монгол судлаач байж, хүлээн зөвшөөрөгдөж чадах билээ! Иймэрхүү

мунхаг туйлшрал нь танин мэдэхүйн эрх чөлөөнд үнэхээр хаалт, чөдөр тушаа болж байдаг урхагтай зүйл юм.

Суурин иргэншилтэй ард түмний хэл болох англи хэл нь нүүдэлчин амьдралын хэв маяг хэл соёлд нь шингэсэн монгол хэлнээс олон талаар ялгаатай бөгөөд бүтэц, найруулгын хувьд ч ихээхэн ондоо байдаг. Хүндэтгэл ба албархуу байдлыг илэрхийлэхдээ англи хэлтнүүд үг яриандаа гол төлөв нэр үг, нэрийн хэлхэцийг ашигладаг байхад монголчууд үйл үгийг түлхүү хэрэглэдэг нь соёл болон сэтгэлгээний ялгаа бөгөөд монгол англи хэлний хооронд орчуулга хийхэд үүнийг санаж байх нь чухал. Жишээ нь бид энгийн, эсвэл, албан түвшинд ч гэсэн доорх байдлаар харилцах нь түгээмэл байдаг. Үүнд:

- *Явах уу?*
- *Өө, явъя явъя.*
- *Дуусчихсан уу?*
- *Дуусчихсан.*
- *Бичсэн үү?*
- *Бичиж байна аа!* гэх зэргээр үйл үгээр бүрэн ойлголцдог.

Харин англи хэлтнүүд өгүүлбэр хэлэх, бичихдээ төлөөний нэр буюу үйлийн эзнийг орхидоггүй, заавал дурддаг. Мөн түүнчлэн таслал, зураас, цэгтэй таслал зэрэг тэмдэг, тэмдэглэгээгээр аливааг тайлбарлаж, утгыг илэрхийлэн тодорхойлдог гэх мэт олон онцлог бичгийн соёлд нь байдаг. Иймд англи хэлнээс бичгийн болон аман орчуулга хийхдээ ийм ялгааг анхаарч, үг хэллэгийг оновчтой сонговол орчуулга үнэн зөв болох боломжтой юм.

Хэл шинжлэлийн үүднээс хэлийг хэлбэр, агуулга, үүргийн гурамсан нэгдэлтэй бөгөөд тэдгээр нь хүний сэтгэхүйтэй нарийн нягт холбоотой байдаг гэж үздэг учраас хэлний энэхүү диалектик шинжийг баримталж орчуулах мэдлэг чадвартай хүн л жинхэнэ орчуулагч байж, үнэн зөв оновчтой орчуулж чаддаг байна. Ер нь аливаа хэлний үг өгүүлбэр, бичигт тэмдэглэгдсэн загвар хэлбэрийг өөр хэлнээ хөрвүүлэн орчуулахдаа агуулга талыг нь баримталбал утга санаа нь тодорхой илэрхийлэгддэг.

Орчуулагч нарын зарим нь түүх соёлын мэдлэг дулимгаас өөр өөр соёлын хүрээний зүйлийг хольж будилсан, буруу орчуулсан жишээ олон. Тиймээс орчуулга бол хүн бүрийн барьж авч дураараа хийгээд байж болох зүйл биш юм. Мэдлэг боловсролоор дулихан атлаа биеэ тоож, ихийг мэддэг дүр үзүүлдэг, тухайн хэл дээрээ ядаж мэдээ ч сонсдоггүй, зохиол бүтээл ч бараг уншдаггүй, эсвэл, мөнгө олохын тулд л орчуулга хийдэг зарим хүнээс болж орчуулгын зарчим эвдэгдэж, орчуулагчдын нэр хүнд унаж, олон сайхан зохиол бүтээл дэх зөв санаа уншигч олонд, оюутан суралцагчдад хүрч очихдоо буруу гажуудсан ойлголтыг өгч, цаашлаад эх хэлний мэдлэгт ч нөлөөлж байгаа нь харамсалтай юм. “Орчуулгаас үүдэлтэй буруу үг, буруу томъёолол нь хүний сэтгэц, ухамсар, сэдэглэгээнд нөлөөлж, өөрийн гэсэн төрмөл оюун, таримал ухааныг нь үрэн таран хийдэг”. (Хишигт, 2012)

Иймд, гадаад хэл сурч, эзэмшиж, цаашлаад уг хэлээрээ мэдээлэл, мэдлэг, соёлыг дамжуулах орчуулагчийн ажлыг хийх бодолтой, хийж буй хэн бүхэн орчуулга гэдэг зөвхөн үг өгүүлбэр, утга санааг дамжуулж байгаа хэрэг бус, харин түүх соёл, зан заншил уламжлал, мэдлэг боловсрол, үзэл бодол, итгэл үнэмшил зэрэг хүн төрөлхтний нийтлэг

ёс зүйд хамаарч болох олон чухал ойлголтыг дамжуулж, түгээн дэлгэрүүлэх чухал агаад үр нөлөөтэй ажил үйлс хийнэ гэдгээ ухаарч, тэнүүн бодолтой, уужим тайван, хүлээцтэй хүндэтгэлтэйгээр аливаад хандвал орчуулгыг жинхэнэ бүтээл болгох боломжтой юм. Олон түмнийг гэгээрүүлж, эрдэм мэдлэгтэй, зөв ойлголттой, хүнлэг ёс зүйтэй болгоход сайн орчуулагчдын үүрэг асар их билээ. Орчуулагчдын ачаар хүн төрөлхтөн бие биетэйгээ танилцаж, мэдлэг мэдээлэл, сайн сайхныг харилцан суралцаж, амин чухал олон асуудлын учрыг тайлж, ухааран ойлгож, танин мэдэж, мэдлэгийн эрх чөлөөнд хүрч чаддаг байна.

Ашигласан ном

Г. Аким “Бэрх утгыг мэдэн чадагч”, “Билгүүн номч Бямбын Ринчен”., Улаанбаатар, 1990

П. Аюушжав “"Орчуулгын тухай өгүүллүүд, гадаад хэлнээс орчуулах нь", “Орчуулах Эрдэм 4”, Улаанбаатар, 1996

Andrew Gillies “Translation Practice Explained: Consecutive Interpreting”., London and New York, 2019

Н. Доржготов “Орчуулгын хэлбэр, агуулгын шүтэлцээ”, Улаанбаатар, 1993

P. Newmark “Approaches to Translation”, London. 1985

Я. Хишигт “Сэтгэц, ухамсар, сэдэхлэгээний хоруу, орчуулгын асуудалд”, “Орчуулах Эрдэм 4, Улаанбаатар 2012



ДАЯАРШИЛ –ИНТЕРНЭТ – ОРЧУУЛГА

Б. Батчимэг³³, У.Лхагвасүрэн³⁴

Abstract: The Cold War that divided the world into mutually opposing two poles ended in the early 1990s, creating favorable conditions to international relations. This transformation led to intensification of relations among world nations. Broadening of cooperation impacted on globalization. The need for barrier free, speedy relations triggered information technology advancement. The internet which initially was created to simply connect computers in order to share information, became the key mediator of global communication. The launch of the internet has opened a new horizon which is not restricted by time and space. The growing flow of information tremendously increased the demand for translation. From this point of view, translation can be defined as an integral part of globalization which has been made possible with the internet. With this paper we aimed to define interconnectedness, reciprocal impacts and future trend of these three phenomena.

Key words: globalization, translation, information, network, technological advancement and progress

Оршил

Дэлхийн олон улс орны эрдэмтэд, судлаачид даяаршлыг судалж өөр өөрийн өнцгөөс янз бүрээр тайлбарласан байдаг. Товчоор хэлэхэд, даяаршил бол улс орнууд нийгмийн түгээмэл салбарт үйл ажиллагаагаа ойртуулан, нягтруулах үйл явц ажээ. Барселоны их сургуулийн профессор Эсперанка Биелса, Английн Уорвикийн их сургуулийн профессор Сюзан Баснет нар ‘Translation in global news’ (Дэлхий мэдээний орчуулга) хэмээх хамтын бүтээлдээ “даяаршлын үндсэн хоёр шинж нь орон зайн саадгүй, мэдлэг мэдээллийн төвлөрсөн байдал бөгөөд үүний үр дүнд хүмүүс болон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний шилжилт хөдөлгөөн эрчимжиж, улмаар улс орон хоорондын харилцаа идэвхэждэг” тухай дурджээ (Bielsa&Bassnett, 2009:18).

МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, доктор Ж.Жаргал “Даяаршлын үеийн Монголын нийгэм ба хөгжлийн асуудалд” номдоо “орчин үеийн даяаршлын үйл явц хорьдугаар зууны эхэн үеэс эхэлж, дэлхийн хоёрдугаар дайны дараа улам эрчимжсэн. Эгнээндээ бараг бүх улсыг нэгтгэсэн НҮБ болон олон улсын бусад байгууллагуудын үүрэг оролцоо нэмэгдэж, дэлхий нийтийн асуудалд улс орнуудын шийдвэр, үйл ажиллагаа улам бүр хамаатай болсон” тухай дурджээ (Ж.Жаргал, 2016:25).

Даяаршил хүчээ авахад мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил яахын аргагүй нөлөөлсөн билээ. Агуу их мэдээллийн сан болсон интернэт амьдралд нэвтэрснээр хүмүүсийн өдөр тутмын харилцааны хэлбэр өөрчлөгдөж байна. Интернэтийн ачаар бид хормын дотор дэлхийн хаана ч хэнтэй ч холбогдох, харилцах, товчлуур дээр нэг дараад л хэрэгтэй мэдээллээ хүлээн авах, түгээх боломжтой болсон юм.

³³ МУИС, ШУС, ХУС-ын ГХТөв, ахлах багш

³⁴ МУИС, ШУС, ХУС-ын ГХТөв, ахлах багш

Даяаршсан дэлхийд олон улсын харилцаа, улс төр, нийгэм эдийн засаг, соёл урлаг, шинжлэх ухаан, техник технологи болон бусад олон салбарын харилцааны ‘лингва франка’ нь англи хэл болсон (Н.Бэгз, Д.Наран, Ж.Долгормаа, 2005:33). Англи хэлийг “даяаршлын хэл” гэж нэрлэж болохоор болжээ. Өнөөдөр дэлхийд 1 тэрбум 212 сая хүн англиар ярьдаг, олон улсын байгууллагуудын 85 хувь нь уг хэлийг албан ёсны хэлээ болгосон, шинжлэх ухааны бүтээл, хэвлэлийн 90 хувь нь англи хэлээр нийтлэгдэж байна. Дэлхийн өнцөг булан бүрийг бараг бүхэлд нь холбож буй интернэтийн орчинд харилцахад хамгийн хялбар, энгийн учраас англи хэлийг өргөнөөр ашигладаг гэдэг. Испанийн Овиедогийн их сургуулийн дэд профессор Фернандез Косталез Альберто “Даяаршил ба орчуулга” судалгааны өгүүлэлдээ “англи хэл интернэтийн хэл болоод байгаагийн учир нь Америкийн технологийн компаниудын нөлөө” гээд В.Г.Хэйворд, К.Тонг нарын судалгаагаар хэрэглэгчдийн ихэнх нь интернэтээс өөрийн эх хэлээр мэдээлэл авахыг хүсдэг гэсэн дүн гарсныг дурдах нь зүйтэй. Үүнээс үзэхэд, англи хэлнээс тус тусын эх хэлнээ орчуулах хичнээн их материал интернэтэд байгаа нь тодорхой” гэж тэмдэглэжээ (Alberto Fernandez, 2011:3). Дээр дурдсан жишээнээс харахад л англиас бусад хэлээр харилцагч улс орон, хүмүүс, байгууллагад даяаршсан дэлхийтэй хөл нийлүүлэн алхахад нь орчуулга ямар их чухал үүрэгтэй болох нь тодорхой харагдаж байна.

Цаашдаа орчуулгын салбарын өнөөгийн байдал, тулгарч байгаа асуудлыг даяаршил, техник технологийн, хөгжил дэвшилтэй холбож судлах ажлыг өргөжүүлэх нь уг салбарын хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход хувь нэмэр болох биз ээ.

Технологийн дэвшил ба даяаршлын харилцан хамаарал

Олон улсын валютын сан 2018 онд дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор нэгэн судалгаа явуулжээ. Судалгаагаар “улс орнуудын хооронд технологи дамжихад даяаршил онцгой чухал нөлөө үзүүлж байна” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна (blogs.imf.org.2018).

Өнөөдөр даяаршил, интернэтийн нөлөө хүрээгүй салбар бараг үгүй болжээ. Ажил хэргийн ертөнцөд даяаршил, интернэт эрс өөрчлөлт авч ирсэн. Дэлхийн бөмбөрцгийн хоёр талд байгаа хүмүүс хажуу дэргэд байгаа мэт харилцах болов. Интернэтээр худалдаа арилжаа хийх боломжтой болсноор буурай ядуу орны жижиг аж ахуйн нэгж ч, өндөр хөгжилтэй орны хүчирхэг корпораци ч бүгд нэг дэвжээнд гарч ирэв. Интернэт, техник, технологийн дэвшлийн ачаар цаасны ажил багасаж, тээвэрлэлтийн зардал буурч, олон улсын худалдаа эрчимжив. И-мэйл буюу цахим шуудан ажил хэргийн харилцаанд чухал байр суурь эзэлдэг болов.

Мэдээллийн техник технологийн хөгжил дэвшлийн ачаар амьдралын хэв маяг эрс өөрчлөгдсөн. Өнөө цагт бид интернэтийг ном, сонин, сэтгүүл, нийтлэл унших, гэр бүл, найз нөхөд, хамт олон, бизнесийн хамтрагчдаа мэдлэг мэдээллээ дамжуулах, янз бүрийн асуудлаар ярилцах, санал солилцох, маргаан мэтгэлцээн өрнүүлэх, хурал, уулзалт, зөвлөгөөн, семинар зохион байгуулах, хамрагдах, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх аргуудад суралцах, сургах, бараа бүтээгдэхүүн борлуулах, худалдан авах, зар сурталчилгаа байршуулах, төлбөр тооцоо хийх, мөнгө шилжүүлэх зэргээр өргөн хүрээнд ашиглан цаг хугацаа, хөрөнгө хүчээ хэмнэж, ажлаа хурдан шуурхай хийж гүйцэтгэж байна. Технологийн компаниуд хэрэглэгчдийнхээ харилцааг идэвхжүүлэхэд анхаарч Фэйсбук, Твиттер, Инстаграм зэрэг нийгмийн сүлжээг нэвтрүүлсэн нь цахим ертөнц мэдээллийн урсгалыг эрчимжүүлэв.

Цахим ертөнцөд ололт амжилтын зэрэгцээ саад бэрхшээлүүд ч их байна. Улс орон, байгууллага, хувь хүний мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учруулан, нууц мэдээлэл, ажил, алба, бизнесийн үнэтэй чухал мэдээлэлд нь хууль бусаар нэвтрэх, хулгайлах, өөрчлөх, устгах, бусдад дамлан зарах зэрэг ноцтой гэмт үйлдлүүд гарах боллоо. Сүүлийн үед хүчирхийлэл, садар самуун байдалд уриалан дуудсан агуулгатай зураг, дүрс бичлэг тараах, хэн нэгний нэр хүндийг унагаах, гутаан доромжлох зорилгоор зураг, бичлэг, хуурамч мэдээ мэдээлэл нийтлэх, бусдыг залилан мэхлэх гэх мэт гэмт үйлдэлдээ цахим сүлжээг ашиглах нь нэмэгджээ.

Энэ нь нэг талаас хууль сахиулах байгууллагын хараа хяналт сул, нөгөө талаас хувь хүний ухамсар, ёс суртахуун сул дорой байгаатай шууд холбоотой юм. Интернетэд улсын хил хязгаар гэж байхгүй учир мэдээ мэдээллийн аюулгүй байдлын асуудал болоод ёс зүйн хэм хэмжээ нь нэг байгууллага, нэг бүс нутаг, нэг улсын асуудал биш, дэлхий нийтэд тулгамдаад буй асуудал болон хувираад байна.

Орчуулгын салбарын хөгжилд даяаршил, технологийн хөгжлийн нөлөө

Дээр өгүүлсэнчлэн даяаршил бол орон зай, цаг хугацааны саадгүй харилцаа юм. Ийм харилцааг бий болгоход интернэт чухал үүрэг гүйцэтгэдэг. Харилцаа холбоо сайжирч мэдлэг мэдээллийн урсгал эрчимжинэ. Мэдээллийн солилцоог амжилттай явуулахад орчуулга “гол зуучлагч”-ийн үүрэг гүйцэтгэдэг. Ирландын их сургуулийн эрдэмтэн Майкл Кронин “Даяаршил ба орчуулга” бүтээлдээ ‘орчуулга бол даяаршлын салшгүй хэсэг’ гэж тодорхойлсон байна. (Michael Cronin, 2003:42)

Мэдлэг мэдээллийн урсгал, солилцоо даяаршил, интернэтийн ачаар эрчимжсэн учир орчуулгын эрэлт маш их нэмэгдсэн. Ийм нөхцөлд орчуулгын салбарт ямар өөрчлөлт гарч байгаа тухай эрдэм шинжилгээ, судалгааны хэд хэдэн өгүүлэл, эрдэмтдийн бүтээлийг судалж харьцуулаад дараах дүгнэлтэд хүрлээ.

Хэдэн жилийн өмнө олон гадаад хэл мэддэг, олон салбарын орчуулга хийдэг мэргэжилтэн хамгийн шилдэгт тооцогдож байсан бол өнөө цагт нөхцөл байдал өөрчлөгдөж салбараар дагнан мэргэших нь орчуулгыг мэргэжлийн түвшинд найдвартай, чанартай гүйцэтгэх баталгаа болж байна.

Өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, орчуулагчийн ажлын ачааллыг хөнгөвчлөх, хурдан шуурхай ажиллахад дэмжлэг болгон машины орчуулга, орчуулгын програм хангамжийг ашигладаг боллоо. Цаашдаа орчуулгын салбарт хиймэл оюун ухаан идэвхтэй нэвтэрч, машины орчуулга, орчуулгын программ хангамж улам боловсронгуй болох байх.

Өнөө үед бараг бүх ажил үйлчилгээг “зэрэгцээ ачаалах, түгээх, илгээх, хүргэх, нийлүүлэх” гэх зарчмаар явуулах болсон нь орчуулгын салбарын хөгжлийн чиг хандлагад нөлөөлж байна. Үүний улмаас бичгийн болон аман орчуулгын зааг ялгаа ч бараг үгүй болж байна, орчуулах, хянан тохиолдуулах, бичих, ярих, техник технологи ашиглах, хэрэглэгчийнхээ үндэс угсаа, хэл соёлын онцлогт тохируулан хүргэх мэдээллийнхээ агуулга, хэмжээг тохируулах гэх мэт хэд хэдэн ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэж байгаа учир “орчуулагч” гэж нэрлэх боломжгүй, шинэ төрлийн мэргэжил бий болж байгаа тухай Минако О’Хаган, Дэвид Ашворт 2002 онд хэвлэгдсэн “Цахим ертөнц дэх орчуулгаар дамжсан харилцаа” номондоо дурьдсаныг Английн Уорвикийн их сургуулийн профессор Сюзан Баснет “Орчуулга” номондоо иш татсан байдаг (Susan Bassnett, 2014:125).

Энэ өнцгөөс харвал улам бүр хурдтай өөрчлөгдөж байгаа даяаршсан ертөнц, зах зээлийн шинэ нөхцөлд дасан зохицохын тулд орчуулагч шинэчлэл, хөгжил дэвшлээс хоцрохгүй, мэдлэг мэргэжлээ дээшлүүлж байх шаардлагатай болж байна. Испанийн Овиедогийн их сургуулийн дэд профессор Альберто Фернандес Косталес “Даяаршлын эрин үед орчуулгын салбарт тулгарч буй сорилт бэрхшээлүүд” эрдэм шинжилгээний өгүүлэлдээ “цахим хэрэглэгчид мэдлэг мэдээллээ хурдан шуурхай солилцох хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр орчуулгын эрэлт улам бүр өссөн”. Улмаар орчуулахуйн шинэ үзэгдэл болох “сонирхогчийн тайлбар орчуулга (fansubbing), “гүйлгэж уншаад гол утгыг тоймлон орчуулах” (scanlations or romhacking) арга дэлгэрсэн” тухай жишээгээр тайлбарласан байна. “Сонирхогч орчуулах материалынхаа ерөнхий агуулгыг ойлгох, ойлгуулахад анхаардаг, орчуулсан агуулга мэдээллээ бусад хэрэглэгчидтэй шууд солилцдог учраас түүнийг хянах, алдааг засаж шүүх боломжгүй, тийм шаардлага ч байхгүй. Гүүгл, Фэйсбүк зэрэг томоохон компаниуд цахим сайтууд болон зарим программынхаа агуулгын орчуулгад сонирхогч орчуулагч нарыг оролцуулдаг. Үүний зэрэгцээ машин, автомат орчуулгын программ нэвтрүүлснээр хэрэглэгчид хүссэн мэдээллээ орчуулж ерөнхий утгыг нь ойлгох боломж олгодог.

Ерөнхийд нь авч үзэхэд цахим орчинд материалын ерөнхий агуулга утгыг тоймлон орчуулах арга зонхилж байна” гэжээ (Alberto Fernandez, 2011:4).

“Раутлэж” хэвлэлийн компаниас 2021 онд хэвлүүлээд байгаа Барселоны Их Сургуулийн Нийгмийн ухааны Тэнхимийн дэд профессор Эсперанта Биелса, Лондоны Роухамптоны Их Сургуулийн ахлах багш Дионисиос Капсакис нар хамтран эмхэтгэсэн “The Routledge Handbook of Translation and Globalization” хэмээх бүтээлд орчуулга даяаршлыг бий болгож байгааг, нөгөө талаас даяаршил нь орчуулгын салбарыг яаж өөрчилж байгааг онолын талаас өргөн хүрээнд авч үзсэн байна. Мөн Шинэ Зеландын Окландын Их Сургуулийн Хэл шинжлэл, Соёл Судлалын Сургуулийн доктор Минако О’Хаган эмхэтгэж, хянан тохиолдуулсан “The Routledge Handbook of Translation and Technology” номонд технологийн болон орчуулгын салбарын сүүлийн үеийн хөгжил дэвшил, шинжлэх ухааны бусад салбарын хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа талаар эрдэмтэд судлаачид тус тусын судалгааны чиглэлийн хүрээнд тайлбарлажээ. Ийнхүү эрдэм шинжилгээ, судалгааны олон бүтээлийг харьцуулан судалж өнөөгийн бодит байдалтай уялдуулан дүгнэхэд орчуулга, даяаршил, технологи нь харилцан бие биенийгээ хөгжүүлдэг, нэг нь нөгөөгүйгээр орших боломжгүй салбарууд болжээ.

Орчуулах чадвар эзэмшүүлэх хэрэгцээ, шаардлага

Даяаршил, ардчилал Монгол оронд олон өөрчлөлт авч ирсэн юм. Эдийн засаг, бизнесийн хөгжил хүрээгээ тэлэхэд нь тээг болж байсан үзэл суртлын саад арилж, Монгол Улс дэлхийн бусад улс орнуудтай олон салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж эхэлснээр түгээмэл гадаад хэл, ялангуяа англи хэлний хэрэглээ өсөн нэмэгдэж байна.

Монгол Улс боловсролын салбартаа өөрчлөлт хийж, бүх шатны сургуульд англи хэл заах болсон билээ. Орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн сургуулиас бусад нь ярианы чадвар эзэмшүүлэхэд анхаардаг. Хэлний мэргэжлийн бус сургуулиудад заах англи хэлний багц цаг хангалтгүй, хоёроос гурван улиралд сургалтын агуулга, монгол хүний сэтгэлгээний ялгаатай байдал, эзэмшиж буй мэргэжлийн онцлогт тэр бүр тохироогүй сурах бичгээр англи хэлний сургалтаа явуулдаг гэхэд хилсдэхгүй. Жишээ нь: МУИС-ийн англи хэлний сургалтад Америк, Англи, Канад зэрэг англи хэлээр ярьдаг оронд их, дээд сургуульд суралцах оюутанд зориулсан сурах бичиг ашигладаг.

Их, дээд сургуульд суралцах хугацаандаа оюутан англи болон бусад гадаад хэлээр бичигдсэн ном, сурах бичиг, цахим эх сурвалж ашиглах хэрэгцээ шаардлагатай өдөр бүр шахам тулгарна. Орчуулах чадвар эзэмшээгүй, гадаад хэлний мэдлэг дулимаг бол тэд голдуу орчуулгын товчоонд хандана. Эсхүл “Google translate” ашигладаг. Энд хөндсөн асуудалд шууд нотолгоо болж чадахгүй ч бодит байдлын жишээ болгож “Хил Хязгааргүй Боловсрол” Нийгэмлэгийн дэргэдэх орчуулгын товчоогоор үйлчлүүлсэн хэрэглэгчдийн талаарх судалгааны дүнгээс заримыг нь энд дурдъя. “Тус товчоо 2007 онд байгуулагдсан бөгөөд өнөөг хүртэл 14 жилийн хугацаанд нийтдээ 20000 гаруй хэрэглэгч тус товчоогоор үйлчлүүлсний 92 хувь нь оюутан байжээ. Орчуулах захиалгыг ангилахад ихэнх нь улс төр, эдийн засаг, нийгэм, техник, технологи, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, уул уурхай, аялал жуулчлал, спорт, анагаах ухааны чиглэлийн англи, орос хэлээр хэвлэгдсэн ном, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээ судалгааны бүтээл, гарын авлагаас авсан академик бичвэрүүд байжээ.” (“Хил Хязгааргүй Боловсрол” Нийгэмлэгийн дэргэдэх орчуулгын товчоо: 2007-2020 тайлан)

Их, дээд сургууль төгсөгчдийн заримынх нь хувьд ажил хөдөлмөр эрхлэхэд нь англи хэл өдөр тутам хэрэг болохгүй. Гэхдээ дийлэнхэд нь англи болон аль нэг түгээмэл гадаад хэлээр бичигдсэн бичиг баримт ашиглах, боловсруулах дүн шинжилгээ хийх, цахим сүлжээний орчинд ажиллах, мэдээ материал цуглуулах, хамтран ажилладаг гадаадын байгууллагатай харилцах хэрэгцээ бараг өдөр тутам гарч орчуулах чадвар зайлшгүй шаардагддаг. Үүнийг илүү тодруулахын тулд дараах жишээг авч үзье.

Их, дээд сургууль төгсөгчдийн англи хэлний мэдлэгийн түвшин, чадварын талаар ажил олгогчдын дунд 1990 оноос QS Global Employer судалгаа явуулж эхэлжээ. 2016 оны судалгаанд дэлхийн 38 орны 20 салбарын 5,373 ажил олгогч оролцсон байна. Судалгааны дүнгээс үзэхэд, “ажилтнуудын англиар уншиж, ойлгох чадвар өндөр байх ёстой гэж нийт оролцогчдын 43 хувь нь, харин 35 хувь нь ярих чадвар сайн байх хэрэгтэй гэжээ. Улс орноор авч үзвэл, Европ тивийн Бельги, Франц, Герман, Португал, Орос, Украин зэрэг оронд ажилтнууддаа англиар уншиж ойлгох өндөр чадвартай байх шаардлага тавьдаг. Харин Итали, Испани, Швейцарьт англи хэлний ярианы өндөр чадвартай байх нь чухалд тооцогддог ажээ. Азийн орнуудаас Гонконг, Япон, Өмнөд Солонгост ажилтнууд нь англи хэлээр уншиж ойлгох чадварыг чухалчилдаг бол харин Хятадад англиар ярих чадвартай байхыг шаарддаг” (QS Global Employer Survey Full Report, 2016: 5-12) гэсэн дүн гарчээ.

Манай улсын хувьд ч олон улсын ийм төрлийн судалгаанд оролцох, эсхүл, дотооддоо үүнтэй адил дорвитой судалгаа зохион байгуулж гадаад хэл, ялангуяа англи хэлний сургалтын чанар, эрэлт хэрэгцээгээ тодорхойлох нь зүйтэй. Даяаршсан дэлхийд улс түмнүүдийн харилцаа, хамтын ажиллагаа эрчимжиж, техник, технологийн дэвшлийн ачаар нийгмийн бүх салбарын мэдлэг мэдээллийг дамжуулах, солилцох боломж бүрдсэн энэ цаг үед бүх шатны гадаад хэлний сургалтын хөтөлбөрөө шинэчлэх, үүнтэй уялдуулан ном, сурах бичиг боловсруулах хэрэгтэй байна.

Дүгнэлт

Өнөө цагт ажил хэргийн ертөнцөд чөлөөтэй харилцах, мэдлэг мэдээлэл солилцох, дамжуулах, хөгжиж дэвжих, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхъя гэвэл гадаад хэлээр ярих, бичих, мөн тухайн гадаад хэл, эх хэлний хооронд орчуулах тодорхой түвшний дадал чадвар эзэмшсэн байх хэрэгтэй болоод байна. Хүн бүр орчуулагч болох албагүй ч орчуулгын анхан шатны мэдлэг эзэмших зайлшгүй шаардлагатай. Салбар тус бүрийн орчуулагч бэлдэх дагнасан сургалтын хөтөлбөртэй болох нь зүйтэй. Энэ өгүүлэлд дурдагдаагүй ч яригдаж байгаа сэдэвт хамаатай нэг асуудал бол эх хэл, соёлын дархлаа, аюулгүй байдал юм. Хэрвээ их, дээд сургууль төгсөгчид орчуулах чадвар эзэмшихвэл гадаад хэлнээс монгол хэлнээ алдаагүй зөв орчуулж, тэр хэрээр эх хэл, соёлынхоо дархлааг хадгалж, хамгаална гэсэн үг. Дэлхийн улс орнуудтай чөлөөтэй харилцах аваас гадаад харилцаа өргөжнө. Гадаад харилцаа өргөжин тэлснээр улс эх орон маань цэцэглэн хөгжинө гэсэн үг юм.

Ном зүй

Монгол хэлээр

1. Гүрбазар Р. (1996), Орчуулгын онол дадлагын асуудал. УБ.
2. Цэвэл Я. (1966), Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
3. Жаргал Ж.(2016), Даяаршлын үеийн Монголын нийгэм ба соёлын хөгжлийн асуудал. УБ
4. Бэгз Н. Наран Д. Долгормаа Ж. (2005) Гадаад хэлний сургалтын өнөөгийн байдал, цаашдын зорилт– “Төрөөс баримтлах хэлний бодлогын асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурал. х.33
5. Хил Хязгааргүй Боловсрол Нийгэмлэгийн дэргэдэх орчуулгын товчоо: 2007-2020 тайлан

Гадаад хэлээр

1. Bielsa E. Bassnett S. (2009), Translation in global news
2. Venuti L. (2012), The Translation Studies Reader
3. Munday J. (2008), The Routledge Companion to translation studies. London, New York
4. Cronin M. (2003), Globalization and translation. London, New York
5. Bassnett S. (2014), Translation. London, New York
6. Fernandez C. (2011), Translation 2.0: facing the challenges of the global era
7. Bielsa E. Kapsaskis D. (2021), The Routledge Handbook of Translation and Globalization, London, New York
8. Minako O'Hagan (2020), The Routledge Handbook of Translation and Technology, London, New York
9. Cambridge English (2016) English at Work: global analysis of language skills in the workplace

Цахим эх сурвалж

1. Merriam-Webster.com Dictionary, Merriam-Webster, <https://www.merriam-webster.com/dictionary/diplomatic>. Accessed 20 March. 2020.)
2. blogs.imf.org.2018



ХЯТАД ХЭЛНИЙ ЦЭЭР ҮГИЙГ ОРЧУУЛАХ АРГА

Г.Элдэв-Очир³⁵, Muqier³⁶

Abstract: Taboo is an important and common phenomenon in which human beings use language consciously, and it is a form of language that people create to avoid taboos or to achieve better results in social interactions. China has historically been a country that values order. In ancient times, taboos were very common.

Түлхүүр үг: Цээр үг, табу, цээр үгийн орчуулга, утгачилах, үгчилэх

1. Цээр үгийн тухай

Цээр үг нь дэлхийн бүх хэлэнд хэрэглэгддэг түгээмэл үзэгдэл бөгөөд энэ нь хүмүүсийн аливаа зүйлийг шууд хэлэхээс зайлсхийх ухамсартай холбоотой бөгөөд нийгмийн харилцаанд зарим талаар нааштай үр дүн үзүүлдэг хэлний үзэгдэл болно. Цээрлэн нэрлэхүй нь “табу” буюу нэр цээрлэх ёсноос улбаалан бий болжээ. Табу гэж онцлон тэмдэглэсэн, ялгасан гэсэн утгатай полинезийн нэг үндэстний үг бөгөөд хэлний судлалд ямарваа нэгэн үгийг хэрэглэхийг цээрлэх, хорих ёсыг хэлдэг. (Пагва.Т, 1976:101)

Өрнөдийн эрдэмтэн, судлаачид эртнээс энэхүү цээрлэн нэрлэх үзэгдлийг судалж эхэлсэн агаад хамгийн анх 1780-аад онд английн эрдэмтэн George Blunt англи хэлэнд “euphemism” гэдэг үгийг хэрэглэж тодорхойлсон байдаг. Тэрбээр, “Euphemism is a good or favorable interpretation of a bad word” (邵军航, 2007:25) гэж тодорхойлжээ. Энэхүү “euphemism” нь грек хэлний “euphemos” буюу “eu-сайн, сайхан” “pheme-хэлэх, илтгэх” гэсэн үгнээс гаралтай бөгөөд утга нь англи хэлний “good speech” буюу “эвтэйхэн хэлэх” хэмээсэн үг ажээ. (“Гадаад хэл, соёл судлал”, МУИС, ЭШБ, 2017) Судлаачид энэхүү ойлголтыг өөр өөрөөр нэрлэсэн байдаг. Тухайлбал, “эерүүлэл”, “тойруулал”, “тойруу үг хэллэг”, “Евфемизм” гэх мэтээр тэмдэглэжээ.

Хэлний харилцааны явцад зарим тохиолдолд хүмүүс шууд хэлж, бичихээс зайлсхийх шаардлагатай үг хэллэг байдаг бөгөөд эдгээр үг хэллэг нь цээр үг болдог. Ийнхүү ярьж бичихэд эвгүй буюу цээрлэгддэг үгс нь “taboo” ажээ. Цээр үг нь бараг хэл үүссэн цагаас бий болсон гэж үздэг. Нэр цээрлэх явдал эрт дээр цагт хүмүүс байгалийн үзэгдлийг танин мэдээгүй, түүнийг ер бусын аймшигт хүчин гэж үзэж байсны үндсэн дээр гарчээ. Хүн төрөлхтний хөгжлийн нэлээд сүүлийн үед нэр цээрлэх явдал нь шашин шүтлэгтэй холбогдож ирсэн бололтой. (Т.Пагва “Хэл шинжлэлийн удиртгал”, 1976:101)

Тиймээс барууны орнуудад зарим хүмүүс хориотой зүйлийг “taboo” гэх үгээр төлөөлөн заадаг. Эртний Грекчүүд тахил өргөхдөө өлзийтэй үгс хэлэхийг шаарддаг байсан бөгөөд тэд бурхдад шууд хандаж нэрээр нь дуудахгүй, харин бурхантай ярихдаа цээр үгийн аргыг хэрэглэх, бурхдыг тайвшруулах, бурхдын анхаарлаас зайлсхийн, гамшиг ослоос сэргийлэх боломжтой гэж

³⁵ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, доктор

³⁶ МУИС, ШУС, ХУС-ын “Гадаад хэл шинжлэл” хөтөлбөрийн докторант

үздэг байсан. Иймэрхүү нөхцөл байдлын үндсэн дээр цээр үг үүсчээ. Нийгмийн хөгжлийг дагаад цээр үгийн хамрах хүрээ улам бүр өргөн болж, эрт дээр үеэс сүнс, бурхдыг цээрлэхээс эхлээд хүмүүсийн төрөлт, хөгшрөлт, өвчин, үхэл зэргийн талаар хориотой цээр үгс, улмаар улс төр, эдийн засаг болон амьдралын бүхий л үйл явдалд хэрэглэгдэх болжээ.

Цээр үг нь хүн төрөлхтний хэлний харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүмүүс үзэл бодлоо солилцох, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ цээр үг ашиглахгүй бол багагүй саадтай тулгарна. Энэхүү харилцааны саад бэрхшээлийг даван туулахад цээр үг туйлын чухал байдаг. Иймд судлаач Энрайт “Хэрэв цээр үг байхгүй бол хүн төрөлхтний харилцаа гацаанд орно. Улмаар хүний ертөнц үзэн ядалт, өшөө хорслоор дүүрэх болно” (邵军航, 2007:113) гэж хэлжээ. Харин тохиромжтой цээр үг хэллэг нь тогтвортой бөгөөд зохистой, эелдэг ёсорхог далд утга нь харилцаа холбоог саадгүй урагшлуулж чаддаг байна.

2. Цээр үгийн орчуулгын тухай

Эхийг гүнзгий ойлгосны дараа сая орчуулах ёстой. Ийнхүү орчуулах явцдаа орчуулгын зарчимуудыг баримтлан орчуулж буй хэлэнд аль болох тэнцүү байх буюу эквивалент илэрхийллийг олох шаардлагатай. Энэхүү зарчим нь цээр үгийг орчуулахад ч хамааралтай бөгөөд цээр үгийн орчуулгад орчуулагчийн авьяас чадвар, мэдрэмж туйлын чухал байдаг. Ерөнхийдөө цээр үгийн орчуулгад үгчилэн орчуулах арга, зүүлт тайлбартай үгчилэн орчуулах арга, утгачилан орчуулах арга, зүүлт тайлбартай утгачилан орчуулах арга зэрэг хэдэн аргыг ихэнхдээ хэрэглэнэ.

2.1 Үгчилэн орчуулах арга

Үгчилэн орчуулах арга нь ерөнхийдөө гурван нөхцөл байдлыг багтаана. Үүнд: 1. Эх хэл ба орчуулгын хэл нь ижил буюу ойролцоо цээр үгтэй байх тохиолдолд ийнхүү шууд орчуулж болно. 2. Орчуулгын хэлэнд ижил буюу төстэй цээр үг байхгүй боловч үгчилэн орчуулсаны дараа уншигчид хялбар ойлгох боломжтой байвал үгчилсэн орчуулгын аргыг хэрэглэж болно. 3. Эхэд буй цээр үгийн эерүүлсэн хэлбэр нь маш чухал бөгөөд түүний хэлбэрийг хэвээр хадгалахын тулд үгчилсэн орчуулгын аргыг ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд зүүлт тайлбартай үгчилсэн орчуулгын аргыг хэрэглэвэл илүү зохимжтой.

Цээр үгийг орчуулахдаа ерөнхийдөө орчуулгын хэлэн дэх харгалзах эерүүллийн хэлбэрийг хэрэглэн орчуулах шаардлагатай. Жишээ нь:

- 尤氏说：“他这些日子，不知怎么了，经期有两个月没有来，叫大夫瞧了，又说不是有喜。”(曹雪芹《红楼梦》第十一回)

- Ёу овогтон өгүүлрүүн: “Энэ хэдэн өдөр юу болсныг мэдэхгүй, түүний сарын хир хоёр сар ирсэнгүй. Домч залан үзүүлсэн ч аанай л аз жаргалтай болоогүй байна гэсэн.” (Цао Шюэчиний “Улаан асрын зүүд” зохиолын 11-р бүлэг)

Энэхүү жишээнд “сарын хир” ба “аз жаргалтай болох” гэсэн хоёр цээр үг байна. Монгол, хятад соёлд хоёуланд нь “сарын хир”-ийг бохир зүйл гэж үздэг бөгөөд жирэмслэхийг мөн “аз жаргалтай болох” гэсэн тойруу утгаар цээрлэн хэлжээ. Тиймээс монгол, хятад хэлний эдгээр үгс ойролцоо тул шууд үгчилэн орчуулахад харшлах зүйлгүй байна. Үүнээс гадна, орчуулгын хэлэнд эх хэлтэй тохирох цээр үг байхгүй ч гэсэн бид үгчилсэн орчуулгын аргыг уншигчийн ойлголтод нөлөөлөлгүйгээр хэрэглэх боломжтой.

2.2 Зүүлт тайлбартай үгчилэн орчуулах арга

Үгчилсэн орчуулгын өөр нэгэн арга бол эх бичвэрийн онцлог шинж чанарыг хэвээр хадгалах, эсвэл, эхийн түвшинд нийлэмжтэй байдлыг хангахын тулд энэхүү зүүлт тайлбартай үгчилсэн орчуулгын аргыг хэрэглэх хэрэгтэй. Зарим тохиолдолд эхэд буй цээр үг нь түүх соёл, үлгэр, домог зэрэгтэй холбоотой мэдээлэл агуулдаг тул орчуулгад зүүлт тайлбар оруулах шаардлага тулгардаг. Эхэд буй цээр үгтэй дүйцэхүйц байдлыг хадгалах, эх хэлний соёлын утгыг дамжуулахын тулд бид зүүлт тайлбартай үгчилсэн орчуулгын хэлбэрийг хэрэглэх ёстой. Жишээ нь:

- 宝玉道：“一言难尽。”说着便把梦中之事细说与袭人听了。然后说至警幻所授云雨之情，羞的袭人掩面伏身而笑。宝玉亦素喜袭人柔媚娇俏，遂与袭人同领警幻所训云雨之事。（曹雪芹《红楼梦》第六回）

- Баоюй: “Нэг үгээр хэлэхэд хэцүү” гэж хэлэхдээ тэр зүүдэлсэн зүйлийг нарийн тайлбарлан, Ши Рэньд сонсгожээ. Дараа нь үүл, борооны явдлын талаар ярьсан бөгөөд Ши Рэнь ичиж нүүрээ дарж инээв. Баоюй нь Ши Рэний уян зөөлөн, дур булаам байдалд тачаадсан тул Ши Рэньтэй үүл, борооны явдлыг үйлджээ. (Цао Шюэчиний “Улаан асрын зүүд” зохиолын 6-р бүлэг)

“Үүл, борооны явдал” нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бэлгийн харьцааны тухай эерүүлсэн илэрхийлэл болно. Энэхүү хэллэг нь Сүн Юйгийн “Гао Тан магтуу”-нд байдаг нэгэн домгоос үүдэлтэй ажээ. Орчуулгын хэл нь уншигчдад ойлгомжтой байх ёстой тул зарим тохиолдолд зүүлт тайлбартай үгчилсэн орчуулгын арга нь зохимжтой байдаг.

2.3 Утгачилан орчуулах арга

Утгачилан орчуулах арга нь гурван нөхцөл байдлыг агуулдаг. Үүнд: 1. Эх хэл соёлд цээрлэсэн зүйл орчуулгын хэл соёлд байхгүй буюу цээрлэдэггүй тохиолдолд, орчуулах хэлэнд түүнтэй дүйцэх цээр үг олдохгүй. Харин үүнийг үгчилэн орчуулахад уншигчдад төдий л ойлгомжтой бус байвал эх зохиолын цээр үгийн утгыг орчуулгын хэл рүү утгачилан орчуулна. 2. Орчуулгын хэлд ижил төстэй цээрлэсэн үг байх хэдий ч тухайн цээрлэсэн юм үзэгдэл нь ялгаатай буюу өнгө аяс нь өөр байх тохиолдол байж болно. Иймд утгачилан орчуулах аргаар утга санааг нь буулгаж болно. 3. Эх хэлний цээрлэсэн үгийн эерүүлсэн хэлбэр өөр байх үед орчуулгад яг тэр хэвээр буулгах аргагүй тохиолдолд утгачилан орчуулаад зүүлт тайлбар хийж болно. Жишээ нь:

- 贾母听了，忙问：“怎么了？”二鬟回答说：“南院马棚子里走了水了。不相干，已经救下了去了。”(曹雪芹《红楼梦》第三十九回)

- Жягийн ээж сонсчихоод тэр даруй: “Юу болсон бэ?” гэж асуухад, Эрхуань хариуд нь: “Урд хашааны морины жүчээнд ус орчихлоо. Гэхдээ зүгээрээ, нэгэнт аврагдсан байна.” (Цао Шюэчиний “Улаан асрын зүүд” зохиолын 39-р бүлэг)

“Ус орох” гэдэг нь “гал гарах” гэсэн утгатай цээр үг болно. Хятад хэлний энэхүү цээр үгийн эерүүлэл нь эсрэг утгаар цээрлэх арга бөгөөд ийм арга хятад хэлэнд мөн түгээмэл байдаг ажээ.

2.4 Зүүлт тайлбартай утгачилан орчуулах арга

Зүүлт тайлбартай үгчилсэн орчуулга ба зүүлт тайлбартай утгачилан орчуулах аргын ялгаа нь: 1. Эхнийх нь уншигчдад тухайн эх зохиолд буй цээрлэсэн хэлбэрийг тэр хэвээр нь ойлгуулахын тулд хэлбэрийн дүйцэх байдлыг хадгалахад голлон анхаардаг бөгөөд зүүлт тайлбарт цээр үгийн цаад мэдээллийг нэмж оруулдаг 2. Нөгөө нь уншигчид үгчилсэн орчуулгыг ойлгох боломжгүй буюу орчуулагч нь цээр үгийг утгачилан орчуулах тохиолдолд, цаад соёлын мэдээллийг хадгалахын тулд зүүлт тайлбар оруулах шаардлагатай болно.

Энэхүү өгүүлэлд цээр үг орчуулгын аргуудыг голчлон авч үзсэн болно. Ерөнхийдөө цээр үгийн орчуулгад үгчилэн орчуулах арга, зүүлт тайлбартай үгчилэн орчуулах арга, утгачилан

орчуулах арга, зүүлт тайлбартай утгачилан орчуулах арга зэрэг хэдэн аргыг хэрэглэнэ. Цээр үгийн харьцуулсан судалгаа, орчуулгын явцад гарах бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар цаашид гүнгийрүүлэн судалбал орчуулгазүйд чухал хувь нэмэртэй болох нь харагдаж байна.

Ашигласан номзүй

“Гадаад хэл соёл судлал”, МУИС, ЭШБ, 2017

Пагва.Т, Хэл шинжлэлийн удиртгал, 1976

陈章国.2000.英语委婉语的出典、理解和汉译[J].宁波大学学报(人文社科版)

从莱庭等.2001.英语婉语详解词典[Z].武汉：湖北教育出版社.

李国南-2001.词格与词汇：M].±海：上海外语教育出版社.

邵军航：《委婉语研究》，中国博士学位论文全文数据库 2007 年



“ТОЛОГДСОН ХҮҮХЭН” ЗОХИОЛЫН “АВАХ” НИЙЛЭМЖ ҮГ ХИЙГЭЭД ТҮҮНИЙ ХЯТАД ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

Д.Алтантуяа³⁷

Abstract: This study analyzed the observation and classifications of the collocation words like ‘noun +take’ and ‘verb +take’ used in the short story “The Rejected Girl” by Damdinsuren Tsend, the Mongolian famous writer. In doing so, we have made semantic and lexical analyses on the frequencies and meanings of those collocation words at the level of translation.

Түлхүүр үг: нийлэмж үг, давтамж, утга, хятад орчуулга

Гадаад хэлийг суралцагч, судлаач, орчуулагчид эх хэл болон тухайн суралцаж буй хэлний үг, нийлэмж үгийг хэрхэн дүйлгэж орчуулахтай давын өмнө нүүр тулгарч байдаг. Өөрөөр хэлбэл, зохиол нь өгүүлбэрээс бүтэж, орчуулгад өгүүлбэр нь үндсэн нэгж болдог бол харин өгүүлбэрийг бүрэлдүүлэгч үг хийгээд нийлэмж үгийн орчуулга бол орчуулга зүйн үндсэн асуудлын нэг болдог. Энэ тухай орчуулагч Г.Аким (1984:14-15) “аливаа зохиолыг орчуулахад дүйлгэх асуудлыг гурван түвшинд авч үзэх хэрэгтэй болдог.

1. Үг, нийлэмж үгийн түвшинд нийцэж байх
2. Өгүүлбэрийн түвшинд тохирч байх
3. Бүх л зохиолын түвшинд тохирч байх

Энэ 3 зарчмыг хослуулан, нягт нэгдэлтэй хэрэглэж чадвал орчуулга эх зохиолтойгоо жинхэнэ ёсоор дүйж, үндэсний утга зохиолын үзэгдэл болдог нь манай ахмад орчуулагчдын бүтээлээс харагдаж байна” гэж томъёолсон нь ч учиртай.

Эх хэлнийхээ зүй тогтол, хэл зүйн бүтэц, үгийн гүн утга санааг ойлгон ухаарсны үндсэн дээр нэгдмэл нэгэн утга санаа илэрхийлэх нийлэмж үгсийг гадаад хэлнээ сая бүрэн орчуулж чадна.

Монгол хэлний нийлэмж үг хэмээх нэр томъёог 1960-аад оны эхээр монгол хэл шинжлэлд хэрэглэж, тухайн хэлний хэл зүйгээр хоёр буюу түүнээс дээш үгийг хооронд нь хэлхэж нэгэн нэгдмэл цогц ухагдахууныг илтгэн нэрлэдгийг нийлэмж үг гэнэ хэмээн тодорхойлжээ (Д.Бадамдорж, 2001:24).

Монгол хэлний үйл үг нь өгүүлбэрт бусад үгсийг захирах чадвар, үүрэг хэрэглээний хувьд илүү байдаг төдийгүй үйл үгийн чухал болохыг гадаад, дотоодын эрдэмтэд онцлон тэмдэглэж, тусгайлан судалсаар ирсэн бөгөөд бидний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгддэг үйл үгийг сонгохын тулд “Одоо үеийн монгол хэлний үгийн давтамжийн толь”-оос үзье. Д.Баатар, Б.Журамт нар уг толио хэлний материалын цахим санд тулгуурлан, үгийн давтамжийг тооцоолон гаргасан бөгөөд “авах” үйл үг нь 4775 удаа давтагдаж, монгол хэлний бүх үгийн жагсаалтын 17-рт орж, хамгийн өндөр давтамжтай үг болохыг (Д.Баатар, Б.Журамт, 1998:4) тогтоожээ. Хамгийн

³⁷ Ph.D, Дорнод их сургууль, Нийгэм хүмүүнлэгийн ухааны тэнхим

их давтамжтай буюу идэвхтэй үгс нийлэмж үг үүсгэх чадамж, хэрэглээ өндөртэй болохыг үүнээс харж болно.

Эрдэмтэн М.Базаррагчаа “ав” хэмээх үйл үгийн утгын хувилбарыг авч үзээд “энэ үг нь нэгдүгээрт “өөрийн болгон эзэмших буюу авах”, “өөрийн болгон эзэмшихгүй буюу салгах” гэсэн үндсэн хоёр хувилбартай болон сална. Ингэж “ав” гэдэг үг маань “авах-эзэмдэх”, “авах-салгах” гэсэн эсрэг утга бүхий үндсэн 2 хувилбартай болж байна” (М.Базаррагчаа, 1978:70-76) гэжээ.

Судлаач Ч.Баттөгс “монгол хэлний “авах” хэмээх үйл үг нь төрөл бүрийн холбоцоор нийлэмж үүсгэж, хорь гаруй салаа утга илэрхийлж байна” (Ч.Баттөгс, 2003:43) гэж үзсэн байна.

Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг, төрийн гурван удаагийн шагналт, ардын уран зохиолч, орчуулагч, академич Цэндийн Дамдинсүрэн 1929 онд уран зохиолын анхны бүлгэм байгуулахад оролцож “Гологдсон хүүхэн” зохиолоо туурвисан нь монголын орчин үеийн анхны богино хэмжээний туужид тооцогддог төдийгүй дэлхийн олон хэлээр орчуулагдан хэвлэгдсэн байдаг. Түүний нэгэн орчуулгын жишээ болох хятадын орчуулагч Жан Юйюань (张玉元) тэртээ 1961 онд орчуулсан “被抛弃的姑娘” бөгөөд одоогоор хятад хэл дээр өөр хувилбар орчуулга гараагүй байна. 2017 онд хятад судлаач, эрдэмтэн Г.Цогзолмаа түүний орчуулсан “Цэндийн Дамдинсүрэн: Түүвэр зохиол” хэмээх бүтээлийг олны хүртээл болгосноор хятад орчуулгын хамт тулган үзэхийн сацуу орчуулгын судалгааны чухал бүрэлдэхүүн хэсэг болж, хэв шинжийн судалгаа хийх аятай боломжийг бүрдүүлсэн билээ.


“Авах” үгийн утгалбар буюу нийлэмж үүсгэх чадамжийн тухай гаргасан бүтээл буй болсоор авч тухайн нэг зохиол бүтээлийн түвшинд нийлэмж үг хийгээд орчуулга зүйн талаас хийсэн судалгаа шинжилгээний ажил ихээхэн үгүйлэгдэж байгааг тэмдэглүүштэй. Ийнхүү бид Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” богино туужийг сонгон авч, “авах” нийлэмж үгийн “нэр + авах”, “үйл + авах” ангиллыг нарийвчлан, “авах” нийлэмж үгийн давталт, утгыг задлан шинжлэхийн зэрэгцээ нийлэмж үгийн орчуулгын түвшинд судлан авч үзсэн юм.

Нэг. “Гологдсон хүүхэн” зохиолын “авах” нийлэмж үгийн ангилал

“Утга судлаач, эрдэмтэн Д.Бадамдорж “Монгол хэлний утгасудлал-3” (Д.Бадамдорж, 2001:24) бүтээлдээ монгол хэлний нийлэмж үгийг захиран голлож буй үгээр нь төв болгож:

1. Нэр нийлэмж үг (нэр, нэр нийлэмж үг; үйл, нэр нийлэмж үг)
2. Үйл нийлэмж үг (үйл, үйл нийлэмж үг; нэр, үйл нийлэмж үг) хэмээн ангилжээ.

Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” зохиолд (Г.Цогзолмаа, 2017:118-164) “авах” нийлэмж үг 51 удаа орсныг түүвэрлэн, нэр, үйл нийлэмж үгийг бодит үг, хийсвэр үг гэсэн 2 бүлэгт хуваагдаж, бодит үг нь нэр үг, төлөөний үгээр илэрч, хам бүтцийн хүрээнд буюу тодорхой тохиолдолд тухайн бодит нэр үгийг товчлон хэрэглэж, хураах буюу эсвэл тухайн үгийн өмнө тодотгол гишүүний үүргээр орж буй задлаг бүтэц бүхий үг, тэмдэг нэр зэргээр төлөөлүүлсэн байна. Харин үйл, үйл нийлэмжийн хувьд дан үйл үгтэй, эсвэл, нэр болон үйл бүхий нийлмэл үгтэй хамт орсон бөгөөд дараах байдлаар дэлгэрүүлж ангилав.



Дээрх бүдүүвч зурагт дүрслэн үзүүлсэн “нэр + авах” нийлэмж үгийг тийн ялгалын нөхцөл, ерөнхийлөн хамаатуулахын нөхцөл, “үйл + авах” нийлэмж үгийг нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй хэрхэн хэлбэржиж байгааг хүснэгтээр тайлбарлан үзүүллээ.

Хүснэгт 1

Ангилал	Үгийн аймаг	Нэр, авах нийлэмж	Тийн ялгал		ЕХН	Давталт	Товчлон хураасан болон төлөөлүүлсэн үгс		
			Заах					Гарах	
			0	-ийг, -г, -ыг	-аас			-аа, -өө	
Бодит	Жинхэнэ нэр	хүүхэд	++	++			4		
		ус	++		++			4	
		үр	++	+				3	
		гэргий	+	+				2	
		хонь	+			+		2	
		эрих		+				2	
		үнээ		+				1	
		хүүхэн		+				1	
	эхнэр		+				1		
	Товчлон хураах	лав авах биз						1	хүүхдийг
		авах хүн олдохгүй						1	Цэрэнг
		Хэрэв эс авбал						1	хүүхдийг
		зарц нар авсан тул						1	ус
		хүн авчээ						1	эрихийг
	Төлөөлүүлэх	Хүү бүсгүй	+					1	хүүхдийг
		хэн дуртай				+		1	хүүхдийг
		хагас		+				1	хонийг
	Төлөөний үг	үүн		+			1		
Хийсвэр	Жинхэнэ нэр	санаа	++					2	
		Өшөө, өс	+			+		2	
		адис	+					1	
		амь	+					1	
		авшиг	+					1	
		сураг	+					1	

Хүснэгт 2

Анги лал	Үйл, авах нийлэмж	Нөхцөлдүүлэн холбох нөхцөл		Нийлэмж үгтэй хамт холбогдсон үгс	Давталт
		Зэрэгцэн холбох: -ж	Хамжин холбох: -н		
Үйл	Хулгайл-		+++	хар зандан эрихийг хулгана орж; чөдөртэй морь гүү хоёрыг; өөр юуг	3
	Үрчил-	++		Болдын; түүнийг	2
	Өргө-	+		Цэрэнг	1
	Хүлээ-	+		Бага сага өгөхөд	1
	Цөлбө-		+	юмыг	1
	Барь-		+	Зүй нь үүнийг даруй	1
	Сонго-	+		арваад хүүхдийг оросууд	1
	Хүзүүд-		+	гэж хашгиран	1
Нэр, үйл	Гэргий болго-	++		Доной; Аргагүйд өөрийн хүүдээ	2
	Эх барь-	+		Хүүхдийг төрөхөд	1

Хоёр. “Гологдсон хүүхэн” зохиолын “авах” нийлэмж үгийн утга

Юуны өмнө “Монгол хэлний их тайлбар толь”-д “авах” үгийн утгалбарыг хэрхэн тайлбарласныг авч үзье:

1. Аливаа юмыг өөрийн болгох, эзэмших
2. Хувцас, эд хэрэглэлийг гараар барьж тайлах, авч тавих, салгах
3. Өмгөөлөл, асрамждаа байлгах
4. Хүн, амьтны биеэс өвчилсөн зүйлийг нь салгах
5. Биенд ямар нэг согог суух
6. Сэрж мэдрэх
7. Хүч нэмэгдүүлэх сул үгийн үүргээр хэрэглэгдэнэ
8. Нэгэнтээ үйлдэн өнгөрөх санааг илэрхийлнэ
9. Нэр үгийн дараа орж тухайн юм буй болох утга илтгэнэ
10. Хамжих нөхцөлөөр хэлбэржин, гарахын тийн ялгалт үгтэй нийлэн, аливаа үйлийн эхлэх утга илэрхийлнэ.

“Нэгтгэн нийлүүлэх-авах” хувилбар бүхий утгад тус зохиолын “авах” нийлэмж үг бүгд орж байна.

Бүдүүвч зураг 2




Үрчилж авах, өргөж авах, хулгайлан авах, цөлбөн авах, сонгон авах, эх барьж авах, хүлээж авах, барин авах зэрэг “үйл, авах” нийлэмж үгээс бүтэж, хэдийгээр “авах” үйл үг нь тухайн үйлийн дагуух үүргээр хэрэглэгдэж байгаа ч гэсэн үүргээр нь бус утгаар нь “Үр хүүхэд өргөж авах”, “Өөрийн болгох, эзэмших, эрхшээлдээ оруулах” зэрэг утгын нэг ангилалд хамааруулан оруулсан болно.

Гурав. “Гологдсон хүүхэн” зохиолын “авах” нийлэмж үгийн хятад орчуулга

Монгол хэлний “авах” үгийг хятад хэлнээ орчуулахад “拿、取” гэж шууд бууна. Харин өөр өөр үгтэй холбогдож, “авах” нийлэмж үг бүхий нэгдмэл санаа илэрхийлснийг хятад хэлнээ оновчтой үгээр буулгах нь амаргүй ажил билээ.

Орчуулагч Жанной Юаний “авах” хэмээх тус зохиолын 51 нийлэмж үгийг орчуулсан байдалд хийсэн дүгнэлтийг дараах бүдүүвч зургаас харж болно.

Бүдүүвч зураг 3



1. “Авах” нийлэмж үгийг бүрэн дүйцэх үгээр орчуулсан – 4

Хүснэгт 3

№	“Авах” нийлэмж үг	Орчуулга
1	Хонь, хонио, хагасыг, гэргийг Жамц, цөлбөн, сонгож, хүний эхнэрийг авах	要……税、把……那七只羊给收下了、收受、喇嘛霸占去了、拿走了财务、抢走、要没出嫁的姑娘，不要媳妇
2	адис, амь, авшиг, сураг	接受了赐福、保住生命、受尽饥饿获和毒打、没通信了
3	Хүзүүдэж авах	立刻扑到他的怀里

Орчуулагч утгыг гярхай ажиглаж, нийлэмж үгийг давхардуулалгүйгээр ойролцоо утгат, мөн монгол хятад толь бичигт байхгүй өөр үгээр орчуулсан нь сайшаалтай.

Хүснэгт 4

“Авах” нийлэмж үг	Монгол хятад толь бичиг	Жанной Юаний орчуулга
Үр-2, охин хүүхэд, хүүхэд-2, үүнийг, хүү бүсгүй, хэрэв эс, хүүхдийг-2, хэн дуртайгаа, үрийг, авах хүн, үрчилж-2, өргөж авах	要孩子、收养孩子、抱养孩子、收容	抱养、要、抱、过继
Гэргий, гэргий болгож-2, хүүхнийг хүчээр авах	娶妻、娶亲	娶妻、求婚，嫁给
Ус-2, уснаас-2 авах	打水、取水	取水，带水，汲水，拿水
Хулгайлан-2, морь гүү хоёрыг авах		偷走、偷

Санаа авах-2	了解、领悟、思索、得来想 法、生出念头、随想、感想	听到这番话、越想 越觉得
Өшөө, өс авах-2	报仇、雪恨、报复	报仇、报复

2. “Авах” нийлэмж үг, өгүүлбэрээр хасч орчуулсан – 4

Үйл явдал, зорилго ойлгомжтой тохиолдолд заавал үгчлэх, нурших шаардлагагүй бөгөөд орчуулагчийн “авах” нийлэмж үгтэй эхний 3 жишээ бол тухайн нийлэмж үгийг хассан ч ойлгомжтой болсон боловч өгүүлбэрээр огт орчуулаагүй байгаа нь утгыг огт гаргаагүйтэй адил алдаа гэж тооцож болохоор байна.

Хүснэгт 5

Үг, өгүүлбэр	“Авах” нийлэмж үг	Хятад орчуулга
“Авах” нийлэмж үг	... хуучин хатсан хавсай боов бага сага өгөхөд хүлээж аваад , нөхөдтэйгээ идсэн нь ганц өдрийн дотор дуусжээ	可是喇嘛只给了些已经发霉的干饽饽，他们几个人一顿就吃光了。 (Г.Цогзолмаа, 2017:135-136)
	Зүй нь үүнийг даруй барин авч зохих газар хүргэвэл зохино>> гэсэн боловч	我本该立时把你送回监狱去，.....(мөн тэнд, 2017:155-156)
	<<Хүү бүсгүй ямар боловч авна гэж Болд өвгөн хэлсэн тул лав авах биз.	“包勒得说了，不论是男的是女的都要。(мөн тэнд, 2017:125-127)
Өгүүлбэр	Ловон шоо орхиж, судар дээр гарсныг хэлсэн хэрэг бөгөөд энэ эрихийг мичин жилтэй хулгана авсан байж болох гэлээ.	(мөн тэнд, 2017:139-141)

3. Товчлон хураасан үгийг нэмж орчуулсан – 3

Зохиолчийн тодорхой тохиолдолд үгийг хураан товчилсныг хятад хэлнээ ойлгомжгүй, зайлшгүй тусагдахуун авах шаардлагатай үед үг нэмэх аргаар буюу утгачилж орчуулжээ.

Хүснэгт 6

“Авах” нийлэмж үг	Орчуулга	Нэмэх буюу утгачилж орчуулсан үг
одоо өөр зарц нар авсан тул	现在改由别的仆人汲水	ус
өөрөө авах гэвэл	要娶她	түүнийг
мичин жилтэй хүн авчээ	是属猴的人偷的	Хулгайлах

4. Нийлүүлэн, сольж орчуулсан – 1

Утгачлан орчуулах аргын нэг бөгөөд хоёр үгийг нийлүүлж, өөр үгээр солин хэрэглэж болдог.

1)Болд нэг үнээг **авч оронд нь** хязгаалан үхэр хөллөж яв гэж **өгөв**.

包勒德把她那头母牛换(солих)了条公牛，.....(мөн тэнд, 2017:139-141)

5. Нэр үгсийн аймгаар өөрчлөн орчуулсан – 1

Орчуулгад үгсийн аймгийг өөрчлөн орчуулах явдал олонтаа тохиолддог.

2)Хүүхдийг төрөхөд эх барьж авах гэсэн Дамдингийн ээж ... 原先答应给木娅达格当**收生婆**
[эх баригч эмэгтэй], (мөн тэнд, 2017:124-126)

Дүгнэлт

“Гологдсон хүүхэн” зохиол нь 14 хэсэгтэй, 8840 орчим үгээс бүтсэн, үүний дотор бидний судалгааны ажлын гол судлагдахуун болох “авах” нийлэмж үг 51 удаа давтагдаж, бүтцийн хувьд “нэр, авах” нийлэмж үг 37, “үйл, авах” нийлэмж үг 14, нэгтгэн нийлүүлэх хувилбартай 7 үндсэн агуулга бүхий утгыг илэрхийлж байна.

“Үр, хүүхэд, өргөх, үрчлэх-авах”, “хүүхэн, гэргий-авах” зэрэг нэр болон үйл үгийг өөр хооронд нь солиход утга нь өөрчлөгдөхгүй чөлөөт нийлэмж үүсгэж болдог байхад харин “санаа, адис, амь, авшиг, сураг” зэрэг хийсвэр үгийн утга өөрчлөгдөж, тогтвортой нийлэмж үүсгэдэг байна.

Орчуулагч Жан Юйюань “авах” бүхий 42 нийлэмж үгийг бүрэн орчуулахын зэрэгцээ олон давтагдсан үгийг ойролцоо утгат өөр үгсээр солин хэрэглэх, зарим тохиолдолд үг хасч, нэмэх, нийлүүлэх, нэр үгсийн аймгаар өөрчлөн орчуулах зэрэг олон аргыг чадмаг ашигласан бөгөөд харин “авах” нийлэмж үгтэй 1 өгүүлбэрийг огт орчуулаагүй орхисон байна.

Бид зөвхөн толиос төдийгүй хос хэлний орчуулгаас ч бас давхар суралцаж, ялангуяа эх хэлнээс гадаад хэлнээ орчуулахад хэл, соёлын мэдлэг, сэтгэлгээний ур чадвараа хөгжүүлэх боломж бүрэн бий.

Ном зүй

- Аким Г, (1984), Орчуулгын санг уудлахад, УБ. Улсын хэвлэлийн газар
- Бадамдорж Д, (2001), Монгол хэлний утгасудлал гутгаар дэвтэр, УБ, “Мөнхийн үсэг” ХХК
- Базаррагчаа М, (1978). “АВ” гэдэг үгийн утгын хувирлын тухай, “Хэл зохиол судлал” ШУА, ХЗХ-ийн ЭШБ, 1979 №13
- Баттөгс Ч, (2003), “Авах” гэдэг үйл үгийн утга зүйн судалгаа (polysemy). Мастерын зэрэг горилсон судалгааны ажил, УБ. МУИС, МХСС-Хэл шинжлэлийн тэнхим
- Монгол хэлний их тайлбар толь, “авах” үг <https://mongoltoli.mn/dictionary/detail/778>
- Баатар Д, Журамт Б, (1998), Орчин цагийн монгол хэлний үгийн давтамжийн толь. Хөх хот. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо
- Цогзолмаа Г, (эмх.), (2017), 达木丁苏伦诗文集 Цэндийн Дамдинсүрэн Түүвэр зохио, УБ. “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр



ЯПОН ХЭЛНИЙ ХЭЛЦ ҮГИЙН ОРЧУУЛГЫН ТУХАЙД ("KI" (気) ГЭХ ҮГ БҮХИЙ ХЭЛЦИЙН ЖИШЭЭГЭЭР)

П.Энхжаргал³⁸, Д.Маралмаа³⁹

Abstract: In this paper, we focused on problems the translating idioms, improvement to translation idioms, and investigate the applicability of many strategies in the translation of idioms from Japanese into Mongolian. This report aimed to find out suitable methods for translating idioms. To get this aim, we used the phraseology classification model: equivalent translation method, literal translation method, analogical translation method, and analytical description method, determined by D. Dashdavaa (1973) We also analyzed the translation of the Japanese phrase "soul" from the sources into the translated phrase, and checked the method of translating the remaining untranslated phrase into Mongolian. Findings show that the analytical description method is suitable for translating Japanese idioms into Mongolian.

Түлхүүр үг: хэлц үг, орчуулгын арга, "ki" (気), сэтгэл

Сүүлийн жилүүдэд манай улсын гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээ өргөжихийн зэрэгцээ дэлхийн улс орнуудад иргэд чөлөөтэй зорчих болсон, нөгөөтээгүүр олон орны байгууллага, иргэдтэй харилцах, мэдээлэл солилцох эрэлт хэрэгцээ өссөнтэй холбоотойгоор хүмүүсийн гадаад хэл сурах сонирхол, эрмэлзэл давамгайлах болжээ. Иймд гадаад хэлнээс монгол хэл рүү утга агуулгын хувьд зөв, оновчтой орчуулах, орчуулах аргачлалыг тодорхойлох шаардлага нэмэгдэж байна. Тэрхүү илэрхийлэл хэлц үгээр илрэн гарч ирж байгаа тул эх хэлний хэлц үгийн утгыг хүлээн авагч хэлний хэрэгслээр илэрхийлж орчуулахад олон бэрхшээл тулгардаг.

Хэлц үг нь бүтэц бүрэлдэхүүнээрээ харьцангуй тогтвортой, утга зүйн хувьд буюу агуулгаараа хуваагдашгүй, хүний ой ухаанд тодорхой дүр дүрслэл бий болгодог нийлмэл үг гэдгийг олон хэлний баримтаар тогтоон судлаачид санал нийлсэн байдаг. Бүхий л ард түмэн түүхийн урт хугацаанд зөвхөн өөрийн үндэстний соёл, ёс заншил, сэтгэлгээний онцлогийг өөртөө агуулсан, хэлнийхээ хэм хэмжээнд нийцсэн хэлц үгийг бүтээн хэлэлцсээр иржээ.

Энэ өгүүлэлд япон сурвалжуудаас япон хэлний ki (気) буюу "сэтгэл" гэх үг орсон хэлц үгийг түүн, монгол хэлээр орчуулагдсан байдалд ажиглалт хийв. Хэлцийн орчуулагдсан байдалд хийсэн ажиглалт болон япон, монгол хэлний өвөрмөц хэлцийн тухай судалгаанд тулгуурлан хараахан орчуулагдаагүй хэлцийг орчуулсан ба япон хэлний хэлц үгийг монгол хэлнээ орчуулах аргыг тохиромжтой аргын талаар санал дэвшүүлэхийг зорив.

³⁸ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор

³⁹ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн магистрант

1. Хэлц үгийн тухай

Монгол хэлний хэлц үгийн талаар эрдэмтэн Чой.Лувсанжав, Г.Аким, Д.Бадамдорж, Ж.Төмөрцэрэн, Ж.Бат-Ирээдүй, М.Базаррагчаа, Б.Пүрэв-Очир, Ж.Баянсан, Ч.Догсүрэн, Д.Баттогтох, Д.Бадамдорж, Ж.Баянсан, Н.Нансалмаа, Л.Дашням, Юнь Со Вонь нар судалж, “өвөрмөц хэлц буюу хэллэг”, “хэлц үг” гэж томъёолон бүтэц, утгыг тодорхойлсон байна. Тухайлбал,

Эрдэмтэн Ц.Сүхбаатар (1988:106) “Хэлц үг гэдэг бол хамтран нэгэн санаа илэрхийлж хэвшсэн хэд хэдэн үгийн нэгдэл юм. Хэлц үгэнд холбогдож байгаа үгийн өөр хоорондын нэгдэл нь салшгүй хэвшиж, тэр хэлэндээ үргэлж бэлхэн материал болж утга хэрэглээний хувьд нэгэн цогц болсон байдаг нь түүний гол шинж мөн. Хэлц үгийн ихэнх нь шилжмэл утгатай бөгөөд хүний санаа сэтгэлийн байдлыг тусган илтгэдэг” гэж тодорхойлсон байна.

Эрдэмтэн Г.Аким (1982:3) “Өвөрмөц хэлц гэдэг бол гагцхүү тухайн үндэстний хэлэнд байдаг, бүрэлдүүлсэн үгийн утга нь алдагдаад нэгэн нэгдмэл утга гаргах болсон тогтвортой нийлэмж үг юм. Хэлний үзэгдлийн хувьд өвөрмөц хэлц нь:

1. Хоёроос дээш үгээс бүтэх боловч утгын хувьд нэгэн бүхэл болж тухайлбал, нэг л ухагдахууныг заана.
2. Өвөрмөц хэлцийг бүрэлдүүлж байгаа үгсийг ганц нэгээр нь салгаж болохгүй.
3. Түүнийг гадаад хэлнээ үгчлэн орчуулж болдоггүй байна” гэжээ.

Япон хэлний хэлц үгийн судалгаа 1960-аад оны сүүл хагасаас эхэлж 1980-аад оноос эрчимжсэн гэж үздэг. Япон хэлний хэлц үгийг Морита Ёшиюки (森田良行), Ширази Даижи (白井大二), Мияжи Ютака (宮地豊), Күнихиро Тэцүя (国広哲弥), Ишида Приссилла (石田プリシラ) нарын судлаачид судалсан байна.

Япон хэлний хэлц үгийн талаар:

Морита Ёшиюки (1966:68) “Хэлц үгийг толины утгын ойлголт болон хэлзүйн мэдлэгээрээ л ухан ойлгох боломжгүй байдаг” гэдгийг онцолсон ба тэрбээр “Утгазүйн болон хэлзүйн хэлбэрийн нэгдлээрээ нэг үгийн утгатай дүйх холбоо үг нь хэлцийн шинжийг хамгийн ихээр агуулсан байдаг” хэмээн тодорхойлсон байдаг. Ширази Даижи (1977:531) “Хэлц гэдэг нь хэлний хэрэглээнд бүрэн тогтворжсон, бүрэлдүүлбэр тус бүрийн утгаас ялгаатай утга санааг илэрхийлдэг хэллэг мөн” гээд хэлний тогтолцооны бүх хүрээнд хэвшмэл байдлаар хэрэглэгддэг хэлний бүх нэгжийг хэлц гэж үзээд, хамгийн бага нь нэг үгээс бүтнэ гэжээ. Жишээ болгож osamui (お寒い) гэсэн үгийг авсан байна. Samui (寒い) буюу үндсэн утга нь хүйтэн, даарах гэсэн утгатай үг нь хүндэтгэлийн хэлбэрт шилжихээрээ o samui naiyou (お寒い内容) буюу “агуулга муутай” гэх мэт сонирхолгүй, муухан гэсэн утгыг илэрхийлдэг. Эрдэмтэн Мияжи Ютака (1982б:238) “Хэлц гэж харьцангуй тогтвортой холбоос бүхий хоёроос дээш үгийн нэгэн бүхэллэг утга санааг илэрхийлсэн холбоо үгийг хэлэх ба хоёроос дээш үгээс бүтдэгээрээ чөлөөт холбоо үгтэй төсөөтэй ч, бүрэлдүүлбэр нь хоорондоо тогтвортой холбоосоор буюу хязгаарлагдмал холбоосоор холбогддоогоороо ялгаатай.” Ито Макото (1989:391) “Холбоо үгээс ялгарах хэлцийн үндсэн шинж бол хэрэглэх бүрт шинээр бүтээгддэггүй, сэргээн санах төдийд бэлхнээ байдаг оршино.” Ишида Приссилла (1996:49) “Хэлц нь хоёроос дээш үгээс бүтэх хэдий ч, хэлбэр утгын хувьд бэхэжмэл, бүхэлдээ нэг үгтэй тэнцэх үүрэг гүйцэтгэдэг тул үгийн нэгэн адил үгсийн сангийн нэгж болно” хэмээжээ.

Дээрх судлаачдын бүтээлээс харахад бүтцийн хувьд хэлц үг нь ихэнхдээ хоёроос дээш үгээс бүтсэн, задалж болохгүй нэгдмэл утга бүхий тогтвортой холбоо үгийн хэлбэртэй болохыг харж болно. Мөн хоёр хэлний хэлц үгийн бүрэлдүүлбэр нь өөрийн үндсэн утгаа гээж, утга шилжин хэлц үгийг бүтээдэг гэдэг нь тодорхой байна.

2. Хэлцийн орчуулгын тухайд

Судлаач Р.Гүрбазар (1996:5) нар орчуулгыг “Орчуулга гэдэг бол нэг хэлний хэрэгслээр илэрхийлсэн утгыг өөр нэг хэлний хэрэгслээр хөрвүүлэн буулгахыг хэлнэ” гэж тодорхойлсон байна. Мөн оросын эрдэмтэн А.Д.Швейцер “Орчуулж болох зүйл зөвхөн эх л байдаг учраас орчуулна гэдэг нь эхийн агуулгатай л ажиллана гэсэн үг юм. Тэгэхлээр “эхийн утгыг тайлах”, “эхийг орчуулах” гэсэн хоёр ойлголт гарч ирнэ. Энэ талаас нь авч үзвэл “эхийн утгыг тайлах” гэдэг нь тухайн хэлний нэгжүүдийн утгын тусламжтайгаар эхэд тэмдэглэсэн утга санааг олж танихыг хэлэх бөгөөд харин “орчуулах” гэдэг нь нэгэнт олж танысан утга санаандаа тохирох нэгжийн утгыг хүлээн авагч хэлнээсээ олж тохируулна гэсэн үг юм” (А.Дэлгэрмаа, 2011) гэж тодорхойлсон байдаг.

Мөн орчуулгад зөвхөн утгын тайллаас гадна соёл судлал гол байр суурь эзлэх болжээ. Соёлын орчуулга судлалд жинтэй хувь нэмэр оруулсан хүн бол Английн Уорвикийн их сургуулийн профессор Сюзен Басснетт (Susan Bassnett) юм. Орчуулга судлал эдүгээ хэл шинжлэлийн хүрээ хязгаараас нэгэнт хальж соёл судлалын үзэгдэл болох эхлэлийг тавьсан үздэг байна. Эрдэмтэн судлаачдын тайлбарлаж байгаагаар орчуулга судлалын соёл уруу чиглэх үзэл, онолын гол утга нь аливаа бүтээлийг орчуулахдаа, соёл судлалын үүднээс авч үзэх, орчуулах явцад уг эхийн гүн чанадад орших соёлын агуулгыг бүрэн гүйцэт илтгэх, орчуулж буй хэлний болон соёлын тэмдгийг дамжуулахдаа соёлын болоод үндэстэн хоорондын соёлын ялгааны үүднээс хандаж орчуулахад оршдог байна. Энэхүү орчуулга судлалын “соёл уруу чиглэх” шинэ үзэл онол дэг сургууль, орчуулга судлалын хөгжлийн түүхэнд гарсан томоохон тэсрэлт, дэвшил нь орчуулга судлалын дүр төрхийг шинэчилж, хүрээ хязгаарыг нь тэлж, өргөжүүлсэн нь орчуулга судлалд өргөн уудам орон зай, шинэ боломж, арга ухааны үүдийг нээсэн үзэл онол хэмээн эрдэмтэн судлаачид тэмдэглэж байна.

Түүнчлэн орчуулгад соёлыг чухалчлан авч үзэх талаар монгол судлаач Р.Гүрбазар (1996:84) “Дэлхийн олон улс түмний ахуй амьдрал, аж төрөх ёс, зан заншилд өөр аль ч улс оронд давтагдахааргүй тийм юм үзэгдэл үлэмжхэн их бий. Тэдгээрийг нэрлэсэн үг хэллэг хязгааргүй олон. Тийм үгсийг өөр хэлээр орчуулах тохиолдолд юуны өмнө таарч тохирохуйц үг хэллэгийг орчуулга хийж байгаа хэлний үгийн сангаас уйгагүй түүж, зарим зүйлд тайлбар хэрэглэн уншигчдад буюу сонгогчдын ой тойнд ортол ойлгуулах, ойлгуулах ойлгуулахдаа яг үнэн зөв ухааруулах үүрэг орчуулагчийн үндсэн зорилт болох ба энэ нь бэрхшээлтэй хэр нь нэр хүндтэй, гавьяатай үйлс юм. Учир нь энэ бол зөвхөн нэг үндэстний утга соёлыг арвижуулан баяжуулж буй хэрэг төдийгүй нийт хүн төрөлхтний соёлыг харилцан баяжуулж байгаа буянт үйлс мөн” хэмээн цохон тэмдэглэсэн байдаг.

Тиймээс орчуулах ажилд тохиолддог хамгийн түгээмэл, хамгийн асуудал дагуулсан, бас маргаантай зүйл бол үндэстэн, угсаатан хоорондын өөр өөр соёл, түүний ялгааг хэрхэн зөв нээж илэрхийлэх, дамжуулах асуудал юм. Ялангуяа хэлц үгийг орчуулах ажилд соёлын ялгааг дамжуулахдаа бэлэн хэв загварыг барин, утга дүйх үг хэллэгээр шууд орлуулах бус харин тухайн соёлын учир холбогдол гарвал түүх, өвөрмөц онцлог зэргийг олон талаас нь шүүн тунгааж, бүрэн илтгэн гаргах нь туйлын чухал байна.

Монгол хэлнээ япон хэлний хэлцийг орчуулах, орчуулгын аргын судалгаа тодорхой хэмжээнд хийгдэж ирсэн юм. Тухайлбал, Л.Чулуунбаатар, Ц.Онон нарын (2009) “Япон, монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” толь бичиг хэвлэгдэн гарсан бөгөөд япон-монгол тайлбар толь⁴⁰ -

⁴⁰ Дэмбэрэл С. (2012) “Япон-Монгол их толь бичиг”, УБ
Арай Шиничи., Сэржав Б. (2009) “Япон монгол толь бичиг”, УБ

уудад хэлц үгийг тодорхой хэмжээгээр орчуулан оруулсан байна. Мөн монгол хэлний хэлцийг япон хэлээр тайлбарласан “Монгол хэлцийн толь”⁴¹ (Д.Наранцэцэг, 2012) хэвлэгджээ.

Япон, монгол хэлний өвөрмөц хэлцийг орчуулах арга, зарчмын талаар А.Дэлгэрмаа (2011), Д.Золзаяа (2003), Д.Дэлгэрмаа (2009) нар судалсан байна.

Д.Золзаяа “Монгол, япон хэлний өвөрмөц хэллэгийн харьцуулсан судалгаа” бүтээлдээ япон эх сурвалжаас япон хэлний 113 хэлцийг түүн авч, монгол хэлний хэлц үгтэй харьцуулж үзсэн байна. Тэрээр хоёр хэлний хэлцүүдийг гурван үндсэн хэсэгт ангилан ажигласны үр дүнд доорх үзүүлэлт гарсан байна.

1. Бүтэц, утга ижил -46 хувь
2. Бүтэц өөр, утга ижил -30 хувь
3. Бүтэц ижил, утга өөр - 24 хувь

Үүнээс үзэхэд япон, монгол хэлэнд бүтэц утга ижил хэлц олон байна гэдэг нь харагдаж байна. Үүний шалтгааныг Д.Золзаяа (2003:52) дүгнэж хэлэхдээ:

1. Адилхан Азийн үндэстэн гэдэг утгаараа
2. Үгсийн сангийн болоод утгазүйн бүтэц ойролцоо

3. Хүний бие эрхтний холбогдолтой өвөрмөц хэллэгүүд орсон байгаа учраас хэдий монгол, япон үндэстэн гэдгээрээ ялгаатай байгаа боловч ижил тал нь хүн гэсэн ерөнхий утгаараа баярлаж хөөрөх, уйлах, гуних гэсэн хүний сэтгэлийн үйл явц нь нэгэн ижил учраас” гэж тайлбарласан байна.

Хэдийгээр энэ судалгаа нь бүтэц, утгын судалгаа боловч “бүтэц, утга ижил”, мөн “бүтэц өөр, утга ижил” хэлц үг 70 орчим хувийг эзэлж байгаа гэсэн дээрх судалгааны үр дүнгээс япон хэлний хэлц үгийг монгол хэлнээ орчуулахдаа шууд хуулбарлан буулгах арга нь хэрэглэх боломжтой гэж харагдаж байна.

Харин судлаач А.Дэлгэрмаа (2011) Япон улсын зохиолч Шибата Рёотароогийн “Тал нутгийн тэмдэглэл”, Сүүлчийн шөөгүн”, Нацүмэ Соосэкигийн “Сэтгэл”, Нитобэ Иназогийн “Бүшидо” гэдэг дөрвөн туужийн орчуулгаас нийт 300 хэлцийг түүж орчуулсан аргад ажиглалт хийсэн байна. Тэрээр монгол хэлээр орчуулсан япон хэлний хэлцийг эрдэмтэн Д.Дашдаваагийн тогтоосон:

1. Тэнцүүлж орчуулах арга-эх хэлний хэлцтэй утгазүйн бүтэц нь бүрэн гүйцэд дүйцэх хүлээн авагч хэлцээр орчуулах арга
2. Хуулбарлан орчуулах арга-эх хэлний хэлцийг хүлээн авагч хэл рүү орчуулсан ч утга санаа болоод дүрслэлийг хэвээр хадгалан хөрвүүлэх арга
3. Аналоги хэлцээр орчуулах арга-эх хэлний хэлцтэй утгазүйн бүтэц, утгын дүрслэлээрээ ялгаатай ч ижил утга санааг дамжуулах хэлцээр орчуулах арга (энэ арга нь тэнцүүлж орчуулах аргатай мөн чанарын хувьд төстэй ч эх хэлний хэлцээс өөр утгазүйн бүтэцтэй хэлцээр орчуулдагаараа ялгаатай)
4. Утгачлан тайлбарлах арга-эх хэлний хэлцийг хүлээн авагч хэлэнд орчуулах эн тэнцүү хэлц байхгүй, эсвэл хуулбарлан орчуулах, аналоги орчуулга зэргийн алиныг нь ч хэрэглэх боломжгүй тохиолдолд чөлөөт холбоо үг, эсвэл энгийн үгээр утгыг нь тайлбарлаж орчуулахыг утгачлан тайлбарлах арга гэсэн дөрвөн аргын дагуу ангилжээ.

Судалгааны дүнд хамгийн олон хэрэглэсэн арга нь утгачлан тайлбарлаж орчуулах арга (74,4%) болохыг тогтоосон байна. “Энэ нь хоёр үндэстний ертөнцийг танин мэдэх сэтгэлгээний хэв шинж, үнэлгээний жишиг хэмжүүрт нийтлэг зүйл байгаа хэдий ч ялгаатай байдал давамгайлж байдгаас үүдэлтэй юм” гэж тэрээр дүгнэжээ.

Дээрх хоёр судалгааны үр дүн япон хэлний хэлц үгийг монгол хэлээр орчуулахад тохиромжтой хоёр өөр аргыг тодруулан зааж байна. Д.Золзаяагийн судалгааны үр дүнгээр япон

⁴¹ 鯉淵信一、ナランツェツエグ D. (2012) 『モンゴル語慣用句用例集』

хэлний хэлц үгийг монгол хэлээр хуулбарлан орчуулах, мөн дүйлгэн орчуулах арга нь илүү зохимжтой байгаа бол А.Дэлгэрмаагийн судалгааны үр дүнгээс харахад утгачлан тайлбарлах орчуулгын арга зохимжтой гэж харагдаж байна. Өөрөөр хэлбэл, энэ хоёр судалгааны үр дүнг орчуулах аргын талаас нь авч үзвэл хоорондоо тохирохгүй үр дүн гарч байна. Тиймээс бид аль аргыг илүү зохимжтой байгааг нарийн тодруулахын тулд япон хэлний “ki” (気) буюу “сэтгэл” гэсэн үг орсон хэлц үгийг жишээ болгон авч монгол хэлнээ хэрхэн орчуулагдсан болон ямар аргуудыг ашиглан орчуулсан байдлыг тодруулахыг зорив.

Япон хэлнээ “ki” буюу “сэтгэл” гэсэн утгатай хийсвэр үг бүхий өвөрмөц хэлц олонтаа тохиолддог. “Япон хэлний тайлбар толь бичиг”⁴² -т “ki” гэдэг үгийг тайлбарлахдаа:

1. Тухайн байгаа газарт мэдэрч байгаа мэдрэмж
2. Амьсгал
3. Хүний зан ааш, хандлага
4. Аливаа зүйлд хандах бодол санаа, сэтгэлийн хөдөлгөөн
5. Ямар нэгэн зүйл хийх үеийн сэтгэлийн байдал
6. Оюун санаа гэсэн утгуудыг илтгэдэг гэж тайлбарласан байна.

Энэ үг нь олон утга илэрхийлдэг боловч өвөрмөц хэлцэд “сэтгэл хөдлөлийг илэрхийлэх хэлцийн нэгж” болж ордгоороо онцлог юм. Бид И Санфүны “ki орсон хэлц үгийн утга, хэрэглээ” өгүүлэл, япон хэлний “goо 辞書” цахим толь бичиг⁴³, “Япон хэлний тайлбар толь бичиг” зэрэг сурвалжаас ki буюу “сэтгэл” гэсэн үг орсон 102 өвөрмөц хэлцийг түүвэрлэн авч судалгаандаа ашигласан болно. Үүнд С.Дэмбэрэл (2012) 70 хэлц, Л.Чулуунбаатар, Ц.Онон нар (2009) 49 хэлц, Араи Шиничи, Б.Сэржав нар (2009) 11 хэлц нийт 75 өвөрмөц хэлцийг монгол хэлээр орчуулсан байна.

Орчуулсан байдлыг япон, монгол хэлний хэлцийн толь бичгийн баримтаар тодруулан үзэв (Хүснэгт 1.).

Хүснэгт 1. Япон хэлний “ki” буюу сэтгэл гэх үг бүхий хэлцийн орчуулга

Орчуулгын аргууд	Хэлцийн тоо	Эзлэх хувь /100%/
Тэнцүүлж орчуулах арга	12	16.4
Хуулбарлах арга	3	4.1
Аналоги арга	13	16.4
Утгачлан тайлбарлах арга	43	56.2
Холимог арга	5	6.8
n=75		

Эдгээр хэлцийг эрдэмтэн Д.Дашдаваагийн хэлц үгийг орчуулах аргын ангиллын дагуу ангилахад утгачлан тайлбарлах аргыг хамгийн их (56.2%) хэрэглэсэн бөгөөд энэ нь А.Дэлгэрмаа (2011:105)-ийн судалгааны үр дүнтэй тохирч байна. Үүний дээр утгачлан тайлбарлах аргын дараа дүйлгэж орчуулах арга, аналоги аргаар орчуулах арга илүү ашигласан нь япон хэлнээ “сэтгэл” гэсэн үг орсон хэлц үг олон байгаатай адил монгол хэлнээ “сэтгэл” гэх үг орсон хэлц үг олон байгаатай холбоотой байж болох юм. Үүний зэрэгцээ хэлц үг нь хэлц үг судлаачдыг тодорхойлсны дагуу хүний сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлдэг нийтлэг онцлогтой байдаг нь дүйлгэж орчуулах арга, аналоги аргаар орчуулах аргыг хэрэглэх боломжийг бүрдүүлж байж болох юм. Тухайлбал: эрдэмтэн С.Дэмбэрэл (2012:347) “Япон, монгол их толь бичиг”-тээ япон

⁴² 林四郎 監修／篠崎晃一（編修代表）相澤正夫・大島資生 編著（2002）『例解新国語辞典』三省堂

⁴³ <https://dictionary.goo.ne.jp/>

хэлний kokoro ga seku (心が急ぐ) буюу сэтгэл яарах гэсэн хэлцийг монгол хэлнээ “сэтгэл тэвдэх” гэсэн хэлц (дүйцүүлж орчуулах арга)-ээр, ki ga ooi (気が多い) буюу “сэтгэл олонтой” гэсэн хэлцийг “олон ааштай, хаврын тэнгэр шиг” гэсэн хэлц (аналоги арга)-ээр орчуулсан байна. Дээр дурдсан тоон үзүүлэлт болон жишээ авсан хэлцүүдийн орчуулгаас харахад хэлцийг орчуулахын өмнө хэлцэд дурдагдаж буй зүйлийг эх хэлтэн болон түүнийг хүлээн авч буй хэлтнүүд хэрхэн ойлгодог талаар танин мэдэх шаардлагатай гэдэг нь анхаарал татаж байна.

Хэлцийн орчуулгын талаар Д.Цэсэрэгзэн (2015) “Хэлц үг нь сэтгэлгээний өвөрмөц хэв маяг, онцлог шинж, төрх байдал зэрэг нь үндэстний өвөрмөц соёлыг бүрдүүлнэ. Хэл соёлын шүтэлцээ нь хэлний бүх түвшингээс үгийн санд хамгийн түрүүнд илэрдэг. Орчуулга хийхдээ хэл, соёлын хоорондын уялдааг авч үзэх хэрэгтэй болно. Мөн нэг хэлээр илэрхийлсэн утга, сэтгэл хөдлөлийн өнгө аясыг өөр хэлэнд буулгадаг. Орчуулгад өөр соёлт үндэстний зүйрлэх арга өөр байдаг. Энэ нь танихуй болон соёл сэтгэлгээтэй холбогдоно.” гэсэн байдаг. Түүнчлэн хүн эхлээд хүрээлэн буй орчинтойгоо танилцаж, тэдгээрийн онцлог шинж болон төсөөтэй талыг таньж мэдэж эхэлдэг байна. Улмаар ижил төсөөтэй талуудыг зүйрлэн шинэ үг бүтээн тухайн хэлний үгийн санг баяжуулж байдаг. Эрдэмтэн С.Долгор (2014:168) “Танихуй нь хүн олж авсан мэдээллээ ашиглан удаа дараагийн дадлагаар туршлага, чадвар хуримтлуулан эзэмших үйл явц юм. Иймээс ч хүний туршлага, зан үйл орчинтой салшгүй холбоотой” гэж тодорхойлсон байдаг зэрэг нь хэлц үг ч хүний танин мэдэхүйтэй холбогдож байдгийг харуулж байна. Иймд хэлц үгийг танихуйн үүднээс, хэл, соёлын үүднээс судалж орчуулбал тухайн хэлний соёл, сэтгэлгээний онцлог, сэтгэл хөдлөлийн нарийн мэдрэмжийг тусгах боломжийг бүрдүүлнэ.

Япон хэлний “ki” буюу “сэтгэл” гэсэн үг орсон хэлцийг утгачлан тайлбарлах аргаар орчуулсныг ажиглахад япон, монгол хүний сэтгэл хэмээх зүйлийг хэрхэн ойлгодгийг харгалзан үзсэнээр орчуулсан байж болох юм. Жишээ нь: ki o nomareru (気を吞まれる) буюу үгчлэн орчуулбал “сэтгэлээ залгиулах”, харин утга нь “shinritekini attou sareru” (心理的に圧倒される) буюу “сэтгэл зүйн хувьд хүнд дарамтад орох” гэсэн хэлцийг монгол хэлнээ буулгахдаа “хүчинд автаж бууж өгөх” гэж утгачлан орчуулсан байна.

Орчуулагч Д.Гүн-Үйлс (2008:6) “Монгол хэлэнд нэг санааг хэд хэдэн янзаар илэрхийлж болдог. Бусад хэлэнд тийм боломж хомс гэж би хэлэхгүй. Гэвч нэг санааг хэд хэдэн янзаар хэлбэршүүлэн илэрхийлэх боломж монгол хэлэнд арай илүүтэй байх шиг надад санагддаг юм” гэжээ. Үүнээс үзвэл дээрх ki o nomareru (気を吞まれる) буюу үгчлэн орчуулбал “сэтгэлээ залгиулах” гэсэн хэлцийг монгол хэлнээ орчуулж болох монгол хэлний хэлцийн хувилбарууд байж болох юм. Монгол хэлнээ “хүчинд автаж бууж өгөх” гэсэн утгыг илэрхийлэх “далаараа тавиулах”, “далан таваар бууж өгөх” гэсэн хэлцүүд байдаг. Дээрх хэлцийг энэ хоёр хэлцээр буюу аналоги аргаар орчуулж болох талтай. Гэвч орчуулгад хэрэглээний таарамж, зохилдолгоог байнга анхааралдаа авах шаардлагатай байдаг. Түүнчлэн А.Дэлгэрмаа (2011:103)-гийн хэлснээр “Аналоги аргыг эх хэл болон хүлээн авагч хэлний хэлцийн утгазүйн бүтцийн ялгаа тухайн хоёр үндэстний онцлог, соёлын ялгаа гэх мэт зүйлийг орчуулгын өгүүлбэр, эхийн найруулга зүйн хэмжээнд нөлөөлөхгүй тохиолдолд л боломжтой” гэж тэмдэглэсэн байна. Мөн аливаа хэлний хэлц үг нь урт удаан хугацаанд хэвшин хэрэглэгдэж дүрслэл, зүйрлэл, адилтгалаар баяжин бүтдэг гэдэг нь тодорхой. Монгол хэлний “далаараа тавиулах” гэсэн хэлц нь хэдийгээр “хүчинд автаж бууж өгөх” гэсэн утгыг агуулдаг ч япон хэлнээс монгол хэл рүү орчуулсан орчуулга дотор “далаараа тавиуллаа” гэсэн өгүүлбэр гарч ирвэл уншигчийн сэтгэхүйд авцалдахгүй байх боломжтой. Учир нь монгол хүний хувьд япон хүнийг “далаараа тавиулах” гэсэн хэллэг хэрэглэж байна гэдэг дээр ой тойнд нь төдийлөн бууж өгөхгүй болов уу. Тиймээс эх хэлний утгатай ижил хэлц үг хүлээн авагч хэлэнд байна гээд тухайн хэлцээр шууд орчуулах нь уншигчид буруу

дүрслэл өгөх талтай учраас “ki o nomareru” (気を呑まれる) буюу үгчилсэн орчуулбал “сэтгэлээ залгиулах” гэсэн хэлцийг монгол хэлнээ “хүчинд автаж бууж өгөх” гэж утгачлан орчуулсан байна.

Япон хэлний “ki” буюу “сэтгэл” гэсэн үг орсон өвөрмөц хэлцийг аналогич аргаар орчуулсан хэлц үгийг ажиглахад япон, монгол хүний “сэтгэл” хэмээх зүйлийг танин мэдэж ойлгож ирсэн байдал илүү тод илэрч байна. Жишээ нь: ki ga ookii (気が大きい) үгчилбэл “сэтгэл том” гэх бөгөөд энэ нь “жижиг зүйлд санаа зовдоггүй, энэрэнгүй” гэсэн утгатай юм. Үүнийг С.Дэмбэрэл (2012:347) “уужим сэтгэл, уужуу сэтгэлтэй” гэсэн хэлцээр орчуулсан байна. Монгол хүний уужуу тавиу сэтгэлзүйн шинжийг угсаатан судлаач Л.Уранцэцэг, Г.Цэрэнханд (2007:45) “Чухамхүү энд л уур уцаар, яарал тэвдэл багатай байж, саруул ухаанаар уужим тэнүүн хандаж, юмны голыг алдалгүй олдог, гүндүүгүй зан төрх, төрөлхийн ноён нуруу, голч мэргэн ухааны нэр томъёо үүссэн байж болох юм” гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, япон хүмүүс “сэтгэл”-ийг том жижиг хэмжээтэй гэж үздэг бол монгол хүмүүс “сэтгэл”-ийг хэр өргөн уудам, уужуу вэ гэж нүүдлийн аж төрөх ёс, оршин суугаа газар оронтойгоо холбон зүйрлэн хэлдгээрээ ялгаатай байна.

Эдгээр япон хэлний “ki” буюу “сэтгэл” гэсэн үг орсон хэлцийн орчуулгад ажиглалт хийх явцад хэдийгээр япон, монгол хүмүүс “сэтгэл” гэх хийсвэр зүйлийг биетэй, хүрч болдог, бас хөдөлдөг зүйл гэж үздэгээрээ ижил боловч тэрхүү “сэтгэл” гэдэг зүйлийн хийж байгаа үйлдэл, дүрслэгдэж байгаа байдал өөр байгаа тул утгачлан орчуулах аргыг илүү олон хэрэглэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, тухайн хэлц үгээр япон, монгол хүмүүсийн сэтгэл хэмээх зүйлийг таньж ойлгож байгаа байдал ялгаатай байгаа учраас япон хэлний өвөрмөц хэлцийг монгол хэлээр утгачлан тайлбарлаж орчуулах нь илүү зохимжтой байна гэж ойлгож болох юм.

Эрдэмтэн Ж.Баянсан (2002:18) “Монгол хэлний СЭТГЭЛ гэдэг үгээр чухам юуг нэрлэн тэмдэглэж байгааг зөвхөн энэ дан үгээр нь бодож үзвэл барим тавим зүйл ер санаанд буухгүй, маш хийсвэр ойлголт болох нь тодорхой байдаг. Тэгвэл энэ концепцийн агуулга багтаамжийг гагцхүү түүнийг тодорхойлсон холбоо нэрлэлтээс олж мэдэхээс өөр аргагүй болно” гэж тодорхойлжээ. Мөн тэрбээр “сэтгэл” нь хийсвэр зүйл хэдий ч монгол хүмүүс сэтгэлийг цагаан сэтгэл, сүүн сэтгэл, шунаг сэтгэл, атгаг сэтгэл гэм мэтээр ярьдаг нь монголчуудын хувьд сэтгэл нь ямар нэгэн “өнгө”-тэй. Сэтгэл уйддаг, давчиддаг гэж ярьдаг. Тэгэхээр сэтгэл нь хүнтэй адил “амьдлийн” зүйл юм байна. Сэтгэл нь бас хөрж, ганддаг учраас “бодислиг” зүйл юм гэж үзсэн байна.

Мөн судлаач Итоо Харүки (1989:386) “сэтгэл бол нүдэнд үзэгддэггүй, гарт баригддаггүй хийсвэр зүйл. Сэтгэл гэж юу вэ гэсэн асуултад яг тодорхой хариулсан тодорхойлолт ч байхгүй. Тэгсэн хэдий ч хүүхэд л биш бол сэтгэл гэж юу вэ гэж асуухааргүй хэмжээний сэтгэлийн талаар хүн бүр мэддэг юм шиг тийм ойрхон зүйл байдаг.” гэж хэлсэн байна. Үнэхээр л бид өдөр тутамдаа өөрсдийн мэдэрч буй мэдрэмжээ сэтгэл гэсэн үг оруулан бусдад хэлж ойлгуулдаг. Түүнчлэн хүний мөн чанарыг тодорхойлохдоо ч бас сайхан, муухай сэтгэлтэй гэж ярьдаг.

Япончуудын хувьд ki ga omoi (気が重い) буюу сэтгэл хүнд, ki ga chiisai (気が小さい) буюу “сэтгэл жижиг”, ki ga ookii (気が大きい) буюу “сэтгэл том” гэж ярьдаг. Тэгэхээр япон хүний хувьд сэтгэл нь том жижиг хэмжээтэй, бас тодорхой хэмжээний жинтэй зүйл байдаг юм гэж хэлж болохоор байна. Мөн бас ki ga hayai (気が早い) буюу “сэтгэл хурдан”, ki ga tatte iru (気が立っている) буюу “сэтгэл босох” гэж байдаг. Энэ нь сэтгэл ямар нэгэн газар байж байгаад тэр байрнаасаа хөдөлдөг зүйл байж болох юм. Тэрчлэн ki ga sawaru (気が障る) буюу “сэтгэл саад

болох”, ki ga sasu (気が差す) буюу “сэтгэл хатгах” гэж хэлдэг нь сэтгэл нь хүрч болдог биетэй зүйл юм байна.

Дээрх байдлаар хэл, соёл, танихуйн үүднээс задлан шинжилгээ хийнгээ япон сурвалжаас түүсэн 102 хэлцэд багтсан, монгол хэлээр орчуулагдаагүй 27 хэлц үг байсныг орчуулав. Ингэж орчуулахдаа эрдэмтэн Д.Дашдаваагийн загварчилсан орчуулгын аргуудыг хэрэглэсэн болно (Хүснэгт 2.).

Хүснэгт 2. “Ki” буюу “сэтгэл” гэсэн үг бүхий хэлцийг орчуулсан аргууд

Орчуулгын аргууд	Хэлцийн тоо	Эзлэх хувь
Дүйцүүлж орчуулах арга	7	25.9
Аналоги арга	6	22.2
Утгачлан тайлбарлах арга	12	44.4
Холимог арга	2	7.4
n= 27		

Хэлцийг орчуулахдаа утгачлан тайлбарлах аргыг илүү олон хэрэглэв. Жишээ нь: “ki ga ueru”(気が飢える) үгчилбэл “сэтгэл өлсөх” гэх бөгөөд “aru mono ni hijou ni ketsubou o kanjite, sore o hidoku hoshigaru”(あるものに非常に欠乏を感じて、それをひどく欲しがる) буюу “ямар нэгэн зүйлээр маш их дутагдах мэдрэмж төрж, түүнийгээ ихэд хүсэх” гэсэн утгатай хэлц юм. Монгол хэлээр энэ хэлцийг шууд хуулбарлан буулгаж болох ч “сэтгэл өлсөх” гэх нь монгол хүний оюун санаанд бүрэн бууж өгөхгүй болов уу. Монгол хүний хувьд ямар нэгэн зүйлээр маш их дутагдах мэдрэмж төрж, түүнийгээ ихэд хүсэхийг “цангах” гэдэг үгээр ихэвчлэн илэрхийлдэг нь олон байдаг. Монгол хэлний “цангах” гэдэг үг нь “ундаасах, унд хүсэх” (Я.Цэвэл, 1966: 782) гэсэн утгатай. Нүүдэлчин монголчуудын хувьд малын ус хамгийн чухал, мал усгүй байх нь өвсгүй байхаас илүү муу гэж үздэг тул усгүй байх, цангахыг илүү гачигдалтай гэж үздэг. Харин Япон улсын хувьд бүх талаараа усаар хүрээлэгдсэн, чийглэг уур амьсгалтай, бороо хур их ордог гэдгээрээ онцлог орон юм. Тиймээс япончуудын хувьд ундны усаар дутагдаж “цангах”-аас илүү “өлсөх” бэрхшээлтэй тулгарах нь хэцүү санагдаж, үүнээс үүдэн “сэтгэл өлсөх” гэсэн хэлц үг гарсан гэж хэлж болохоор юм. Тиймээс “ki ga ueru”(気が飢える) гэдэг хэлцийг “ихээр хүсэх” гэж утгачлан орчууллаа. Энэ мэтчилэн япон хэлний ki (気) буюу “сэтгэл” гэсэн үг орсон хэлц үгийг орчуулахдаа эхлээд яагаад ингэж хэлдэг болсон тухай, энэ нь япон хүний ахуй соёл, сэтгэлгээтэй хэрхэн холбогдож байгааг үндэслэн орчуулав.

Мөн япон хэлний ki ga hairu (気が入る) буюу “сэтгэл орох” гэсэн хэлц нь “хичээх, хичээнгүй болох” гэсэн утгатай байна. Үүнийг орчуулахдаа тайлбар үгээр нь шууд орчуулан “хичээнгүй болох” гэж орчуулсан. Эндээс бид хэлцийг утгачлан тайлбарлаж орчуулах аргын нэг давуу талыг харж болох юм. Тэр бол аливаа хэлэнд хэлц үгийн утгыг тайлбарласан эх хэлний тайлбар толь бичиг байдаг бөгөөд толь бичгийн эх хэлээрх тайлбар бол тухайн хэлцийн утгыг хамгийн оновчтой тайлбарласан хувилбар гэж ойлгож болно. Утгачлан тайлбарлах арга бол угийн тухайн хэлцийг чөлөөт холбоо үгээр тайлбарлаж орчуулах арга тул эх хэлнээ тайлбарласан тайлбарыг шууд орчуулан буулгах нь ч бас энэ аргад багтах учиртай. Тиймээс хэлц үгийг утгачлан тайлбарлах аргаар орчуулахад хэлцийн эх хэлний тайлбарыг ашиглаж болдог нь давуу тал юм.

Дүгнэлт

Хэлц үг бол зөвхөн тухайн үндэстний хэлэнд буюу тухайн соёлын хүрээнд үйлчилж байдгаараа ард түмний соёл, ёс заншил, сэтгэлгээний онцлогийг өөртөө агуулж байдаг, бусад ард түмнээс ялгарах гол илэрхийлэл юм. Иймд аливаа хэлцийг орчуулна гэдэг нь тухайн улс орны соёл болоод уламжлалт аж ахуй, сэтгэлгээ, зан заншил, ертөнцийг үзэх үзлийг өөрийн хэлээр нэвтрүүлэн таниулна гэсэн үг. Япон хэлний хэлц үгийг монгол хэлээр орчуулсан аргын судалгаа, мөн япон хэлний “сэтгэл” гэх үг орсон хэлцийн орчуулагдсан байдал, зарим баримтыг орчуулах үйл явц зэргээс үзэхэд япон хэлний хэлц үгийг монгол хэлээр орчуулахдаа утгачлан тайлбарлах аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой байна.

Номзүй

- Араи Шиничи., Сэржав Б. (2009) “Япон монгол толь бичиг”, УБ
- Баянсан Ж. (2002) Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, УБ
- Гүн-Үйлс Д. (2008) “Орчуулга, найруулга зүй”, Мөнхийн үсэг ХХК
- Дэлгэрмаа А. (2011) “Япон-Монгол хэлний хэлцийг орчуулах араг, зарчмын судалгаа” докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, УБ
- Дэмбэрэл С. (2012) “Япон-Монгол их толь бичиг” нэг дүгээр боть, УБ
- Золзаяа Д. (2003) “Монгол-Япон хэлний өвөрмөц хэллэгийн харьцуулсан судалгаа /Хүний бие, эрхтний нэр орсон хэллэгийн жишээн дээр/” магистрын ажил
- Нансалмаа Н., Долгор С. (2014) “Танихуйн хэл шинжлэл”, УБ
- Сүхбаатар Ц. (1988) “Орчин цагийн монгол хэлний найруулгазүй”, УБ
- Уранцэцэг Л., Цэрэнханд Г. (2007) “Угсаатны сэтгэл судлал”, УБ
- Цэвэл Я. (1966) “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ
- Чулуунбаатар Л., Онон Ц. (2009) “Япон, монгол хэлний өвөрмөц хэлцийн толь”, УБ
- 李尚勲(2015) 「『気』を使用した慣用句の意味と使い方」『日本文化レポート 99』
https://ir.lib.hiroshima-ac.jp/files/public/3/38918/20160122144707991228/ReportJTP_14_40.pdf
- 呉琳 (2016) 「日本語の慣用句に関する研究の概観」『日中語彙研究』(6), 87-105. 愛知大学中日大辞典編纂所
- 林四郎、野一元菊雄、南不二男、国松昭 (2002) 『例解新国語辞典』第六版
- 森田 良行 (1966) 「慣用的な言い方」:61-78 講座日本語教育 第2分冊
- 白石大二 (1977) 「解説 国語慣用句とその研究のもたらすもの」『国語慣用句大辞典』: 525-593. 東京堂出版
- 伊藤眞 (1989) 「Phraseologic をめぐる諸問題」『福岡大学人文論叢』第21巻 第1号: 385-411
- 石田プリシラ (1996) 「日英語の対照研究『目』の慣用句を中心として」『筑波応用言語学研究』3: 49-63. 筑波大学文芸・言語研究科 応用言語学コース
- Goo 辞書: <https://dictionary.goo.ne.jp/>

Хавсралт: “ki” гэх үг бүхий хэлц үгийн орчуулга

1. 気があせる	Үгч: сэтгэл сандрах	Орч: сэтгэл тэвдэх
2. 气がいい	Үгч: санаа сайн	Орч: сайхан сэтгэлтэй
3. 気がそがれる	Үгч: санаа алга болох	Орч: хүсэлгүй болох
4. 気がない	Үгч: санаа байхгүй	Орч: санаа төрөхгүй байх
5. 気が乗る	Үгч: сэтгэл мордох, унах	Орч: сэтгэл бадрах
6. 气が入る	Үгч: сэтгэл орох	Орч: хичээнгүй болох
7. 気が回る	Үгч: сэтгэл эргэлдэх	Орч: хүн бүрт санаа тавих.
8. 気に変になる	Үгч: сэтгэл эвгүйрэх	Орч: дотор сонин болох
9. 気が変わる	Үгч: сэтгэл өөрчлөгдөх	Орч: санаа хувирах
10. 気が尽きる	Үгч: сэтгэл барагдах	Орч: сэтгэл хоосрох
11. 気が引ける	Үгч: сэтгэл халшрах	Орч: зүрх алдах, бэргэх
12. 気が減る	Үгч: сэтгэл хорогдох	Орч: сэтгэл үймрэх
13. 気が若い	Үгч: сэтгэл залуу	Орч: залуу сэтгэлгээтэй
14. 気が触れる	Үгч: сэтгэл хөндөх	Орч: сэтгэл нь хямрах
15. 気が詰まる	Үгч: сэтгэл бөглөрөх	Орч: дотор давчдах
16. 気が通る	Үгч: сэтгэл нэвтрэн гарах	Орч: сэтгэлийг татах
17. 気が飢える	Үгч: сэтгэл өлсөх	Орч: ихээр хүсэх
18. 気が高ぶる	Үгч: сэтгэл тэвдэх	Орч: сэтгэл гэгэлзэх
19. 気で気を病む	Үгч: сэтгэлээр сэтгэлээ өвтгөх	Орч: дэмий зүйлд сэтгэлээ чилээх
20. 気を取る	Үгч: сэтгэлийг авах	Орч: сэтгэлийг тайвшруулах
21. 気を回す	Үгч: санаагаа эргэлдүүлэх	Орч: сэрэмжтэй байх
22. 気を失う	Үгч: сэтгэлээ гээх	Орч: сэтгэлээр унах
23. 気を尽くす	Үгч: сэтгэлээ шавхах	Орч: сэтгэлээ зориулах
24. 気を張る	Үгч: сэтгэлээ татаж, чангаах	Орч: сэтгэлээ чангалах
25. 気を抜く	Үгч: сэтгэлээ тайлах	Орч: тайвшрах
26. 気を砕く	Үгч: сэтгэлээ бутлах	Орч: сэтгэлээ мохоох
27. 気を移す	Үгч: сэтгэлээ зөөх	Орч: сэтгэлээ хувиргах



УЛС ТӨРИЙН ИЛТГЭЛИЙН ОРЧУУЛГА ДАХЬ СОЁЛЫН НӨЛӨӨ

О.Мөнхчимэг⁴⁴

Abstract: In recent years with political translation, this is considerable demanding subject for translating political texts and translation as a political statement, and topics relevant to political contexts are central to the analysis in both linguistic and social sciences. Agreeing there are always talks about power or resistance when a text or an action is likely to be political and thanks to the translations of political contexts and behavior, this has a wide range of information and data from countries to countries, not limited to nationalities as the translation is played the core tool for bridging. More likely, this contributes a lot unto the development of political discourse. In the way of translating such materials, this opens the opportunities to see and taste different political views, beliefs, and social conditions related to the translation database collected for the theoretical frameworks in the fields of both translation studies and linguistics. The study is to be basing on the translation materials, followed by the political speeches and interviews, research, theoretical concepts, reviews, related terms, research methodology, research literature, examples, specific politicians' speeches, sourced from English into Mongolian language. It focuses on the challenges and difficulties encountered in the two-language translation process, the experience and solutions gained in the research process, and summarizes the basic research work on the cultural impact of the translation of political speeches and interviews in particular. The study is examined in detail by highlighting cultural influences to political speeches and interviews, which may lead to produce complex translation works for further research works but the fact that there is no recipes for translating a political speech.

Key words: Translation methods, and techniques, political discourse, translation experience, discourse analysis, speech with purpose.

Энэхүү судалгаагаар англи хэлнээс эхтэй ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө тавигдсан аливаа бичвэр, шууд ярилцлага, хэлэлцүүлэг, илтгэлийг багтаасан нийт 231 тооны аман болон бичгийн хэлбэрийн дискурс яриаг судалж, тэдгээрт тулгуурлан хийгдсэн орчуулга, соёл хоорондын шүтэлцээний асуудлыг хөндсөн болно. Ингэхдээ хэлний хэрэглээний түвшний судалгаа (Brown & Yule, 1983)-г улс төрийн текст орчуулах ажилтай хослуулан дискурсийг дахин текстжүүлэх анилиз буюу реконтекст анхдагч эх бичвэрийн утгыг анхны контекстийн утгаар аливаа өнгө аяс, утгазүйг алдагдуулахгүй хоёрдогч хэлэнд буулгах (Li & Xu, 2018) анализууд дээр түлхүү ажилласан. Улс төрийн дискурсийн уран яруу хэрэглүүр, соёлын өнгө аяс бүхий утга агуулгыг тухайн эх сэдвээс орчуулахдаа Вермеер 1970-аад онд орчуулгын онолд нэвтрүүлсэн өдгөө хамгийн чухалд тооцогдох онолын ойлголт болох Скопосын онолыг ашиглан (скопос нь грекээр “зорилго” гэсэн утгатай) тухайн улс төрийн ярилцлага, илтгэлүүдийн харилцааны явцад гаргаж буй дискурс санааны тодорхой зорилго чиглэлийг судалж ярианы метафункцид дүн шинжилгээ хийж үзсэн болно (Vermeer, 1989/2000). Түүнчлэн орчуулгыг судлаач эрдэмтэн Рейссийн (1977/1989) дэвшүүлсэн дөрвөн ангиллаар хувааж (үүнд: мэдээллийн, илэрхийллийн, үйл ажиллагааны болон хэвлэлд өгсөн) үзсэн.

⁴⁴ ХИС, Хэл, соёлын сургууль, Англи хэлний тэнхимийн багш, Докторант

Хэл, соёл, нийгмийн шүтэлцээтэйгээр орчуулах үйл явц нь аль нэг хэлэнд бичгээр болон аман хэлбэрээр илэрхийлсэн мэдээллийг өөр нэг хэлний хэрэглүүрээр дамжуулах бүтээлч ажил тул орчуулах явцад тухайн хоёр хэлний хэв шинжийн ялгаа, уг хоёр хэлээр ярилцагч ард түмний түүх, соёл, амьдрал ахуй, орчин нөхцлийн онцлогоос үүдэлтэй орчуулгын өнгө аяс, утга санааг зөв гаргахад соёлын шинжтэй олон асуудал хөндөгддөг. Энэ бүхнийг даван туулахад өмнөх үеийн орчуулагчдын хуримтлуулсан туршлага, орчуулгазүйн онолын ойлголт, тухайн орчуулах сэдвийн талаарх өргөн мэдлэг, мэдээлэл, орчуулгын туршлага, соёлын нөлөө асар их. Иймд орчуулга нь тэр дундаа улс төрийн агуулга бүхий орчуулгад зөвхөн хэл шинжлэлээс гадна нийгэм, түүх, байгаль шинжлэл зэрэг олон салбар ухааныг хамруулж ойлгох юм (Л.Туул, 2010:68). Орчуулгын онолд эх бичвэр, ярианы хэл, орчуулах хэлний үгийн сан, хэлзүйн болон үг хэллэгийг холбон найруулах, утга дүйлгэх, тухайн хоёр хэлээр хэлэлцэгч ард түмний соёлын зөрөөнөөс шалтгаалсан реали үг хэллэгийг орчуулгад зөв зүйтэй гаргах явдал цөөнгүй тохиолдоно. Зөв зүйтэй орчуулга, соёл шингээсэн орчуулгыг зорилтот уншигчдад хүргэх, найруулгазүйн асуудлыг чухалчлах зэрэг нь тухайн хэлний хэм хэмжээний хүрээнд урьдаас бэлтгэгдсэн эх бичвэр, ярианы дискурс, санааг яаж оновчтой, бүрэн төгс илэрхийлэх тухай нийт хэл бичгийн ухааны олон салбарын асуудал тул орчуулга судлалд тухайн нийгэм, соёлыг ойлгох явдал асар их ач холбогдолтой. Орчуулга нь найруулгазүй, соёлын шүтэлцээ, хэлний хэм хэмжээ бол тухайн хэлээр хэлэлцэгч улс түмний хамгийн зүй зохистой, үлгэр дууриал болохуйц бүтэц, бодит ахуй байдлыг үнэн зөв харилцагч хэлэнд хөрвүүлэх явдал чухал тул энд орчуулгын төдийгүй, хэл, соёлын төвшинг илэрхийлсэн нарийн тогтолцоо хөндөгдөх нь зүйн хэрэг юм (Р.Гүрбазар, 1996:182).

Аливаа хэлэнд урьдаас тогтсон систем болох хэлний хэм хэмжээг алдагдуулахгүй, орчуулгын явцад эх санааны хувьсал өөрчлөлт, өнгө аясыг утга, найруулгазүйд шингээж өгөхөд соёлын асуудал чухал. Жишээ нь: орчуулахдаа хэлний яруу илэрхийллийн олон хэрэглүүрийг чадамгай ашиглах, найруулан бичих арга барил, дуун хөрвүүлгийн аргуудыг аль тохирох хувилбарыг ашиглах, төрөл бүрийн улс төрийн ярилцлага, илтгэлүүдийг соёлын онцлогтой уялдуулж, текстийн төрөл, орчуулгын стратеги хоорондын уялдаа холбоог гаргаж, орчуулгын бүтээлийн хоёр үндсэн төрөл болох аман болон бичгийн хэлбэрээс тухайн эх хэл дээр улс төрийн фигурын талаарх мэдээлэл, намтар, арга барил, тухайн нийгэм, цаг үеийн талаарх нарийн судалгаа явуулж байж сая орчуулга нэг бүрийг хийж гүйцэтгэсэн болно.

Онолын үүднээс тайлбарлавал тухайн хэлний соёлын харилцааг судалж (Норд, 1988/1991:72) зорилтот текстийн хүрээнд зохих орчуулгын стратеги ашиглан орчуулгыг хоёрдогч хэл рүү (Жи, 2017:54) хөрвүүлэхдээ тухайн эх бичвэрийн яригч, илтгэгч, зохиолчийн болоод зорилтот сонсогчдод хандсан тухайн үеийн сэтгэл хөдлөл, илэрхийлж буй сэтгэлгээ, тухайн нийгмийн соёл зэргийг харилцан бодолцож орчуулдаг. Орчуулгын явцад эх бичвэрийн утга санааг алдагдуулахгүй, мөн өөрийн үндэстний соёл, зан заншил, ард түмний сэтгэхүйн онцлогтой уялдуулахаар оролдсон болно. Хэл нь тухайн улсын соёлыг дамжуулдаг хэрэглүүр бөгөөд аливаа улсын соёл, ахуй амьдрал, ёс заншил, хэл яриа өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Үндэстний хэл бүр тухайн үндэстний соёлын дүр төрхийг харуулж, улсын соёл бүрэлдэн тогтох, хөгжихөд шууд нөлөөлдөг гэж үздэг. (Э.Равдан, 2005)

Хэл, соёл оршин байж, сая хүн төрөлхтөн, аль нэг үндэстэн ястны ертөнцийг үзэх үзэл, хорвоог танин мэдсэн байдал, түүнд хандах хандлага, байгаль, нийгмийн юмс үзэгдэл, үйл, хэрэг явдал, шинж чанар тэргүүтнийг тодорхойлохын зэрэгцээ тэрхүү онцлог уг үндэстний сэтгэлгээний тогтвортой хэв шинж болж, улмаар төрөлх хэлнийх нь ямар баримт хэрэглэгдэхүүнд тусч илэрсэн болохыг судалдаг (Ж.Баянсан, 2010). Сүүлийн жилүүдэд орчуулга, соёлын шүтэлцээний талын судалгаа илүүтэй анхаарлын төвд судлагдсаар байгаа (Romagnuolo, 2009:1) нь улс төрийн хэл тусгайлсан зорилгын хүрээнд хэлийг ашиглаж буй хэрэг гэдгийн тод

жишээ болно. Тэр дундаа улс төрийн орчуулгад ашиглагдаж байгаа үгийн сонголт тэдгээрийн ухагдахуун, үүсэл гарвал, найруулга гээд хэлзүйн бүхий л түвшинд соёлын нөлөө асар их. Иймд судалгааны хэрэглэгдэхүүн болгон улс төрийн орчуулгын ажилд соёлын нөлөө, тусгалыг судалж эхэлсэн ба үүгээр зөвхөн орчуулга бус тухайн улс үндэстний ертөнцийг үзэх үзэл, үзэж туулснаа илэрхийлж буй байдал, оюуны хэм хэмжээ нь чухамхүү тэдний хэлээр дамжин илэрхийлэгдэн гарч буй санаанд нь агуулагдаж буй ажгуу. Өгүүлэлдээ Америкийн нэрт хэл судлаач Э.Сапир, Б.Л.Уорф болон бусад нэр бүхий эрдэмтдийн хэл, соёлын талаар дэвшүүлсэн тодорхойлолт үзэл санааг чухалчлан, онолын үүднээс авч үзсэн бөгөөд улс төрийн агууламжтай аливаа орчуулгын явцад хэл, соёл хоорондын холбоо, шүтэлцээний талаар судлаачдын дэвшүүлсэн онолын үүднээс жишээгээр баяжуулан, дүгнэлтийг хавсаргахад чиглэсэн болно. Тэр дундаа англи хэлээр яригч орны улс төрчдийн сэтгэлгээний онцлог, түүнийгээ илэрхийлэн гаргаж буй байдал, соёлт нийгмийн орчин зэрэг нь монгол хүмүүсийн сэтгэлгээ, хүлээж авах өнцгөөс тэс ондоо төдийгүй, яриа, илтгэлдээ авч буй жишээ нь хүртэл эрс ялгаатай байгаа нь ажиглагдаж байв. Тухайлбал: Барак Обама Ардчиллын конвенцид хэлсэн үгэндээ: *The Republican nominee, John McCain, has worn the uniform of our country with bravery and distinction, and for that we owe him our gratitude and respect.* Үүгээрээ тэрээр нийгэм, нийтэд өөрийн эрх мэдлээ нэмэгдүүлэх зорилгоор хоёр чухал арга ашигласан нь: Мккэйн-тай, мөн түүнгүй Америкийн өнгө төрхийг тал тохой засахгүйгээр илэрхийлсэн. Тэрбээр илтгэлдээ Мккэйн гэдэг нэрийг нийтдээ 21 ашигласнаас 5 удаа сенатор Мккэйн, нэг удаа Сенатич, 1 удаа Бүгд Найрамдах намаас нэр дэвшигч, 14 удаа Жон Мккэйн гэж ашигласан байдаг. Мөн тэрбээр хэлсэн үгэндээ Мккэйн-г олон удаа дурьдсан нь түүнийг Бүгд Найрамдах намын нэр дэвшигч төдийгүй Вьетнамын дайны ахмад дайчин, эх орондоо хийж бүтээсэн бүхнийг нь хүндэтгэж буйгаа илэрхийлэхдээ илүүтэй егөөдлийн өнгө аястай хүүрнэж, түүнийг шууд тэтгэвэрт гарах гэж буй нэгэн гэхээс зайлсхийж, харин оронд нь маш соёлч, эелдэг байдлаар гаргасан байна. Иймээс орчуулгын судлалд улс төрийн дискурс шинжилгээ хийснээр аливаа хэлний хэрэглээнд өөрчлөлт оруулах, илтгэгч өөрийн эрх мэдлээ олж авахад хэлийг ашиглан нийгэмд нийгмийн хийгээд соёлын өөрчлөлт бий болгохоор зорьж буйн тод илрэл болсон. Дискурс анализ нь хэл, соёл, нийгэм, хэлшинжлэлийн салбар хоорондын шинжлэх ухаанд тусгайлсан онцлох үүрэгтэй. Мөн тэрээр ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж, ялсны дараа тангараг өргөх ёслолын илтгэлдээ олон нийтэд илүү хүртээмжтэй бөгөөд яриа нь сонсогчдод илүү дотно хэв маягийг төрүүлэх яруу хэрэглүүр ашигласан нь ч, тэр зорилгодоо ард түмнээ багтааж, нийгэм, нийтийн бодол, соёл, сэтгэлгээг илүүтэй чухалчилсан богино өгүүлэмжээс харагдсан болно. Судалгаанаас үзэхэд аливаа улс төрийн эх бичвэрийг орчуулан, цааш гүнзгийрүүлэн тайлбарлах, задлан шинжлэх нь хэл-соёлын шүтэлцээ, хэл ба нийгмийн харилцан хамаарлын хүрээнд багтаж буй асуудал юм. Зарим судлаачдын тодорхойлсноор товчхон авч үзвэл хэл, соёл нь дараах шүтэлцээтэй. Үүнд: аж хэрэглээний үүднээс хэл, соёлын харьцаанд хөтлөгч хүчин зүйл нь соёл бөгөөд соёл нь хэлэнд нөлөөлж, хэлийг тодорхойлогч болно; хэл, соёл нь хүн хийгээд хүний аж байдал, хүчин зүйлгүйгээр үл оршино. Тийм учраас хүний хүчин зүйлийн асуудал нийт хэл шинжээч, орчуулагч, дуун хөрвүүлэгчдийн анхаарлын төвд орших учиртай. Түүнчлэн хэл нь соёлыг түгээгч, дамжуулагч гол гүүр, хэрэглүүр юм. Хэл, соёлын шүтэлцээний тухай асуудал нь орчин үеийн гадаад хэл заах аргын хүрээнд хэл шинжлэлийн нэгэн хавсарга судлал билээ. Соёл нь ард түмний түүхэн цаг хугацаанд хэвшиж дадсан амьдралын хэв маяг юм. Харин хэл, соёлын шүтэлцээг тухайн улс үндэстний, ард түмний түүхэн цаг хугацааны явцад хэвшин тогтсон амьдралын хэв маяг загварчлагдан хэлэндээ шингэж, хэл өөрөө эргээд энэхүү ёс заншил, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх хэрэгсэл болдог. Тухайлбал, хэл, соёлын холбоо хамаарлыг тодорхойлдог хэлний тогтвортой илэрхийллийн нэг нь зүйр цэцэн үг бөгөөд энэ нь өвөрмөц хэлцийн бие даасан нэг хэлбэр гэж ойлгогддог. Тэгвэл энэ төрлийн санааг орчуулахад үндэстний сэтгэлгээний онцлог, соёл,

уламжлалыг харгалзан орчуулах нь асар чухал болохыг бид тодхон харж болох юм. Хэрвээ текст (эх бичвэр)-ийн соёлын талыг үл тоомсорловол орчуулгын үйл явцад төдийгүй орчуулгын чанарт нөлөөлдөг. Орчуулгын прагматик хандлага, соёлын бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх нь ач холбогдолтой (Blakesley & Munday 2018; Ginter 2002; Lefevere 1999; Maitland 2017; Newmark 1988; Olalla-Soler 2015; Valerio 2013; Vermeer 1978; Reiss 1981).

УЛС ТӨРИЙН ХЭЛ БА ОРЧУУЛГЫН АСУУДАЛ

Улс төрийн хэл бол тодорхой зорилготой хэлийг үйлдэл, илэрхийллийн зэвсэг болгон ашиглаж буй нэг талт хэл. Сүүлийн жилүүдэд улс төр судлаачид энэ сэдвийн хүрээний судалгааг улам их сонирхох болсон (Ромагнуоло, 2009:1) байна. Нэн ялангуяа аман хэлбэрийн улс төрийн илтгэл, хэлэлцүүлгийг англи хэлнээс монгол хэлэнд орчуулахад дан ганц хэлзүй, үгзүй, найруулгазүйн асуудал хөндөгдөөд зогсохгүй тухайн илтгэгчийн зан байдал, үйл хөдлөл, нүүрний хувирал, гарын хөдөлгөөн гэх мэт, тухайн орчин, зорилтот сонсогчид хүртэл нөлөөлөх бөгөөд тэдгээр нь нэгдэж байж сая утгыг бүрэн төгс гаргах бололцоотой болохыг ажиглав. Энэ дагуу дүйцлийн, ойролцоо утгаар орчуулах эквивалент (синоним) зэрэг орчуулгын аргуудыг ашиглаад зогсохгүй нэг эх бичвэрийг орчуулахад л тухайн илтгэгч, сонсогч, илтгэгчийн өмнөх ярилцлага, илтгэл, тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдал харилцан уялдаатай оролцож, зөвхөн нэг агуулга орчуулах бус хэлэлцэгдэж буй сэдвийн хүрээнд суурь мэдлэг, нэн ялангуяа тухайн соёлын нөлөө асар их байв. Улс төрийн эх бичвэрийг үнэн зөв, алдаа мадаггүй төрөлх хэлнээ хөрвүүлэхэд улс төр судлаач байх шаардлагатай биш авч улс төрийн хүрээний түгээмэл нэр томьёо, түүнчлэн хэл шинжлэлийн онол, практиктай хослуулах зайлшгүй шаардлага тулгарсан билээ.

Ингэснээр хэлний корпусыг ашиглан улс төрийн илтгэлүүдийг монгол хэл рүү орчуулж, тэдгээрт анализ хийх боломж бүрдсэн юм. Түүнчлэн соёлын агуулгыг тусгасан орчуулгын бүтээлийн бие даасан байдал нь эл харилцааны зорилгыг ойлгоход асар их түлхэц болсон юм. Түүнчлэн Америкийн улс төр, засаглалын стратеги, бодлого үйл ажиллагаа нь олон улс оронд улс төр, эдийн засаг, дипломат харилцаа, соёл гэх мэт хүчин зүйлийг ойлгоход нөлөөлсөөр ирсэн тул улс төрийн эл ярилцлага, илтгэлүүд нь аливаа улс төрийн бүлэг, нам үүсгэхэд асар их нөлөөтэй төдийгүй, англи хэл дээрх улс төрийн дискурс орчуулах нь олон улс, үндэсний соёл, харилцааны нөхцөл байдлыг монголчуудад харах, суралцах боломжийг олгож буй хэрэг билээ. Энэ ч утгаараа улс төрийн орчуулга нь яах аргагүй аливаа улсын асуудлыг дэлхийн хэмжээнд хэлэлцэх бололцоог олгоод зогсохгүй тухайн бичвэр, яриа, эх ярилцлага, илтгэлийг орчуулахад зөвхөн хэлшинжлэлийн үүднээс тайлбарлах нь өрөөсгөл тул улс төрийн эх бичвэрийг орчуулахад тухайн соёлын нөлөөг тусгал болгон судалсан болно. Улс төрийн орчуулга нь улс төрийн хүрээнд үл тоомсорлодог боловч үнэндээ улс төрийн үйл ажиллагааны бүхий л хэлбэр, хүрээг илэрхийлдэг (Schäffner & Bassnett, 2010:22). Шаффнерийн бүтээлд дурдагдсанаар улс төрийн аливаа яриа нь орчуулгаас ихэвчлэн хамааралтай байдаг бөгөөд энэ нь үндэсний хэмжээнээс гадна олон улсын чанартай мэдлэг, мэдээллийг нээлттэй байлгах үүрэг, зорилго агуулдаг (Шафнер, 2004:120). Улс төрийн орчуулгын цаана “гадаад улс орнуудын улс төрийн үйл явдал, удирдагчийнх нь хувийн зорилтот соёлыг уншигчдад мэдээлэх нь эргээд бусад улс үндэстнүүдийн ирээдүйд нөлөөлж болохуйц үр нөлөө авчирч болзошгүй” юм (Ромагнуоло, 2009:23). Даяаршлын хүрээнд улс төрийн орчуулга сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдэж байна. Хэл нь улс төрийг явуулахад зайлшгүй шаардлагатай (Шафнер, 2004:117–118), улс төрийн орчуулга нь үндэсний хил хязгаараас гадуур мэдээллийг нээлттэй байлгах хэрэгсэл болох нь улс төрийн яриаг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг (Шафнер, 2004:120) бөгөөд энэ нь прототип утгаараа "улс төрийн үзэл санаа, итгэл үнэмшил, нийгмийн байдал"-ын талаар хэлэлцэх улс

төрийн хүрээг ойлгоход тухайн орчуулгын текстүүдийг чухал ач холбогдолтой (Шафнер, 2004:119). Улс төрийн чиглэлийг орчуулах нь олон улсын хийгээд олон нийтийн харилцааны орчуулга (Lv & Zhou, 2014) -д чухал гэж үздэг бөгөөд энэ нь олон улсын нийгэмд батлагдсан стратеги, бодлогыг илүү сайн ойлгоход туслах болно гэж үзэж байна (Huan et al, 2014:5).

Орчуулгын судалгаагаар улс төрийн орчуулгын жанрын шинжилгээ боловсруулахад “тодорхой академик болон мэргэжлийн нөхцөлд явагдаж буй ярианы зарим үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, нягтлах” шаардлага тулгарна (Bhatia & Nodoushan, 2015:22).

Үүргийн (функционалист) талаас нь авч үзвэл улс төрийн орчуулгыг тодорхой зорилготой орчуулгын төрөл зүйл гэж үзэж болно. Гэсэн хэдий ч улс төрийн орчуулгын харилцааны зорилгыг янз бүрийн туршлага, нийгэм соёлын үндэслэлтэйгээр орчуулагч нар янз бүрээр ойлгож болно. Ерөнхийдөө улс төрийн орчуулгын дүн шинжилгээг улс төрийн ярианы талбарт онцгой хамааралтай гэж үздэг (Шафнер, 2004:145). Улс төрийн эрх мэдлээ хэрэгжүүлэх, хэл ярианы хоорондын хамаарлыг ойлгоход туслах үүднээс улс төрийн орчуулгыг хэрэгсэл болгон ашиглах нь ч бий (Gagnon, 2010:253).

Улс төрийн орчуулгын олон судалгаа орчуулгын шилжилт, үзэл суртлын манипуляцийн хоорондын уялдаа холбоонд анхаарлаа хандуулах хандлагатай байдаг ч орчуулгын бүх сонголтыг сониуч байдлаар хийдэггүй тул судлаачид дүгнэлт хийхдээ болгоомжтой хандах хэрэгтэйг тэмдэглэх нь зүйтэй (Munday, 2007:200). Орчуулагчаас асуухгүйгээр үзэл суртал, үзэл бодол, орчуулгын шилжилт хоорондын хамаарлыг тодорхойлоход хэцүү байдаг (Gagnon, 2010:255). Орчуулга нь харилцааны үр нөлөөний шилжилттэй хэрхэн уялдаж байгаа нь орчуулагчийн үзэл бодлын хоорондох динамик, үзэл суртлын эсвэл харилцан ойлголцлын хоорондох динамикийг илүү сайн ойлгоход тусална. Энэ ч талаасаа авч үзсэн улс төрийн орчуулгаас хэлэхүйн олон төрлийн хувирал гарч ирэх төдийгүй, соёлын ойлголтыг хөндөхгүй байх аргагүй болж ирж байна.

Дүгнэлт

Хэл, соёл нь бүхэлдээ тухайн нийгмийн толь гэлтэй харилцан хамааралтай зэрэгцэн оршиж буйг энд тэмдэглээд судлаачийн хувиар дараах дүгнэлтэд хүрч байна.

Улс төрийн орчуулгын хүрээнд хэл, соёлын шүтэлцээний асуудал нь харилцааны дунд өрнөж буй соёл, сэтгэлгээний ялгааг харуулж буй бөгөөд тухайн хэлээр ярилцагч орны хувьд төдийлөн асуудал болохгүй боловч орчуулгын бүтээлд хэл, соёлын харилцан шүтэлцээ нь тухайн өөр нэг нийгэм, соёл, сэтгэлгээг ахин өөр нэг хэл, соёл, сэтгэлгээтэй хүмүүст үзүүлэн таниулж буй тул ямар нэг байдлаар санааг гажуудуулахгүйгээр орчуулгыг гүйцэтгэх нь чухал байна. Иймд орчуулга нь зөвхөн орчуулгазүйн арга техник бус хэлшинжлэлийн үүднээс судалж, соёлын нөлөөг онцгойлон гаргах нь зүйтэй болоод байна.

Аливаа соёл нь тухайн улс үндэстний нийгэм, аж төрөх ёсон, амьдралын хэмнэл бөгөөд түүнийг бид хэлээр дамжуулан суралцаж, хоёр хэлийг холбогч гүүр болгох үүднээс орчуулгын ажлыг явуулах нь зүйтэй гэдэг олон эрдэмтдийн саналтай ижил бодолтой байна. Энэ ч утгаараа орчуулгын судалгаагаар дамжуулан хэл шинжлэл, нийгмийн антропологи, соёл хоорондын харилцан уялдаа холбоог судлав. Судалгааны үр дүнгээс харахад текстэн болон дүгнэлтийн дүн шинжилгээ хийх нь орчуулгын даалгаврыг гүйцэтгэхээс өмнө эх бичвэрийг ойлгоход чухал хэсэг мөн болно.

Ашигласан номзүй

Монгол эх сурвалж, материал

- Болормаа, Б. Булганцэцэг, М. (2013). Ерөнхий хэл шинжлэл. Улаанбаатар.
Гүрбазар, Р. (1996). Орчуулгын онол, дадлагын үндэс. Улаанбаатар, 110-117
Дорждагва, Т. (2011). Соёл судлал. Монголын соёл судлалын холбоо. Улаанбаатар
Соёл урлагийн их сургууль. Соёл судлалын их семинар. (2008). Улаанбаатар, 62-63
Цэцэгням, Ү. (2015). Үндэсний онцлог үгийн орчуулга. НХУС-ийн ЭШБ №1. Улаанбаатар,
Ган Уран Бичээс, 169-174.
Дорждагва, Т. (2011). Соёл судлал. Монголын соёл судлалын холбоо. Улаанбаатар

Англи хэлээр

- Brown, G., & Yule, G. (1983). *Discourse analysis*. Cambridge University Press.
Baker, M. 2005. *Translation and conflict*. London and New York: Routledge.
Bassnett, S. 2014. *Translation studies*. New York: Routledge.
Gagnon, C. (2010). Political translation. In Y. Gambier & L. van Doorslaer (Eds.). *Handbook of translation studies* (Vol. 1; pp. 252–256). John Benjamins.
Blakesley, J. & Munday, J. Eds. 2018 *Sociologies of poetry translation: Emerging perspectives* (Bloomsbury Advances in Translation). London: Bloomsbury Academic.
Blum-Kulka, S. 1986. "Shifts of cohesion and coherence in translation." *Interlingual and Intercultural Communication: Discourse and Cognition in Translation and Second Language Acquisition Studies*, 17-35.
Brumfit, C. J. 1984. *Communicative methodology in language teaching*. Cambridge: Cambridge University Press.
Catford, J. C. 1965. *A Linguistic Theory of Translation*. London: Oxford University
Chesterman, A. 1993. *Translation as theory*. New York: Routledge. Chesterman,

**НЭР ТОМЬЁОНЫ
ОРЧУУЛГА СУДЛАЛ**



АНГЛИ ХЭЛНИЙ АДИЛТГАЛ НЭР ТОМЬЁОГ ОРЧУУЛАХ АСУУДАЛД

Н.Мөнхцэцэг⁴⁵

Abstract: In today's fast-paced world of science and technology, there is a constant need to name new discoveries, inventions, things, and phenomena. A Metaphorical approach has been commonly used for naming those new things because it makes people perceive concepts easily.

In this study, we selected B.Jigjidsuren's "Business English-Mongolian Dictionary" (2006) with about 5,000 words to study methods used to translate English metaphoric terms into Mongolian. There are 190 English metaphoric terms in the dictionary, of which 78% are in semantic translation, 10% are calqued (word for word translation), 4% are translated with another equivalent metaphoric terms, 3% are translated in simple equivalent words, 3% are translated in explanation, and 2% are directly borrowed.

Metaphoric terms are similar to realia (culture-specific words). So when you translate the metaphoric terms, you need to take consideration on the linguistic, cognitive, and cultural differences between the source and target language speakers.

Түлхүүр үг: метафор, нэр томьёо, орчуулга, ухагдахуун, соёл, сэтгэлгээ, танин мэдэхүй, орчуулгын арга, идэвхшүүлэх, ондоошуулах

1. Удиртгал

Метафор судлал нь Аристотелийн үеэс эхтэй бөгөөд тэрээр метафорыг уран зохиолын хэрэгсэл талаас нь судалсан бол, харин Цицерон тухайн үгэнд нийцэх ухагдахуун байхгүйгээс төстэй шинж дээр нь үндэслэн утга шилжүүлэн нэрлэх хэлний жирийн үзэгдэл хэмээн үзсэн байдаг (Фрейденберг, 1996: 218). Харин Лакоф, Жонсон, Блэк нар адилтгалыг "хэлний үгийн сангийн бүтцийг сэргээж, бэхжүүлэх эх сурвалж" хэмээгээд "хүмүүсийн харилцаа, ертөнцийг ойлгож таньж мэдэхэд хэрэглэдэг сэтгэлгээний механизм юм" (Lakoff and Johnson, 1980:5; Black, 1990: 153-172) гэж тэмдэглэжээ.

Ортони (Ortony, 1979), Либерт (Liebert, 1994) зэрэг судлаач танин мэдэхүйн шинжлэх ухааны үүднээс судалсан бол, харин Новелз (Knowles, 1996), Мэйер ба бусад (Meyer et al, 1997), Павел (Pavel, 1993) зэрэг эрдэмтэд мэргэжлийн хэл, нэр томьёо судлалд метафор хэмээх ойлголтыг авч үзэх болжээ.

Шинжлэх ухаан, технологи эрчимтэй хөгжиж буй өнөө үед хүн төрөлхтний шинэ нээлт, бүтээл, юмс, үзэгдлийг нэрлэх хэрэгцээ шаардлага байнга тулгарч байдаг. Үүнтэй уялдан хүний ахуй амьдралд ойр зүйлийн нэрийн утгыг шилжүүлэн шинэ үг зохиох тохиолдол их болжээ. Ялангуяа нэр томьёо бүтээхэд утга шилжүүлэх арга болох адилтгалын аргыг түгээмэл хэрэглэж байна. Тиймээс нэр томьёоны метафор нь судалгааны шинэ салбар болон хөгжиж байна.

Хэдийгээр адилтгал нь уран дүрслэлт, сэтгэлийн өнгө аяс илэрхийлдэг, харин нэр томьёо нь уран яруу бус, сэтгэлийн өнгө аяс илэрхийлдэггүй, хоёрдмол утгагүй байх зарчимтай гэсэн эсрэг тэсрэг шинжтэй хоёр зүйлийг нэгтгэсэн адилтгалын аргаар бүтсэн нэр томьёо буюу

⁴⁵ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор (Ph.D)

адилтгал нэр томьёог орчин үед шинжлэх ухааныг шинэ ойлголт ухагдахууныг нэрлэхэд түгээмэл хэрэглэх болжээ. Тухайлбал, мэдээлэл, технологийн салбарт: *feeder link* - тэжээх шугам, *mouse* - хулгана, *memory* - санах ой, *messenger* - элч, улаа, зарлага, автомат мэдээ, *backbone* - гол шугам, гол кабель, тулгуур сүлжээ, *firewall* - галт хана, хамгаалалтын хана, хамгаалалтын программ гэх мэт; эдийн засгийн салбарт: *cash inflow* - мөнгөн орлогын урсгал, *cash outflow* - мөнгөн зардлын урсгал, *ballpark figure* - ойролцоо дүн, ойролцоо тоо хэмжээ, *bear position* - горьдлого тавьсан байдал гэх мэт; улс төрийн салбарт: *back politics* - бохир улс төр, *backroom* - нууц улс төр, *soft power* - зөөлөн хүч гэх мэт адилтгалын арга буюу утга шилжүүлэх аргаар бүтсэн олон нэр томьёог дурдаж болно.

Ийнхүү адилтгалын арга нь нэр томьёо бүтээхэд хамгийн бүтээмжтэй арга хэрэгсэл болдог нь дараах хүчин зүйлстэй холбоотой. Үүнд: 1. Шинэ зүйлийг нэгэнт мэдэж буй зүйлтэй адилтган нэрлэх нь тухайн шинэ ухагдахууныг хялбар ойлгох 2. Хэлний тогтолцоо, хэрэглээнд амархан хэвших 3. Шинээр авиа үсгийг нийлүүлж шинэ үг бүтээхгүй, харин төрөлх хэлний боломж ба олон улсын шинжтэй үгийг өргөн хэрэглэдэг 4. Нэр томьёоны адилтгал нь хоёрдмол утгаа гээх боловч дүрслэл нь шинжлэх ухааны тодорхой нэг салбарын нэр томьёоны тогтолцоонд шинэ нэгжийг танилцуулахад түлхэц болдог зэрэг юм.

Монгол хэлэнд метафорыг уран зохиолын дүрслэх хэрэглүүр талаас нь болон танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс судалсан бүтээл нэлээд бий боловч нэр томьёоны хувьд янз бүрээр оноон хэрэглэсээр иржээ. Тухайлбал, уран зохиолд Б.Содном (1956), Э.Вандуй, Дашдорж (1970), О.Адьяа (1996) нар “зүйрлэл”, С.Дулам, Ц.Хасбаатар (1980), Ш.Гаадамба (1989), Д.Ёндон (1995), Д.Галбаатар (2012) нар “адилтгал” гэж орчуулжээ (Д.Цэвээндорж, 2018: 101).

Хэл шинжлэлд метафор гэсэн нэр томьёог Ж.Төмөрцэрэн (1974), Ц.Өлзийхутаг (1979), Э.Равдан (2005), Н.Нансалмаа (2011) нар “зүйрлэл” гэж; М.Базаррагчаа (1993, 2005, 2017), Ц.Сүхбаатар (1988), Ж.Баянсан (2016) “адилтгал” гэх мэт нэрлэдэг.

Харин О.Шинэбаяр, Б.Золжаргал нар нэр томьёоны метафорын чиглэлээр тусгайлан судалж, “Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо” (2020) ганц сэдэвт бүтээл хэвлүүлсэн бөгөөд уг бүтээлдээ *метафор* хэмээх нэр томьёог “*адилтгал*” хэмээн оноосныг үндэслэлийн талаас нь дэмжин цаашид ийнхүү хэрэглэх болно.

Монгол хэлэнд адилтгал нэр томьёоны орчуулгын талаар тусгайлан судалсан нь ховор бөгөөд бид энэ удаагийн судалгаандаа адилтгал нэр томьёоны орчуулгын асуудлыг бизнес, эдийн засгийн нэр томьёоны жишээн дээр голлон тодорхойлно.

2. Адилтгалын аргаар нэр томьёо бүтэх


Адилтгалын мөн чанар нь нэг зүйлийг өөр нэг зүйлтэй адилтган ойлгож мэдэх, өөрөөр хэлбэл, хэлэнд нэгэнт байсан ухагдахуунд тулгуурлан, түүнтэй адил шинжтэй өөр нэгэн ухагдахуун бий болгох хэрэгсэл гэж үзэж болно.

Адилтгалын хоёр гол ойлголт нь *source domain* (сурвалж хүрээ), *target domain* (зорилтот хүрээ) юм. Уг хоёр ухагдахуун буюу нэр томьёог анх Ж.Лакоф, М.Жонсон нар “*Metaphors we live by*” (1980) бүтээлдээ танилцуулсан. Харин өмнө нь И.А.Ричардс дээрх хоёр ухагдахууныг “*vehicle*”, “*tenor*”, (I.A.Richards, 1936) гэсэн өөр нэр томьёогоор нэрлэдэг байжээ. Гэвч энэ хоёр уламжлалт нэр томьёо нь 2 хүрээ буюу ухагдахууны харилцан үйлчлэлийг илэрхийлээгүй тул сүүлийн үеийн эрдэмтэд Ж.Лакоф, М.Жонсон (1980) нарын дэвшүүлсэн *source domain* (сурвалж хүрээ), *target domain* (зорилтот хүрээ) гэсэн нэр томьёог тухайн ухагдахуунуудыг зөв илэрхийлсэн хэмээн үзэж хэрэглэх болсон байна. Энэ талаар Виллиам П.Браун “Сурвалж хүрээ, зорилтот хүрээ хоёр нь адилтгал ба тэмдэглэхүүн (*referent*) хоёрын тодорхой харьцааг тэмдэглэдэг

зогсохгүй, адилтгалыг илэрхийлэхэд нэг хүрээнээс нөгөө хүрээнд шилжих тодорхой хөдөлгөөнт шинжийг тусгадгаараа сайн талтай (William Brown, 2017) хэмээн үзсэн байдаг.

Эмпирист судлаачдын онолоор тухайн адилтгалын бүтцийн төрлөөс хамаарч уламжлалт (ухагдахууны) адилтгал⁴⁶ буюу ухагдахууныг ухагдахуунаар буулгах, дүрслэлт адилтгал⁴⁷ буюу дүрслэлээс дүрслэлд буулгах (Lakoff, 1989., 1992) гэж ангилдаг. Дүрслэлт адилтгал нь нэг ухагдахууны дотоод бүтэц буюу шинжийг нөгөө бүтцэд шилжүүлэх буюу буулгахыг хэлдэг (Lakoff, 1992:418).

Ж.Лакоф, М.Жонсон (1980) нарын уламжлалт буюу ухагдахууны адилтгалын онолоор авч үзвэл, нэр томьёо бүтэх үйл явц нь ихэвчлэн дараах загвартай байдаг. Үүнд:



Зураг 1. Адилтгалын аргаар нэр томьёо бүтэх утга зүйн үйл явц

Зураг 1-ийг тайлбарлавал, сурвалж хүрээ буюу бодит ухагдахуун, зорилтот хүрээ буюу хийсвэр ухагдахууны хоорондын төстэй шинжээр нь авалцуулан холбож утга шилжүүлэн адилтгал нэр томьёо үүсгэнэ гэсэн үг. Ж.Баянсан адилтгал үүсэх үйл явцыг “Тухайн үгийн утгыг хийсвэрлэн ондоошуулж, өөр юмны нэрлэлт болгон хэрэглэхдээ жишин харьцуулж байгаа хоёр юмыг нэгэн адил юм уу, төслүү шинжээр нь авалцуулан холбож (ассоциаци), улмаар авалцуулсны (аналоги) үр дүнд л сая адилтгал (метафор), адилтгасан нэрлэлт бий болно (2016:67) гэж тодорхойлсон байдаг. Ийнхүү үүссэн нэр томьёог бид жишээгээр тайлбарласныг Хүснэгт 1-ээс харж болно.

Ж.Лакоф, М.Жонсон нар (1980) ухагдахууны адилтгалыг агуулгын хувьд бүтцийн (structural metaphor), орон зайн (orientational metaphor), онтологи буюу оршихуйн (ontology metaphor) гэж гурав ангилдаг.

Бүтцийн адилтгалд *price war* - үнийн өрсөлдөөн, *virus* - вирус, *seed capital* - эхлэлтийн хөрөнгө *blanket agreement* - ерөнхий тохиролцоо гэх мэт аливаа зүйлийг бодит юм, түүний бүтэц, агуулгатай адилтгасан байдаг. Мэдээлэл технологийн салбарт *вирус* хэмээх нэр томьёо нь бүтцийн адилтгалын жишээ юм. Учир нь “хэрэглээний болон системийн программ дотор далдлагдаж, өөрийгөө бусад программ руу хуулбарлан, их төлөв техник хангамж, программ хангамж, файл эсвэл тодорхой өгөгдөлд гэмтэл учруулдаг нуугдмал программын команд”-ыг “вирус” хэмээх бодит ухагдахууны агуулгын бүтэцтэй адилтган нэрлэсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр тайлбарлая.

Хүснэгт 1. Биологи ба мэдээллийн технологийн салбарын “вирус” хэмээх адилтгал нэр томьёоны утга

Сурвалж хүрээ: вирус (биологи)	Зорилтот хүрээ (компьютер)
Хүн, амьтанд халдварладаг	Компьютерт халдварладаг
Эрүүл хүн, амьтныг өвчлүүлдэг	Эрүүл файл, программыг гэмтээдэг
Хүн амьтны амь насанд аюултай	Компьютерын файлыг устгах аюултай
Мутацид ордог	Мутацид ордог

⁴⁶ Conventional (conceptual metaphor) (Lakoff, 1989., 1992)

⁴⁷ Image metaphor (Lakoff, 1989., 1992)

Дээрх хүснэгтээс харахад, зорилтот хүрээний шинэ ухагдахуун (компьютерыг гэмтээдэг нуугдмал программ)-ыг “вирус” хэмээн нэрлэхдээ сурвалж хүрээний “вирус” хэмээх бодит ухагдахууны бүтэц агуулгын адил шинжид тулгуурласан байна.

Орон зайн адилтгал гэж ертөнцийн юмс үзэгдлийг орон зай, зүг чигийн харьцаанд байгаа шинжээр утга шилжүүлэн үүсгэсэн адилтгалыг хэлнэ. Жишээ нь: *down payment* - хямд төлбөр, *mark-up* - үнийн өсөлт, *upgrade* - сайжруулах, *mark-down* - хямдрал, *backwardation* - алдагдал, *зарлага*, *backdown* - ухрах, *down-and-out alcoholic эмгэг архичин*, *to vote down a draft law* - хуулийн төсөл унах, *pull-back* - саад, *backdating* - огноог урагшлуулж бичих, *frontier* - хил, *front-line* - дайны фронтын шугам, *zoom in* - томруулах, *томсгох*, *zoom out* - багасгах, *жижжээрүүлэх*, *outsourcing* - гаднын үүсгүүр, *log in* - нэвтрэх, *log out* - гарах гэх мэт жишээнээс харахад, *up*, *down* гэсэн үгс нь аливаа зүйлийн өсөх, буурах, өөдлөх, уруудах шинжээр юмс үзэгдлийг адилтгадаг бол *back*, *front* гэсэн үг нь ухрах, давших, далд, ил гэсэн утгын шинжийг илтгэж байна. Харин *in*, *out* гэсэн дотор, гадна гэсэн утгатай утгвар үгс нь зорилтот хүрээнд орох, нэвтрэх, гарах гэсэн утгаар хэрэглэгдэж байна.

Онтологи буюу оршихуйн адилтгал гэдэг нь байгалийн юмс, эд зүйл, хүний бие махбодтой холбоотой туршлага дээр үндэслэсэн адилтгалыг хэлнэ. Англи хэлний адилтгалд монгол хэлний нэгэн адил аливаа зүйлийн гадаад харагдах байдал, дотоод шинж чанар, хэлбэр дүрс, овор дүрээр нь амьтаншуулах (animification), хүншүүлэх (personification) аргыг хэрэглэдэг.

Адилтгалын аргаар бүтсэн англи нэр томъёоны санд хүн, түүний оюун ухаан, зан чанар, гадаад төрх, эрхтэн, үйл ажиллагаатай төстэй шинжээр нь зүйрлэсэн нэр томъёо олон байдаг. Өөрөөр хэлбэл, амьгүй юм, үзэгдлийг хүнд байх зан чанар, үйл хөдлөл, мэдрэх, сэтгэх онцлогтой адилтган нэрлэхийг хэлнэ. Жишээ нь: *messenger* - элч, *улаа*, *server* - сервер, *толгой машин*, *smart phone* - ухаалаг утас, *memory* - санах ой гэх мэт. Бидний судалгаанаас үзэхэд, энэ төрлийн адилтгалыг амьтаншуулсан адилтгал нэр томъёотой харьцуулахад харьцангуй бага байна.

Англи хэлний нэр томъёонд адгуус амьтан, түүний гадаад төрх, овор дүр, эрхтэн, үйл хөдлөл, төстэй шинжээр нь адилтгаж бүтээн, амьтаншуулсан *mouse* - хулгана, *wing nut* - эрвээхий эрэг, *butterfly bolt* - эрвээхий боолт, *worm shaft* - могой гол, *bear market* - баавгай зах зээл [БСНТТТ, х. 416], *bull market* - бух зах зээл [БСНТТТ, х. 416], *butterfly spread* - *эрвээхий *spread* гэх мэт олон нэр томъёо байна.

Түүнчлэн адилтгалын аргаар бүтсэн англи нэр томъёонд юмшуулах үзэгдэл бас бий. Жишээ нь: *coronavirus* - титэм вирус, *короновирс*, *web* - тор, *black kite* - сохор элээ, *homepage* - вэбийн нүүр хуудас гэх мэт.

О.Шинэбаяр “Адилтгалын аргаар нэр томъёо бүтээж ирсэн туршлага” өгүүлэлдээ техник технологийн адилтгасан 2000 гаруй монгол нэр томъёог түүвэрлэн хэрэглээний давтамж, утга зүйн үүднээс задлан шинжилсэн байна. Тэрээр “Монгол хэлний нэр томъёонд метафорын аргаар үүссэн нэр томъёо олон бий бөгөөд энэ нь үг бүтээж ирсэн сэтгэлгээний уламжлалтай холбоотой. Ийм аргаар бүтсэн нэр томъёонд танин мэдэхүйн онцлог хадгалагдаж олон салбар шинжлэх ухааны үүднээс судлах шаардлага бий” (2018:121)-г дурдсан байна.

Мөн Б.Золжаргал “Утга шилжих аргаар бүтсэн ургамлын нэр томъёо” хэмээх өгүүлэлдээ “Мэргэд гарахын орон”-ы Тэжээхүйн ухааны ургамлын нэр томъёо, Дөрвөн зүйлийн үсэг хавсарсан толь бичиг”-ийн 29-р дэвтрийн “Өвсний зүйл”, “Модны зүйл”, “Цэцгийн зүйл” болон “Улсын нэр томъёоны комиссын мэдээ”, “Монгол хятад латин хавсарсан үрт ургамлын нэрс”, “Ургамлын дүймэн”, “Монголын нууц товчоо” зэрэг зарим сурвалж бичгүүдээс түүвэрлэн авсан утга шилжүүлэн нэрлэсэн ургамлын 700 гаруй нэр томъёог түүвэрлэн хэрэглээний давтамжийг тооцоолон, утга зүйн ангилал хийж судалсан байна. Судалгааныхаа үр дүнд “Утга шилжүүлэн нэрлэхдээ амьтантай зүйрлэх нь хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд үүнд монголчуудын нүүдэлчин соёл, мал аж ахуй эрхэлдэгтэй холбоотойгоор таван хошуу мал болон түүний эд

эрхтэн, өнгө зүс, хэв шинж хэлбэр хэмжээгээр жишин зүйрлэх нь давамгай байгаа” (Золжаргал, 2018: 50)-г тодорхойлсон байна.

Үүнээс үзэхэд, адилтгал нэр томьёо бүтээхэд амьтаншуулах, юмшуулах үзэгдэл англи монгол хэлний аль алинд түгээмэл байх боловч уг хоёр хэлт ард түмний ахуй амьдрал, сэтгэлгээний онцлогоос шалтгаалан ямар амьтантай, ямар шинжээр нь хэрхэн адилтган нэрлэж байна гэдэг нь ялгаатай байна.

3. Адилтгал нэр томьёоны орчуулга

Нэр томьёоны адилтгал судлал, тэр дундаа адилтгал нэр томьёоны орчуулга нь цоо шинэ судлагдахуун биш боловч маш бага судлагдсан гэхэд болно. В.Н.Комиссаров (Komissarov V.N. 1990), О.Казакова (Kazakova, O. 2001), Ньюмарк (Newmark, 2008), Лакоф (Lakoff, 1980, 1993) нар нэг талаас орчуулгатай холбоотой, нөгөө талаас адилтгалын онолтой холбоотой олон ном бүтээл бичсэн байдаг. Гэвч орчуулгын онолд уг хоёр судлагдахууныг нэгтгэнэ гэдэг нь хамгийн бэрхшээлтэй асуудлуудын нэг тул адилтгалыг орчуулагдах, орчуулагдахгүй шинжийн талаас авч үздэг. Тухайлбал, Дагут адилтгалын орчуулагдах, орчуулагдахгүй чанар нь тухайн сурвалж хэл, зорилтот хэлний хэлэлцэгчдийн соёлын туршлага хэр нийтлэг байгаагаар тодорхойлогдоно” (Dagut, 1976:28) гээд адилтгалын орчуулгын гурван тохиолдлыг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- Шинээр бий болсон адилтгал нь орчуулагдахгүй;
- Адилтгал шинжээ алдаж, хэлний хэрэглэгчдэд адилтгал гэж мэдэгдэхээ байсан хэвшмэл адилтгал буюу “богино наст” адилтгал;
- Хэдийгээр шинэ боловч хэлний хэрэглээнд орж, шинэ, онцгой шинжээ алдсан адилтгал (stock metaphors) гэсэн гурван тохиолдлыг дурджээ.

Харин Ван ден Броек (Van den Broeck 1981:78) адилтгалыг орчуулах аргыг

1. Хэрвээ сурвалж хэл, зорилтот хэлний “vehicle” ба “tenor” нь таарч байвал “sensu stricto” буюу дүйцүүлэн орчуулах
2. Сурвалж хэлний vehicle -ийг зорилтот хэлний өөр нэгээр орлуулах
3. Зорилтот хэлэнд адилтгалыг арилгаж, өөр үгээр сольж орчуулах гэж ангилсан бол,

Ньюмарк (2008) адилтгалыг орчуулах аргыг

1. Зорилтот хэлэнд ижил дүрслэлийг хуулбарлан бүтээх,
2. Сурвалж хэлний дүрслэлийг зорилтот хэлний соёлтой харшлахгүй тийм дүрслэл (зорилтот хэлний)-ээр солих “соёлын дүйцэл”,
3. Адилтгалын дүрслэлийг хадгалсан адилтгалаар орчуулах,
4. Адилтгалыг орчуулахдаа адилтгал дээр утга санаа нэмэх,
5. Адилтгалын утга санааг хөрвүүлэх,
6. Хэрвээ адилтгал илүүц бол хасах,
7. Тухайн дүрслэлийг батжуулахын тулд утга санаа нэмж ижил адилтгал хэрэглэх гэж долоо ангилжээ.

Манделблит адилтгалыг орчуулах гол бэрхшээл нь сурвалж хэл ба зорилтот хэл хооронд ижил санааг илэрхийлэх дүрслэлийн ялгаа байдагт оршино (Mandelblit, 1995:483) гэсэн байдаг. Ийм тохиолдолд нэг хэлнээс нөгөө хэлэнд төдийгүй, ертөнцийг зураглах нэг аргаас нөгөө аргад шилжих үйл явц болж байдаг. Тэрээр адилтгалын орчуулгын талаар хоёр таамаглалыг дэвшүүлсэн. Нэгдүгээрт, төстэй зураглалын нөхцөл (Similar Mapping Condition) буюу сурвалж ба зорилтот хэлэнд хэлний адилтгал нь ижил дүрслэл буюу зураглал дээр тулгуурласан тохиолдолд орчуулга нь бэрхшээл бага, шулуун байдаг. Хоёрдугаарт, ялгаатай зураглалын нөхцөл (Different Mapping Condition) нь сурвалж ба зорилтот хэлний хооронд өөр өөр адилтгал үг төдийгүй өөр

ухагдахууны адилтгал хэрэглэх тохиолдлыг хэлнэ. Энэ тохиолдолд орчуулга бэршээлтэй болох бөгөөд эхний тохиолдолтой харьцуулахад тухайн асуудлыг шийдэх илүү цаг шаардагдана (Mandelblit, 1995:484) хэмээн бичжээ.

Мөн Родригиз Марказ (Rodriguez Marquez, 2010), Пападюди (Papadoudi., 2010, 2014) нар шинжлэх ухааны бичвэр дэх адилтгал үг хэллэг, нэр томьёо хэрхэн орчуулагддагийг судлаад, адилтгалыг адилтгал бус үг, хэллэгээр орлуулах гэсэн саналыг нэмжээ.

Харин Арабын орчуулга судлаач Хадижа Меракчи дээрх эрдэмтдийн адилтгалыг орчуулах арга зарчмыг харьцуулан үзээд зорилтот хэлэнд хэлний ба ухагдахууны адилтгалыг орчуулах дараах арга, техникийг санал болгосон. Үүнд:


1. Сурвалж ба зорилтот хэлэнд хэлний ба ухагдахууны ижил адилтгалыг хэрэглэх
2. Сурвалж хэлний ухагдахуунд дөхүүлэхийн тулд зорилтот хэлэнд хэлний адилтгалыг тайлбарлах
3. Хэлний хувьд ялгаатай, ухагдахууны хувьд ижил адилтгал хэрэглэх (Khadidja Merakchi, 2017)

Манай эрдэмтэн судлаачдаас Р.Гүрбазар адилтгал, зүйрлэлийг орчуулахдаа түүгээр илэрхийлсэн далд санааг илрүүлж олох нь хамгийн чухал бөгөөд жинхэнэ утгыг олсон үед цөөн тохиолдолд хуулбарлан орчуулж болох ба голдуу боломжийн үг хэллэгээр орлуулах нь үр дүнтэй гэдгийг тэмдэглэсэн байдаг. Ингэснээр хоёр хэлний хэрэглүүр заавал тохирч байх албагүй ч тухайн нэр томьёоны агуулга буюу ухагдахууныг монгол хэлээр бүрэн төгс гаргаж, хэлний хэм хэмжээ, найруулга зүйн хувьд зөв байх ёстой. Гэхдээ сурвалж хэлний буюу үндэсний онцлог бүхий, зөвхөн тухайн улс орны хувьд байх ухагдахууныг илэрхийлж байгаа тохиолдолд утгачлан орчуулаад тайлбар хавсаргах эсвэл шууд зээлдэн хэрэглэнэ (1996:203) хэмээн адилтгалыг орчуулах аргын талаар өгүүлжээ.

Бид дараагийн дэд бүлэгтээ англи хэлний адилтгал нэр томьёог монгол хэлнээ хэрхэн орчуулж байгааг тодорхой нэг салбарын нэр томьёоны англи-монгол толь бичгийн жишээгээр судлан тайлбарлаж, хэрхэн орчуулж болох боломжийг тодорхойлох болно.

3.1. Адилтгал нэр томьёог монгол хэлэнд орчуулж буй арга

Бид энэхүү судалгаандаа монгол хэлэнд англи хэлний адилтгал нэр томьёог орчуулахдаа ямар аргуудыг хэрэглэж байгааг судлахын тулд Б.Жигжидсүрэнгийн 5000 орчим толгой үгтэй “Бизнесийн англи - монгол толь” (2006)-ийг сонгон, хөмрөг хэл шинжлэлийн TextStat программыг ашиглан хөмрөг үүсгэн, түүнээс адилтгал нэр томьёог түүвэрлэн судаллаа. Уг толинд англи хэлний адилтгал нэр томьёо 190 байгаа бөгөөд тэдгээрийг орчуулгын ямар аргаар орчуулсныг диаграммаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:



Зураг 2. Англи хэлний адилтгал нэр томьёог орчуулсан аргуудын хувь хэмжээ

Зураг 2-оос харахад англи хэлний адилтгал нэр томьёог энгийн үгээр утгачлан орчуулсан нь хамгийн их буюу 78%, хуулбарлан орчуулсан нь 10%, монгол хэлэнд өөр адилтгалаар дүйлгэсэн 4%, энгийн үгээр дүйлгэсэн 3%, тайлбарлан орчуулсан 3%, шууд зээлдсэн 2%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд, англи хэлний адилтгал нэр томьёог энгийн үгээр утгачлан орчуулсан

нэр томьёо ихэнх хувийг эзэлж байгаа нь англи, монгол хэлтний ахуй амьдрал, танин мэдэхүй, сэтгэлгээний онцлогийн ялгаанаас үүдэлтэй тул монгол хэлэнд тэдгээртэй шууд дүйх монгол адилтгал нэр томьёо байхгүйг илтгэж байна. Энэхүү орчуулгын аргуудыг доор тус бүрд нь авч үзье.

3.1.1. Энгийн үгээр утгачлан орчуулах

Адилтгал нэр томьёог орчуулахад ихэнх тохиолдолд зорилтот хэлэнд ухагдахуун хийгээд тэмдгийн түвшинд дүйцлийг олох хэцүү бөгөөд хуулбарлах, дүйлгэн орчуулах боломжгүй үед утгачлан орчуулна. Аливаа хэлний адилтгал нэр томьёог өөр хэл рүү орчуулна гэдэг нь түүний утгын уугуул орныг эвдэнэ гэсэн үг юм. Учир нь үгийн тодорхой өнгө аяс, утгыг орчуулгад бүрэн гүйцэд гаргана гэдэг хэцүү байдаг (McGrath, 2005:13). Англи хэлнээс монгол хэлэнд адилтгал нэр томьёог орчуулахад ихэвчлэн адилтгал шинжээ алддаг. Өөрөөр хэлбэл, адилтгал нэр томьёог орчуулахад адилтгасан санааг яг адилхан илэрхийлэх боломжгүй. Иймд утгачлан орчуулах шаардлага гардаг. Жишээ нь: *umbrella fund* - гадаад сан, *down payment* - хямд төлбөр, *catch a cold* - мөнгөө алдах, халаасаа хоослох, *face value* - нэрлэсэн үнэ, *boar position* - *горьдлого тавьсан байдал⁴⁸, *price war* - үнийн өрсөлдөөн, *blanket agreement* гэх мэт. Тухайлбал, англи хэлний *blanket agreement* гэсэн нэр томьёо нь хуулбарлан буюу үгчлэн орчуулбал, “хөнжил гэрээ” болно. Гэвч энэ нийлмэл үгийг хууль, бизнес эдийн засгийн салбарт “ямар нэг байгууллага, үйлдвэр, газар зүйн бүс нутагт хэрэглэдэг өргөн хүрээтэй гэрээ”⁴⁹-г нэрлэдэг. Энэ нэр томьёог монгол хэлэнд “ерөнхий тохиролцоо, ерөнхий зөвшилцөл” [БАМТ, х.45] гэж утга ерөнхийлөн орчуулсан байна.

Англи хэлний *windfall* гэсэн үгийн шууд утга нь мод бутнаас салхинд унасан жимсийг нэрлэдэг бөгөөд үгчлэн орчуулбал “салхинд унасан” гэсэн үг. Харин бизнес эдийн засгийн салбарт энэ үгийг утга шилжүүлэн санаандгүй, гэнэт олдсон их хэмжээний мөнгө, ашиг орлогыг нэрлэсэн нэр томьёоны үүргээр хэрэглэж байна. Энэ нэр томьёог монгол хэлэнд “гэнэтийн ашиг” [БАМТ, х.357] хэмээн энгийн үгээр утгачлан орчуулсан байна.

3.1.2. Хуулбарлан орчуулах

Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан толь бичигт адилтгал нэр хуулбарлан орчуулсан нь 10%-ийг эзэлж байна. Энэ аргыг хоёр хэлэнд ухагдахуун хийгээд хэлний илэрхийлэл адил байвал хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл, тухайн адилтгал нэр томьёоны агуулга, хэлбэрийн аль аль нь тохирч байвал хуулбарлан орчуулж болно. Жишээ нь: *blacklist* - хар данс, *memory* - санах ой, *mouse* - хулгана, *wing nut* - эрвээхий эрэг, *valve body* - хавхлагын бие, *dead capital* - үхмэл хөрөнгө, *bridge loan* - гүүр зээл гэх мэт хуулбарлан орчуулахад тухайн ухагдахууныг илэрхийлж чадахуйц байна. Бидний судалгаанаас үзэхэд, энэ арга нь бодит зүйлийг нэрлэсэн адилтгал нэр томьёог орчуулахад илүү тохиромжтой, харин хийсвэр зүйлийг нэрлэсэн *butterfly spread* (*эрвээхий *cnped*), *bear market* (баавгай зах зээл), *bull market* (бух зах зээл) гэх мэт тухайн хэлний тэмдэг буюу нэр томьёог хараад утгыг шууд тааварлах, тухайн ухагдахууныг ойлгоход бэрх тул хуулбарлан орчуулах нь төдийлөн тохиромжгүй юм

Адилтгал нэр томьёо нь тухайн үндэстний амьдрал ахуй, соёл сэтгэлгээний онцлогтой салшгүй холбоотой тул шууд үгчлэн орчуулахад монгол хүний сэтгэлгээнд тухайн ухагдахууны талаарх мэдээлэл шууд буухгүй юм уу эсвэл буруу ойлгогдохоор байж болно. Иймд англи ба өөр ямар ч хэлний адилтгал нэр томьёог хуулбарлан орчуулахад хэтэрхий зохиомол, хуулбар шинжтэй болохоос болгоомжилж, зөв оновчтой онооход онцгой анхааруштай.

⁴⁸ (*) тэмдгээр оновчгүй орчуулсан нэр томьёог тэмдэглэв.

⁴⁹ an agreement that applies throughout an organisation, industry or geographical area (<https://www.translegal.com/dictionary/>)

3.1.3. Өөр адилтгал нэр томъёогоор дүйлгэн орчуулах

Энэ удаагийн судалгааны хүрээнд авч үзсэн “Бизнесийн англи - монгол толь бичиг”-т англи хэлний адилтгал нэр томъёог монгол хэлнээ өөр адилтгал нэр томъёогоор дүйлгэн орчуулсан нь 3%-ийг эзэлж байна.

Гадаад хэлний адилтгал нэр томъёог монгол хүний хэл соёл, сэтгэхүйн онцлогт тохируулан өөр адилтгал нэр томъёогоор дүйлгэн орчуулна гэдэг бол их бүтээлч арга юм. Ийм аргаар орчуулсан *backbone* - ноён нуруу, *тулгуур* (улс төр), *black economy* - сүүдрийн эдийн засаг, *umbrella organization* - толгой компани, *crown corporation* - толгой корпорац, *land bank* - нөөц газар, *deadlock* - мухардал гэх мэт монгол хэлний онцлогт тохируулан адилтгал нэр томъёо бүтээсэн жишээ бизнес, эдийн засгийн толь бичгүүдэд нэлээд байна. Тухайлбал, англи хэлний *black economy* гэсэн адилтгал нэр томъёог үгчлэн орчуулбал, “хар эдийн засаг” гэсэн үг болно. Энэ нэр томъёог Кембрижийн толь бичигт “татвараас зайлсхийхийн тулд нуун дарагдуулсан орлого, бизнесийн үйл ажиллагаа”⁵⁰ хэмээн тодорхойлжээ. Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан Бизнесийн англи монгол толь бичигт “сүүдрийн эдийн засаг” [БАМТ, х.44] хэмээн орчуулсан байна. Тодруулбал, “татварын дарамт, нийгмийн даатгалын өндөр шимтгэл болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа дүрэм журмаас зайлсхийхийн тулд иргэд, ААН эрхэлж буй үйл ажиллагаагаа үнэн бодитой мэдээлэхгүй, албан эдийн засгийн бүртгэлээс орхигдуулж далд хэлбэрээр явуулдаг үйл ажиллагаа” (Энхзаяа, 2012: 6)-г хэлж байна. Иймд далд буюу сүүдэрт явагдаж буй эдийн засгийн үйл ажиллагаа гэсэн утгыг гаргаж, англи хэлний *black* буюу *хар* гэсэн үгийг “сүүдрийн” гэсэн үгээр сольж хувирган орчуулсан нь оновчтой болжээ.

3.1.4. Энгийн үгээр дүйлгэн орчуулах

“Бизнесийн англи - монгол толь бичиг”-т англи хэлний адилтгал нэр томъёог энгийн үгээр дүйлгэн орчуулсан нь нийт адилтгал нэр томъёоны 3%-ийг эзэлж байна. Жишээ нь: *back pay* - нэмэгдэл цалин, *bug* - алдаа, *chair* - дарга, *mark-down* - хямдрал, *branch* – салбар, *kickback* - хахууль гэх мэт цөөн нэр томъёо байна. Эдгээрээс зарим жишээг тайлбарлая. Англи хэлний *bug* гэсэн үг нь хортой бичил биет буюу бактерийг нэрлэдэг үг бөгөөд компьютер, технологид энэ үгийн утгыг шилжүүлэн компьютерын үйлдлийн систем дэх алдаа, согогийг нэрлэхэд хэрэглэгдэг. Үүнийг монгол хэлэнд “алдаа” [БАМТ, х.51] гэсэн энгийн үгээр дүйлгэн орчуулсан нь хэдийгээр тухайн англи нэр томъёогоор илэрч буй ерөнхий ухагдахууны гол шинжийг гаргаж чадаж буй боловч нөгөө талаар ийнхүү хэт ерөнхийлөн орчуулах нь бусад ойролцоо утгатай *mistake*, *error* гэх мэт нэр томъёоны орчуулгатай давхцах магадлалтай тул тухайн ухагдахууныг илүү тодотгон “программын алдаа” гэх мэт орчуулах хэрэгтэй юм.


Англи хэлний *branch* гэдэг үгийн үндсэн утга нь модны мөчир юм. Харин орчин үед нийгэм эдийн засгийн салбарт томоохон бизнесийн байгууллагын бүрэлдэхүүнд багтдаг хэсэг ба бүлгүүдийн нэгийг нэрлэх болсон нь *branch* буюу *мөчир* гэсэн сурвалж хүрээ буюу бодит ухагдахууны салаалах шинжтэй адилтган утга шилжүүлэн нэрлэсэн хэрэг юм. Монгол хэлэнд энэ үгийг “салбар” [БАМТ, х.48] гэсэн үгээр орчуулсан байна.

Мөн англи хэлний *kickback* гэсэн хэлц нэр томъёо нь *kick* - өшиглөх, *back* – буцаах, эргүүлэх гэсэн хоёр үгээс бүтсэн (үгчлэн орчуулбал, *буцааж өшиглөх*) “огцом хариу үйлдэл” гэсэн утгатай нийлмэл нэр томъёо юм. Харин бизнес, эдийн засгийн салбарт “ажил үйлчилгээ, томилгоог хөнгөвчилсний хариуд хэн нэгэнд өгсөн хууль бус төлбөр”⁵¹ гэсэн ухагдахууныг нэрлэх болсон байна.

⁵⁰ [business activity](https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy) and [income](https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy) that [people](https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy) do not [record](https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy) in [order](https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy) to [avoid paying tax](https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy) on it. (<https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy>)

⁵¹ an illicit payment made to someone in return for facilitating a transaction or appointment (Oxford dictionary).

Энэ үг нь англи хэлний *corruption*, *bribe* гэх мэт үгтэй ойролцоо утгатай боловч утгын нарийн ялгаатай байна. Тодруулбал, англи хэлний *corruption*-ыг “Албан тушаалтан ба төрийн итгэмжлэгдсэн хүн албан тушаалаа урвуулан ашиглаж, өөртөө болон бусдад давуу байдал олгох зорилгоор өөрийн үүрэг, бусдын эрх ашгийн эсрэг үйлдсэн хууль бус үйлдэл”⁵² гэж тодорхойлсон бол *bribe*-ыг “Өөртөө давуу байдал, давуу эрх олж авахын тулд албан тушаалтан, төрийн албан үүрэг гүйцэтгэж буй хэн нэгэнд нөлөөлж үүргээ зөрчихөд хүргэсэн хууль бус өглөг, үнэт зүйл, авлига”⁵³ гэж тодорхойлсон байна. Эдгээр тодорхойлолтоос үзэхэд, хүрээний хувьд дараах байдлаар дүрсэлж болохоор байна.



Зураг 3. Англи хэлний *corruption*, *bribe*, *kickback* гэсэн нэр томъёоны ухагдахууны хүрээ

Дээрх Зураг 3-ыг тайлбарлавал, *corruption* нь *bribe*, *kickback* хоёрыг багтаасан өргөн хүрээтэй, төлөөлсөн ерөнхий нэр томъёо, *bribe* нь *kickback*-ыг багтаасан хоёрдогч шатны төлөөлсөн нэр томъёо бол *kickback* нь дээрх хоёр нэр томъёонд багтах харьцаанд буй тусгай нэр томъёо болж байна. Мөн англи хэлний *bribe*, *kickback* гэсэн хоёр ухагдахууны гол ялгааг авч үзвэл, *bribe* нь өөрийн ажил үйлийг бүтээхийн тулд хууль бус үйлдлийн өмнө нь өгснийг хэлдэг бол *kickback* нь өөрийн ажил үйлийг бүтээсний дараа буюу хууль бус үйлдлийн хувь хүртээх буюу бүтээсний төлөөх шан харамж⁵⁴-ийг нэрлэдэг ажээ.

Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болох “Бизнесийн англи монгол толь бичиг”-т *kickback* - хахууль [БАМТ, х.166], *bribe* - хахууль, хээл хахууль [БАМТ, х.50], *corruption* - хахууль [БАМТ, х.80] гэж бүгдийг ижил нэр томъёогоор орчуулжээ. Хэдийгээр эдгээр нэр томъёо нь ойролцоо утгатай боловч дээр дурдсанчлан, өөр хоорондоо ухагдахууны хүрээ болоод утгын хувьд нарийн ялгаатай тул ийнхүү нэг нэр томъёогоор оноож болохгүй юм. Тиймээс эдгээр нэр томъёогоор илэрхийлэгдэж буй ухагдахууны ялгаатай шинжүүдийг харгалзан монгол хэлэнд өөр өөр нэр томъёогоор оноох хэрэгтэй. Судалгаанаас үзэхэд, англи хэлний “*corruption*” нь монгол хэлний

⁵² Illegality; a vicious and fraudulent intention to evade the prohibitions of the law. The act of an official or fiduciary person who unlawfully and wrongfully uses his station or character to procure some benefit for himself or for another person, contrary to duty and the rights of others. (<https://thelawdictionary.org/corruption/>)

⁵³ Any valuable thing given or promised, or any preferment, advantage, privilege, or emolument, given or promised corruptly and against the law, as an inducement to any person acting in an official or public capacity to violate or forbear from his duty, or to improperly influence his behaviour. (<https://thelawdictionary.org/bribe/>)

⁵⁴ The main difference is that bribes are usually provided up front (before the unethical activity) whereas kickbacks usually refers to something that is given in return as a reward (after the unethical activity). <https://hinative.com/en-US/>

“авилга”⁵⁵-тай, “bribe” нь монгол хэлний “хээл хахууль”⁵⁶-тай, харин “kickback” нь “шан харамж”⁵⁷-тай дүйж байна.

Дашрамд дурдахад, англи-монгол нэр томъёоны толь бичгүүдэд англи хэлний ойролцоо утгатай нэр томъёог монгол хэлэнд нэг үгээр оноосон тохиолдол олон байдаг бөгөөд эдгээр нь аливаа салбарын харилцаанд төөрөгдөл үүсгэж болох сөрөг нөлөөтэй тул тэдгээрийн ухагдахууны нарийн ялгааг гаргаж тус бүрд өөр нэр томъёо оноох хэрэгтэй юм.

3.1.5. Тайлбарлан орчуулах

Уг аргыг тухайн адилтгал нэр томъёо үндэсний онцлог үгийн шинжтэй, эсвэл дүйцэлгүй тохиолдолд хэрэглэнэ. Жишээ нь: *dark horse* - амер. намын тэргүүний суудлын “битүү” нэр дэвшигч [УТҮХНТТ, х. 53], *two-leg core* - хоёр шилбэтэй/туйвантай соронзон дамжуулагч, *backbencher* - Их Британийн парламентын жирийн гишүүн, *blue sky laws* - хөрөнгө оруулалтад хяналт тавих тухай хууль гэх мэт.

“Бизнесийн англи монгол толь бичиг” (2006)-т англи хэлний адилтгал нэр томъёог тайлбарлан орчуулсан нь 3%-ийг эзэлж байна. Жишээ нь: *black knight (stock exchange) (informal)* - хууль бус аргаар компанийг гартаа авахыг санаархагч, *Galumphs (sales)* Үнийг нэмэгдүүлэх, тохиролцсоны дараа өндөр үнэ хэлэх, *Big Bang (stock exchange)* Биг Банг (1986 оны 10-р сарын 27-нд Английн Хөрөнгийн Биржид гарсан томоохон өөрчлөлт) гэх мэт тайлбарлан орчуулсан цөөн хэдэн нэр томъёо байна. Эдгээрээс зарим жишээг тодруулбал, англи хэлний *Big Bang* гэсэн үг нь үгчлэн орчуулбал, “том цохилт” гэсэн үг бөгөөд энэ нь олон салбарт хэрэглэгддэг. Бизнес, эдийн засгийн салбарт энэ үгээр тодорхой цаг хугацаанд, тодорхой газарт болсон тодорхой үйл явдал (1986 оны 10-р сарын 27-нд Английн Хөрөнгийн Биржид болсон томоохон өөрчлөлт)-ыг нэрлэж байгаа тул уг үгийг галигчлан буулгаад тайлбарласан байна. Учир нь энэ үгийн тохиолдолд үүнээс өөр арга байхгүй юм.

Тайлбарлан орчуулахад утгыг илтгэн гаргахад бүрэн дамжуулж болох сайн талтай ч үргэлж хэрэглэх арга биш бөгөөд эх хэлний үг хэрэглээний хэм хэмжээ, найруулгад нь харш байж болох талтай.

3.1.6. Шууд зээлдэх

Энэ аргыг ихэвчлэн тухайн адилтгал нэр томъёоны дүйцэл байхгүй, эсвэл, үндэсний онцлог үгийн шинжтэй, утгачлан орчуулах боломжгүй үед хэрэглэнэ. Жишээ нь: *virus* - вирус, *bulldog bond* - бульдог бонд, *put bond* - пут бонд. Гэвч адилтгал нэр томъёог шууд зээлдсэн тохиолдолд тухайн нэр томъёогоор илэрч буй ухагдахууныг тайлбарлах зайлшгүй шаардлагатай. Учир нь соёл сэтгэлгээний ялгаанаас шалтгаалан шууд зээлдсэн адилтгал нэр томъёоны хэлбэрийг хараад тухайн нэр томъёогоор илэрч буй ухагдахууныг ойлгох боломж ховор байдаг.

“Бизнесийн англи монгол толь бичиг” (2006)-т англи хэлний адилтгал нэр томъёог шууд зээлдсэн вирус, Биг Банг, (тайлбар орчуулгатай) *Gearing* - Геаринг (тайлбар орчуулгатай) гэсэн цөөхөн тохиолдол байна. Дээр дурдсанчлан, эдгээр нэр томъёог шууд зээлдэхдээ утгын тайлбарыг хавсаргасан байна.

⁵⁵ 1.Өөрийн ажлыг бүтээхийн тулд холбогдох албан тушаалтанд ил, далд өгөх хахууль, 2. Хууль бусаар бусдаас авсан зүйл; ашиг хонжоо (<https://mongoltoli.mn/dictionary/>) 3. Хуульд заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил (Авлигын эсрэг хууль).

⁵⁶ хувийн үйл хэргийг биелүүлэхийн тулд бусдад аргадан өгөх эд юм, мөнгө төгрөг (<https://mongoltoli.mn/dictionary/>)

⁵⁷ шагнал болгосон зүйл, хишиг болгон өгсөн юм (<https://mongoltoli.mn/dictionary/>)

3.2. Адилтгалын аргаар бүтсэн нэр томьёоны орчуулгын зарим асуудал

Аливаа ард түмний хийсвэрлэх буюу зүйрлэх, адилтгах сэтгэлгээ тухайн орны соёл, орчин ахуй, зан заншлын ялгаанаас шалтгаалан өөр өөр байдаг. Тиймээс гадаад хэл сурах болон орчуулгад анхаарах асуудлын нэг нь монголчуудын уламжлалт зүйрлэх, адилтгах сэтгэлгээний онцлогийг ойлгож ухамсарлах явдал юм. Ш.Лувсанвандан 1987 онд нийтлүүлсэн “Нэр томьёоны тухай асуудалд” гэдэг өгүүлэлдээ тухайн соёл - хэлт үндэстэн байгаль, нийгмийн юм, үзэгдлийг аль нэг тал, аль нэг шинжээс нь харж, ухамсар, сэтгэхүйдээ хэвшүүлэн тогтоож, улмаар тэр нь хэлний шууд ба дам утгатай илэрхийлэлд мөн нэгэн адил хэвшил зуршил болдог учраас эсвэл шинээр бүтээж бий болгосон юм, үгүй бол шинээр таньж мэдсэн юм, үзэгдлийн тухай ухагдахуун ойлголтыг нэрлэхийн цагт үндэстний сэтгэлгээ, түүний илэрхийлэл болсон хэлний тэмдгийн шүтэлцээг зайлшгүй харгалзах ёстойг онцлон тэмдэглэсэн байна (Пүрэвжав, 2009:20). Адилтгал нэр томьёо нь тухайн үндэстний сэтгэлгээ, танин мэдэхүйн онцлогтой салшгүй холбоотой тул англи хэлний адилтгал нэр томьёог орчуулахдаа үндэстний сэтгэлгээ, түүний илэрхийлэл болсон хэлний тэмдгийн шүтэлцээг онцгойлон анхаарах хэрэгтэй юм. Гэтэл бидний тусгайлан авч үзэж буй бизнес эдийн засгийн салбарын нэр томьёонд энэ онцлогийг төдийлөн харгалзаагүйгээс үүдсэн нэр томьёоны олон асуудал байна. Бид энэ хэсэгт зөвхөн сонгон авсан эх хэрэглэгдэхүүнийхээ хүрээнд авч үзсэнгүй, ер нь бизнес, эдийн засгийн салбарт англи хэлний адилтгал нэр томьёог орчуулахад ямар асуудал тулгарч байгааг бусад толь бичиг, эх сурвалжуудын жишээгээр авч үзэх болно.

Монгол хэлэнд өөрийн ард түмнийхээ танин мэдэхүй, соёл, сэтгэлгээний онцлогийг судлаагүйгээс англи зэрэг гадаад хэлнээс шууд орчуулан авсан ухаалаг *гар утас*, *ухаалаг карт*, *эрсдлийн удирдлага*, *өрийн удирдлагын хууль* - (*debt management law*), *хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ* (*accredited property management*) *өрийг дахин санхүүжүүлэх* гэх мэт монгол хүний уламжлалт сэтгэлгээнд үл тохирох амьгүй зүйлийг хүншүүлэн нэрлэсэн үг хэллэг, нэр томьёог “махчилан” орчуулсан жишээ салбар бүрийн нэр томьёоны санд олон байна. Тухайлбал, Компанийн тухай хуульд “толгой компани”, “охин компани” гэсэн нэр томьёо бий. Тэгш хэмийн (*equivalent*) зарчмаар харьцуулж үзвэл, эцэг эх гэвэл охин, толгой гэвэл салбар компани гэж нэрлэх нь ангилал зүйн хувьд зохистой юм. О.Шинэбаяр, Б.Золжаргал нар “Англи хэлний “daughter company” гэдгийг гадаад хэлний толь бичигт “аль нэг томоохон компанид хагас буюу бүтэн өмчлөгдсөн компани” гэж тодорхойлсон байна. Тэргүүлэх компаниас салбарласан компани гэсэн утгаараа үүнийг “салбар компани” гэж нэрлэж ч болох юм. “Parent company” гэсэн үгийг “толгой компани” хэмээн орчуулан авсан нь монгол хэлний утга шилжүүлэх аргыг ашиглан бүтсэн үндэсний шинжтэй нэр томьёо болж чадсан бол “daughter company” гэдгийг “охин компани” гэж орчуулсан нь үгчлэн авсан тохиромжгүй нэр болжээ (Шинэбаяр, Золжаргал, 2019:88).

Англи, монгол хүний хэл соёл, амьдралын хэв маяг, нийгмийн байдал, шашин шүтлэг зэргийн ялгаанаас шалтгаалан тэдний юмсыг адилтгаж, зүйрлэн сэтгэх арга өөр байдаг нь орчуулгын дүйцлийн тухай асуудалтай салшгүй холбоотой. Тухайлбал, англи хэлний “death valley”, “angel investor” хэмээх адилтгал нэр томьёотой шууд дүйх нэр томьёо монгол хэлэнд байхгүй. Гэтэл манай улсын бизнес эдийн засгийн салбарт “*үхлийн хөндий*”, “*анжел хөрөнгө оруулагч*” гэж хуулбарлан орчуулан хэрэглэж байна. Энэ хоёр нэр томьёо нь гарааны бизнестэй холбоотой бөгөөд “death valley” хэмээх нэр томьёо нь “аливаа бизнесийн хөгжлийн эхлэлийн болон эхэн үе шатуудад тулгардаг хамгийн хүнд, эмзэг үе” -ийг нэрлэдэг бөгөөд энэ хүнд үеийг олон бизнес давж гарч чаддаггүйгээс бизнесийн “үхлийн хөндий” гэж нэрлэжээ. Харин “angel investor” хэмээх нэр томьёо нь “жижиг стартап компаниудыг үйл ажиллагаагаа эхлэхэд нь тусалж эхэн үеийн бага хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг бие даасан хөрөнгө оруулагч”-ийг нэрлэдэг ажээ. Уг хоёр нэр томьёо нь ухагдахууны хувьд харилцан уялдаатай. Тодруулбал, “death valley”

буюу энэ хүнд үеийг давахад “angel investor” хөрөнгө оруулж тусалдаг. Тиймээс тэдгээрийг ухагдахууны холбоогоор хамтад нь авч үзэх хэрэгтэй юм. Англи хэлний уг хоёр адилтгал нэр томъёонд шууд дүйх үг монгол хэлэнд байхгүй. Монгол хэлэнд “death valley”-г “үхлийн хөндий” хэмээн хуулбарлан орчуулж, “angel investor”-г “анжел хөрөнгө оруулагч” хэмээн галигчлан орчуулсан нь Буддын шашин, бөөгийн шүтлэгтэй, үгийн цээрийг хатуу баримталдаг, бэлгэдэлт сэтгэлгээтэй монгол хүний оюун санаанд шууд буухгүй нэр томъёо юм. Үүнээс үзэхэд, адилтгал нь үндэстний сэтгэлгээний хувьсал, үндэсний хэлний хөгжлийн явцад бий болдог тул үндэсний онцлог бүхий үг, хэллэгтэй ойртож очих юм. Иймээс адилтгалыг үндэсний онцлогтой үг, хэллэгийг орчуулах аргаар буулгах өөрөөр хэлбэл, соёлын онцлог орчуулгын арга илүү тохиромжтой гэж үзэж болно.

Орчуулга судлаач М.Чимэдцэеэ соёлын онцлог орчуулгын талаар:

“Орчуулахуйн ухааны уламжлалт хоёр арга болбоос үгчлэх, утгачлах билээ. Орчуулгын онолын уламжлалт чиг баримжаа, үндсэн жаяг зарчмын үүднээс, орос хэлний “сүүн зам”, хятад хэлний “тэнгэрийн гол”-ыг монгол хэлний утга тохирох үгээр оноон “тэнгэрийн оёдол”, “тэнгэрийн заадаас” хэмээн утга дүйлгэн орчуулах нь зүйд нийцнэ. Харин соёлын орчуулга судлалын үндсэн хоёр арга ухаан буюу стратеги бол “идээшүүлэх” (domestication, доместификация) ба “ондоошуулах” (foreignization, форенизация) юм. “Идээшүүлэх” гэдэг нь өөрийн үндэстний соёлыг гол цөм болгон, эх бичвэр дэх харь үнэлэмжийг орчуулж буй хэлнийхээ соёлд шингээн, өөрийн хөрснөө нутагишуулах, “ондоошуулах” гэдэг нь эх бичвэрийг гол цөм болгон, эх бичвэрт буй хэл соёлын ялгаа зөрөөг хэвээр хадгалан, харь соёлыг таниулж, ондоошуулах явдал юм. Унишгч хүнд ойлгомжтой байхыг чухалчилбаас эрхбиш “идээшүүлэх”, эх бичвэрт үнэнч байхыг чухалчилбаас эрхбиш “ондоошуулах” хэрэгтэй болдог байна. Эх бичвэр дэх соёлыг “идээшүүлэх”-ийн тулд хэт дүйлгэн орчуулбаас тухайн үндэстэн угсаатны соёлын утга агуулга, учир холбогдол бүдгэрч, унишгч хүний сэтгэлгээ нь зохиогчийн буюу эх бичвэрийн сэтгэлгээ, соёл лугаа ижилсэх хандлага буй болдог ажээ. Дээр өгүүлсэн жишээн дээр үзвээс, өрнө дахины “сүүн зам”, дорно дахины “мөнгөн гол” хэмээх ухагдахууныг “тэнгэрийн заадаас” хэмээн утгачлан орчуулж “идээшүүлбээс” нэг талаар монгол унишгч тэрхүү өрнө дахины “сүүн зам”, дорно дахины “мөнгөн гол” хэмээхүйн соёлын гүн чанад утга агуулгыг огт мэдэхгүй өнгөрөх, нөгөө талаар харийн соёл сэтгэлгээг монгол унишгчид хүчээр тулгасан хэрэг болж хувирах гэмтэй юм” (2019:96 - 97) гэсэн байдаг. Тиймээс ийм төрлийн нэр томъёог хуулбарлах, зээлдэхийг урьтал болголгүй өөрийн хэл соёлд тохируулан хувиргал хийн орчуулах нь зүйтэй юм.

“Death valley” хэмээх үгийн утга, хэрэглээг авч үзвэл “эрсдэлт үе”, “angel investor”-г “авралт хөрөнгө оруулагч” хэмээн утга ерөнхийлөн хувиргаж орчуулсан дээр юм. Ер нь адилтгал нэр томъёог орчуулахдаа сурвалж (SL) ба зорилтот хэл (TL)-ний соёл сэтгэлгээний ялгааг сайтар ойлгож, таниж мэдэн нухацтай хандах хэрэгтэй юм.

Бизнес, эдийн засгийн англи-монгол нэр томъёоны толь бичгүүдийг үзвэл, англи хэлний адилтгал нэр томъёог олон хувилбараар орчуулсан байна. Тэдгээрээс зарим жишээг авч үзье.

Хүснэгт 2. “Bull market”, “bear market” хэмээх нэр томъёоны олон хувилбарт орчуулга

Англи нэр томъёо	Орчуулгын хувилбар
Bull market	1. Том зах зээл /Жигжидсүрэн, Б. 2006. Бизнесийн англи хэлний англи - монгол толь, УБ., Сорхон цагаан ХХК, 366х./ 2. Бух зах зээл /Форекс нэр томъёоны тайлбар толь/ 2013, /Банк санхүүгийн нэр томъёоны тайлбар толь/ 2017: 416 3. Өсөх хандлагатай зах зээл / Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг, УБ., 2017/

Bear market	1. Ханасан зах зээл /Жигжидсүрэн, Б. 2006. Бизнесийн англи хэлний англи - монгол толь, УБ., Сорхон цагаан ХХК, 366х./ 2. Баавгай зах зээл /Форекс нэр томъёоны тайлбар толь/ 2013, /Банк санхүүгийн нэр томъёоны тайлбар толь/ 2017: 416 3. Буурах хандлагатай зах зээл / Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг, УБ., 2017/
-------------	--

Дээрх хоёр нэр томъёоны утгыг бизнес эдийн засгийн англи толь бичгүүдээс судалж үзвэл, дараах байдалтай байна. Үүнд:



Bull market - хувьцааны үнэ өсөхийг хүлээж урт хугацаанд хөрөнгө оруулах стратегийг баримталдаг арилжааг нэрлэнэ. Хөрөнгийн зах зээл дээр хувьцааны ханш огцом өсөх үйл явцыг бух өрсөлдөгчөө эврээрээ сэжин өлгөж дээшээ шидэх үйлдэлтэй зүйрлэсэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, зах зээл дээр хувьцаа, үнэт цаасны үнэ ханш өсөх үзэгдлийг *"bull market"* буюу *"бух зах зээл"* гэж нэрлэнэ.

Bear market - хувьцааны үнэ буурахад богино хугацааны хөрөнгө оруулах стратегийг баримталдаг арилжааг нэрлэнэ. Санхүүгийн зах зээл дээр хувьцааны ханшийг доош огцом бууруулах стратегийг баавгай хүчит савраараа доош нь савардах төрөлх араншинтай зүйрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, зах зээл дээр хувьцаа, үнэт цаасны үнэ ханш буурах үзэгдлийг *"bear market"* буюу *"баавгай зах зээл"* гэж нэрлэнэ.

Зураг 4. "Bull market", "bear market" хэмээх адилтгал нэр томъёоны эсрэгцсэн утга

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд, тухайн хоёр адилтгал нэр томъёоны гарал нь бух, баавгай гэсэн хоёр амьтны тулалдах шинжтэй адилтган үүссэн байна. Бид дээрх нэр томъёонуудын гарал үүсэл, үүрэг, утгыг харгалзан үзвэл, *бух зах зээл*, *баавгай зах зээл* гэсэн хуулбар орчуулга нь тухайн хоёр ухагдахууны онцлогийг илэрхийлж чадахгүй бөгөөд уншигч, хэрэглэгч ямар ухагдахуун илэрхийлж байгааг шууд төсөөлөхөд бэрх байна. Харин *өсөх хандлагатай зах зээл*, *буурах хандлагатай зах зээл* гэж орчуулсан нь хэдийгээр тайлбар шинжтэй боловч тухайн ухагдахуунуудыг ойлгоход арай илүү дөхөм болжээ. Харин дээрх хоёр нэр томъёоноос *"хандлагатай"* гэсэн үгийг хасаж, *өсөх зах зээл*, *буурах зах зээл* гэж хураангуйлбал, утга гажуудах зүйлгүй юм.

Дүгнэлт

Адилтгалын аргыг нэр томъёо бүтээхэд өргөн хэрэглэх болсон нь шинжлэх ухааны шинэ ойлголт ухагдахууныг ахуй амьдрал, орчин нөхцөлтэй ойр зүйлээр адилтган нэрлэвэл, тухайн ухагдахууныг хялбар ойлгох, улмаар хэрэглээнд хэвшихэд дөхөм хэмээн үзэж байгаа хэрэг юм. Түүнчлэн адилтгал нэр томъёо нь тухайн зохиогчийн ертөнцийн юмс үзэгдлийг хэрхэн ойлгож, танин мэдэж байгаатай шууд холбоотой.

Аливаа улс орон өөрсдийн соёл, сэтгэлгээ, танин мэдэхүйн онцлог, амьдралын туршлагад үндэслэн нэг юмс үзэгдлийг нөгөөтэй адилтган нэрлэсэн байдаг тул адилтгал нэр томъёо нь нэг талаас үндэсний онцлог үгтэй ойролцоо гэж үзэж болно. Тиймээс тэдгээрийг орчуулахдаа гадаад сурвалж буюу орчуулгын эх хэл (SL), зорилтот буюу орчуулах хэлний (TL) онцлогийг харгалзан ямар үед идээшүүлж, ямар үед ондоошуулж орчуулах вэ гэдгийг сайтар бодож орчуулах хэрэгтэй.

Бидний судалгаанаас үзэхэд, бизнес, эдийн засгийн салбарт адилтгал нэр томъёог энгийн үгээр утгачлан орчуулах, хуулбарлан орчуулах, өөр адилтгал нэр томъёогоор дүйлгэн орчуулах, энгийн үгээр дүйлгэн орчуулах, тайлбарлан орчуулах, шууд зээлдэх аргуудыг хэрэглэж байна.

Эдгээрээс энгийн үгээр утгачлан орчуулах аргыг хамгийн түгээмэл хэрэглэсэн байна. Гэвч бидний энэ удаагийн судалгаа зөвхөн нэг салбарын нэг зохиогчтой толь бичгийн хүрээнд авч үзсэн тул аль ч салбарын адилтгал нэр томьёог орчуулахад утгачлан орчуулах арга давамгайлдаг гэж яаран дүгнэж болохгүй юм. Учир нь адилтгал нэр томьёог хэрхэн орчуулах, ямар арга, хувиргалыг түлхүү хэрэглэх зэрэг нь орчуулагчийн танин мэдэхүй, соёл сэтгэлгээний онцлогоос гадна түүний тухайн салбар шинжлэх ухааны хийгээд орчуулга, хэл шинжлэлийн мэдлэг чадвараас шалтгаална.

Англи хэлний адилтгал нэр томьёоны орчуулгад ажиглагдаж буй түгээмэл асуудал нь англи, монгол хүний хэл соёл, амьдралын хэв маяг, нийгмийн байдал, шашин шүтлэг зэргийн ялгааг үл анзааран шууд үгчлэн орчуулснаас монгол хүний оюун санаанд шууд буухгүй, оновчгүй нэр томьёо олон байна. Тиймээс хуулбарлан орчуулах, шууд зээлдэхийг урьтал болгохгүй, тухайн ухагдахууны мөн чанарыг алдагдуулахгүйгээр хэлбэр буюу дүр төрхийг хувирган өөрчилж, орчуулах хэрэгтэй.

Бид энэ удаад адилтгал нэр томьёоны орчуулгын асуудлыг ерөнхийлөн авч үзсэн бөгөөд цаашид танин мэдэхүйн хэл шинжлэл, соёл хэл шинжлэлийн үүднээс улам нарийвчлан гүнзгийрүүлэн судлах болно.

Ном зүй

Монгол хэлээр

- Базаррагчаа, М. (1993). *Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр*. Уб., Орчлон компани. 141х.
- Базаррагчаа, М. (2005). *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Уб., МУИС-ийн хэвлэх үйлдвэр. 420х.
- Базаррагчаа, М. (2017). *Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган*. МУИС-ийн хэвлэх үйлдвэр. Уб.,
- Баянсан, Ж. (2016). *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Уб., МУИС-ийн хэвлэх үйлдвэр. 227 х.
- Гүрбазар, Р. (1996). Орчуулгын онол, дадлагын үндэс, Уб., 275 х.
- Золжаргал, Б. (2018). Утга шилжих аргаар бүтсэн ургамлын нэр томьёо. *Хэрэглээний хэл шинжлэл*. Боть III (18). Уб., “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр. х. 39-53.
- Нансалмаа, Н. (2011). *Хэл шинжлэлийн судалгааны арга зүй*. Уб., “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр. 221 х.
- Өлзийхутаг, Ц. (1988). *Монгол хэлний үгийн сан судлал*. Уб., АБЯХ. 125 х.
- Пүрэвжав, Э. (2009). Монгол нэртөмьёо судлалд академич Ш.Лувсанванданы оруулсан хувь нэмэр. *Нэр томьёо судлал* №11. Уб., х.17-25.
- Равдан, Э. (2005). *Бүтэц хэл шинжлэл*. Уб., 171 х.
- Сүхбаатар, Ц. (1988). *Монгол хэлний найруулга зүй*. Уб., УХГ. 171 х.
- Төмөрцэрэн, Ж. (1974). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Уб., УХГ. 161 х.
- Цэвээндорж, Д. (2018). Монголын утга зохиолын онолын ойлголт, нэр томьёог шинээр авч үзэх нь. *Хэрэглээний хэл шинжлэл*. Боть III (18). Уб., “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр. х.96-110.
- Чимидцэеэ, М. (2019). Хэл, соёл, сэтгэлгээ, орчуулгын шүтэлцээ. Хэлний соёл судлал-2019, СУИС-ийн ЭШХ-ын эмхэтгэл. х. 95-98.
- Шинэбаяр, О. (2018). Адилтгалын аргаар бүтсэн нэр томьёо. *Хэрэглээний хэл шинжлэл*. Боть III (18). Уб., “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр. х.111-122.
- Шинэбаяр, О., Золжаргал, Б. (2019). *Ур ухаан тэлэх уламжлалт мэргэжлийн үгс*. Уб., Соёмбо принтинг. 154 х.
- Шинэбаяр, О., Золжаргал, Б. (2020). *Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо*. Уб., “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр. 167 х.

Энхзаяа Д. (2012). *Сүүдрийн эдийн засаг*. Монгол банкны судалгааны ажлын товхимол-8. Уб., 26х

Гадаад хэлээр

- Black, M. (1990) *Metafora*. //Teoriya metafori./ Tr. into Russian from English. M.: Progress.
- Dagut, Menachem. (1976). Can "Metaphor" Be Translated? Published online: 01 January <https://doi.org/10.1075/babel.22.1.05dag>.
- Khadidja Merakchi. (2017). The Translation of Metaphors in Popular Science from English into Arabic in the domain of Astronomy and Astrophysics. doctoral dissertation submitted to University of Surrey.
- Knowles, Frank (1996) Lexicographical Aspects of Health Metaphor in Financial Text. In Gellerstam et al. (eds), EURALEX '96 Proceedings I-II. Papers submitted to the Seventh EURALEX International Congress on Lexicography, G teborg, Sweden, 1996, Part II. G teborg: G teborg University Department of Swedish, 789-796.
- Lakoff, G. (1992) Metaphor and semantics. In W. Bright, ed., *International Encyclopedia of Linguistics*. Oxford: Oxford University Press. pp. 417-419.
- Lakoff, George and Mark Johnson. (1980). *Metaphors we live by*. Chicago: University of Chicago Press, 241 p.
- Liebert, Wolf-Andreas (1994). Lascaux-A Hypermedia Lexicon of Metaphor Models for Scientific Imagination. In Martin et al. (eds), EURALEX '94 Proceedings. Amsterdam: Vrije Universiteit, p.494-500.
- Mandelblit, N. (1995). The cognitive view of metaphor and its implications for translation theory. *Translation and Meaning*, Part 3, pp.483 – 495.
- Meyer, Ingrid, Victoria Zaluski and Kristen Mackintosh (1997). Metaphorical Internet Terms: A Conceptual and Structural Analysis. *Terminology* 4 (1), p.1-33.
- Newmark P. A (2008). *Textbook of Translation*. Harlow: Pearson Education Limited. 292 p. [URL: <http://rllinguistics.ru/en/journal/article/694/>].
- Orthony Andrew. (1979). *Metaphor and Thought*. Cambridge: Cambridge University Press
- Pavel, Silvia (1993). Neology and Phascology as Terminology-in-the-Making. In Sonneveld and Loening (eds), *Terminology: Applications in Interdisciplinary Communication*. Amsterdam/Philadelphia: John Benjamins, p.21-34.
- Richards, I. A. (1936). "Metaphor" *The Philosophy of Rhetoric* (Oxford: Oxford University Press).
- Thoiron, Phillippe (1994). La terminologie multilingue : une aide   la ma trise des concepts. *Meta* 39(4), p.765-773.
- Van den Broeck. R. (1981). The limits of translatability exemplified by metaphor translation. *Poetics Today* 2, pp.73–87.
- William P.Brown. (2002). *Seeing the Psalms: A Theology of Metaphor*. Louisville and London: Westminster and John Knox. xiii + 274 p.
- Казакова Т.А. (2001). *Практические приемы перевода*. СПб.: Союз. 320 с.
- Комиссаров В.Н. (1990). Теория перевода (лингвистические аспекты): Учеб. для ин-тов и фак. иностр. яз. - М.: Высш. Шк. 253 с.
- Фрейдинберг, О.М. (1996). *Античные теории языка и стиля*. М.: Русский словарь. 344 с.

Ашигласан хэрэглэгдэхүүн

Базаррагчаа, М., Ганзориг, А., Болд, Л., Буянтогтох, Г., Батсайхан, Д., Ганбат, Ж., Нямаа, Б. (2017). *Банк санхүүгийн нэр томъёоны тайлбар толь*. Уб., 495 х.

Жигжидсүрэн, Б. (2006). Бизнесийн англи хэлний англи - монгол толь. Уб., Сорхон цагаан ХХК, 366х./

Форекс нэр томъёоны тайлбар толь. http://ambaga.blogspot.com/2009/06/blog-post_4579.html

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо. (2017). Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг. Уб., <https://openjicareport.jica.go.jp/pdf/12303764.pdf>

Цахим хэрэглэгдэхүүн

<https://mongoltoli.mn/dictionary>

<https://thelawdictionary.org/bribe/>

<https://hinative.com/en-US/>

<https://www.translegal.com/dictionary/>

<https://dictionary.cambridge.org/dictionary/english/black-economy>

Товчилсон үг

БСНТТТ – Банк санхүүгийн нэр томъёоны тайлбар толь

БАМТ- Бизнесийн англи-монгол толь



УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭР ТОМЬЁОГ ХУУЛБАРЛАН ОРЧУУЛАХ НЬ

С.Дугармаа⁵⁸, Ц.Одончимэг⁵⁹

Abstract: Two words and multi words compound terms related to hydraulic structure in Mongolian are often created by literal translation from foreign languages as Russian and English. Two words compound terms have structure as joining two words as Noun+Noun, Adj+Noun, Verb+Noun and as blending multi words: compound word+word, word+compound words, compound words+compound words. The compound terms are formed using case in Russian, suffixes and possessive case in Mongolian. In English, compound terms are often formed as N+N, Adj.+N, and Past Particles +N.

Түлхүүр үг: нийлмэл нэр томьёо, үгийн бүтэц, утга, үндэс, дагавар, нөхцөл

Оршил

Усны барилга байгууламжийн (УББ) нэр томьёог оноон тогтоохдоо хуулбарлан орчуулах аргыг элбэг хэрэглэж ирсэн байна. Орчуулгын аргуудаас хуулбарлан орчуулах нь нэр томьёо бүтээхэд гол үүрэгтэй арга бөгөөд энэ нь үгийн сан, үг бүтэх ёс, утга зүйг хамарсан судлагдахуун юм. Нэр томьёо тогтоох уламжлалт туршлагыг манай нэр томьёочил өргөн хэрэглэж, ялангуяа хуулбарлан орчуулах аргыг орчин цагийн аргуудтай бүтээлчээр хослуулан хөгжүүлсний үр дүнд шинжлэх ухааны олон салбар өөрийн гэсэн олон зуун хуулбар нэр томьёотой болсон.

Хуулбарлан орчуулах аргыг зэргээр нь бүтэн хуулбарлах, хагас хуулбарлах гэж ангилахыг олон судлаач, орчуулагч нар өөрсдийн бүтээлдээ дурдсан байна.

Усны барилга байгууламж дахь хагас хуулбарласан нэр томьёо

Хоёр хэлний нэр томьёоны утга тохирч байгаа тохиолдолд уг аргыг хэрэглэх болно гэж судлаач Н.Мөнхцэцэг үзээд үүнийг хэлшинжлэлийн онолын үүднээс лавшруулан үзвэл, нэг хэлний өнгөн ба гүн бүтцийг нөгөө хэлэнд яг тусгана гэсэнтэй бид санал нийлж байгаа юм. (Н. Мөнхцэцэг, 2020:221) Хагас хуулбар нэр томьёог хагас хуулбарлан орчуулсан энгийн үг, хагас хуулбарлан орчуулсан нийлмэл үг гэж хуваан үзэж болно. Монгол хэлний -лт дагавар нь орос хэлний -ация, -ание, -иние дагавар болон англи хэлний -tion залгавраар дүйцүүлэн хагас хуулбарлан орчуулж нэр үг бүтээсэн нь УББ-ийн нэр томьёонд нэлээд байна.

ammonification -аммонификация-амонжилт- (Л.Жанживдорж, 2018:17)

ionization -ионирование-ионжуулалт (Н. Чагнаа, 2006:137)

phosphatization -фосфатирование-фосфатжуулалт (Н. Чагнаа, 2006:298)

hydraulic excavation -гидромеханизация-гидромеханикжуулалт (Л.Жанживдорж, 2018:107)

⁵⁸ ШУТИС-ийн ГХС-ийн Англи хэлний тэнхим, доктор, дэд проф.

⁵⁹ ШУТИС-ийн ГХС-ийн Англи хэлний тэнхим, докторант

Толь бичиг, нэр томъёоны стандартад энгийн үгээр илэрсэн хагас хуулбарласан нэр томъёо цөөн байгаа ч сүүлийн үеийн ном бүтээлд монгол оноолттой нэр томъёо хэдий ч хагас хуулбар хэлбэрээр тохиолдох нь элбэг байна. Жишээлбэл: “...цэвэрлэх байгууламжийн технологит *денитритжүүлэлтийн аргыг* зайлшгүй хэрэглэх шаардлагатай болоод байна. Учир нь байгалийн усан орчин болох гол, нуур, цөөрөм зэрэгт *эвтрофикацийн процесс* эрчимтэй явагдаж усны температур нэмэгдэх, төрөл бүрийн завсрын амт, үнэр бий болох, усны өнгө муудаж, замаг ихээр ургаснаас ... загасны амьдралын үйл ажиллагаа алдагддаг”. (БОАЖЯ “Хөгжлийн түлхүүр ус” 2018: 210-212). Энд *денитритжүүлэлтийн арга*-азотын хүчлийн давсны задрал (Н.Чагнаа, 2006:20) *эвтрофикацийн процесс* - цөөрөм замгаар бохирдох үйл явц (Н.Чагнаа, 2006:554) гэсэн байна.

Харин нийлмэл бүтэцтэй хагас хуулбар нэр томъёо *гадаад үг+монгол үг, монгол үг+гадаад үг* гэсэн бүтэцтэй байгаа бөгөөд энэ нь англи, орос, монгол хэлэнд адилхан хэлбэртэй үүсчээ.

Гадаад үг+монгол үг бүтэцтэй нэр томъёо.

hydraulic tunnel - гидротехнический туннель-гидротехникийн хонгил (MNS 6694:2017)

turbine casting- турбинная камера- турбины хорго (Н.Ч, 2006, х.232)

chlorination plant- установка для хлорирования- хлоржуулах төхөөрөмж (Н.Ч, 2006, х.407)

anchor wall- анкерная стенка- анкер хана (Л.Ж, 2018, х.376)

Монгол үг+гадаад үг бүтэцтэй нэр томъёо.

vertical shaft turbine- вертикальная турбина- босоо турбин (Н.Ч, 2006, х.42)

sinking pump- погружной насос- гүний насос (Л.Ж, 2018, х.2436)

slush ice sampler- шугобатометр- зайрын батометр (Н.Ч, 2006, х.125)

Хагас хуулбар дэлгэрэнгүй нийлмэл нэр томъёо нь дараах бүтэцтэй байна.

Нийлмэл үг+үг эсвэл үг+нийлмэл үг хэлбэртэй байна.

automatic regulator- автоматический регулятор- автомат тохируулгат тэнцүүлэг(Л.Ж, 2018, х.255)

tidal hydroelectric station- приливная электростанция- түрлэгийн цахилгаан станц (Н.Ч, 2006, х.238)

ice gauging staff- ледемерная рейка- мөс хэмжүүрийн рейк (Н.Ч, 2006, х.155)

back sheeting- задняя шпунтовая стенка- арын шпунтэн хана (Л.Ж, 2018, х.286)

Нийлмэл үг+нийлмэл үг хэлбэртэй байна.

main drainage channel- магистральный дренажный коллектор- хатаах системийн үндсэн коллектор (Л.Ж, 2018, х.51)

drainage pumping plant- осушительная насосная станция- хатаалтын системийн шахуурга станц (Н.Ч, 2006, х.394)

Усны барилга байгууламж дахь бүтэн хуулбарласан нэр томъёо

Хэл шинжлэлийн лавлахад “харь хэлний үгийг хуулбарлан орчуулах гэдэг нь эх хэлэнд өөр хэлний үгийн сан-утгазүй, үгийн сан-өгүүлбэрзүйн загвараар, эсвэл, тэр хэлний бүтээврийг хуулбарлан шинэ үг үүсгэхийг хэлнэ” (О.С.Ахманова, 1966:19) гэж үздэгийг манай судлаачид нэлээд баримталсан байдаг. Г.Баярмаа 2014 онд “Мэдээлэл холбооны технологийн нэр томъёо, түүний цахим сан бүрдүүлэх нь” бүтээлдээ нэр томъёог орчуулахдаа “үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүнээс нэр томъёоны үүргээр хэрэглэсэн нь тун цөөн, харин хуулбарлах аргаар авсан нь дийлэнх байна” гэж үзсэн. Шууд хуулбарлах энэ аргаар нийлэмж нэр томъёо бүтээх нь сайн, муу хоёр талтай гэж тэрээр үзсэн байна. Эерэг тал нь шинэ нэр томъёо бүтээж үгийн санг баяжуулах нөлөөтэй ч, орчуулгын онолд махчилж орчуулах гэж нэрлэдэг бөгөөд гадаад үгийг хэт баримталснаас буруу найруулгатай нэр томъёо үүсэх үзэгдэл байна гэжээ.

Доорх жишээнээс харахад орос хэлний -ация, -азия, -чить, -ания дагавар нь дагавар англи хэлний-tion дагавартай, харин монгол хэлэнд үйлийн явц зааж -лт дагавартай дүйх тохиолдол элбэг, цөөн тохиолдолд -л, -лгаа дагавраар үүссэн байна.

кислотность	Acidity	хүчилшил	(Н. Чагнаа 2006:441)
диссимиляция	dissimilation	Задалгаа	(Н. Чагнаа 2006:123)
разбавление	dilution	шингэлэлт	(Н. Чагнаа 2006:459)
испарение	evaporation	Ууршилт	МУС 2016
дистилляция	Distillation	Нэрэлт	МУС 2016
минерализация	mineralization	эрдэсжилт	МУС 2016
экстракция	Extraction	ялгалт	МУС 2016

Бүтэн хуулбар нийлмэл нэр томьёоны бүтцийг хураангуй, дэлгэрэнгүй гэж хуваан, хураангуй нийлмэл үгийг а/ хамжуулах аргаар үүссэн хураангуй нийлмэл үг, б/ найруулах аргаар үүссэн хураангуй нийлмэл үг, дэлгэрэнгүй нийлмэл үгийг а/ нийлмэл үг+үг, б/ үг+нийлмэл үг, в/ нийлмэл үг+нийлмэл үг гэсэн бүтэцтэй байна.

Хамжуулах аргаар үүссэн хураангуй нийлмэл бүтэн хуулбар нэр томьёо:

Орос хэлний тэмдэг нэрс жинхэнэ нэрд үндсээрээ захирагдан бүтсэн нийлмэл нэр томьёо монгол хэлэнд мөн тэмдэг нэрс жинхэнэ нэрд үндсээрээ захирагдан хамжуулах аргаар бүтсэн нийлмэл үг хэллэгээр хуулбарлан орчуулсан байна. Жишээ нь:

солёноватая вода	brackish water	давсархаг ус
солёная вода	saline water	давстай ус
мягкая вода	soft water	зөөлөн ус
серая вода	greywater	саарал ус
питьевая вода	drinking water	ундны ус
тяжелая вода	heavy water	хүнд ус
пресная вода	fresh water	цэнгэг ус

Орос хэлний тэмдэг нэр, жинхэнэ нэртэй үндсээрээ хамжин холбогдож үүссэн нийлмэл үг хэллэгийг монгол хэлэнд мөн тэмдэг нэрийг жинхэнэ нэртэй үндсээр нь хамжиж холбож хуулбарлан орчуулсан байна. Жишээ нь:

намывная плотина- hydraulic fall dam- хурдас боомт (Н. Чагнаа, 2006:435)
 водосток прочищающий- mudlark- цэвэрлэгч ус(УНТКМ) №117-118
 жидкость сточная- discharge liquid- бохир шингэн (УНТКМ) №117-118
 камера смесительная- mixing chamber- холиур хорго (УНТКМ) №117-118

Найруулах аргаар үүссэн хураангуй нийлмэл бүтэн хуулбар нэр томьёо

Орос хэлний жинхэнэ нэрийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбож бүтсэн найрсан хавсраа нийлмэл нэр үгийг мөн монгол хэлний жинхэнэ нэрийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбож бүтсэн найрсан хавсраа нийлмэл нэр үгээр бүтэн хуулбарлан орчуулсан хэлбэртэй ба энэ нь англи хэлэнд N+N хэлбэртэй байна. Жишээ нь: возраст ила- sludge age- лагийн насжилт (MNS 6279:2011)

загрязнения вод- water pollution- усны бохирдол (МУС 2016)

интенсивность аэрации-aceration intercity-агааржуулалтын эрчимшил (УНТКМ, №117-118)

Жинхэнэ нэрийг нөгөө нэр үгэнд жинхэнэ нэрээс тэмдэг нэр бүтээх үүрэгтэй -тай, -тэй, -той нөхцлөөр захируулан холбож үүссэн нийлмэл үгээр орос хэлний тэмдэг нэр, жинхэнэ нэртэй үндсээрээ хамжин холбогдож үүссэн нийлмэл үгийг хуулбарлан орчуулсан байна. Харин англи хэлэнд энэ нь N+N, Adj+N, PP+N хэлбэртэй байна. Жишээ нь: соленые воды- salt water- давстай

ус (МУС, 2016), напорные воды- artesian water- түрэлттэй (артезийн) ус (Н.Чагнаа, 2006:240), ил обезвоженный- dewatered sludge- чийгтэй лаг (Н.Чагнаа, 2006:454)

Орос хэлний тэмдэг нэрийг жинхэнэ нэрэнд үндсээр нь захируулан холбосон нийлмэл үгийг монгол хэлний жинхэнэ нэрээс тэмдэг нэр үүсгэх -т, -лаг, -мал, -аа, -ээ гэх мэт нөхцлөөр тэмдэг нэрийг нэр үгэнд захируулан холбож найрсан хавсраа үгээр хуулбарлан орчуулсан байна.

Үүнд а. -т дагавар: Тэмдэг нэр, нэр үгээс үүссэн нийлмэл үгийн дотор бидний дээр дурьдсан жинхэнэ нэрээс тэмдэг нэр бүтээх үүрэгтэй –тай, -тэй, -той нөхцөлийн хувилбар болох –т нөхцлийн тусламжтайгаар үүссэн нийлмэл үг зонхилох байрыг эзэлж байна. Мөн “-тай, -тэй, -той” нөхцөл нь илэрхийлж байгаа үгийнхээ юм зүйлийг нэрлэсэн болон тодорхой шинж байдлыг заасан байхад, харин –т нөхцөл нь шинж чанар, хийсвэр ухагдахууныг заасан байна. Жишээ нь: ячеистая перемычка - cellular cofferdam - үүрэн хийцэт далан (Л. Жанживдорж, 2018:56)

двухрядная перемычка- double-wall cofferdam - хоёр эгнээт далан (Л. Жанживдорж, 2018:56)

Бид доорх жишээг УНТКМ №117-118 –аас түүвэрлэсэн. Үүнд:

среда питательная- nutrient medium- шимт орчин
задвижка клиновaя- wedge plug- шаантагт хаалт
водазабор башенный- water intake tower- цамхагт ус хураамж
насос лaпостной- vane pump- хүрээт хөөрөг
насос многоступенчатый- multistage pump- олон шатат хөөрөг
колодец трубчатый- well point- хоолойт худаг
фильтр трубчатый- pipe filter- хоолойт шүүлтүүр
опор подвижная- free support- хөдөлгөөнт тулгуур
водозабор нестационарный- mobile intake- хөдөлгөөнт ус хураамж
клозет уборная- water-closet pan- татуурт хөтөвч
горизонт водоносный- aquifer- уст давхарга
труба ребристая- ribbed pipe- сархиат хоолой
труба с муфтой- socket pipe- бугуйвчит хоолой

б. -лаг (-лэг, -лог, -лөг), -лиг –рхаг(-рхэг, -рхог, -рхөг) нөхцлөөр бүтсэн нийлмэл үг нэр томъёоны салбарт маш өргөн хэрэглэгддэг боловч усны барилга байгууламжийн нэр томъёонд цөөн боловч тааралдаж байна. Жишээ нь: кислое брожение ила- acid fermentation of sludge-лагийн хүчиллэг эсэлт (Н.Чагнаа, 2006:145)

пористая среда горных пород- porous condition of rocks/porous media-чулуулгийн сүвэрхэг орчин- (МУС: Усны чанар. Нэр томъёо. Тодорхойлолт MNS 4079: 2016)

солоноватые воды-brackish water-давслаг ус (МУС: 2016)

в. -саг (-сэг, -сог, -сөг), -уур (-үүр), -мал, (-мэл), -маг (-мэг), -мтгай (-мтгэй) -вар, -втар, -нги, -рхуу (-рхүү), -дуу (-дүү), -аа (-ээ, -оо) нөхцлөөр үүссэн тэмдэг нэр түгээмэл хэрэглэгдэхгүй байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь: подвешенные воды- perched water-өргөгдмөл ус, подвешенные воды- suspended water- зүүгдмэл ус (Н.Чагнаа, 2006:183)

Орчин цагийн монгол хэлний нэр томъёонд үйлт нэр өргөн хэрэглэгддэг. Үйлт нэрийн үндсэн хэлбэрээс нэр томъёо үүсгэхэд хамгийн өргөн хэрэглэгддэг дараах бүлгийн үйлт нэр байна. Үүнд:

1. Ирээдүй цагаар тодотгон холбох –х нөхцөлөөр үйлт нэрийг нэр үгэнд захируулан холбож найрсан нийлмэл үг нэр томъёоны салбарт хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд ямар нэг зориулалт бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ихэвчлэн заан нэрлэсэн байна. Жишээг УНТКМ №117-118 –аас түүвэрлэсэн.

установка водоочистная- purification plant- ус цэвэрлэх төхөөрөг
установка дробильная- crushing plant- бутлах төхөөрөмж
установка очистительная- cleanning installation- цэвэршүүлэх төхөөрөг

устройства вспомогательное- auxiliaries- туслах төхөөрөг

устройства дренажные- drainage facilities- шүүрүүлэх төхөөрөг

Хуулбарлаж буй хэлбэрийг ажиглавал орос хэлний одоо цагаар тодотгон холбох –уш-, -юш- нөхцөлөөр үйлт нэрийг жинхэнэ нэрэнд захируулан холбох, орос хэлний тэмдэг нэрийг нэр үгэнд үндсээр нь захируулан холбосон нийлмэл үгээр буюу орос хэлний нийлмэл үг нь дагуул үг+цөм үг, цөм үг+дагуул үг гэсэн бүтцийн аль аль нь байж болж байхад харин монгол хэлэнд дагуул үг+цөм үг гэсэн бүтэцтэй байна. Мөн орос хэлний нэр үгийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбосон нийлмэл үгийг мөн дээрх загвараар хуулбарлан орчуулсан байна. Үүнд: установка для смягчения воды-softning plant- ус зөөлрүүлэх төхөөрөмж

2. Өнгөрсөн цагаар тодотгон холбох –сан нөхцөлөөр үйлт нэрийг нэр үгэнд захируулан холбож найрсан нийлмэл үг үйлийн төгссөн, дууссан шинж чанараар юм зүйлийг тодорхойлж байна. - сан нөхцөлтэй үйлт нэр нь нэр томьёонд хэрэглэгдэж байгаа тохиолдолд өнгөрсөн цагийн утгаа алдаж бүхэлдээ юм зүйлийн шинж чанар заасан утга илэрхийлж байна. Орос хэлний тэмдэг нэрийг жинхэнэ нэрэнд үндсээр нь захируулан холбосон нийлмэл үгийг хуулбарлан орчуулсан хэлбэртэй байх бөгөөд орос хэлний нийлмэл үг нь дагуул үг+цөм үг, цөм үг+дагуул үг гэсэн бүтцийн аль аль нь байж болж байхад харин монгол хэлэнд дагуул үг+цөм үг гэсэн бүтэцтэй байна. Жишээг УНТКМ №117-118 –аас түүвэрлэсэн.

Водопровод зонный- zoned water supply network- бүсчилсэн ус түгээгүүр

Канализация комбинированная- sewerage system- нэгтгэсэн бохир ус татуурга

Насос герметизированный- canned pump- нягтруулсан хөөрөг

Сушилка вакуумная- vacuum dryer- сийрэгжүүлсэн хатаалга

Трубопровод обводной- bypass line- тойрсон хоолой

Вентиляция местная- piece ventilation- тусгайлсан агаар сэлгүүр

Труба оцинкованная- galvanized pipe- цайрласан хоолой

Водозабор лучевой- radial water intake- хигээсэлсэн ус хураамж

Умывальник групповой- set wash-stand- хэсэгчилсэн угаагуур

Магистраль замкнутая- ring main- хүрээлсэн гол хоолой

Бүтэн хуулбарласан дэлгэрэнгүй нийлмэл нэр томьёог нийлмэл үг+үг, үг+нийлмэл үг, нийлмэл үг+нийлмэл үг бүрэлдэхүүнээр бидний авч үзэж буй хэрэглэгдэхүүнд нэр томьёог хэрхэн орчуулсныг дараах байдлаар авч үзлээ.

Үг+нийлмэл үг: Баня коммунальная-нийтийн халуун ус-municipal bath (УНТКМ №117-118, х.4) үгэнд “халуун ус” гэсэн хураангуй нийлмэл нэр томьёо “нийтийн” гэсэн үгээр захируулан холбож үүссэн байна. Жишээг УНТКМ №117-118 –аас түүвэрлэсэн.

Водопровод- water pipeline -ус дамжуулах хоолой

Вода межпластовая-давхрагын завсрын ус-inter-stratum water

Вода облучённая-цацрагаар хордсон ус-activated water

Нийлмэл үг+үг: Ассенизация-бохир ус тээвэрлэх-sanitation (УНТКМ №117-118, х.3) гэсэн нэр томьёонд “бохир ус” гэсэн хураангуй нийлмэл үгэнд салангид нэр үгийн зүйл буюу нэрийг болон үйл үгийн зүйл буюу үйлийг хамжуулан буюу найруулан холбож, гурван үгтэй дэлгэрэнгүй нэрийн болон үйлийн нийлмэл үгийг бүтээж байна. Жишээг УНТКМ №117-118 –аас түүвэрлэв.

Водоотведение- бохир ус татуурга-sewerage

Оборудование трубопроводное-дамжуулах хоолойн төхөөрөмж-pipeline equipment

Оголовок водозаборный-ус хураамжийн толгонцор-intake head

Опора трубопровода-дамжуулах хоолойн тулгуур-pipe support

Отведение сточных воды-бохир шингэнийг зайлуулах-sewage disposal

Нийлмэл үг+нийлмэл үг: Аерация механическая поверхность-усны гадаргууг механикаар агааржуулах-mechanical surface aeration гэсэн үгэнд “усны гадаргуу” гэсэн харьяалахын тийн

ялгалаар найруулан холбосон нийлмэл үгийг “механикаар агааржуулах” гэсэн үйлдэхийн тийн ялгалын нөхцлөөр найруулан холбосон үйлийн нийлмэл үгээр хэлбэржсэн нийлмэл үг+нийлмэл үгээр бүтсэн дэлгэрэнгүй нийлбэр бүтэн хуулбарласан нэр томъёо үүсчээ. Жишээг УНТКМ №117-118 –аас түүвэрлэсэн. Үүнд: Очистка сточных вод биологическая- sewage biological treatment- бохир усны биологийн цэвэрлэгээ, очиста сточных вод естественная- sewage treatment under natural conditions- бохир шингэний ердийн цэвэрлэгээ, очиста сточных вод механическая- mechanical sewage treatment- бохир усны механик цэвэрлэгээ

Дүгнэлт

Бүтэн хуулбар нийлмэл нэр томъёоны бүтцийг хураангуй, дэлгэрэнгүй гэж хуваан, хураангуй нийлмэл үгийг хамжуулах аргаар, найруулах аргаар үүссэн хураангуй нийлмэл үг гээд дэлгэрэнгүй нийлмэл үгийг нийлмэл үг+үг, үг+нийлмэл үг, нийлмэл үг+нийлмэл үг гэсэн бүтэцтэй байна.

Орос хэлний жинхэнэ нэрийг нөгөө нэр үгэнд тийн ялгалын нөхцлөөр захируулан холбож бүтсэн нийлмэл нэр үгийг мөн монгол хэлний жинхэнэ нэрийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбож бүтсэн нийлмэл нэр үгээр бүтэн хуулбарлан орчуулсан хэлбэр байна. Түүнчлэн жинхэнэ нэрийг жинхэнэ нэрээс тэмдэг нэр бүтээх үүрэгтэй нөхцлөөр захируулан холбож үүссэн нийлмэл үг, жинхэнэ нэрэнд үндсээр нь захируулан холбосон нийлмэл үгийг монгол хэлний жинхэнэ нэрээс тэмдэг нэр үүсгэх нөхцлөөр тэмдэг нэрийг нэр үгэнд захируулан холбосон нийлмэл нэр томъёо үүсгэж байна. Англи хэлэнд нийлмэл нэр томъёо нь Noun+Noun, Adj+Noun, Past Participle+Noun гэж холбон бүтээсэн нь элбэг байна.

Ашигласан ном хэвлэл

- Ахманова О.С.,(1966) “Словарь лингвистических терминов” Советская энциклопедия. М., 603 стр.
- Балдандорж Ц. (Ред.), (2018) БОАЖЯ “Хөгжлийн түлхүүр ус” УБ., 590 х, Сэлэнгэ Пресс ХХК
- Баярмаа Г.,(2014) “Мэдээлэл холбооны технологийн нэр томъёо, түүний цахим сан бүрдүүлэх нь” 158 х.
- Жанживдорж Л.,(2018)“Усны менежментийн англи-монгол-орос толь” 462 х., Мөнхийн үсэг ХХК
- Монгол Улсын Стандарт: Усны чанар. Нэр томъёо. Тодорхойлолт MNS 4079: 2016,
- Мөнхцэцэг Н., (2020)“Нэр томъёоны орчуулга судлал” 312 х. Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр
- MNS ISO 6707-1: 2010. Барилга ба иргэний барилга байгууламж
- Улсын Нэр Томъёоны Комиссын Мэдээ (УНТКМ) №117-118 1982 он, 115 х.
- Чагнаа Н.,(2006) “Усны аж ахуйн нэр томъёоны тайлбар толь” 590 х., Адмон ХХК



АНАГААХЫН НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

Б.Төмөрхуяг⁶⁰

Abstract: Translation of medical terms is extremely complicated. There must not be any error in the translation of medical terms such as symptoms, diagnosis, treatment and prescription. Any minor error can lead to irreparable damage. (Khainovskaya 2013:290) Despite the fact that the quality of translation of medical terms is constantly improving, there are still many mistakes occurring: double meanings of words giving ambiguity, errors in word-formations and use of technical terms wrongly.

Aim of the study is to evaluate English- Mongolian translation of medical terms.

Objectives: 1) to determine current situation of English- Mongolian translation of medical terms 2) to identify ways of improving the accuracy of translating medical terms.

Methods: In our study we used a documentary research method, team interview and questionnaires.

Conclusion: The main difficulty in translating medical terms is that the terms appear in multiple forms in dictionaries.-The translation of medical terms needs to be refined. To achieve this, the establishment of a National Committee on Medical Terminology and the involvement of specialists in each field is considered to be the right step.

Түлхүүр үг: анагаахын нэр томьёоны орчуулга, үгийн оноолт, нэр томьёог жигдлэх

Үндэслэл

Нэр томьёог орон орны судлаачид өөр өөрөөр тодорхойлж ирсэн. Монгол хэлний их тайлбар толинд нэр томьёо гэдэг нь мэргэжлийн ухагдахууныг бүрэн дүүрэн илэрхийлэх дан үг болон нийлмэл үг гэжээ. Оросын судлаач Герд.А.С нэр томьёог нилээд өргөн хүрээтэй тодорхойлсон. Бодит болон зохиомол хэлний нэгж, тухайн хэлний авиазүй, хэлзүйн дүрмийн дагуу тусгайлан бүтээсэн, шинжлэх ухааны аливаа ойлголтын үндсэн шинжийг хадгалсан үгийг нэр томьёо гэнэ. (Герд, 1979:14)

Орчуулга хэл шинжлэлийн анхаарлын төвд байнга орших ёстой гэж Р.Якобсон хэлсэнчлэн анагаахын нэр томьёонд анхаарлаа хандуулахыг хүслээ. (Jakobson, 1959:233)

Шинжлэх ухаан, техникийн хэлний орчуулга нь орчуулагчаас тухайн салбарын мэдлэг шаарддаг онцлогтой. Орчуулагч нь шинжлэх ухаан, техникийн хэлний өндөр мэдлэгтэй байхаас гадна, эх хэл, орчуулж буй хэлний өндөр чадвартай байх ёстой (Рецкер, 2007:15)

Анагаахын нэр томьёоны орчуулга нь хамгийн ярвигтай. Өвчний шинж тэмдэг, онош, эмчилгээ, жор гээд нэр томьёоны орчуулгын нэг ч алдаа гаргах учиргүй. Нэр томьёоны орчуулгын ялимгүй алдаа нь нөхөж баршгүй хохиролд хүргэнэ. (Хайновская, 2013:290)

Анагаахын эхүүдэд метафор болон бусад найрлага зүйн хэрэгслэлүүд, сэтгэл хөдлөл нэг их таардаггүй харин мэргэжлийн нэр томьёо, товчлол ихээр таардаг нь анагаахын орчуулгыг төвөгтэй болгодог. (Солнцев, 2010:131). Түүнчлэн анагаах нь зүрх судлал, мэдрэл судлал, нүд

⁶⁰ Ph.D, Department of Foreign Languages, MNUMS

судлал, нүүр ам судлал, эм судлал гэх мэт асар олон салбартай, хамгийн олон нэр томъёотой салбар юм.

Монголын анагаах ухаанд нэр томъёог эртнээс орчуулж ирсэн. Анагаах ухааны орчуулгын зохиол нь XII зуун, Ганжуур Данжуурын орчуулгаас эхтэй. 1630 онд “Анагаах ухааны дөрвөн үндэс” хэмээх орчуулгын бүтээл нь монгол уламжлалт анагаах ухааны үндэс болсон ба одоо ч ач холбогдлоо алдаагүй гэжээ (Раднаабазар, 2014:130)

1953 онд Н.Наваан - Юндэн анагаах ухааны нэр томъёоны анхны толь бичиг “Анагаах ухааны нэр томъёо” –г хэвлүүлсэн. 1961-1990 онуудад анагаах ухааны нарийн мэргэжлийн нэр томъёоны суурь тавигдсан үе гэж болно. (Нямдаваа, 2014:118)

1990 он хүртэл анагаахын нэр томъёог голдуу орос хэлнээс орчуулан хэрэглэдэг байв.

ШУА - ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн ОМНТТ бичгийн 3 ботид анагаах ухааны ерөнхий болон нарийн мэргэжлийн олон нэр томъёо багтсан байдаг.

Гэвч тус 3 ботид: гепатит хронический - архаг элэгтэс (1), аденин - аденин, булчирхайлуур (2), аденит – аденит, булчирхайтас (2), адреналин - адреналин, бөөр булчирхайдуур (2), аденома бронха - гуурсан хоолойн булчирхайнгар (2) гэх мэт -уур², -тас⁴, -нгар⁴ дагаврыг буруу хэрэглэсэн олон жишээ байна хэмээн судлаач Н.Мөнхцэцэг дурджээ. (Мөнхцэцэг, 2020:67)

Л.Балдан орос хэлнээс орчуулахдаа нэг нэр томъёог монгол хэлэнд олон нэр томъёогоор оноосон тохиолдол байгааг дурджээ Жишээ нь: “ангиома” гэдэг үгийг “судсан хавдар” “Анагаах ухааны нэр томъёо” -нд (1953), “Мэс заслын нэр томъёо” (1968) -д “судгар”, “Хүүхдийн өвчин судлал” (1968:80)-д “судсангар” гэж гурван янзаар нэрлэжээ (Мөнхцэцэг, 2020:67)

Түүнчлэн “Тогтоосон нэр томъёонд буруу өгсөн нэр хааяа байдаг. Жишээлбэл: родовые схватки - г төрөх базал гэжээ. Гэтэл монгол хэлэнд хэдэн зуун жил “хучилгах” гэж ном сударт тэмдэглэж байсан байна. (Раднаабазар, 2014:132)

Ийнхүү анагаахын нэр томъёог орчуулах ажил тасралтгүй хөгжсөөр байгаа хэдий ч нэг үгийн утгыг олон янзаар оноосон, зарим нэг үг бүтээх аргыг буруу хэрэглэсэн, уламжлалт үгсийг үл огоорон нэр томъёог амжилтгүй бүтээсэн зэрэг алдаа мадаг оршсоор байна. Бидний судалгааны ажил нь энэ зүгт анхаарлаа хандуулахыг зорьсон болно.

Судалгааны зорилго: Анагаахын нэр томъёоны орчуулгын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх.

Зорилтууд: 1) Анагаахын нэр томъёоны орчуулгын өнөөгийн байдлыг тодорхойлох
2) Анагаахын нэр томъёоны орчуулгын оноолтыг боловсронгуй болгох арга зам хайх

Судалгааны арга: Бид судалгаандаа баримтын арга, бүлгийн ярилцлага, асуулгын аргуудыг хэрэглэсэн. Баримтын аргын хүрээнд 4 өөр толь бичгээс түгээмэл хэрэглэгддэг анагаахын нэр томъёог түүвэрлэн үгийн оноолтыг судаллаа. Судалгаанд анагаахын англи хэл заадаг багш нар оролцов. Судалгааны асуумжийг Ликертийн аргаар боловсруулсан. Багш нар 5 хариу бүхий нийт 8 асуумжид хариулав. Судалгааны үр дүнг Excel программ ашиглан статистик боловсруулалт хийх замаар гарган авсан болно.

Анагаахын нэр томъёо

Англи болон бусад хэл дээрх анагаахын нэр томъёо нь бүгд өвөрмөц шинжтэй. Латин, грек гаралтай үг зонхилдог. Латин, грек гаралтай нэр томъёо нь бараг бүх европын хэлнүүдэд давамгайлдаг тул англи анагаахын нэр томъёог олон улсын нэр томъёо гэж хэлж болох юм. (Самойлов, 2017)

Анагаахын нэр томъёоны латин, грек үгийн үндэс нь нэг ижил утга илэрхийлдэг. Жишээг доорх хүснэгтээс харж болно.

Орчуулгазүй - IX

Англи нэр томьёо	Грек, латин нэр томьёо	Үгийн үндэс	Орчуулга
skin	dermatos (Greek) cutis (Latin)	dermat cutane	dermatitis - арьсны үрэвсэл cutaneous - арьсны
kidney	nephros (Greek) renes (Latin)	neph ren	nephroma- бөөрний хавдар renal- бөөрний
mouth	stomatos (Greek) oris (Latin)	stomat or	stomatitis- амны үрэвсэл oral амны

Анагаахын нэр томьёо нь үгийн язгуур (word root), угтвар (prefix), дагавар (suffix), жийргэлэсэн эгшиг (combining form) гэсэн 4 хэсгээс бүрддэг. Жишээ нь:

Угтвар	үгийн үндэс	дагавар	Анагаахын нэр томьёо	Орчуулга
	gastr	-cele	gastrocele	Ходоодны ивэрхий
	Arthr	-centesis	arthrocentesis	Үенд хатгалт хийх
Pseudo	appendix	-itis	Pseudoappendicitis	Мухар олгойн хуурамч үрэвсэл

Анагаахын нэр томьёо нь хэд хэдэн үгийн үндсээс бүтэж болно. Жишээлбэл:

Combining form жийргэлэсэн эгшиг	Үгийн үндэс	Дагавар	Анагаахын нэр томьёо	Орчуулга
oste/o	oste яс chondr мөгөөрс	-itis	osteochondritis	Яс мөгөөрсний үрэвсэл
	arthr үе	-itis	osteoarthritis	Үений ясны үрэвсэл

Аливаа суралцагч, орчуулагч нь анагаахын нэр томьёог үүсгэж буй угтвар, дагавруудыг мэдэж байвал тухайн үгийн утгыг олоход хялбар байдаг.

Анагаахын нэр томьёог бид доорх байдлаар ангилж болно:

1. Нэг үгнээс бүтсэн нэр томьёо: Ulcer
2. Хоёр үгнээс бүтсэн нэр томьёо: immunofluorescence method
3. Олон үгнээс бүтсэн нэр томьёо: saccular aneurysm of aorta

Нэр томьёог орчуулах зарчим, аргын талаар үе үеийн судлаачид анхаарал хандуулсаар ирсэн.

Анагаахын нэр томьёог орчуулахдаа гол төлөв доорх аргыг хэрэглэж ирсэн. Үүнд:

1. Дүйлгэх
2. Харь үг буюу нэр томьёог яг хэвээр нь авч хэрэглэх (зээлдэх)
3. Утгачилан орчуулах
4. Шинээр үг зохиох
5. Галигчлан буулгах

Судалгаа 1

Англи хэлнээс орчуулахдаа нэг нэр томьёог монгол хэлэнд олон нэр томьёогоор оноосон тохиолдол элбэг байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Жишээлбэл, -itis (үрэвсэл); -oma

(хавдар) дагавраар төгссөн нэр томъёо нь хамгийн энгийн, түгээмэл хэрэглэгддэг анагаахын нэр томъёонууд билээ. 4 өөр толь бичигт эдгээр дагавраар төгссөн үгийг хэрхэн буулгасныг доорхи хүснэгтээс харж болно.


- itis; - oma дагавраар үүссэн түгээмэл нэр томъёонууд	Ж. Раднаабазар (1997)	Ө.Цолмон С.Наранчимэг (2010)	М.Шагдарсүрэн (2010)	Б. Оргил (2017)
Adenitis	булчирхайтас, булчирхайн үрэвсэл	тунгалагийн зангилааны үрэвсэл		булчирхайлаг эдийн үрэвсэл
Arteritis	артерийн судастас	тараагуур судасны үрэвсэл, артерийн судасны үрэвсэл, артериит	тараагуур судасны үрэвсэл; тараагуур судастас; артерийн үрэвсэл,	артрит буюу тараагуур судасны үрэвсэл
Arthritis	идээт үетэс	үений үрэвсэл	үений үрэвсэл	артрит буюу үений үрэвсэл
Chondritis		мөгөөрсний үрэвсэл	мөгөөрсний үрэвсэл; мөгөөрстөс	Хондрит буюу мөгөөрсөн эдийн үрэвсэл
Cholangitis	цөсний хүүдийн үрэвсэл	цөсний сувгийн үрэвсэл; холангит	цөсний цоргоны үрэвсэл; цөсний сувгийн үрэвсэл;	холангиит буюу цөсний замын үрэвсэлт өвчин
Hepatitis	гепатит	Гепатит, хепатит, элэгний үрэвсэл	элэгний үрэвсэл, шар өвчин	хепатит буюу элэг үрэвсэх өвчин
Tonsillitis	1. бах 2. гүйлсэн булчирхайтас	гүйлсэн булчирхайн үрэвсэл; тонзиллит	ангина	тонзиллит буюу гүйлсэн булчирхайн үрэвсэл
Adenoma	булчирхайнгар	булчирхайн ур, булчирхайн хоргүй хавдар	булчирхайн хавдар, булчирхай(н)гар; булчирхайт ур, булчирхайнгар; булчирхайн бундуу	булчирхайлаг эдийн хоргүй хавдар
Chondroma	мөгөөрсөн хавдар	мөгөөрсний хоргүй хавдар, хондрома	мөгөөрсний хавдар; мөгөөрсөн ур	хондрома буюу мөгөөрсөн эдийн хоргүй хавдар

epatoma	элэгний бундуу	элэгний хоргүй хавдар, гепатом	элэгний хорт хавдар; элэгний бундуу; элэг (эн) гэр	хепатома буюу элэгний анхдагч өмөн
lymphoma	тунгалгангар, лимфом	тунгалгийн эсийн хавдар, лимфом	тунгалгийн зангилааны хорт хавдар	
Myoma	булчингийн хавдар	булчингийн хоргүй хавдар, миом	булчингар, умайн булчингийн хавдар	Миома буюу булчингийн эдийн хоргүй хавдар

Судалгаа 2


Анагаахын нэр томъёоны орчуулга, үгийн оноолтыг үнэлэхийн тулд АШУҮИС-ийн төв болон салбар сургуулийн Гадаад хэлний тэнхимийн багш нараас судалгаа авсан. Судалгаанд нийт 16 багш оролцов. Бидний асуулга 5 хариу бүхий сонгох 6 асуулт, түүнчлэн бичиж хариулах 2 асуулт нийт 8 асуултаас бүтсэн. Судалгаанд оролцсон багш нар нь анагаахын англи хэлний хичээлийг 1-15 жил зааж байгаа багш нар юм.

2. Анагаахын нэр томъёог орчуулахад хүндрэл гардаг уу?
16 responses




Диаграм 1. Анагаахын нэр томъёог орчуулахад хүндрэл гардаг эсэх.

Хэрэв хүндрэл гардаг бол хүндрэлийн зэргийг үнэлэнэ үү
16 responses




Диаграм2. Анагаахын нэр томъёог орчуулахад гардаг хүндрэлийн зэрэг.

5. Анагаахын нэр томъёоны толь бичгүүдэд нэг нэр томъёог өөр өөрөөр орчуулсантай хир олон таарч байсан бэ?
16 responses



Диаграм 3. Толь бичгүүдэд анагаахын нэр томъёоны оноолтыг өөр өөрөөр орчуулсантай таарч байсан тохиолдлын давтамж

6. Анагаахын нэр томьёоны орчуулгын оноолтыг сайжруулах хэрэгтэй гэж бодож байна уу?
16 responses



Диаграм 4. Анагаахын нэр томьёоны оноолтыг сайжруулах хэрэгтэй эсэх.

Судалгааны бичгээр өгсөн хариултын хэсгээс харахад анагаахын нэр томьёог орчуулахад гардаг гол хүндрэл нь нэг нэр томьёог монгол хэл дээр олон янзаар оноосон явдал. Бүлгийн ярилцлагын үед мэргэжлийн эмч нарт ч тус асуудал хүндрэл учруулдаг нь тодорхой болсон юм.

Анагаахын нэр томьёоны орчуулгын оноолтыг хэрхэн сайжруулах вэ гэсэн асуултад багш нарын ирүүлсэн хариултыг тоймлон дурдвал:

- Анагаахын нэр томьёоны монголчлох шаардлагагүй үгсийн жагсаалт гаргах
- Анагаахын нэр томьёоны журамласан толь гаргах
- Салбар дундын хамтын ажиллагааг үүний гарц гэж харж байна
- Хэлэлцүүлэг, сургалт, семинар зохион байгуулах
- Нэгдсэн нэр томьёоны хороотой болох
- Орчуулагч, хэл шинжлэлийн баг -эмч нар хамтран ажиллаж тогтсон нэр, томьёотой болох

Судалгааны үр дүн:

1. Анагаахын нэр томьёоны толь бичгүүд олноор гарч байгаа нь сайшаалтай хэдий ч нэг нэр томьёог олон янзаар оноох явдал маш түгээмэл байна. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг энгийн нэр томьёог ч өөр өөрөөр оноосон нь судалгааны явцад тодорхой болсон.
2. Анагаахын нэр томьёог орчуулахад хүндрэл учирсаар байна. Судалгаанд оролцогчдын 50% нилээд их хүндрэл гарч байна гэж үзсэн бол 31% нь бага зэрэг хүндрэл гардаг гэж үзжээ. Тус хүндрэлийн гол шалтгааныг судалгаанд оролцогчид анагаахын нэр томьёоны орчуулгын зөрүүтэй байдал гэжээ.
3. Анагаахын нэр томьёог толь бичгүүдэд өөр өөрөөр оноож хөрвүүлсэн тохиолдол олон байна. Судалгаанд оролцогчдын 37,5 % нь толь бичгүүдэд нэр томьёог өөр өөрөөр буулгасантай их таарч байсан бол 43,8% нь хааяа таарч байжээ.
4. Судалгаанд оролцогчдын 87,5 нь анагаахын нэр томьёоны орчуулгын оноолтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн

Дүгнэлт

Анагаахын нэр томьёог орчуулахад гардаг гол хүндрэл нь нэр томьёог толь бичгүүдэд олон янзаар нэрлэсэн явдал юм. Анагаахын нэр томьёоны орчуулгын оноолтыг боловсронгуй болгох шаардлагатай. Үүний тулд анагаахын нэр томьёоны үндэсний хороо байгуулан салбар бүрийн мэргэжилтнүүдийг татан оруулах нь асуудлыг шийдвэрлэх зөв алхам болно гэж үзэж байна.

Анагаахын нэр томьёо нь гол төлөв латин, грек үгийн үндсээс бүтдэг, дэлхийн олон улсад ижил нэршлээр нэрлэгддэг. Иймд оношлогоо, эмчилгээний ямар нэг алдаа, будилаанаас

сэргийлэхийн тулд зарим нэг орчуулахад хүндрэлтэй нэр томъёог англи эхээс нь шууд хуулбарлан хэрэглэж болох юм.

Ном зүй

Монгол хэлээр:

1. Мөнхцэцэг И.(2020) Нэр томъёоны орчуулга судлал. УБ. “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр.
2. Нямдаваа П. (2014) Анагаах ухааны монгол нэр томъёог төлөвшүүлэх асуудалд. Монгол нэр томъёо судлал – 90 олон улсын хурлын эмхэтгэл. УБ. “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр.
3. Оргил Б. (2017) Анагаахын нэр томъёоны латин- англи- орос- монгол товч тайлбарт толь.УБ. “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр.
4. Раднаабазар Ж. (1997) Анагаах ухааны англи-орос- монгол толь. УБ “Адмон принтинг” хэвлэлийн үйлдвэр.
5. Раднаабазар Ж. (2014) Монгол анагаах ухааны нэр томъёо, түүний хөгжил. Монгол нэр томъёо судлал – 90 олон улсын хурлын эмхэтгэл. УБ. “Соёмбо принтинг” хэвлэлийн үйлдвэр.
6. Цолмон Ө, Наранчимэг С. (2010) Анагаахын ба сувилахуйн ухааны англи-монгол-орос толь. УБ
7. Шагдарсүрэн М. (2010) Анагаах ухааны англи- монгол толь УБ “Адмон принтинг” хэвлэлийн үйлдвэр.

Англи хэлээр:

1. Jakobson R (1959) On linguistic aspects of translation
<https://web.stanford.edu/~eckert/PDF/jakobson.pdf>

Орос хэлээр:

1. Герд А.С. (1979) Проблемы становления и унификации научной терминологии. Вопросы языкознания. №1.
2. Рецкер Я.И. (2007) Теория перевода и переводческая практика. Москва Р.Валент http://lib.yu.am/open_books/311203.pdf
3. Солнцев, Е.М. (2010) Общие и частные проблемы перевода медицинских текстов. Вестник МГЛУ, №9 <https://docplayer.ru/72704306-Obshchie-i-chastnye-problemy-perevoda-medicinskih-tekstov.html>
4. Хайновская Т.С (2013) Особенности перевода медицинских текстов <https://elib.bsu.by/bitstream/123456789/102527/1/290-291.pdf>



ХУУЛБАРЛАН ОРЧУУЛСАН НЭР ТОМЬЁОНЫ УТГАЗҮЙН СУДАЛГААНЫ АСУУДАЛД

Д.Баярмаа⁶¹

Abstract: *It is assumed that the semantic of the terms should be consistent with the meaning it conveys. Semantic aspect of scientific terminology requires absence of ambiguity and synonymic rows, in other words, professional terms must be completely consistent with the meaning expressed in its form and unambiguous. To put it simply, there must be one word — one meaning. But multiple meanings in a scientific term should not be considered as non-existent, because professional term is not only one of many other terms of that particular field, but it is also a unit of language as a whole. If the same term is used in many different fields of science, it is not considered as a contradiction in terms. But it is not appropriate for one particular term of one field to have multiple different meanings. For example: isolation (isolation action, result), pressure (action, quantity).*

The meaning of a word is real, and phenomena and movements are considered in linguistics as a cult of concepts and language symbols. As the reality of the phenomenon, society, and people's consciousness changes, the meaning of the word changes. This change is not noticeable to us, it is gradual, and in some cases, it even has the opposite meaning to its original value.

The main objective of this report is to study native mongolian words that are widely used in forming new terminology by changing their word semantic, by adding suffixes to the root word and by forming compound terms. We truly hope that studying structure and meaning of calque translated terms will help in some ways to systemize professional terms, to do further research work and to use calqued terms in academic tools.

Түлхүүр үг: *холбоо мэдээллийн технологи, нэр томьёо, хуулбарласан орчуулга, утгазүйн судалгаа, нэрийн нийлэмж нэр томьёо, үйлийн нийлэмж нэр томьёо*

Хуулбарлан орчуулсан нэр томьёонд хэрэглэгдэж байгаа уугуул монгол хэлний үг:

Мэдээлэл холбооны салбарт хэрэглэгдэж байгаа нэр томьёоны дотор монгол хэлний уугуул үг тодорхой байр эзэлж байна. Тэдгээр монгол үг нь үгийн утгаас шилжүүлэн хэрэглэсэн, эсвэл урьд нь монгол хэлэнд байсан язгуур үндсэнд үг бүтээх дагавар залган шинэ үг үүсгэсэн, эсвэл монгол хэлэнд нийлмэл үг үүсгэдэг загварт тулгуурлан шинэ нэр томьёо бүтээсэн байна.

Уул салбарын хэмжээнд түгээмэл бөгөөд идэвхтэй хэрэглэгдэж байгаа монгол хэлний уугал үгсийн жишээг үзүүлбэл доорх маягтай байна.

Эсэргүүцэл: 1.эсэргүүцэх хүчин, чадал, 2. аливаа юмыг шууд эсэргүүцсэн илэрхийлэл, 3. аливаа зүйлийг үл зөвшөөрснийг мэдэгдэж гаргах мэдэгдэл. Антенны идэвхтэй эсэргүүцэл - сопротивление антенны активное, фото эсэргүүцэл-фоторезистор

Цахилгаан: 1.Үүлний давхаргад гялсхийн үзэгдэх гэрэл, 2.эрчим хүчний нэгэн зүйл, гэрэл гаргах, цахилгаан механик — электромеханика, цахилгаан статик — электростатический, цахилгаан станц- электростанция, зурагт цахилгаан мэдээний аппарат -аппарат фототелеграфный, фото цахилгаан- фотоэлектричество

⁶¹ ШУТИС, ГХС, Англи хэлний тэнхим, доктор

Орон: 1. Оршин суух газар, 2. Нутаг дэвсгэр: гипер орон зай- гиперпространство,

Чадал: 1. тамир тэнхээ, бял хүч, 2, эрдэм мэдлэг, ид чадвар, 3.хөрөнгө чинээ чадлын коэффициент "коэффициент мощности", антенны чадал -мощность в антенне

Соронзон: төмөр буюу болд зүйлийг биедээ татаж чадах төмрийн хүдэр буюу болд соронзон график- магнитная графика,

Эдгээрээс гадна **хүч, талбай, туйл, туршлага, хөдөлгөөн, унтраалга, гүйдэл, утас, хэлхээ, сүлжээ** гэх мэт үгийг нэрлэж болно.

Уул жишээ баримтаас үзвэл мэдээлэл холбооны салбарт хэрэглэгдэж байгаа монгол үг нь үгийн утгаас шилжүүлэн хэрэглэсэн, эсвэл урьд нь монгол хэлэнд байсан язгуур үндсэнд үг бүтээх дагавар залган шинэ үг үүсгэсэн, эсвэл монгол хэлэнд нийлмэл үг үүсгэдэг загварт тулгуурлан шинэ нэр томьёо бүтээсэн байна.

Нэрийн нийлэмж нэр томьёоны утга

Монгол хэлний нийлэмж нэр томьёоны хураангуй бүтэц нь 2 бүрдүүлэгчтэй буюу дагуул-цөм гэсэн загвартай байна.

Үгзүйн аргаар шинэ нэр томьёо бүтээх хамгийн түгээмэл загвар бол дагаврын арга юм. Нийлэмж нэр томьёог утгын хэлхээ болон гол утгыг харгалзан **нэрийн нийлэмж** нэр томьёоны утга, **үйлийн нийлэмж** нэр томьёоны утга гэж ангилж байна.

Нэрийн нийлэмж нэр томьёоны гол үг нь утгын мөн чанарыг, харин захирагдаж буй үг нь ялгаврыг үзүүлдэг. Нэрийн нийлэмж нэр томьёог дараах байдлаар ангилсан байна.

1.Хамаа харьяаны утгатай нэрийн нийлэмж

Хамаа харьяаны цөм утга нь тодотгогч, тодотгуулагчийн олон хийсвэр утга илэрхийлдэг. Хамаа харьяаны утга нь ерөнхийгөөс тодорхой руу чиглэсэн нарийн байрлалтай байдаг. Тодорхой хамааны утгаа ерөнхий харьяаны утгаар тодотгосон шинжтэй байна. Тухайлбал: дотоод сүлжээний бүтэц - бүтэц гэдгийг сүлжээний гэсэн тодорхой хамааны утгаар тодруулж, дотоод гэдэг үгээр сүлжээний бүтцийг тодотгон ерөнхий харьяаны утга үүсгэжээ. Хамаа харьяаны утгыг хагас хуулбарлан орчуулсан нэр томьёонд дараах байдлаар гаргасан байна. Үүнд:

1/ Жинхэнэ нэрийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбосон: энергийн үүсгүүр - энергодобыча, атомын хөдөлгүүр - атомный двигатель, программчлалын хэл- язык программирования, кодын үг- кодовое слово, Вирусын хамгаалалт - защита Вируса, Нууцлалын систем - криптосистема, Өгөгдлийн карт- карта данных, Дууны акустик - Звук Акустическая, Урсгалын диаграмм – блок - схема, Кабелийн нэвтрүүлэг - передачи кабеля, тооцооны программ- расчетная программа, дууны карт- звуковая карта, өгөгдлийн сан-база данных, телеграфийн аппарат- телеграфный аппарат, тестийн төв - тестовый центр, текстийн агуулга- текстовое содержание, Зөөврийн радио станц - Портативная радиостанция.

2/. Оноосон нэрийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбосон: Ийм загварын нэр томьёо шинжлэх ухаан практикт аль хэдийн нэвтэрч дэлхийн бүх улс оронд хэрэглэгдэж байна. Павловын сургаал -‘учение Павлова’, Канын урвал - ‘реакция Кана’, Варбургын аппарат - ‘аппарат Варбурга’, Гукын хууль - ‘закон Гука’, Курловын томьёо - ‘формула Курлова’, Вольфын бие - ‘Вольфово тело’, Гауссын солбицол- ‘координата Гаусса’, Пифагорын теорем - ‘теорема Пифагора’)

3/. Жинхэнэ нэрээс тэмдэг нэр бүтээх үүрэгтэй –**тай, -той,-тэй** нөхцлөөр үүссэн нийлмэл үгс: Монгол хэлний хамтрахын тийн ялгалд байгаа нэр үг нь “ямар нэгэн зүйлийг агуулсан”, “ямар нэгэн зүйлийг эзэмшиж байгаа” гэсэн утга илэрхийлдэг бөгөөд энэ нь тэмдэг нэрийн утгатай ижил байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа өөр нэг нэр үгийн өмнө орсон тохиолдолд энэ байдал улам тод харагддаг: хугацаатай программ- программа со сроком

Хэрвээ –тай, -той, -тэй нөхцөлтэй нэр үг нь өмнөө тодотгол авч байгаа бол өөрийн үгийн сангийн утгаа хадгалж байна гэж үзээд харин бусад тохиолдолд тэмдэг нэрийн бүлэгт

хамааруулж үзэх нь зүйтэй. Тухайлбал: хугацаатай программ – Энэ нийлмэл үгэнд орж байгаа – тай, нөхцөлтэй нэр үг нь өмнөө тодотгол авч болж байна. (Урт хугацаатай программ г.м.) Бидний энд жишээ авсан “хугацаатай программ” нийлмэл үгийн бүрэлдэхүүнд орсон –тай нөхцөлтэй үгийн өмнө хүч нэмэгдүүлсэн үг орж болохгүй байгаа нь /маш хугацаатай программ гэж хэлэх боломжгүй/ түүнийг өөрийн үгийн сангийн утгаа хадгалж байгааг харуулж байна.

Харин “Нууцлалтай компьютер” нийлмэл үгэнд орсон –тай, нөхцөлтэй үг нь юм зүйлийн шинж чанарыг заасан байгаа тул өмнөө тодотгол авахаас гадна хүч нэмэгдүүлсэн үгтэй ч мөн хэрэглэгдэж болж байна. (маш нууцлалтай компьютер г.м.)

Үүнээс харахад, хамтрахын тийн ялгалд байгаа нэр үг нь “ямар нэгэн зүйлийг агуулсан”, “ямар нэгэн зүйлийг эзэмшиж байгаа” гэсэн утгаа алдаж, байнгын шинж чанар заасан утга руу хялбархан шилжиж байгаа нь харагдаж байна. Энэ байдлаас улбаалж –тай (-той, -тэй) нөхцлийг тийн ялгалын үг хувилгах нөхцөл биш, харин шинэ үг буюу тэмдэг нэр бүтээх үүрэгтэй гэж үздэг.

Уг аргаар бүтсэн нийлмэл үг мэдээлэл холбооны салбарын үг хэллэгт цөөнгүй тохиолдож байна. Жишээ нь: Аюултай вирус, Баталгаатай программ, Найдвартай техник, Дуутай машин, Нууцлалтай компьютер,

4/. Жинхэнэ нэрээс тэмдэг нэр үүсгэх нөхцлөөр тэмдэг нэрийг нэр үгэнд захируулан холбосон найрсан хавсраа үг: Ийм загварын нийлмэл үг нь нэр томъёоны салбарт өргөн хэрэглэгддэг. Учир нь тэмдэг нэр юм зүйлийн шинж чанарыг бүрэн дүүрэн, тодорхой илэрхийлж чаддаг. Жинхэнэ нэрээс тэмдэг нэр бүтээдэг дараах нөхцөлүүд байна. 1. -т нөхцөл: Тэмдэг нэр, нэр үгээс үүссэн нийлмэл үгийн дотор бидний дээр дурдсан жинхэнэ нэрээс тэмдэг нэр бүтээх үүрэгтэй –тай, -той,-тэй нөхцөлийн хувилбар болох –т нөхцөлийн тусламжтайгаар үүссэн нийлмэл үг зонхилох байрыг эзэлж байна. Т.А. Бертагаев «тодорхой тохиолдлуудад эдгээр нөхцөлүүдийн хооронд утгын мэдэгдэхүйц ялгаатай байгаа нь харагдаж байна. - тай, -той,-тэй нөхцөл нь илэрхийлж байгаа үгийнхээ юм зүйлийг нэрлэсэн болон тодорхой шинж байдлыг заасан байхад, харин –т нөхцөл нь шинж чанар, хийсвэр ухагдахууныг заасан байна” гэжээ. Жишээ нь: Утгат график- идеографика, Дүрст телефон- видеотелефон, Товчлуурт телефон-клавишный телефон

2.Шинж чанарын утгатай нийлэмж нэр томъёо

Энэ утга нь чанар чансааны болон шинж чанарын утгатай байна. Хагас хуулбарлан орчуулсан нэр томъёонд шинж чанарын утгатай нийлэмж нэр томъёог дараах байдлаар гаргасан байна. Үүнд:

1.Тэмдэг нэрс жинхэнэ нэрд үндсээрээ захирагдан бүтсэн нийлмэл үг хэллэг: бичил схем-микросхема, хоёр катод-бикатод, хос конус - биконический, давхар дуплекс-бидуплексированы, давхар металл - биметаллический, хоёр фаз - двухфазный, хатуу диск - жесткий диск, дотоод систем – внутренняя система, олон протокол - многопротокольный, товч код - краткий код, цахилгаан механик – электромеханика, цахим оптик – электрооптический, цахилгаан статик – электростатический, гео төв - геоцентр, гипер орон зай - гиперпространство, соронзон график - магнитная графика, олон процессор - многопроцессорный, цахилгаан станц - электростанция, реактив эсэргүүцэл - реактивное сопротивление, цахим карт - интеллектуальная карточка.

2. Жинхэнэ нэр жинхэнэ нэртэй үндсээрээ хамжин холбогдож үүссэн нийлмэл үг хэллэг: рентген туяа, вэб дуу - webtone,

3. Хэлний бэлэн бүтээгдэхүүн хэрэглэх аргаар бүтсэн нийлмэл үг: Дэд - дэд цикл - подцикл, дэд программ - подпрограмма, эсрэг - эсрэг циклон - ‘антициклон’, эсрэг фаз - противофаза,

Хоорондын - модуляц хоорондын нөлөөлөл - интермодуляция, процедур хоорондын - межпроцедурный, процесс хоорондын - межпроцессный, тив хоорондын пуужин 'межконтинентальная ракета'. Энэ үг нь –х нөхцөлтэй тэмдэг нэртэй хамт хэрэглэгдэж байгаа нь ажиглагдаж байна: нейроны хоорондох холбоо - 'межнейронная связь',

бичил - бичил компьютер, бичил схем - микросхема,

хэмжүүр - фаз хэмжүүр-фазометр, гальвани хэмжүүр - 'гальванометр',

бус, гүй-цикл бус- ациклический, синхрон бус - асинхронный, резонансгүй - антирезонанс, арифметик бус - неарифметический,

автомат:- автомат тохируулга - 'авторегулировка', автомат тоног төхөөрөмж - 'автоматическое оборудование', автомат хариулагч- автоответчик, автомат тохируулга- автоматическая настройка, автомат цараа- диапазон автоматический,

радио:- радио нэвтрүүлэг - 'радиопередача', радио долгион - 'радиоволна', радио холбоо- радиосвязь,

электрон - электрон шуудан – электронная почта, э-зөөгч – е-носитель, электрон мөнгө – электронные деньги, электрон худалдаа – электронная коммерция, электрон олшруулагч- электронное ксерокопирование, э-мэйл – электронная почта, электрон гарын үсэг- электронная подпись, электрон сэтгүүл- электронный журнал,

фото-фото дамжуулалт- фотопроводник, фото гүйдэл- фототок, фото цэнэг алдалт- фоторазряд, фото цахилгаан - фотоэлектричество, фото эсэргүүцэл - фоторезистор, фото мэдрэгч - фотодатчик, **макро**-Макрохандалт - макроподход, макро тодорхойлолт-макроопределение, макро эдийн засгийн - макроэкономический, макро заавар -макроинструкция, макро хэл - макроязык, макро онол - макротеория,

мета-, **мега**-Мега цэг- мегапиксельная, метасан- метабаза, мета өгөгдөл- метаданные, мета өгөгдлийн сан- метаданных, мета мэдээлэл- метаинформация, мета хэл-метаязык, мета тогтвортой- метастабильный,

гипер- гипер орон зай- гиперпространство,

3.Цаг хугацааны утга:

Нийлэмж нэр томьёоны дагуул бүрдүүлэгч нь цаг хугацааны утга заана. Цагийн утгыг илэрхийлэх нийлэг хэрэглүүр нь сан, аа, маар, хуйц, даг болон задлаг хэрэглүүр болох эрт орой маргааш өнөөдөр зэрэг цагийн утгатай үгс болно. Өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн утгатай гэж ялган үздэг. Жишээ нь: ирээдүй цаг: холбох утас, өнгөрсөн цаг: хөрвүүлсэн код

Үйлт нэрийн дараах хэлбэрүүд хагас хуулбарлан орчуулсан нэр томьёонд цагийн утга гаргаж байна. Үүнд:

1/. Ирээдүй цагаар тодотгон холбох –**х** нөхцлөөр үйлт нэрийг нэр үгэнд захируулан холбож найрсан нийлмэл үг нэр томьёоны салбарт хамгийн өргөн хэрэглэгдэж байна. Энэ нь юм зүйлийн зорилго, зориулалтыг заадаг бөгөөд ихэвчлэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж гэх мэт техникийн нэр томьёонд ашиглагдаж байна. Жишээ нь: мөрдөх программ - программа отслеживание,

2/. Өнгөрсөн цагаар тодотгон холбох –**сан** нөхцөлөөр үйлт нэрийг нэр үгэнд захируулан холбож найрсан нийлмэл үг үйлийн төгссөн, дууссан шинж чанараар юм зүйлийг тодорхойлж байна. -сан нөхцөлтэй үйлт нэр нь нэр томьёонд хэрэглэгдэж байгаа тохиолдолд өнгөрсөн цагийн утгаа алдаж бүхэлдээ юм зүйлийн шинж чанар заасан утга илэрхийлж байна: дараалсан бит - последовательный бит, үргэлжилсэн функц - 'непрерывная функция', Шифрлэгдсэн текст - зашифрованный текст, Шифрлэсэн утсан холбоо- Зашифрованные телефоны, Кодлогдсон- Кодовый

4.Хэлбэр дүрсийн утга

Аливаа юм үзэгдлийн хэлбэр хэмжээ овор дүрийг заасан утгыг дараах байдлаар гаргасан байна: өндөр антен, **супер**- супер сүлжээ - суперсеть, **мини** - мини компьютер

5.Бүтсэн эдийн утга

Тодотгуулагч үгийнхээ бүтсэн материалыг заасан дараах жишээ байна: шилэн кабель

Үйлийн нийлэмж нэр томъёоны утга

Нийлэмж нэр томъёоны гол үг нь үйл үг байгаа жишээ цөөн боловч байна. Монгол хэлний үйл үг хүчтэй захирах чадвартай бөгөөд захирагдаж байгаа үг нь түүний нэмэлт утгыг илэрхийлдэг.

Үйлийн байцыг заасан нөхцөл үйл үгийн гүйцэтгэх үүрэг орчин цагийн монгол хэлний нэр томъёоны салбарт улам өргөжин тэлсээр байна. Гэхдээ нөхцөл үйлийн нийт 15 хэлбэрээс зөвхөн 2 хэлбэр нь л нэр томъёо үүсгэхэд идэвхитэй хэрэглэгдэж үйлийн шинж чанар, үйлийн дүр байдлыг заасан утга гаргаж байна.Үүнд:

1.Нөхцөл үйлийн –н нөхцөлөөр үйл үгэнд захируулан холбож найрсан нийлмэл үг: зохион бүтээх -‘конструирование’, гурвалжлан холбох -‘соединение треугольником’, хүлээн авах - ‘принимать; прием, приемная’, хянан шалгах - ‘контролировать’, харилцан үйлчлэх- взаимодействие, Харилцан холбох- межсоединение,

2. Нөхцөл үйлийн –ж нөхцөлөөр үйл үгэнд захируулан холбож найрсан нийлмэл үг: сэлгэж залгах -‘переклечение’

Дүгнэлт



Шинэ цагийн монгол нэр томъёоны үгийн санд хуулбарлан орчуулсан нэр томъёо нилээн томоохон байр суурийг эзэлж байгаа бөгөөд цаашдаа ч улам дэлгэрэх хандлага илэрхий ажиглагдаж байна. Үгзүйн аргаар шинэ нэр томъёо бүтээх хамгийн түгээмэл загвар бол дагаврын арга юм. Монгол хэл үг бүтээх дагавраар асар баялаг боловч нэр томъёо үүсгэхэд тэр бүр жигд хэрэглэгдэхгүй байгаа нь хэл шинжлэлийн болон бусад хүчин зүйлээс хамаарсан бодит шалтгаантай байна. Ялангуяа хагас хуулбарлан орчуулсан нэр томъёонд энэ байдал нилээд тод ажиглагдаж байна.

Мэдээлэл холбооны салбарын нэр томъёонд дараах монгол хэлний уугал үгс давтамжтай хэрэглэгдэж байна. Үүнд: эсэргүүцэл, цахилгаан, гүйдэл, орон, чадал, соронзон, товч, дуу, туяа, долгион, нэвтрүүлэг, зангилаа, хэл, үг, хамгаалалт, урсгалын, орц, утас, холбоо, шугам, хүрд, хэц, суваг, хүрээ, урсгал, дохио, удирдлага, дэд, эсрэг, бичил, худалдаа, бичлэг, сүлжээ, мэдээлэл, хүч, талбай, туйл, туршлага, хөдөлгөөн, унтраалга, хиймэл хэлхээ гэх мэт. Уул жишээ баримтаас үзвэл мэдээлэл холбооны салбарт хэрэглэгдэж байгаа монгол үг нь үгийн утгаас шилжүүлэн хэрэглэсэн, эсвэл урьд нь монгол хэлэнд байсан язгуур үндсэнд үг бүтээх дагавар залган шинэ үг үүсгэсэн, эсвэл монгол хэлэнд нийлмэл үг үүсгэдэг загварт тулгуурлан шинэ нэр томъёо бүтээсэн байна.



Эцэст нь дүгнэж хэлэхэд нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгох зорилт өнөөдөр ч гэсэн мэргэжлийн эрдэмтэд, хэл судлаачдын өмнө тулгамдсан хэвээр байна. Энэ асуудлыг шийдэн, бүх сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн болон бусад мэргэжлийн ном зохиолд жигд хэрэглэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Номзүй

1. Болд Л. (2003) *“Монгол хэлний зөв бичих зүйн толь”*
2. Буянхишиг З, Жавзансүрэн Ж, Эрдэнэтуяа Э. (2013) *“Дохио дамжуулах онол”*
3. Вандуй Э, Содном Б, Лувсанбалдан Х, Мижиддорж Го. (1979) *“Орос-Монгол нэр томъёоны толь” III боть.*
4. Гэрэлмаа Г. (2000) *“Нэр томъёо боловсруулахад хуучин үгийг ашиглах нь”*
5. Гэрэлмаа Г. (2011) *Мэдээлэл холбооны нэр томъёог оноосон туршилага, аргазүйн асуудалд- “Нэр томъёо судлал”, №12-13,*
6. Мөнхцэцэг Н. (2020) *“Нэр томъёоны орчуулга судлал”*
7. Өнөрбаян Ц. (2004) *“Орчин цагийн монгол хэлний үгзүй”*
8. *“Орос-Монгол толь”*(1982)
9. Сүхбаатар Б. (2007) *“Мэдээлэл холбооны технологийн англи-монгол толь”*
10. *“Радио, телевизийн салбарт мөрдөх үндэсний стандартын эмхэтгэл”*(2008)
11. Цэвэл Я. (1966) *“Монгол хэлний товч тайлбар толь”*



ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ





МОДОН БАР УУ? ТӨМӨР БАР УУ?

Г. Эрдэнэчимэг⁶²

요약

지난 20 여년 동안 몽골에서 한국문학작품 번역이 매우 활발하게 이루어졌지만, 번역에 대한 비평은 거의 찾아볼수 없습니다. 하지만 번역에 대한 심도 있는 비평이 이루어져야 번역의 수준이 향상될수 있습니다.

저는 이번에 한국의 문학번역원 지원으로 출간된 ‘한국학의 즐거움’의 몽골어 번역본을 읽어보았습니다. 번역본은 전반적으로 몽골어 번역이 매끄럽지 못해서 원저자의 의도를 제대로 살리지 못한 부분이 상당히 여러 군데 보였습니다. 번역이 매끄럽지 못하다는 것은 정확한 어휘 대역이 이루어지지 않았고, 번역문 몽골어의 문체가 일반 몽골인 독자들에게 생경하거나 부자연스럽다는 것입니다. 각 분야에서 왕성하게 활동중인 필자 22 명의 원고를 몽골어로 좀더정확하고 매끄럽게 번역했다면 몽골독자들이 ‘한국적인 것’을 좀더깊이 이해하는 계기가 되었을 것이라는 아쉬움이 남습니다.

Түлхүүр үг : соёл судлал, үг оноолт, хам сэдэв, хорголжин хэвлэл, модон бар, “Дөрвөн бичиг, таван ном”, садэбү, янбанъ

БНСУ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн Яамны харьяа Солонгос Судлалыг Дэмжих Албанаас Солонгос судлал (Korean Studies) гэдэг ухагдахууныг мэргэжлийн түвшинд тодорхойлох шаардлагатай гэж үзээд 2009 оны өвөл нэр хүндтэй эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн ажээ. Хэлэлцүүлгийн дүнд 2011 оны 8-р сард их сургуулийн профессор эрдэмтэн, гүн ухаантан, яруу найрагч, утга зохиолын шүүмжлэгч зэрэг Өмнөд Солонгосын 22 соён гэгээрүүлэгчийн бичсэн өгүүллийг эмхэтгэсэн “Солонгосыг судлахын цэнгэл (한국학의 즐거움)” хэмээх бүтээл уншигчдын гарт очжээ. Уг бүтээлийг БНСУ-ын их, дээд сургуулиудад ахисан түвшинд суралцаж, мэргэжлээрээ чамгүй олон жил ажилласан, их, дээд сургуулийн багш голцуу монгол судлаачид орчуулж, 2017 онд “Солонгос түмнийг тольдохуй” нэрээр хэвлэн монгол уншигчдын гарт хүргэв.

Аливаа бүтээлийг орчуулахад соёл судлалын үүднээс хандах, уг хэлний өнгөн бүтэц төдийгүй, түүний гүн чанадад орших соёлын утга агуулгыг нь бүрнээ нээж илтгэхийг чухалчилж буй⁶³ эдүгээ үед ийм бүтээл гарсанд ихэд олзуурхсан боловч уншиж үзээд урам хугарав. Тэгээд орчуулгын чанарын талаар хэдэн үг нэмэрлэх нь зүйтэй гэж бодлоо. Алив бичиг зохиолд уншууртай байх гэж нэг чухал чанар бий. Үг үсгийн алдаагүй, утга төгөлдөр, найруулга сайтай бүтээлийг унших нь автомашинаар зүйрлэвэл толь шиг замаар салхи сэнгэнүүлэн давхих мэт гацаж торохгүй хурдан байдаг. Уг номыг уншихад эхний хуудаснаасаа энхэл догол замаар элэг бөөрөө доргион сэгсчүүлэх мэт санагдсаныг нуух юун.

⁶² Ph.D, МУИС, ШУС, ХУС-ын Ази Судлалын тэнхим

⁶³ М. Чимэдцэе, “Улсыг засах, жараахай шарах хоёр адилхан. Харин амархан уу? Хэцүү юу?”, Орчуулгазүй, МУИС, Күнзийн Институт, 2014, №03

Гэхдээ 22 өгүүлэл бүгд ийм уншуургүй биш. Номд орсон солонгос зохиолчдын бүтээл хэзээ ч үнэ цэнээ алдахгүй. Ямар нэг бичиг зохиолыг хэдэн ч хүн, хэдэн ч удаа орчуулж болох тул эдгээр өгүүллийг монгол уншигчдад илүү сайн хүргэхээр авьяас чадвараа сорих боломж манай орчуулагч, судлаачдад байна.

Энэ удаад бид уг номын дөрөвдүгээр өгүүлэл болох Кан Мёнгуань профессорын “Солонгос ном – Жусон улсын үеийн хэвлэл, дангаар эзэгнэсэн мэдлэгийн үйлдвэрлэл” (орчуулсан Ч. Төмөрбаатар)-ийг авч үзье.

Өмнөд солонгосчууд өнөөгийн өндөр хөгжлийн нууцаа бичиг үсгийн соёлтойгоо, тэр дундаа эрт дээр цагаас уламжлан хөгжүүлж ирсэн хэвлэлийн хөгжилтэй холбон тайлбарлаж ихэд бахархдаг. Ялангуяа дэлхийд анх удаа, өөрөөр хэлбэл өрнийхнөөс даруй 200 жилээр түрүүлэн цутгамал үсэг хийж, хорголжин хэвлэлийн аргыг боловсруулсан гэж үзээд ихэд бахархдаг юм. Тийм учраас энэ өгүүлэл хамгийн их анхаарал татсан бөгөөд монгол уншигчдад хэрэгтэй, ач холбогдолтой өгүүлэл байв.

Гэвч эхнээсээ л ойлгомж муутай байлаа. Тэр тусмаа уг өгүүллийн амин сүнс, гол ухагдахуун болох хорголжин хэвлэл буюу цутгамал үсгийг төмөр бар (67-р нүүр), гуулин бар (68-р нүүр) гэж хоёр янзаар ташаа оноожээ. Хэвлэлийн хөгжлийн эхэн үед модон бараар ном бичиг хэвлэдэг байсан бөгөөд модон бар хийнэ гэдэг тун их ур ухаан шаарддаг, бэрх ажил. Эрт болоод дундад зууны үед хүмүүс төмрөөр бар хийгээгүй нь ямартай ч тодорхой. Ингэж хамгийн чухал, гол үгийг монголоор ташаа оноосноос бүхэлдээ ойлгомжгүй, утга учир нь олдохгүй зүйл болж хувирчээ.

Нэгэнт Солонгос ном хэвлэлийн түүхийн тухай өгүүлж байгаа учир өгүүлэлд хятад, солонгос ном судрын нэр олон гарна. Номын нэрийг орчуулахдаа уламжлалт орчуулгаар нь, уламжилж ирсэн зүйл үгүй бол боломжтойг орчуулаад, боломжгүйг нь “Оноосон нэрийг кирилл монгол бичгээр галиглах журам”-ын дагуу галиглан бичих учиртай. Түүнээс гадна газар усны нэр, хүний нэр гарах бөгөөд тэр бүгдийг хятад, солонгосоор нь ялгаж салгах учиртай. Харин орчуулагч “тэрэгний тэнхлэгт тэнцүүлэн цавчих мэтээр” бүгдийг нь орчин цагийн солонгос хэлний дуудлагаар галигласан нь уншигчдыг төөрөгдүүлнэ. “Дөрвөн бичиг, таван ном”-ыг “Сасө угён (73-р нүүр)” гэж галиглаж нэг тэмдэглэсэнээ “Дөрвөн ном, таван судар” (71-р нүүр), “Дөрвөн хөлгөн таван их судар” (75-р нүүр) гэж хэдэн янзаар оноосон нь уншигчийг будилуулмаар. “Бага суртахуй”-г “Сушаг ёс суртахууны бичиг” гэж оноосон нь орчуулгын уламжлалаа мэдэхгүйн илрэл гэлтэй.

Уг өгүүллийг уншиж ойлгох, монголоор орчуулахад Хятад, Солонгосын түүх, хэвлэлийн хөгжлийн түүх, хүнийн суртлын талаар гадарладаг байхыг орчуулагчаас шаардана. Тэр дундаа Солонгосын түүхийн мэдлэг хэрэгтэй бөгөөд 1990-ээд онтой харьцуулахад энэ талаар монгол хэлээр хэвлэн гаргасан ном зохиол бас ч цөөнгүй бий⁶⁴.

Энд олонтаа давтагдах *садэбү*, *янбань* гэдэг хоёр ухагдахууны тухай товч дурдъя. Энэ хоёр нь түүхэн хөгжлийн явцад хувирч өөрчлөгдөж ирсэн, тусдаа хоёр зүйл бөгөөд өгүүллийн утга учрыг ойлгох түлхүүр үг гэлтэй. *Садэбү* гэж хэн болохыг зохиогч бээр өгүүлэлдээ “Неоконфуцизмын үндсэн зарчмаар төр улс/нийгмийг сэхээтнүүд удирдах ёстой. “Бичиг уншвал са (士) хэмээмүй. Төрд зүтгэвэл тэбү (大夫) хэмээмүй” гэсэнчлэн *садэбү* нар нь үндсэндээ уншигчид байлаа. Эдгээр уншигчид “орогсдын шалгалт”-т тэнцсэнээр түшмэл болж, засаг захиргааны ажилд зүтгэнэ” хэмээн тодорхой тайлбарласан байна. Гэтэл орчуулагч *садэбү*-г *янбань*-тай хутгаж, нэг зүйл хэмээн ойлгосон нь бараг л догол мөр болгонд харагдана. *Садэбү*-г *янбан*, бичиг цэргийн ямбад, язгууртан ямбатан гэж гурван янзаар оноосон, мөн *янбань* гэдэг үгэнд олон тооны -д нөхцөл залгаж *янбад* гэж оноосон нь уншигчийг бүрэн төөрөгдүүлнэ. Ямар

⁶⁴ Г. Эрдэнэчимэг, Солонгосын түүх, Тэргүүн дэвтэр, 2006, Адмон; Солонгосын түүх, ОУУБИС, 2016

нэг зүүлт тайлбар хийгээгүй тул монгол уншигч үүнийг алдаатай бичсэн юм болов уу гэж эргэлзмээр. *Янбань* нь хоёр анги буюу бичиг, цэргийн түшмэд гэсэн утгатай үг бөгөөд түүхэн хөгжлийн үе бүрд утга нь бага зэрэг өөрчлөгдөн хувьсаж иржээ. Ялангуяа Чосөн-ий үед нийгмийн ноёлогч ангийг нэрлэх нэр болж хэвшин тогтсон ба Чосөн-ий вант улсыг *янбань* феодал улс гэж түүхчид томъёолдог.

Солонгосчууд улс төрийн тэргүүнээ эртнээс хаан бус ван гэж цоллож ирсэн бөгөөд дундад зууны Солонгос нь олон улсын Хятад төвт дэг журмыг хүлээн зөвшөөрсөн улс байлаа. Дэлхийн соёл иргэншлийн төв – Дундад улсын эзэн хэмээн өөрийгөө өргөмжилсөн Мингийн хуанди болоод түүнийг нь хүлээн зөвшөөрч, их улсад бага улс нь үйлчлэх ёстой гэж боддог Чосөн-ий ван хоёрын цол хэргэм нь зэрэг дэвийн хувьд ялгаатай. Харин орчуулагч үүнийг эс харгалзан хуандиг ч хаан (Мин улсын Ёнраг эзэн хаан, 74-р нүүр) ванг ч хаан (Жусон улсын Сэжун хаан, 71-р нүүр) гэж оноосон нь учир дутагдалтай. Цол хэргэмийн нэр нь солонгосчуудын, түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон ертөнцийг үзэх үзлийн тусгал, уламжлалт соёлын тод илэрхийлэл тул бага гэж үл тоох зүйл биш юм.

Монголоор оноох боломжтой нэрийг галигласан, тухайлбал, 68-р нүүрт Гугым Санжон Еэмүн, 71-р нүүрт “Гуса Чуалю”, “Сасо Угён”, “Гүмүн Жиньбу”, “Сузах”, “Хяняг Жибсонбан”, номын нэрийг ташаа оноосон, тухайлбал, 69-р нүүрэнд “Нэн шинэ цагийн судар” (近思錄), “Дөрвөн их судар” (四書集注) зэрэг нь орчуулгын чанарыг дордуулжээ.

Ерөөс хоёр хэлний толь барьж байгаад үгчилж орчуулна гэдэг бол орчуулгын доод шатны ажил юм. Ингэвэл эх бичвэрийн утга санааг бүрэн илэрхийлж чадахгүй. Тийм ч учраас манай нэртэй гүүш, дуун хөрвүүлэгч нар эртнээс үгчилж орчуулахыг шоолж, утга төгс байлгахыг чухалчилж ирсэн түүхтэй. Харин утга төгс орчуулахын тулд орчуулж буй зүйлийнхээ талаар мэддэг байх, мэдэхгүй бол уншиж судлаж, эрэл хайгуул хийх хэрэгтэй. Харамсалтай нь үүнд тун хойрго ханджээ.

71-р нүүрт, “Төрийн албан ёсны бичгийн хэл нь ханз үсэг байсан бөгөөд номууд ч мэдээж хэрэг ханз үсгээр бичигдсэн учраас өөриймсөг биш гадны гэгдэх бар нь “ханз үсгэн бар” байхаас өөр аргагүй юм”, 74-р нүүрт “Их судрууд Жусон улсын үеийг дуусах хүртэл Дөрвөн их хөлгөн судар болон Угён судрын тайлбар дангаар ноёрхож байсан төдийгүй цорын ганц сурах бичиг нь болжээ” гэснийг хэдэндээ давтаж уншаад утга учрыг нь ухаж эс дийлэв. Юуны өмнө “өөриймсөг биш гадны гэгдээд” байгаа зүйл нь модон бар уу, эсвэл ханз үсэг үү гэдэг нь тодорхойгүй. Эхийг няглахаар “Өөриймсөг биш гадны гэгдэх” гэдэг хэсгийг орчуулагч нэмсэн нь тодорхой байна. Их эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуай орчуулгад “үгийг нэмж хасах гайгүй хэрэг” гэсэн тул гайгүй хэрэг гэж үзье. Харин утгад айхавтар халдсныг гайтай хэрэг гэхээс өөр аргагүй. Солонгосчуудын хувьд модон бар хийгээд ханз бичиг үсэг бол өөриймсөг биш гадны зүйл огтоос биш ээ. Бидний үед уламжлан ирсэн дэлхийд хамгийн эртний модон барын хэвлэлийг БНСУ-ын Кйөнжү хотод байдаг Пүлкүг хийдийн Шагжамүни-гийн суваргыг засан сэргээх үед олжээ. Тэр нь 6 см өргөнтэй, 620 см урттай, буддын шашны тарни бичсэн хуйлмал бичиг юм. Уг суваргыг Нэгдсэн Шилла улсын үед буюу 751 онд барьсан тул ямартай ч 751 оноос өмнө солонгосчууд модон бараар шашны ном судар хэвлэж байжээ гэсэн үг юм.

Корйөгийн үед модон бараар ном хэвлэх явдал улам хөгжиж, улмаар Корйөгийн сүүл үед Монголын довтолгооноос улс орноо хамгаалах зорилгоор 1230-аас 1251 оны хооронд Бурхан багшийн сургаалыг барлах найман түмэн модон бар бүтээсэн түүхтэй. Тэрхүү наян мянган модон барын хүндийн жин нь 280 тонн, нэг модон бар 4 см өргөн тул давхарлаад өрвөл 3,200 метр өндөр болно. 16 жилийн туршид 500 гаруй хүн модон барыг сийлсэн атал яг л нэг хүний гараар сийлсэн мэт уран нарийн жигд сийлсний дээр ханз бичиг нь ямар ч алдаа мадаггүй байгаа нь үнэхээр

гайхалтай.⁶⁵ Эдгээрийг дэлхийн соёлын өвд солонгос үндэстний оруулсан гайхамшигт хувь нэмэр хэмээн бахархдаг.

Ханз бичгийн хувьд мөн адил. Орчин цагийн солонгосчууд ханз бичгийг эрхэмлэн дээдлэх уламжлалаа гээгээгүй хэвээр бөгөөд ханз бичгийг дан хятад үндэстний төдийгүй нийт Зүүн Азийн улс орнуудын уламжлалт соёлын нандин өв гэж үздэг. Орчин цагийн солонгос хэлний үгийн сангийн далаас илүү хувийг ханз үг эзлэх бөгөөд ханзны мэдлэггүй бол солонгос хэлээр мэргэжиж мэргэших тухай санах ч хэрэггүй. Өгүүлэн буй Чосөнх улсын үед ханз бичиг нь эрх мэдэл, эрдэм мэдлэг, соёл иргэншлийн бэлгэ тэмдэг байлаа. 15-р зууны дундуур зохиосон авианы үсгийг күнзийн сурталтай бичгийн түшмэд “эм бичиг” гэж нэрлээд эмс охид хэрэглэвэл таарна хэмээн ад үздэг байв. Тэгэхээр ханз бичиг бол солонгос үндэстний хувьд харь, гадны зүйл бус харин ч эсрэгээрээ үндэсний соёлынх нь “өөриймсөг” зүйл юм.

Мөн 79-р нүүрт, *Муньчэ Баньжонг* гэдэг нь “ханз үсгийн бүтцийг эртний бичгээр эргүүлэн хэвэнд нь оруулах гэсэн үзэл” гэж утга бүрхэг, ташаа тайлбар зүүжээ. Гэтэл эх бичвэрт “Бээжингээс ном оруулахыг зогсоон, түшмэдийнхээ ном болон уран бүтээлийг хянан шалгаж тэрс үзэлтнийг хөөх зайлуулах”-ыг *муньчэ банжонг* гэдэг гэж тодорхой тайлбарласан байна. Энэ бол тухайн цаг үедээ өргөн дэлгэрч эхэлсэн шинэ хэв найруулгаар уран зохиол бичихийг хатуу хориглож, хэдэн мянган жилийн тэртээх эртний хэв найруулга баримтлахыг шаардсан Чөнжо вангийн бодлого юм. Чөнжо нь 18-р зууны сүүлээр улс төрийн шинэчлэлт хийхийг оролдсон ван бөгөөд түүний “Зөв өгүүлбэрээс зөв засаглал төрнө” гэдэг үг алдартай. Гэвч Чосөнх-ий бусад вангийн адилаар хийх гэж зорьсон шинэчлэлтдээ өөрөө ч тууштай байж чадаагүйн илрэл нь уг бодлого юм. Үзэл бодлоороо талцаж хуваагдсан күнзийн сурталт түшмэдийн тэмцэл өрнөх үед Чөнжо ван өөрийн талынхныг дэмжихээр энэ бодлогыг хэрэгжүүлсэн гэж судлаачид үздэг.⁶⁶ Тэгэхлээр “үсгийн бүтцэд” халдах тухай огтоос яриагүй гэдэг нь тодорхой байна.

Энэ мэтчилэн учир утга нь ойлгомжгүй, эсвэл ташаа тайлбарласан зүүлт, үүнд, “Дөрвөн их номыг ишлэлээ болгосон Хятадын ном (69-р нүүр)”, “Жүжагийн сургаалыг шүүмжлэн гарч ирсэн Жүжа судлалын ухаан (79-р нүүр)” зэрэг нь утгыг тодруулах бус харин баллаж орхижээ.

Эцэст нь дүгнэхэд

Орчуулгын ажлын үе шатыг орчуулга хийх гэж буй хүн сайтар мэдэх шаардлагатай. Чимхлүүр, нягт нямбай ажиллагаа шаарддаг энэ ажлын тодорхой үе шатыг гүйцэтгэлгүй, бэх нь хатаагүй шахам анхны нооргоо хэвлэлийн газар руу барьж гүйдэг⁶⁷ байж болохгүй. Солонгос хэлнээс орчуулахад солонгос бичгийн хэлний мэдлэг, Солонгосын соёл, түүхийн мэдлэг, монгол хэлээрээ найруулан бичих чадвар, үгийн баялаг сайтай байх нь тун чухал. Үг ташаа оноосон зүйл цөөнгүй тул нэг бүрчлэн тоочсонгүй. Нэг үгийг хэдэн янзаар оноох нь уншигчийг төөрүүлж орхино.

Оноосон нэрийг монгол кирилл үсгээр галиглахдаа ямар галигийн журам ашигласан нь тодорхойгүй. Солонгос хэлний оноосон нэрийг монгол хэлээр галиглах журам байдаг ч улсын хэмжээнд нэг мөр мөрдөхөөр батлаагүй тул түр орхив.

Орчуулагч хүн бол орон судлаач байх хэрэгтэй. Орчуулах гэж буй зүйлийнхээ талаар мэдлэг хомс, утга учрыг нь олоогүй бол яаран орчуулах гэж оролдох хэрэггүй. Эхлээд холбогдолтой ном, материалыг олж уншиж судлах нь нэн чухал. Орчуулагч хүн бүгдийг мэдэх албагүй. Харин байнга эрж хайж, сурч судлах шаардлагатай. Толь бичгээс өөр “багаж зэвсэг”-

⁶⁵ 이제정 글, 문화재 이름도 모르면서, 나는 책, 2015, 48 쪽.

⁶⁶ 김용심, ‘문체반정, 나는 이렇게 본다’, 보리 2012

⁶⁷ (Р. Гүрбазар, Орчуулгын онол дадлагын үндэс, 7-9 тал)

гүй ахмад үеийн орчуулагч нартай харьцуулахад интернэтийн эриний залууст эрэл хайгуул хийх нь хялбар ажил болсныг сануулах юун.

Орчуулгыг ариутган шүүх үүргээ редактор гүйцэтгэсэнгүй. Номын редактор хийх хариуцлагатай үүргийг хүлээж авсан бол нэрээ тавиад орхих бус, мэдлэг, ерөнхий боловсролоо зузаатгасны үндсэн дээр⁶⁸ ажил үүргээ үнэнчээр гүйцэтгэж, цэвэр сайхан монгол хэлээ эвдэхгүйн төлөө хичээж чармайх хэрэгтэй.

Сүүлийн хорь гаруй жилд солонгос хэлтэй орчуулагч, судлаач олширч, Солонгосын уран зохиолын 400 гаруй бүтээлийг монгол хэлээр орчуулсан ч орчуулгын шүүмж бараг гарсангүй. Цаашид чанар чансааг нь сайжруулах шаардлагатай тул солонгос-монгол орчуулгын үйлсэд санаа аваасай хэмээн хэдэн үг нэмэрлэв.

Ном зүй

Монгол хэлээр:

1. Гүрбазар Р (1996), Орчуулгын онол дадлагын үндэс, ШУА, ХЗХ, УБ
2. Орчуулгазүй, МУИС, Күнзийн Институт, №1-6
3. Оюунзаяа Н.(2014), Монгол орчуулгын онолын уламжлал, “Орчуулга зүй” МУИС, ШУС-ийн ЭШБ, №03
4. Солонгос түмнийг тольдохуй, 2017, УБ, Соёмбо принтинг
5. Чимэдцэеэ М(2014), “Улсыг засах, жараахай шарах хоёр адилхан. Харин амархан уу? Хэцүү юу?”, Орчуулгазүй, МУИС, Күнзийн Институт, №03
6. Г. Эрдэнэчимэг, Солонгосын түүх, Тэргүүн дэвтэр, 2006, Адмон
7. Йё Бйөн мү, Солонгосын түүх, ОУУБИС, 2016
8. Д.Ундрах бусад, Дэлхийн соёл иргэншил, МУИС, Пресс хэвлэлийн газар, 2020

Солонгос хэлээр:

1. 김용심, ‘문체반정, 나는 이렇게 본다’, 보리 2012
2. 주영하 외 지음, 한국학의 즐거움, Humanist, 2011
3. 이계정 글, 문화재 이름도 모르면서, 나는 책, 2015,

Цахим сүлжээнээс:

1. Б. Ринчен, Марк Твений минь махыг идэж дээ.
<http://mongoliantranslation.blogspot.com/2010/05/1958.html>)
2. <https://news.join.com/article/2657833>

⁶⁸ Б. Ринчен, <http://mongoliantranslation.blogspot.com/2010/05/1958.html>)



“ТУНГАЛАГ ТАМИР” РОМАНЫ ХЯТАД ОРЧУУЛГЫН АЛДААНД ХИЙСЭН СУДАЛГАА

Б.Нэргүйжаргал⁶⁹, Gegan Zhula⁷⁰

ТҮЛЭР

Монгол-хангай хэлний судалгаа нь монгол хэлний судалгаа болон хангай хэлний судалгаа хоёрын хооронд оршдог. Монгол хэлний судалгаа нь монгол хэлний судалгаа болон хангай хэлний судалгаа хоёрын хооронд оршдог. Монгол хэлний судалгаа нь монгол хэлний судалгаа болон хангай хэлний судалгаа хоёрын хооронд оршдог. Монгол хэлний судалгаа нь монгол хэлний судалгаа болон хангай хэлний судалгаа хоёрын хооронд оршдог.

Түлхүүр үг: “Тунгалаг тамир” роман, орчуулгын харьцуулсан судалгаа, орчуулга

Удиртгал

Орчуулга гэдэг нь урт удаан түүхийн явцад нэг хэлнээс нөгөө хэл рүү хөрвүүлэн бүтээх хүний бүтээлч үйл ажиллагаа юм. Хүмүүс төрөл бүрийн хэлээр харилцаж эхэлснээс хойш орчуулга буй болсон гэж үздэг. Орчин үеийн дэлхийн даяаршлаас үүдэн орчуулгын практик ч мөн хөгжиж байна. Олон төрлийн орчуулгын бүтээлүүд ар араасаа тасралтгүй цувран гарч хүн төрөлхтний хөгжилд онцгой хувь нэмэр оруулж байна. Орчуулга нь нэг хэлээр илэрхийлсэн үзэл суртлын агуулга бүхий урлагийн хэв маягийг нөгөө хэл рүү зөв оновчтой хөрвүүлэн буулгах бүтээлч үйл ажиллагаа юм.

Хэл шинжлэл, утга зохиолын үүднээс авч үзэхэд орчуулга нь ямар ч улс ямар ч үндэстний хооронд утга зохиолын харилцааны гүүр болж өгдөг. Энэ гүүрийн хоёр үзүүр нь хоёр өөр хэл, хоёр ондоо соёлыг холбож байдаг. Энэ гүүргүйгээр хүмүүс бие биеэ ойлгож харилцаж чадахгүйгээр барахгүй өөр хоорондын соёлын болон техник, технологийн гайхамшгийг түгээж, сурталчилж чадахгүй болно. Орчуулга байхгүйгээр өнөөгийн ертөнц мөн өнөөгийн амьдрал ч байхгүй болно гэж хэлж болно.

Орчуулгын талаар нэрт зохиолчид, судлаач шүүмжлэгчдийн хэлсэн үгнээс эш татвал А.С.Пушкин: «Орчуулагч нь “гэгээрлийн хөтөч” юм», Гёте: «Орчуулга нь дэлхий дахины хамгийн чухал, нэр төртэй үйл хэргийн нэг бөгөөд цаашид ч хэвээр байх болно», М.Горький: «уран зохиолын орчуулга нь ард түмнүүдийн хооронд нь хурдан сайн танилцуулдаг»⁷¹ гэсэн байдаг.

Уран зохиолын орчуулга гэдэг нь орчуулгын нэг төрөл зүйл бөгөөд орчуулгын болон уран

⁶⁹ Ph.D, МУИС, ШУС, ХУС-ийн Ази судлалын тэнхим

⁷⁰ МУИС, ШУС, ХУС-ийн “Гадаад хэлний орчуулга”-хөтөлбөрийн магистрант

⁷¹ Орчуулах эрдэм II “ЭШХ” илтгэл, өгүүллийн эмхэтгэл Улаанбаатар, 2010, 16-р тал

зохиолын онцлог шинжийг бүхнийг багтаадаг. Орчуулга нь үнэн зөв, бүрэн төгс, яруу тод, оновчтой байдлыг чухалчилна. Өөрөөр хэлбэл, аль болох эх зохиолтой ойртохыг шаарддаг. Уран зохиол нь харин хэлний уян хатан, уянгалаг яруу үг хэллэгийг шаарддаг бөгөөд уншигчдад гоо сайхныг мэдрүүлэхийн тулд янз бүрийн найруулгын аргуудыг зөв зохистой харьцаанд ашигладаг. Гэхдээ хоёр хэл хоорондын соёлын ялгаатайгаас байдлаас үүдэн хэлний хэлзүйн бүтэц болон гоо зүйн сэтгэлгээний онцлогоор бас ялгардаг. Энэ нь утга зохиолын бүтээлийг орчуулахад хүндрэл учруулдаг. Уран зохиолын орчуулгын бүтээл нь бидэнд бусад өөр үндэстэний зан заншил, соёлыг ойлгон судлахад орлуулшгүй ач холбогдолтой. Мөн үүнээс гадна уран зохиолын бүтээлийг орчуулан дэлхийн өнцөг булан бүрт түгээн дэлгэрүүлэн хүмүүсийн сэтгэхүй болон сэтгэлгээнд нөлөөлж, соёл дамнан амьдрах боломжийг олгон дэлхийн аль ч үндэс угсаатны сэтгэлзүйн ялгаатай орон зайг багасгаж болох олон талын ач холбогдолтой.

Монголын их зохиолч Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” роман нь монголын орчин үеийн уран зохиолын түүхэн дэх алдартай бүтээлүүдийн нэг юм. Эл зохиол нь ХХ зууны эхэн үеийн монгол орны түүхэн ахуй байдал ба гол баатрын хайр дурлал, өшөө хорслыг Тамирын голд зураглан буулгасан бүтээл юм. Малаа хариулж, махаа идэх монгол хүний аж амьдрал айраг архиа дээдэлж, зочид гийчдээ хүндэлдэг монгол хүний зочломтгой зан, хэт цахиураа агсан, монгол эр хүний сүр жавхаа, шүр сувдаа зүүж гоёж чимэх, сааль саваа эргэцүүлдэг монгол бүсгүйн гоёмсог дүрүүд нь монгол үндэстний дүр төрх, аж амьдралын онцлог билээ. Тус роман зохиолын баатруудаа орчин тойрны дүрүүдээр дүрслэн амилуулжээ. Энэ бүтээл нь монгол хэл, уран зохиол, үндэсний түүхийн судалгааны чухал ач холбогдолтой юм.

1984 онд Өвөр монголын ардын хэвлэлийн хороо “Тунгалаг Тамир”-ын дэд дэвтрийн хятад орчуулгыг анх хэвлэн түгээсэн байна. Тэр нь одоо хүртэл цорын ганц хятад орчуулгын дэвтэр болох юм. Орчуулагч Вэнь Жунхө энэ орчуулгын бүтээлдээ түүний хүчин чармайлтаа хэрхэн зарцуулсныг эх зохиолын гүн гүнзгий утга санааг хэрхэн шударга үнэнээр нь амилуулан орчуулсныг бид харж болно. Гэхдээ зохиолын орчуулгыг унших явцад, ялангуяа эхний бүлэгт хүн, газар усны нэрийг дураараа орчуулах, үгийн утгыг буруу ойлгож орчуулах, өгүүлбэрийг махчлан орчуулах, зүйр цэцэн үгийг буруу хэрэглэх зэрэг зуу орчим алдаа байх юм.

Кирилл монгол дэвтрийн 41-р талд “Булган уулын оройгоор гарч ирсэн...” гэдгийн “Булган” нь Архангайд байдаг уулын нэр, дуудлагаар нь “布拉干”, эсвэл, “布拉根” гэвэл зүйтэй. Гэхдээ орчуулагч үүнийг “宝格达” (богд хан уул) гэж хоёр уулын нэрийг буруу орчуулан уншигчдад буруу ташаа ойлголт өгсөн.

Үг нь өгүүлбэр бүрдүүлдэг үндсэн нэгж билээ. Үг бүрийн утгыг зөв ойлгох нь тухайн бүтээлийг зөв орчуулах үндэс болдог. Энэ нь орчуулагчийн хэлний талаар сайн мэдлэгтэй байх ёстой бөгөөд орчуулж буй гадаад хэлнийхээ утга учрыг бүрэн ойлгохыг шаарддаг. “Тунгалаг тамир” романы хятад орчуулга нь үгийн утгыг буруу ойлгосноос үүдэн орчуулгын олон алдааг гаргасан байна. Жишээлбэл: кирилл монгол дэвтрийн 12-р талд: “Удалгүй гурван цагаачин гүн нойрондоо цохигдон унтжээ” Үүний орчуулга нь “没过多久,这三颗纯真善良的心儿,便沉沉地进入了梦乡” [8] буюу “Удалгүй гурван цэвэр сайхан сэтгэлтэй хүн гүн нойрондоо оров” гэсэн утгаар буруу орчуулав. “Цагаачин ” гэдэг нь “тэнүүчлэгч, цагаач” гэсэн утгатай. Үүнийг “цэвэр, сайхан сэтгэл” болгон орчуулах нь зохисгүй юм. Буруу орчуулгын учир орчуулагч өөр нэг “цагаан” гэдэг үгтэй андуурсан нь дамжиггүй. “Цагаан” гэх үгийн үндсэн утга нь “цагаан өнгө”, дэлгэрэнгүй утга нь “сайхан сэтгэл”, энэ нь “цагаачин” гэсэн үгийн үндсэн цагаантай тун төстэй боловч үгийн утгын хувьд огт өөр асуудал юм.

Бас нэгэн жишээ дурдвал кирилл монгол дэвтрийн 19-р талд: “Өлзий гуай сайн сууж байгаарай. Би эргэж байна” үүнийг “乌力吉老人, 您不必怕,我气糊涂了!” [38] “Өлзий гуай, айх хэрэггүй, би уурандаа эргүүтсэн байна” гэж утгыг буруу орчуулан гаргасан байна. Уг нь тус

зохиолд энэ үг нь Цахиур Төмөр нь Пүрэв тайжийг сүрдүүлж, Өлзий өвгөнийг тайвшруулахаар хэлсэн юм. Зохиолын урд хойтох өгүүлбэрийн утгатай нь холбовол “сайн сууж байгаарай” гэдгийг “请放心” буюу “Та сэтгэл тайван сууж байгаарай” гэж орчуулбал зохино. “Эргэж байна” гэдэг нь орчуулагч “толгой эргэж ухаан бодол самуурах” гэсэн утгаар орчуулсан байна. Уг нь зохиолыг үндэслэвэл “我会再来的” “Би буцаж ирнээ, эргэж уулзъя” гэж орчуулах нь зүйтэй юм.

Кирилл монгол дэвтрийн 28-р талд: “Чийгтэй сэрүүн салхи үлээн өндөр улиасны навч үл мэдэг шажигнан байв” гэдгийг “潮湿的风吹拂着, 高高的芦苇的叶子仿佛在表示“不晓得”似的, 连连地摇晃着” [58] (Чийглэг салхи үлээж, өндөр зэгсний навч “мэдэхгүй” гэж байгаа юм шиг найгаж байв) гэж орчуулжээ. Энд “улиас” модыг “зэгс”-ээр орчуулсан бөгөөд “үл мэдэг” гэснийг “мэдэхгүй” гэж орчуулсан байна. “Үл мэдэг” нь зөөлөн намуухан утгатай. Орчуулагч “үл мэдэг”-тэй андуурсан бололтой. “高高的白杨树叶随凉风轻轻摇曳, 沙沙作响” (Өндөр улиасны навчис сэрүүн салхинд шажигнан зөөлөн найгана) гэж орчуулвал зөв болох юм. Эдгээр алдаанууд нь орчуулагч орчуулгын явцад хянамгай хандсангүйг харуулж байна

Уран зохиолын орчуулга хийхэд заавал уг зохиолын баатруудын орших орчин тойрон, нийгмийн байдал, гадаад, дотоод сэтгэлийн хөдөлгөөнийг бүхнийг сайтар нарийвчлан ойлгох хэрэгтэй. Кирилл монгол дэвтрийн 4-р талд “.... хир хөлсөнд нэвтэрч урагдсан дээлээ есөн өнгийн юмаар нөхсөн” гэж Эрдэнийн өмссөн хувцас, түүний байр байдлыг дүрслэн үзүүлсэн хэсгийг орчуулахдаа “补着五颜六色的补丁” [3] (олон өнгө солонгорсон нөхөөс) гэсэн байна. Энэ хэлц үгийн утга нь таашаал үг, гоёмсог сайхан гэсэн утгыг илэрхийлдэг. Эрдэнэ бол далан нөхөөстэй дээлтэй ядуу харц, түүнийг олон өнгө солонгорсон нөхөөстэй сайхан дээлтэй гэж орчуулах нь ойлгомжгүй, “千补百纳” (мянган нөхөөс түмэн зүйдэл) гэвэл зохино.

Монгол хэлнээ уран зохиолд янз бүрийн хэлц үгийг өргөн хэрэглэдэг. Эдгээр үг хэллэг, өгүүлбэрийн хувьд зүгээр л дан ганц утгыг чухалчлан орчуулж болохгүй. Харин жинхэнэ утгыг ойлгосны дараа орчуулгын зохих аргыг сонгох хэрэгтэй. Жишээлбэл: кирилл монгол дэвтрийн 7-р талд: “Одоо яадаг билээ, хүний газар гүний нутагт гахай явган хаачих билээ?” хэмээн Долгор уйлахад нулимс хацрыг нь даган урсав”. Орчуулагч үүнийг орчуулахдаа “这可怎么办啊? 背井离乡,在人家洛公旗境内像猪一样步行,可向哪儿走啊?” [9]. Энэ өгүүлбэрийн “хүний газар гүний нутаг” нь зүйр цэцэн үг юм. Энэ нь “өөр газар гэрээсээ холдох”-той дүйцэх бөгөөд үүнийг тусад нь ойлгох боломжгүй. Үүнийг орчуулагч ойлгосон байх “гүний нутаг”-ийг тусад нь дурдсан бөгөөд “洛公旗境内” гэж орчуулсан байна. “Гахай явган” үсэгчилбэл “猪走”. Харин монголд гахай яаж явдгийг хүмүүс нэг их анзаардаггүйн адил хятадаар “拍马屁” энэ үгийн жинхэнэ утга нь “морны хондлойг ташуурдах”-тай ямар ч холбоогүй юм. Тиймээс иймэрхүү хэлц үгсийг орчуулахдаа шууд утгаар орчуулах нь хүний наргиа болох нь дамжиггүй юм. “Гахай явган” нь монгол сэтгэлгээнд явах унаа хөсөггүй болох, явган явахаас өөр аргагүйд хүрч байгаадаа санаа зовж байгаа байдлыг илэрхийлж байна. Зохиолчийн энэ өгүүлбэрийн талаарх шинэчилсэн дүгнэлт нь “这可怎么办啊? 这里人生地不熟的, 又失去了代步的马儿,咱们可向哪儿走啊?” (Одоо яадаг билээ, таних мэдэхгүй газар унаа хөсгөө алдаад хаачих билээ?) гэж орчуулах нь зүйтэй.

Монгол, хятад хэлний бүтэц, тогтолцооны хувьд харилцан адилгүй бөгөөд хятад хэлний үг, үгсийн дэс дарааллын байрлал солигдвол өгүүлбэрийн утга нь огт өөр утгатай болдог. Монгол хэлний өгүүлбэрийн гишүүдийн дараалал чөлөөтэй сэлгэж, байрлал солиход утга хувирахгүй. Иймээс монгол, хятад хэлний бичгийн хэлний хэм хэмжээ, найруулгын тал дээр утгыг хэрхэн яаж илэрхийлэн гаргахад анхаарал хандуулан үгийн утгыг үхмэлээр орчуулж болохгүй юм. Жишээ нь, 110-р талд “Энэ үед зүүн талын майхнаас хоол хийж байсан Галсан гарч ирэхэд, орос утган

очи́ж гарыг нь атган.....”, Харгалзах орчуулга нь “这时,从左边的帐篷里走出来做饭的嘎拉桑,那个俄国人迎上前去,握住了他的手” [84]. “从左边的帐篷里走出来做饭的嘎拉桑” (Зүүн талын майхнаас гарч ирсэн хоол хийж байгаа Галсан) Энэ хэлбэрийн илэрхийлэл нь хятад хэлээр илэрхийлэхэд зөрчилтэй байна. Хэрэв үгийн дарааллыг жаахан сэлгэн авч үзвэл “忙着做饭的嘎拉桑从左边的帐篷里走了出来” (хоол хийж байгаа Галсан зүүн талын майхнаас гарч ирэв) гэж соливол хятад хэлнээ нийцэн орчуулгын хэл хэллэг илүү урсам ойлгомжтой, уян яруу утгатай болох юм. Уран зохиолын орчуулгын эх зохиолыг зөв оновчтой, уянгалаг ойлгомжтойгоор илэрхийлэхийг урьтал болгохоос гадна орчуулах хэлний үг хэллэгийн утгазүй талаас хэрхэн нийцэж байгааг бас анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт

Орчуулагч тухайн орчуулгаараа хятад уншигчдад Монголын өвөрмөц зан заншил, соёлын онцлог болон тухайн орчуулгын хэл хэллэг уянгалаг уян яруу ойлгомжтой байх, ялангуяа үгийн утгын орчуулга найруулгын тал дээр эндүү ташаа ойлгон орчуулснаас нэлээд орчуулгын алдааг гаргасан байна. “Тунгалаг Тамир” гэх энэхүү алдартай роман нь Хятад орны уншигчдын дунд өргөнөөр түгэн дэлгэрч олны хүртээл болж уншигчдад хараахан бүрэн төгс хүрч чадаагүй нь харамсалтай хэдий ч энэхүү орчуулга нь хятад хэлнээ орчуулсан анхны орчуулгын хувилбар бөгөөд бидний орчуулгын судалгааны гол судлагдахуун болж байна.

Номзүй

1. Д.Дашдаваа. Орчуулгын зарим асуудал УБ.1977
2. Д.Дашдаваа. Уран зохиолын орчуулгын тухай УБ.1988
3. Ч.Жаргалсайхан. Д.Нацагдоржийн зохиол бүтээл орос хэл дээр УБ.20
4. Ч.Лодойдамба. “Тунгалаг тамир” УБ. 2005
5. Ч. Лодойдамба. “Тунгалаг тамир” Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.1971
6. 温中和译. “清澈的塔米尔河”.内蒙古人民出版社.1985
7. Зоригт. “Орчуулгын товч”. Үндэстний хэвлэлийн хороо.1988.7
8. Гэрэнчимэг. “Хятадыг монголчлох тайламж” Өвөр монгол .2011
9. “Орчуулах эрдэм II” ЭШӨ эмхтгэл. МУИС-ийн хэвлэх үйлдвэр. 2010.6



“ДУБЛИНЧҮҮД” ЗОХИОЛЫН ОРЧУУЛГАД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Д.Отгонтуяа⁷², А.Сүхмаа⁷³, Г.Энхбаяр⁷⁴

Abstract: Different cultures of humankind influence their views and perceptions of society. This principle is vital in the translation process, and the translator aims at conveying the message of the source text (ST) to the target text (TT) accurately and understandably for the readers. Therefore, every translator should have some theoretical knowledge about how to deal with different strategies of translating Culture-Specific Items (CSI) and use appropriate methods. In translation, CSI are common to all languages, nevertheless they are unique to the culture of the source text (ST). In this paper, some CSI in the Mongolian translation of *Dubliners* by James Joyce, which comprises of 15 short stories, have been analyzed by using Newmark's model of CSI. In translation, universal words do not cause any particular issues because it is usually easy to find their equivalents in the TT. On the other hand, cultural vocabularies are difficult to translate and therefore they belong to the group of non-equivalent lexis.

Түлхүүр үг: Уран зохиолын орчуулга, соёлын онцлог бүхий үг хэллэг, П.Ньюмарк, Дублинчүүд, дүйцэл

Удиртгал

Хүн төрөлхтний түүхэнд мэдэгдэж буй орчуулгын үйлийн үүсэл нь эртний уламжлалтай. МЭӨ 196 оны үед хамаарах 5-р Птолемейд өргөсөн зарлиг болох “Сарнайн чулуун бичээс” (*Rosetta Stone*)-ийг 1799 онд Египетээс олсон. Ижил утгатай энэхүү гурван бичээс бүхий дурсгалыг Эллиний үед (*Hellenistic period 323-31BC*) сийлсэн бөгөөд чулууны дээд хэсэгт эртний Египетийн дүрс үсэг, дунд нь эртний мисир таталган бичиг, доод хэсэгт нь эртний грек үсгээр бичжээ. Грек бичвэрийн анхны бүрэн орчуулгыг 1803 онд хийснээр бусад бичээсийг бүрэн тайлж уншихад дөхөм болсон бөгөөд эл бичээсийг дуурайсан уу, эсвэл, орчуулсан уу гэдгийг тогтооход түвэгтэй хэмээн судлаачид үздэг.

20-р зуунаас өмнөх үеийн орчуулгын сэтгэлгээ нь нэг талаас Библи судрын орчуулга, нөгөө талаас уран зохиолын орчуулга дээр үндэслэж байсан бөгөөд тухайлбал, Жефри Чосер, Жон Драйден, Александр Поп, Гёте зэрэг алдартай зохиолч, яруу найрагчдын олон арван орчуулгын бүтээл хэвлэгдэн гарч байсан. Монголчууд Европын тэр дундаа орос болон бусад хэлнээс шууд болон дам орчуулах ажил 20-р зууны эхнээс идэвхжсэн бөгөөд сүүлийн жилүүдэд дэлхийн шилдэг яруу найраг, тууж, роман, өгүүллэг бүхий утга зохиолын олон ном бүтээлийг эх хэлнээс нь монгол хэлнээ орчуулан хэвлүүлэх нь олширсоор байна. Монголын үе үеийн дуун

⁷² Ph.D, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбарын Гадаад хэлний төв

⁷³ Докторант, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбарын Гадаад хэлний төв

⁷⁴ Докторант, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбарын Гадаад хэлний төв

хөрвүүлэгчдийн орчуулах арга барил өөр өөрийн гэсэн онцлогтой, эх хэлний баялаг сайхныг илтгэсэн, бие даасан байдал, үндэсний соёл, уламжлалаа хадгалсан шинжтэй байсан байна.

Уран зохиолын орчуулга тун адармаатай бөгөөд тухайн эх зохиолд дүрслэгдэж буй орны түүх, соёл, шашин шүтлэг, зан заншил, ахуй амьдралыг сайтар мэдэх шаардлага орчуулагч хүнд байнга тулгарч байдаг. Хүн төрөлхтний үүтгэсэн олон янзын соёл нь тэдний нийгмийг үзэх үзэл, ойлголтод нөлөөлдөг. Энэхүү зарчим нь орчуулгын үйлд чухал ач холбогдолтой бөгөөд орчуулагч орчуулгын эхийг (ST) орчуулах хэлэнд (TT) үнэн зөв, ойлгомжтойгоор уншигчдад хүргэх үүрэгтэй. Иймд орчуулагч бүр соёлын онцлог бүхий үг хэллэгийг (CSI) орчуулах талаар тодорхой онолын мэдлэгтэй байж тохиромжтой арга, тактикийг ашиглан бүтээлч орчуулга хийх хэрэгтэй. Соёлын онцлог бүхий үгийн сан нь бүх хэлэнд нийтлэг байдаг хэдий ч орчуулгын эх (ST)-ийн соёлд өвөрмөц байдлаар илэрхийлэгддэг ажээ.

Дэлхийн олон эрдэмтэн судлаачид, орчуулгын онолчид соёлын тухай ойлголтыг өөр өөр судлагдахууны үүднээс судалж шинжилсээр иржээ. Соёлын утгат үг хэллэгийн хэрэглээг тодорхойлохын тулд орчуулагчдын хэрэгжүүлж буй стратегид дүн шинжилгээ хийх, тайлбарлах, эдгээр стратеги нь түгээмэл эсвэл өвөрмөц шинжтэй эсэхийг олж мэдэх зорилготой. Бидний амьдарч буй дэлхийд олон хэлээр хүмүүс хоорондоо харилцах нь соёлын олон янз байдлыг үүсгэж, эдгээр хэл хоорондын харилцааны хүрээнд орчуулга зайлшгүй хэрэгцээ болж хувирдаг. Орчуулагчид соёлын тухайт үг хэллэгийг орчуулахдаа зарим бэрхшээлтэй тулгардаг тул хэлбэрийг бус утгыг дамжуулахад төвлөрөх хэрэгтэй болдог.

Эл өгүүлэлдээ 15 богино өгүүллэгээс бүрдэх Жэймс Жойсын “Дублинчүүд” зохиол, түүний монгол орчуулга дахь соёлын онцлог бүхий зарим үг хэллэгийг хэрхэн орчуулсныг П.Ньюмаркийн загварчлал, ангиллыг (*Culture-Specific Items*) ашиглан дүн шинжилгээ хийхийг зорилоо. Энгийн үг хэллэгийг орчуулгын хэлэнд буулгахад түүний дүйцлийг олоход хялбар байдаг бол соёлын онцлог бүхий үгийн санд тохирсон дүйцэл олоход бэрхтэй. Орчуулгад бүрэн дүйцэл гэж байхгүй хэмээн үзэх Якобсон (Jakobson, 2013:114) нэг хэлний хүрээнд орчуулахад ч утгыг тайлбарлахын тулд дохионы нэгжийн хослолыг (*code-units*) хэрэглэх хэрэгтэй гэж үзжээ. Уран зохиолын орчуулгыг эх бичвэртэй харьцуулж, тактик бүрийг илүү сайн ойлгохын тулд жишээгээр тайлбарлав.

20-р зууны Ирландын нийгмийн амьдралыг олон талаас нь тусгасан “Дублинчүүд” хэмээх богино өгүүллэгийн түүврийг орчуулагч О.Чинбаяр 2012 онд монгол хэлнээ орчуулсан бөгөөд 2014 онд “Зураачийн залуугийн хөрөг”, “Улисс” романыг тус тус орчуулж уншигчдын гар дээр тавьжээ.

Ирландын нэрт зохиолч Жэймс Жойс (1882-1941)-ын уран бүтээлийн өв нь шүлгийн хоёр эмхэтгэл, нэг жүжигчилсэн зохиол, богино хэмжээний өгүүллэг, гурван романаас бүрддэг. Тэрээр яруу найрагч, жүжгийн зохиолчийн хувьд шинийг санаачлагч, гарамгай нэгэн гэж тооцогддоггүй ч хүүрнэл зохиолууддаа хийсэн хувьсгал нь түүнд том ололт авчирсан юм. Ж.Жойс XX зууны роман бичигчдэд тулгарч асан хамгийн гол асуудал буюу реализм, символизм хоёроос сонгох эсэх асуудлыг ухаарлын аргаар шийдвэрлэсэн гэдэг. Нэг талаас хүүрнэл зохиолд урд өмнө бараг хөндөгдөөгүй бодит байдлын шинэ орон зайг нээж, нөгөө талаас зохиолчид бэлгэдэлт загвараар бодит үнэнийг илэрхийлэх арга замыг эрэлхийлж байв. Энэ хоёр хандлагын төв дундыг баримталж ямар ч реалист зохиолчоос илүү Жойс өдөр тутмын амьдралд тулгамдаж байсан асуудлыг бодитоор, илэн далангүй нээн харуулжээ. Ийм ч учраас түүний “Улисс” эрээ цээргүй зохиол гэж арав буюу түүнээс илүү жилээр Англи, Америк улсад хэвлэх, борлуулахыг хориглосон ч Францад хэвлэгдсэн номын хуулбарыг хууль бусаар орчуулан хэвлэж байв. (Бөрт, 2016:47)

Орчин үеийн богино өгүүллэгийн төрөлд “Дублинчүүд” нь шинэ хэв маяг, арга барилыг оруулсан юм. “Зураачийн залуугийн хөрөг” зохиолоороо Жойс роман бичих уламжлалт арга

барил, хөгжлийн нэг хэвийн явц, чиг хандлагыг цоо шинээр баяжуулсан. “Улисс”-д Жойс хуучин цагийн улиг болсон хэрэг явдлыг халж, эхнэртээ хууртагдсан Леополд Блүүм гэх еврей залуугийн Дублинд өнгөрүүлсэн нэг өдрийг харуулж (Гомерийн “Одиссей”-н үйл явдлаас сэдэвлэн), шинэ дүрийг бүтээсэн. Зүүдний логик буюу цаг хугацаа, орон зайн саад тээгийн сүйтгэл маягаар бичсэн “Финнегийн хойлго” нь “Улисс” номныхоо нэмэлт буюу тайлбар бүтээл бөгөөд Хампри Чимпдэн Ийрвикер нэрт шар айргийн мухлагийн эзний амьдралаас сэдэвлэсэн түүхийг бичихдээ уран зохиолын цоо шинэ хэлийг боловсруулсан хэмээн үнэлэгддэг төдийгүй хэлний агуу их чадвар, хошин шогийн нарийн мэдрэмжээр бичсэн тул уг номыг уншиж ойлгохын тулд уншигчдаас их хүч хөдөлмөр зарцуулах шаардлагатай болдог. (Бөрт, 2016:48)

“Дублинчүүд” нь богино хэмжээний өгүүллэгээс бүрдэх зохиолын дүрүүд нь “Улисс” романд үргэлжлэн амьдардаг онцлогтой. Эцэг Флинн хэмээх сүмийн тахилч нас барснаар “Эгч дүүс” өгүүлэл эхлэх агаад эцэг Флинний ойр байсан залуугийн бодол ба эцэг Флиннийг юунаас болоод өөд болсон талаар ярилцаж буй эгч дүүсийн харилцан яриагаар үйл явдал өрнөнө. Сүмийн эцэг ламын хувьд шашны ариун зан үйлээ хүндлэн үздэг байсан нь гарцаагүй бөгөөд цуглааны нэгэн үйлчлэгч “Ариун хундага”-ыг унагааж хагалснаас болж Флинн оюун санааны гүн хямралд орж улмаар тархинд нь гурван удаа цус харваад нас бардаг.

Эгч дүүс (The Sisters) өгүүллэгийн сэдэв, өгүүлэмж эгч дүүсийн яриатай огт хамааралгүй бөгөөд зохиолч яагаад энэ нэрийг өгсөн нь сонирхолтой. Зохиолын өгүүлэгч нь нэгэн залуу католик санваартантай нөхөрлөж байснаа дурсдаг өгүүлэмжийг ойлгохын тулд дүн шинжилгээ хийх, утга учрыг олохыг уншигчдад үлдээдэг нь Жойсын “ухамсрын урсгал” гэх ойлголт зохиолуудад нь шингэсэн байдагтай холбоотой.

Хэл шинжээч, орчуулгын онолч Петер Ньюмарк “Орчуулгын сурах бичиг” хэмээх онолын бүтээлдээ соёлын онцлог бүхий үг хэллэгийг (Culture-Specific Items) орчуулах хэд хэдэн ангиллыг анх тодорхойлсон. Тухайлбал, шилжилт, нутагшуулалт, соёлын дүйцэл, үүргийн дүйцэл, дүрслэн тайлбарласан дүйцэл, ижил утгатай үг, дуурайлах, сэлгэлт, модуляц хийх, стандарт орчуулга, нөхөлт, утгын дүн шинжилгээ, хосолсон, ихэсгэл ба багасгал, дахин бүтэцжүүлэлт, тайлбар зэрэг болно. (Newmark, 1988:81-93)

Ньюмаркийн томьёолсон соёлын дүйцэл (Newmark, 1988:82) гэдэг нэр томьёо нь орчуулгын эх (SL) дэх соёлын тухайт үг хэллэгийг орчуулах хэлний (TT) соёлын тухайт үг хэллэгээр орчуулдаг ойролцоо орчуулга болно. 1964 онд Е.Найда орчуулгын эх (SL) ба орчуулах хэл (TT) хоёр нь соёлын хувьд өөр хоорондоо зэрэгцэн байх орчуулгын харилцаа зохицол, асуудлыг шийдсэн. Үүнийг ашиглаж Ньюмарк таван “соёлын ангилалзүй”-гээ (*cultural categories*) гаргасан. (Newmark, 1988:96)

1. Экологи (ургамал, амьтан, салхи, тал, толгод)
2. Материаллаг соёл (хоол, хувцас, орон байр, тээвэр)
3. Нийгмийн соёл (ажил, амралт)
4. Байгууллага, зан заншил, үйл ажиллагаа, журам үзэл баримтлал (улс төрийн, захиргааны, шашны, урлагийн)
5. Дохио зангаа, зуршил

Зарим ангилалд тохирох соёлын онцлог бүхий үг хэллэгийн орчуулгыг жишээлэн авч үзье.

A. Шилжилт (Transference)

Ньюмаркийн үзсэнээр, “Шилжилт нь орчуулгын эх (SL)-ийн үг хэллэгийг орчуулах хэл (TT)-ний үг хэллэг рүү орчуулах орчуулгын явц юм”. Зөвхөн жижиг бүлэг бүхий соёлын ухагдахуун ойлголтыг шилжүүлнэ. Тухайлбал, амьд ба амьгүй хүний нэр, газарзүйн нэр томьёо, сонин сэтгүүлийн нэр, орчуулагдаагүй уран зохиол, жүжиг, киноны нэр, хувийн компанийн ба төрийн байгууллагын нэр, гудамжны нэр, хаягийг орчуулахгүйгээр шилжүүлнэ. Орчуулагч энэ

аргыг бичвэр ба уншигч хоёрын хооронд ойр дотно байдлыг мэдрүүлэх зорилгоор ашиглана гэж Ньюмарк үзсэн.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (ТТ)
The Rev. James Flynn aged sixty-five years.	Санваартан Жэймс Флинн 65 насандаа өөд болов.	Дээрхийн гэгээн Жэймс Флинн (...сүмийн ламтан асан) 65 настай.

James Flynn бол хүний нэр учир зохиолч энд галигт (*transliterated*) шилжүүлсэн байна. *Rev.* гэсэн товчилсон үг нь *Reverend* буюу санваартан, номлогч гэсэн утгатай үг бөгөөд Буддын шашинтай монгол уншигчид ойлгоход дөхөмтэй гэдэг үүднээс ‘Дээрхийн гэгээн’ хэмээн орчуулсан болов уу. Христийн болон Иудын шашны санваартны өндөр цол хэргэм ажээ.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (ТТ)
He had a little library made up of old numbers of <i>The Union Jack, Pluck and The Halfpenny Marvel</i> .	Тэрээр <i>Юнион Жак, Плак, Хафпэнни Марвел</i> сэтгүүлийн хуучин хэдэн дугаар бүхий цуглуулгатай байв.	"Британийн далбаа", "Чин зориг", "Адал явдлын хямдхан номын сан"-гийн хуучин дугаараас бүрдсэн багашаархан номын сан түүнд байв.

Энэ өгүүлбэрт орчуулаагүй уран зохиолын бичвэрийн (*untranslated literary texts*) нэр байна. Ньюмаркийн соёлын ангилал зүйн гуравт буй “нийгмийн соёл” (*social culture*) хэсгийн жишээ болно.

“*The Union Jack*”, “*Pluck*” and “*The Halfpenny Marvel*” нь 19-р зууны сүүл, 20-р зууны эхэн үеийн Америкт гарч байсан цуврал сэтгүүлүүд бөгөөд оноосон нэрийг орчуулахаас илүүтэй галиглан буулгавал тохиромжтой болов уу. “*little library*” холбоо үгийг “*багашаархан номын сан*” гэж орчуулсан нь байна. “*library*” гэдэг нь “*номын сан*” гэсэн үндсэн утгаас гадна “*олон номын цуглуулга*” (*a collection or set of books or other things*) гэсэн хоёр дахь утгаар нь энд авч үзвэл зохилтой байна.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (ТТ)
... near it on a plate lay a segment of very light plum-pudding .	... хажуугийн тавган дээр чавгаар хийсэн зөөлөн бялууны хэлтэрхий байв.	...дэргэдэх тавган дээр хямдхан цэлцэгнүүрийн дөрөвний нэг мэлтийнэ.

Вебстерийн цахим тольд *pudding* (анхдагч утга нь зайдас гэсэн латин гаралтай үг, чихэрлэг, ихэвчлэн халуун бүлээн иддэг бялуу) гэж тайлбарлажээ. Орчуулагч *pudding* гэдэг үгийг цэлцэгнүүр (*jelly*), *light* гэдгийг хямдхан, *segment* (хэсэг) гэдгийг дөрөвний нэг хэмээн орчуулсан нь орчуулгын эхийн (ST) утгыг алдагдуулсан гэж үзэж болохоор байна.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (ТТ)
There he lay, solemn and copious, vested as for the alder, his large hands loosely retaining a chalice .	... түүний том гарт ариун хундагыг мөчидхөн атгуулжээ.	Чухал хийгээд албархуу тэр яг л буян номын ажил үүргээ гүйцэтгэх гэж буй мэт хувцасласан байх агаад хорчгор том гарт нь хэлтгий аяга бариулжээ.

“*Chalice*” гэдэг нь Христийн шашинд итгэгчдийн хувьд хүндэтгэлийн утга бүхий “Ариун хундага” хэмээгддэг. Христэд итгэгчид Есүс дэлхийд ирснийг дурсан санахын тулд нэг

хундаганаас дарс уух ариун ёслол үйлддэг байна. Энэ ариун ёслолын эрхэм зүйл болох ариун хундагыг “хэлтгий аяга” хэмээн орчуулсан эндүү ташаа болсон байна. Санваартан нь ариун хундагыг унагаж хагалсанд ихээхэн хямарч буйгаас харвал уг хундага итгэл үнэмшлийн хувьд ямар үнэ цэнтэй зүйл вэ гэдгийг нь мэдэж болно. Мөн зохиол эхлэхэд “...it was the third stroke” буюу “энэ нь гурав дахь харвалт байсан” гэсэн өгүүлбэрийн *харвалт* гэдгийг *цохилт* гэж орчуулсан нь үг сонголтын алдаа гэж үзэж болохоор байна.

Энэ ангилалд зохиолын зарим өгүүлэгийн нэрийн орчуулгын тухайд авч үзлээ.

Шороо (Clay) өгүүлэлд Дублин хотын нэгэн угаалгын газрын гал тогоонд ажилладаг дунд эргэм насны, ганц бие, католик шашинтай эмэгтэй Мария гол дүр агаад зохиолч чухам юуг өгүүлэх гээд байгаа нь оньсого мэт. Нэг удаа Мария Сүнсний баярын өмнөх орой ах дүү Жо-гийн гэр бүлд зочлон нүдээ боогоод тавган дээрх нэгэн зүйлд гар хүрч тоглодог нэг тоглоомд оролцдог. Энэ тоглоом нь хүрч буй зүйл нь ирээдүйг нь зөгнөдөг гэсэн утгыг бэлгэддэг аж. Мариагийн ээлж болоход тэрээр нэг нойтон, наалдамхай зүйлд гар нь хүрдэг. Зохиолд тэр зүйл “шавар” гэж дурдаагүй ч уншигч өгүүлэгийн нэрнээс таамаглаж болно. Энэ тоглоомд “шавар” үхлийг бэлгэддэг. Энэ өгүүлэгийн нэрийг “шавар” бус “шороо” гэж орчуулсан нь нэгэн шашны үйлтэй холбогдох соёлын утга үг бүхий үгийн агуулгыг сайтар ухаж ойлгоогүйтэй холбон үзэж байна.

Эрэлхэг хоёр (Two Gallants) Англи хэлний ‘gallant’ хэмээх нэр үг нь монгол хэлний эелдэг (ялангуяа эрчүүр эмэгтэй хүнтэй харилцахдаа үзүүлдэг хүндлэлтэй зан) ганган хээнцэр, дэгжин гэсэн анхдагч утга, нөгөө талаар эрэлхэг, зоригтой гэсэн утгаар хэрэглэгддэг. Эл өгүүлэлд гарах Корли, Ленехан гэх хоёр залуугийн эрэлхэг, зоригтой үйлийн тухайд бус, харин гэрийн үйлчлэгчдийг эздээс нь салгах замаар хялбар аргаар мөнгө олдог дүрүүд юм. Өгүүллийн гарчиг нь хошин егөөдсөн утга аястай бөгөөд зохиолын өгүүлэмжийг ойлгохын тулд Жойс уншигчдад өөрсдөө дүн шинжилгээ хийх, утга учрыг олох буюу “ухамсрын урсгал” гэх ойлголтоо зохиолууддаа шингээж өгсөнтэй нь холбон үзэж хэрэгтэй. Өгүүлэгийн нэрийг шууд оноон орчуулсан нь өрөөсгөл болжээ.

Б. Нумаржуулал (Naturalization)

Ньюмаркийн соёлын ангилал зүйн дөрөвт буй “шашны нэр томьёо” (*religious terms*) хэсгийн жишээг авч үзлээ.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (TT)
... like the word gnomon in the Eucilid and the word simony in the Catechism.		...Эвклидийн хувьд “Гномон” мөн товч сургаалд гарах “Симония” гэх үгс тун гайхалтай сонсогддог байв.

Орчуулагч эдгээр шашны холбоотой үгийг орчуулгын эхийн (SL) дуудлагаар нь орчуулгын хэл (TL)-ний үгзүйн бүтцэд зохируулан буулгаж, зүүлтээр тайлбар өгчээ.

В. Үүргийн дүйцэл (Functional equivalent)

Ньюмаркийн үзсэнээр үүргийн дүйцэл нь “соёлын утга бүхий үгсэд хэрэглэгддэг, заримдаа шинэ тодорхой нэр томьёо хэрэглэдэг; тиймээс орчуулгын эхийн (SL) үгийг саармагжуулж эсвэл ерөнхийд нь оруулдаг”. Тэрээр мөн үүргийн дүйцлийг "орчуулгын хамгийн зөв арга, өөрөөр хэлбэл соёлын холбоотой үгсийн утгыг саармагжуулах" гэж тодорхойлсон байдаг (Newmark, 1988:83).

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (TT)
Ignatius Gallher made a catholic gesture with his right hand.	... Игнатий Галлахер баруун гараараа адислав .	Игнатий Галлахер ёслол төгөлдөр байдалтай гараа өргөв.

Catholic gesture нь Христийн шашны зан үйлд хамаарах дохио зангаа бөгөөд Буддын шашинтай уншигчдад буухгүй байна. Ньюмаркийн соёлын ангилал зүйн тавд буй “дохио зангаа, зуршил” (*gesture and habit*) хэсгийн жишээ юм.

Г. Дүрслэн тайлбарласан дүйцэл (*Descriptive equivalent*)

Дүрслэн тайлбарласан дүйцэл нь орчуулгад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. (Newmark, 1988:84) Энэ тактикийг ашигласнаар бусад үг хэллэгийн ашиглан соёлын утгат үг хэллэгийн зөв ойлголттой болох боломжийг бүрдүүлдэг. Найда “Дүрслэн тайлбарласан дүйцэл нь хүлээн авагчийн хэлэнд тогтсон нэр томъёогүй юмс, үйл явдал, шинж чанар, хамаарлыг хувьд хангалттай дүйцэхүйц санаагаар илэрхийлдэг” гэж үзээд юмс ба шинж чанар нь хамгийн түгээмэл гэжээ. (Nida, 1964:237)

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (TT)
She was very fond of that purse because Joe had brought it to her five years before when he and Alphie had gone to Belfast on a Whit-Monday trip.	Ариун сүнсний баярт оролцохоор явахдаа ...	Сүнснүүдийн өдөрт оролцохоор Белфаст руу явахдаа авчирч өгсөн энэхүү хэтэвчиндээ тун их хайртай байв.

Ньюмаркийн соёлын ангилал зүйн дөрөвт буй “байгууллага, зан заншил, үйл ажиллагаа, журам үзэл баримтлал (улс төрийн, захиргааны, шашны, урлагийн)” (*organization, customs, activities, procedures, concepts*) хэсгийн жишээ юм. Орчуулагч шашны холбогдолтой баяр гэж дүрслэх дүйцэл ашиглан орчуулсан байна. Энэ өгүүлбэрт Христийн шашны Ариун Сүнс ирсэн баярын өдөр/ Ургац хураалтын баяр (Holy Spirit/The Christian holiday of Pentecost) хэмээх тэмдэглэлт баярын өдрийн тухай өгүүлжээ.

Д. Сэлгэлт (*Shifts or transpositions*)

Энэ тактик нь “орчуулгын эх (SL)-ээс орчуулах хэлэнд (TL) хувиргах хэлзүйн дүрэмд хамаарна”. Эхний хэлбэрийн сэлгэлт нь ганц тооноос олон тооны хэлбэрт шилжих үед тохиолддог. Орчуулгын эх (SL)-ийн дүрмийн бүтэц орчуулах хэлэнд (TL) байхгүй тохиолдолд хоёр дахь сэлгэлтийг хий шаардлагатай. Гурав дахь сэлгэлтэд үгчлэн орчуулах боломжтой, гэхдээ тохирохгүй байх магадлалтай. (Newmark, 1988:86) “Соёлын ялгаатай байдлаас болж эх бичвэрийн хэлний үгтэй ижил эрэмбийн түвшинд байгаа үг үнэндээ өөр тохиолдолд сэлгэлт шаардлагатай болно” гэж Найда (Nida, 1964:237) үзжээ.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (TT)
In the sacred college , you know, of cardinals and archbishops and bishops there were two men who held out against it while the others were all for it.	Гэгээн ламтан, санваартнуудыг ариун газарт байхыг олонх нь дэмжиж хоёр хүн зөвшөөрсөнгүй.	Кардиналууд, архиепископ болон епископ нарыг Гэгээн зөвлөлд байхыг бүгд зөвшөөрч байхад хоёрхон хүн эсрэг саналтай байлаа.

Cardinals гэдэг нь Католик шашны их лам, *archbishops* – их ламын дараагийн дэв зэрэг, *bishops* - зэрэг дэв нь арай доогуур гуравдугаар түвшин гэж тайлбарлажээ. *Sacred college* гэдэг нь Ариун газар (Holy place) гэсэн үгээр сэлгэж болох юм.

“Учрал” өгүүлэлд “Шашны сургууль”-ийн нэгэн хүү адал явдлыг эрж хайж буйг дүрсэлнэ. Махони гэдэг хүүгийн хамт хичээлээ таслан өдөржингөө сэлгүүцсэний эцэст нэгэн хөгшинтэй тааралдаж яриа өрнүүлж буйг голчлон хүүгийн бодрол, мэдрэмжээр дүрслэн үзүүлжээ.

Англи эх (ST)	Шууд утга	Монгол орчуулга (TT)
... we fought a pitched battle on the grass ... He looked like some kind of an Indian when he capered round the garden, an old tea-cosy on his head, beating a tin with his fist and yelling : "Ya! yaka, yaka, yaka!"	... бид ногоон зүлгэн дээр ширүүн тулалдана. ... толгой дээрээ цайны гүцний хуучин ноосон бүрх дарж өмсчихөөд, атгасан гараараа лааз цохин: - Ия-як-як! хэмээн цэцэрлэгээр орилон гүйх нь Индиантай төстэй харагдана.	...бид шалбааг дээр цуст дайн өрнүүлнэ. Үнэн хэрэгтээ тэр цэцэрлэгээр гүйж, харайж байхдаа данхны хуучин хөлчлөг толгой дээрээ дарж өмсчихөөд, атгасан гараараа лааз цохин: - Ия-як-як! хэмээн орь дуу тавих нь индиантай тун төстэй санагдана.

“pitched battle” холбоо үгийн орчуулгыг англи хэлний тайлбар толиноос (<https://www.merriam-webster.com/dictionary>) харахад 1. Эсрэг талууд ойрхноос ширүүн тулалдах, 2. Газар, цагаа товлон дайтах гэсэн утгатай байна. Эх зохиолоос (ST) орчуулахад хүүхдүүд дээврийн хонгилд эсвэл ногоон зүлгэн дээр ширүүн тулалдаж тоглодог тухай өгүүлнэ. Орчуулгын хувьд үг сонголтыг буруу хийсэн нь ажиглагдлаа.

“tea-cosy” – Монгол хэлний их тайлбар толиноос харахад “хөлчлөг” гэдэг үг нь “халуун жин” гэсэн утгатай бөгөөд харин “tea-cosy” хэмээх англи үгийн утгыг хөөн үзвэл 19-р зууны үеэс цайгаа хөрөхөөс сэргийлэх зорилгоор цайны гүцнийхээ гадуур даавуу болон ноосон утсаар нэхэн хийдэг бүрээсийг хэлдэг байжээ. Энэ нь утгын хувьд дүйж болох ч уншигчдад хуучин үг хэллэгийг шууд ойлгоход хүндрэлтэй.

Дүгнэлт

Уран зохиолын орчуулга нэн адармаатай бөгөөд тухайн эх зохиолд дүрслэгдэж буй орны түүх, соёл, шашин шүтлэг, зан заншил, ахуй амьдралыг сайтар мэдэх шаардлага орчуулагч хүнд байнга тулгарч байдаг.

Жойсын уран бүтээлүүд нь аливаа зүйлийг ухамсарлан ойлгох буюу “хамгийн энгийн зүйлсийн мөн чанар илүү гялалздаг” гэх ойлголт, ухамсрыг танин мэдэх шинэ арга, амьдралыг ойлгох нарийн төвөгтэй үйл явцыг гаргаснаараа дэлхийн шилдэг бүтээлүүдэд зүй ёсоор тооцогдож олон хэлээр орчуулагдсан байна.

Олон янз соёл нь ертөнцийг таних өвөрмөц шинжтэй учраас орчуулагч нь орчуулах эхийг (ST) орчуулгын бичвэрт (TT) буулгахдаа соёлын утгат үг хэллэгийг (CSI) тусгайлан авч орчуулгын онол, зарчим, арга аргачлал, ангилалд тулгуурлан зорилго, агуулга, нөхцөл байдалдаа уялдуулан тохирох стратегийг ашиглах нь зүйтэй болов уу.

Ном зүй

Монгол хэлээр:

Даниэл С.Берт. (2016) Сонгодог 100 Зохиолч, Үе үеийн сонгодог найраг, сод туурвил, шилдэг жүжгийг бүтээгчид, (Daniel S.Burt, The Literary 100) Боть I, II, (Англи хэлнээс орчуулсан Д.Отгонтуяа, Д.Түвшинтөгс) NEPKO publishing, Улаанбаатар.

Жэймс Жойс (2012) Дүблинчүүд, Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар.

Д.Отгонтуяа (2015) “Монголын нууц товчоон”-ы хэлцийн англи орчуулгыг задлан шинжлэх нь, Диссертаци, Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Bawden, C. (1997) Mongolian-English Dictionary, London, Great Britain.

Newmark, P. (1984) Approaches to Translation'. Oxford and New York.

Newmark, P. (1988) A Textbook of Translation'. New York: TiceHall Press

Nida, E. (1964) Towards a Science of Translating, Leiden: E.J.Brill Publishing.

Jakobson, R. (2013) On Linguistic Aspects of Translation, Harvard University Press.

Цахим эх сурвалж:

Joyce, J (2019) Dubliners, The Project Gutenberg EBook.

<http://merriam-webster.com>



П.Уянга⁷⁵, Б.Хавар⁷⁶

147

дарангуйлан, оюун санааг нь боолчлох төрийн бодлогыг хэрэгжүүлж, феодалын ёс суртахуун, феодалын мунхаг бишрэл болон ардыг мунхруулах төрийн бодлогыг ашиглаж байв. А-Кюгийн дүрээс феодалын зориг санааны боолчлолын “гавьяа зүтгэл” ба “боолчлогдогчийн хүнд ноцтой зориг санаа”, “дотор шарх”-ыг мэдэж болно. Зохиолч өөрийн оршиж байгаа нийгэм, харьцаж байгаа хүмүүн, өөрийн өнгөрүүлсэн хувьсгал зэрэгт анхаарал тавьж, уран нарийн сэтгэмжилж зохиожээ.

Тухайн үед хоёр улсын харилцаа төдийлөн сайн биш байсан бөгөөд Хятад улс олон талт гадаад харилцааны төрийн бодлого хэрэгжүүлээгүй байсан цаг үе тул хоёр орны бүх талын харилцаа учраа олоогүй байсан юм. Тиймээс Монголын уншигчид “А-Кюгийн үнэн түүх” зохиолоор дамжуулан Хятад улсыг ойлгож болно. А-Кю баян айлд хөлсний ажил хийж, олсон мөнгөө мөрийтэй тоглоом, эсвэл, архины пүүст үрдгийг бичсэн зэрэг нь тухайн үеийн Хятадын нийгмийн ялзарсан байдлыг шууд тусгаж байгаа явдал болно.

2. Хятадын зохиол бүтээлийн хэв маяг, хөгжлийг ойлгон орчуулгын чадварыг дээшлүүлнэ.

“А-Кюгийн үнэн түүх” зохиол нь хятадын утга зохиолын төлөөлөл мөн. Тиймээс тус зохиолыг орчуулах нь тухайн улс үндэстний зохиол бүтээлийн хэв маягийг ойлгож, зохиол бүтээлийн хөгжлийг нь мэдэж болно. Үндэстэн болгон өөрийн соёл иргэншилдээ суурилсан үг хэл, үсэг бичигтэй байдаг. Үндэстний үг хэл, үсэг бичиг нь өөрийн гэсэн хэлж ярих, бичиж туурвих дүрэм журамтай. Уран зохиолоор авч хэлсэн ч тэр нь тухайн үндэстний үг хэл, үсэг бичгийн санг илэрхийлж, зохиомж сэтгэхүй, зохион бичих арга хэлбэрийг шууд тусгаж байдаг.

Монгол, хятадын утга зохиолын орчуулгыг хорьдугаар зууны гучаад он хүртэл авч үзэж болно. Монгол улсад хамгийн анх орчуулсан хятадын орчин үеийн утга зохиолын алдарт бүтээл бол Лү Шюний “Гүн И Жи” өгүүллэг юм. Үүнийг монгол хэлнээ орчуулагч Б.Бат хятад хэлнээс орчуулсан бөгөөд орчуулгыг 1939 оны гуравдугаар сард нийтэлжээ. 1956 онд Монгол улсын хэвлэлийн хорооноос Лү Шюний туужисийн сонгомол бичгийг гаргаж, түүнд “Нутаг” ба “Гүн И Жи” гэсэн хоёр богино зохиолыг сонгон оруулсан байдаг. 1952 оноос эхлэн хятадын агуу их зохиолч Лү Шюний “А-Кюгийн үнэн түүх”, “Талзуу хүний өдрийн тэмдэглэл”, “Архины асар дээр”, “Эргэлзэл”, “Хашгирал” болон “Маргааш” зэрэг хорин хэдэн богино зохиолыг монгол хэлэнд орчуулан хэвлүүлж, монголын олон уншигчдын хүртээл болгосон байна. 1955 оноос эхлэн Монгол улсад тусгайлан хятадын уран зохиолын орчуулга хийдэг хэдэн орчуулагч төрөн гарч, тэдний шаргуу хөдөлмөрөөс монголын уншигчид маш олон содон бүтээлүүдтэй танилцсан юм.

3. Үндэстний соёлын харилцааг ахиулна.

“А-Кюгийн үнэн түүх” зохиол нь 40 гаруй янзаар орчуулагджээ. Энэхүү зохиолын япон орчуулга гэхэд л арван хэдэн хувилбар бий. Шанхайн кино үйлдвэр 1981 онд Лү Шюний мэндэлсний зуун жилийн ойн дурсгалд зориулж “А-Кюгийн үнэн түүх” киног хийжээ. “А-Кюгийн үнэн түүх” мэтийн хятад зохиол бүтээлийг монгол хэлэнд орчуулж буулгах нь монгол ба хятад үндэстний соёлын харилцааг ахиулж байдаг. Зохиол бүтээлд тухайн улс үндэстний амьдралын хэв маяг, мөн тухайн үндэстний зан заншил, соёл түүх агуулагдаж байдаг болохоор уран зохиолын орчуулгаар дамжуулан үндэстэн хоорондын харилцааг чангатгаж, соёлын солилцоог ахиулна. Жишээлбэл, “А-Кюгийн үнэн түүх”-т бичигдсэн Ү-Магийн байр суурь, А-Кюгийн нийгмийн байр суурь, тэд нарын хооронд өрнөж байгаа яриа, идээ ундаа зэрэг маш олон зүйлээс тухайн үндэстний идээ ундааны соёл, ураг гэр бүлийн соёл, нийтийн харилцааны соёл зэргийг олж харж болно.

Хоёр. “А-Кюгийн үнэн түүх” зохиолын гурван монгол орчуулгыг харьцуулах нь

Уншигчид ямар нэгэн зохиол бүтээлийг гарчгаар нь цээжилж, гарчиг нь тухайн зохиолын амин сүнс нь болдог. Тиймээс гарчгийг зөв зохистой орчуулах нь маш чухал юм. “А-Кюгийн үнэн түүх” зохиолын гурван монгол орчуулгын гарчиг нь харилцан адилгүй байна. Энэ зохиол нь нийт

есөн хэсгээс бүрдэх ба зохиолын гарчигтайгаа нийлээд арван гарчигтай болно. Гурван орчуулгын гарчгийг харьцуулбал:

Уг зохиол	Ж.Артөр ⁷⁷	Б.Бат ⁷⁸	Өвөр Монгол ⁷⁹
阿 Q 正传	“А КЬЮГИЙН ҮНЭН ТҮҮХ”	“А-КЮГИЙН ҮНЭН ТҮҮХ”	“А-КЮГИЙН ЖИНХЭНЭ НАМТАР”
序	“Оршил”	“Удиртгал”	“Оршил”
优胜记略	“Гаргуун ялалтын товч тэмдэглэл”	“Яруу ялалтын товч тэмдэглэл”	“Яруу ялалтын товч тэмдэглэл”
续优胜记略	“Гаргуун ялалтын товч тэмдэглэлийн үргэлжлэл”	“Яруу ялалтын товч тэмдэглэлийн үргэлжлэл”	“Яруу ялалтын товч тэмдэглэлийн үргэлжлэл”
恋爱的悲剧	“Хайр дурлалын эмгэнэлт явдал”	“Амраглалын эмгэнэл”	“Янаг дурлалын гуниг”
生计问题	“Амьдрах аргын асуудал”	“Амьдралын асуудал”	“Амьдралын асуудал” .
从中兴到末路	“Сэргэлтээс мухардалд”	“Мандлаас доройтол хүртэл”	“Дэгжрэлээс доройтолд”
革命	“Хувьсгал”	“Хувьсгал”	“Хувьсгал”
不准革命	“Хувьсгалд оруулсангүй”	“Хувьсгалд нийлэхийг эс зөвшөөрөв”	“Хувьсгал хийхийг эс зөвшөөрөв”
大团圆	“Их бүрдэл”	“Их гүйцэтгэл”	“Их эцэслэлт”

Эдгээр орчуулгад “яруу” ба “гаргуун”, “эмгэнэл” ба “гуниг”, “бүрдэл” ба “гүйцэтгэл”, “намтар” ба “түүх” зэрэг адил бус үгсийг адил нэгэн утгыг илтгэхэд хэрэглэжээ.

Үгсийн онцлог

“А-Кюгийн үнэн түүх” зохиолын гурван монгол орчуулгын үгийн хэрэглээний онцлогийг дурдвал:

Өвөр Монголын орчуулгын хэл нь хятад хэлний нөлөөнд нэлээд автсан байна. Жишээлбэл, “太太” гэх үгийг шууд дуудлагаар нь “тайтай” гэж орчуулсан, “洋钱” гэх үгийг “янчаан”, “亏” гэх үгийг “күй”, “掌柜” гэх үгийг “жангүйд” гэх мэтээр орчуулсан байна. Өвөр Монголын орчуулгын дэвтрийг 1974 онд орчуулж хэвлүүлсэн болохоор одоогийн орчуулгын түвшинтэй харьцуулахад маш их ялгаа оршиж байна. Хорьдугаар зууны 70-аад оноос өөрчлөлт шинэчлэлтийн нээлттэй бодлого хэрэгжиж эхэлснээр гадаадын уран зохиолын хэв маяг ч аажмаар нэвчин орж ирсэн юм. Гэхдээ тус өгүүлэлд ашигласан Өвөр Монголын орчуулгын дэвтрийн⁸⁰ үг хэллэг нилээд хөшүүн онцлогтой байна. Энэ нь орчуулагчийн хувь хүний орчуулгын чадвар болон монгол хэлний үгсийн сантай шууд холбоотой юм.

Тус өгүүлэлд ашигласан Б.Батын⁸¹ орчуулга нь 1952 оны хэвлэгдсэн бөгөөд арай хуучны орчуулгын бүтээл юм. Өвөр Монгол ба Монгол Улс нь үгийн хэрэглээний тал дээр ялгаатай байна. Жишээлбэл, “传” гэдэг үгийг Өвөр Монголд “намтар” гэж хэрэглэж дадсан бөгөөд Монгол Улсад “түүх”, “цадиг” гэж хэрэглэж байна.

⁷⁷ 1.Ж.Артөрийн орчуулга. Лу Синь “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, Нэпко хэвлэлийн газар, 2019 он

⁷⁸ Б.Бат. “А-Кюгийн үнэн түүх”, Улаанбаатар, улсын хэвлэх үйлдвэр, 1952

⁷⁹ Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. “Лү Шүний өгүүллэгийн түүвэр” Хөх хот, 1974 он

⁸⁰ Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. “Лү Шүний өгүүллэгийн түүвэр” Хөх хот, 1974 он

⁸¹ Б.Бат. “А-Кюгийн үнэн түүх”, Улаанбаатар, улсын хэвлэх үйлдвэр, 1952

Тус өгүүлэлд ашигласан Ж.Артөрийн⁸² орчуулга нь 2019 онд “Нэпко” хэвлэлийн газраас хэвлэсэн “Лу Синь “Галзуу хүний өдрийн тэмдэглэл” гэдэг номын эмхэтгэлд хэвлэгдсэн байна. Зохиолыг уншихад орчуулгын бүтээл гэж хэлэмгүй, монгол хэлний яруу тансаг үгийн санг маш сайхан ашиглаж, үг сонголтыг зөв хийсэн байна. Үг сонголтын талаар Монгол Улсын хоёр орчуулгын үг хэллэг нь уран яруу, үгийн сонголт нь сайн байна.

Тус гурван орчуулга нь тус тусын үг хэллэг, өгүүлбэр, найруулгазүйн онцлогийг илтгэсэн байна. Өвөр Монгол орчуулга болон Монгол Улсын орчуулга нь хоорондоо үг хэлний хэрэглээ, сонголтын талаар нэлээд ялгаатай байгаа нь тодорхой ч, Монгол Улсын хоёр орчуулгын хооронд мөн илэрхий ялгаа байна. Эдгээр ялгаа нь орчуулагчийн хувь хүний орчуулах чадвараас шалтгаалах нь лавтай.

Холбоо үгийн онцлог

Хятад хэл нь Монгол улсын уншигчдад танил бус хэл учир хятад хэлний битүү утгатай үгийг орчуулахдаа уг зохиолын утгыг оноож орчуулахаар байна. Жишээлбэл: хятад хэлний “叉腰” гэх үгийг Өвөр монгол орчуулгад “сүвээгээ тулах” гэж орчуулаад, Б.Батын орчуулгад “нуруугаа үүрч” гэж орчуулсан байна. Ж.Артөрийн орчуулгад “ташаа тулан” гэж орчуулсан байна. Гурван орчуулга нь нэлээд зөрөөтэй болсон бөгөөд өөр өөрийн үйл хөдлөлийг зааж байдаг. Эдгээр орчуулгын оноолт нь нэг утгатай үг биш юм.

Хятад хэлний зарим нэр үгээр бүтсэн холбоо үгийг орчуулахдаа нэр үг ба үйл үгээр бүтсэн холбоо үг болгон хувиргасан үзэгдэл оршиж байна. Энэ нь гурван орчуулгад адилхан оршиж байгаа асуудал юм. Жишээлбэл “行状” гэх үгийг “өнгөрүүлсэн хэрэг” гэж орчуулсан байна.

Хятад хэлний нэг онцлог нь хоёр үгтэй холбоо үгээр утгын чимэг болгож болдог. Жишээлбэл, 孤孀 (бэлбэсэн) гэх үг нь шууд энгийн хэрэглээний үгээр бол 寡妇 (бэлбэсэн) гэх үг байж, утгын хувьд зөрөөгүй. Гэвч өмнөх нь утга зохиолын хэллэгийг улам чимэглэж өгдөг. Монгол хэлэнд ямар нэгэн утгыг гүнзгийрүүлэх буюу тодотгоход тусгай тодотгол авдаг, харин хятад хэлэнд өөр үгээр илэрхийлж болдог. Иймэрхүү үгийг орчуулахдаа, гурван монгол орчуулга цөм утгачилж орчуулсан байна. Утгачилж орчуулах нь уг зохиолын утгыг хадгалж чаддаг ч, хураангуйлж чадахгүй бол илүүц үг арвидаж, ойлгоход хүчир болдог.

Өгүүлбэрийн онцлог

Гурван орчуулгын өгүүлбэрийг харьцуулан авч үзвэл, зарим өгүүлбэрийн гишүүний байрлал нь өөр болсон байдал ажиглагдлаа. Жишээлбэл, Жао авгайн А-Кюг зандарч хэлсэн үгийг нийлмэл өгүүлбэрээр илтгэхдээ “...гэж зандрав. А-Кю дугарсангүй” гэдэг хоёр өгүүлбэрийг Б.Батын орчуулгад нийлмэл өгүүлбэр болгож “....гэж зандарсанд А-Кю дугарсангүй” гэж байршуулжээ. Үүнээс үүдээд хэлзүйн хувирал гарч хоорондоо ялгаатай болсон байна.

Гурван орчуулга харилцан адилгүй хэмжээгээр хятад үгэндээ баригдаж орчуулсан байдал илэрч байна. Үүнд Ж.Артөрийн орчуулга нь Хятад хэлэнд баригдаж орчуулсан нь бага байна. Ж.Артөрийн орчуулга нь монгол хэлний үгийн сангаар зохиолыг дахин бүтээжээ. Зохиолын утгыг маш сайн ойлгож утгыг үндэслэн өгүүлбэрийг цөм өөрийн хэв маягаараа орчуулжээ. Үүнээс гадна, уг зохиолын утгыг хадгалсан суурин дээр илүүц өгүүлбэрийг хасжээ. Б.Бат болон Өвөр Монголын орчуулга нь нэлээд их хэмжээнд хятад хэлний нөлөөнд автсан байна. Жишээлбэл:

Уг зохиол “然而要做这篇速朽的文章，才下笔，便感到万分的困难了”.

Ж.Артөр “харин энэхүү нас богинотой өгүүллээ бичье хэмээн бийрээ автал түмэн бэрхшээл учрах шиг санагдлаа”.

Өвөр монгол орчуулга “чингээд энэхүү үтэр балрах зохиолыг бичье гээд бийр барихтай зэрэг зүйл зүйлийн хүчир бэрх сэтгэгдэж эхэллээ”.

⁸² Ж.Артөрийн орчуулга. Лу Синь “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, Нэпко хэвлэлийн газар, 2019 он

Б.Бат “бас энэхүү нэгэн балрахад ойртсон түүхийг бичье гээд, сая бийрээ шүүрэн авмагц, сэтгэлийн дотор түмэн зүйлийн бэрхшээл сэтгэгдэв”.

Гурван зүйлийн орчуулгаас илэрсэн бас нэг онцлог гэвэл, аялгуу үгээс болсон өгүүлбэрийн ялгаа болно. Өвөр монгол орчуулгад хүний сэтгэлийн хөдөлгөөнийг тусгасан аялга үг өгүүлбэр харьцангуй цөөн, харин Б.Бат болон Ж.Артөрийн орчуулгад аялга үг дагуулсан өгүүлбэрийн хувийн жин нь их байна. Тухайлбал “хө, даа, үү, уу, ээ...” гэх мэтийн үгсийг арвин хэрэглэжээ.

Найруулгын талаас авч хэлбэл, эдгээр хоёр орчуулга нь зүйрлэл ба зүйрлэл бус, хүнчлэл ба хүнчлэл бус, орлуулал ба орлуулал бус, хэвшмэл хэллэгээр оноон орчуулсан эсэх, жич хятад хэллэгт нь баригдан орчуулсан эсэх дээр ялгаатай байна. Үүнд В-г бодвол А нь зүйрлэл, хүнчлэл, орлуулал, хэвшмэл хэллэг хэрэглэсэн нь харьцангуй цөөн байна. А-г бодвол В нь хүүрнэл болон дүрслэл хэрэглэн орчуулснаараа давамгайл.

Орчуулгуудын ялгаатай болсон шалтгаан

1. Адил бус улс төр, аж ахуйн орчны нөлөөлөл

Гурван зүйлийн монгол орчуулгад өөр өөрийн хэл хэллэгийн заншил, өөр өөрийн хэлэнд бүрэлдэж тогтсон бэлэн үг, өөр өөр уншигчдын хүлээн авах чадварт зохицсон хэв хэлбэрийг баримталсан нь үзтэл илхэн байна. Мөн энэ тал нь улс төрийн орчин тойрны нөлөөллөөс болоод хэлэнд ялгаа гарсан үзэгдлийг тодорхой харуулж байна.

Монгол, хятад хоёр улсын нийгэм, улс төрийн байгууллаас болж хэрэглэгдэж байгаа үг хэллэг нь тус тусын онцлогтой хөгжжээ. Мөн дээрх хэдэн жишээнээс Б.Батын орчуулгад “гацаан дарга”-ыг “газар тарианы даамал” гэж өөрөөр орчуулжээ. Орчуулгын үг сонголтын талаар иймэрхүү ялгаа илэрсэн нь тус тусын хэл хэллэгийн заншил, өөрийн хэлэн дэх бэлэн үг, уншигчдынхаа хүлээн авах чадвар зэргийн аль алиныг цөмийг нь харгалзах гэсэн зорилгоос болсон онцгой үзэгдэл биз ээ. Монгол Улс ба Өвөр Монголын улс төр, эдийн засгийн ялгаатай хөгжил нь хэл соёлын хөгжилд ихээр нөлөөлжээ. Энэ нь засаг захиргааны нэршлийн орчуулга дээр бас илэрч байна. Жишээлбэл, “地保” гэснийг Өвөр монгол орчуулгад “дарга” гэж орчуулаад, Б.Батын орчуулгад “даамал” гэж орчуулсан байна. “酒店” гэснийг Өвөр монгол орчуулгад “архины пүүс” гэж орчуулаад, Б.Батын орчуулгад “дарсны пүүс” гэж орчуулжээ. “中兴” гэх үгийг Өвөр монгол орчуулгад “дэгжрэл” гэж орчуулаад, Батын орчуулгад “мандал” гэж орчуулсан байна. Эдгээр орчуулга нь өөр өөрийн уншигчдадаа уг зохиолын утга агуулгыг бүрэн зөвөөр нь хүргэх гэсэн оролдлого юм.

2. Адил бус хэлний орчны нөлөөлөл

Мянгаад жилийн үсэг бичгийн түүхтэй Монголчууд онцгой түүхэн шалтгаанаас болоод өөр өөр хэлний орчинд оршин амьдарч ирчээ. Энэхүү хэлний орчин нөлөөллөөс болсон монгол хэлний хувирал нь хоёр зүйлийн монгол (уйгуржин ба кирилл) орчуулгын үг хэрэглээн дээр бас илэрсэн байна. Өвөр монголчууд нь хятад хэлээр гол болгосон олон хэлний орчинд ажиллаж амьдарч байна. Өвөр Монгол дахь монгол хэлний нутгийн аялгууг гурав хувааж байна. Үүнд, баруун аялгуу буюу ойрад аялгуу, дундад аялгуу, зүүн хойт аялгуу буюу барга буриад аялгуу гэх мэт. Улсын дотоод дахь монгол хэлний суурь аялгуу бол дундад аялгуу болно. Гэвч тариалах орон, хагас тариалах хагас малжих орон жич хөдөөнөөс хотод ирж амьдарч байгаа монголчуудын тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгааг дагаад хэлний орчинд хувиралт гарч, хятад хэлийг хэрэглэх Өвөр Монголчуудын тоо нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд монгол хэлний нийгмийн харилцааны үйлдэл ч суларч байгаа хандлагатай байна.

Иймэрхүү нийгэм хэл соёлын орчинд хятад хэлэнд нөлөөлөгдөж хятадаар сэтгэх, хятадыг авиачлан тэмдэглэх, хятадад баригдаж орчуулах үзэгдэл ихээр илэрч байна. “А-Кюгийн үнэн түүх”-ийн монгол орчуулгаас авч үзвэл, “掌柜” гэх үгийг Өвөр монгол орчуулгад “жангүйд” гэж орчуулаад, Монгол Улсын хоёр орчуулгад “эзэн” гэж орчуулсан байна. “洋钱” гэх үгийг Өвөр

монгол орчуулгад “янчаан” гэж авиачлан орчуулаад, Б.Батын орчуулгад “мөнгөн төгрөг” гэж орчуулжээ. Ж.Артөрийн орчуулгад “юань” гэж орчуулсан байна. “搭连” гэх үгийг Өвөр монгол орчуулгад “далиар” гэж орчуулаад, Б.Батын орчуулгад “хавтага” гэж орчуулсан байна. Ж.Артөрийн орчуулгад “юань” гэж орчуулсан байна. Монгол улс тусгаар тогтносны сүүлээр улс төр, аж ахуй, соёл, шинжлэх ухааны талаар ЗХУ-д суралцаж, бичиг үсгээ өөрчлөн, 1940-д оноос улсын сонин сэтгүүл албан бичигтээ кирилл бичгийг хэрэглэсэн байдаг. Гэвч Өвөр монголоос ялгаатай нь, Монгол улс халх аялгууг суурь болгон, монгол хэлний орчинд амьдарч байгаагаараа үгийн сан нь харьцангуй баялаг юм. Энэ нь монгол хэлийг зохих хэмжээгээр баяжуулсан боловч нөгөө талаар хэл аялгуу хоорондын нөлөөлөл нь Өвөр монгол болон Монгол улсын монгол хэлний хоорондох ялгааг улам тод болгожээ.

2. Адил бус соёлын орчны нөлөөлөл

Өвөр монгол болон Монгол улс хоёр эрт дээд үеэсээ үндэс угсаа нэгтэй боловч түүхэн шалтгаанаас болоод хоёр өөр замаар хөгжжээ. Өөрөөр хэлбэл, Монгол улс болон Өвөр монголд хоёр өөр соёлын орчин нөлөөлсөнд оршино. Монгол улс бол нүүдлийн мал аж ахуйн соёл голлодог болохоор түүний хэрэглэж байгаа үгсийн санд нь мал аж ахуйн соёлтой холбоо бүхий үгс харьцангуй их байдаг. Харин Өвөр монгол бол малжих соёл, хагас тариалах хагас малжих соёл, тариалах соёлын орчинд амьдран оршиж байдаг учир Өвөр монголчуудын хэрэглэж байгаа монгол хэл нь өөрийн хэрэглэж дадсан холбоо бүхий үгс нь харьцангуй хөгжжээ. “А-Кюгийн үнэн түүх”-ийн орчуулгын хэл нь энэ талыг тусгаж чадсан байна. Жишээлбэл, “算被儿子拿去了罢” гэх өгүүлбэрийг Өвөр монгол орчуулгад “хүүдээ булаагдчихлаа гэж бодъё” гэж орчуулсан байхад, Б.Батын орчуулгад “дүрсгүй хүүхдэдээ булаагдав гэж бодъё” гэж орчуулсан байна. Тус өгүүлбэрийн орчуулгын хувьд Б.Батын орчуулгад дүрсгүй хүүхэд гэж уг зохиолын утгыг үндэслэн үг нэмж орчуулсан байна. “有一年的春天” гэх өгүүлбэрийг Өвөр монгол орчуулгад “нэг жилийн хавар сан” гэж орчуулсан бол, Батын орчуулгад “нэг жилийн хаврын сайхан өдөр” гэж орчуулсан байна. Тус өгүүлбэрийн орчуулгад Б.Батын орчуулгад хаврын сайхан өдөр гэж чимэг нэмсэн нь монгол уран зохиолын яруу утгыг гүйцэд илтгэжээ. Үүнийг зөвхөн үгийн дундаж ба хүндэтгэлийн ялгаа гэж үзээд зогсохгүй, соёлын орчноос бий болсон үг гэж үзэлтэй.

Дүгнэлт

Тус өгүүлэлд, “А-Кюгийн үнэн түүх” зохиолын гурван зүйлийн монгол орчуулгын үг хэрэглэх, өгүүлбэр, найруулга зэрэгт дүн шинжилгээ хийж, харьцуулснаар Хятад улсын монголчууд болон Монгол улсын монголчуудын хэрэглэж байгаа монгол хэлний ялгаатай болсон шалтгааныг дурдан дэвшүүллээ.

Энэхүү өгүүллийн агуулга нь гурван орчуулгын хүрээ хэмжээнд л хязгаарлагдсан тул сэдэвлэн өгүүлсэн үг, өгүүлбэр, найруулгын жагсаан харуулсан жишээнүүд нь номоос ажиглагдан олсон материал төдий юм. Гурван монгол орчуулгын хэллэгийн ялгаатай болсон шалтгааныг соёлын өөр орчин, өөр өөр хэлний нөлөөллөөс шалтгаалан ялгаатай болж хувирсан хэлний үзэгдэл мөн гэж нотолж байна.

Орчуулагчийн ажил нь дээд хэмжээний хариуцлага шаардагдах нарийн ажил юм. Орчуулагч болсны хувьд бичиг материалыг сайтар уншин ойлгож, нарийн задлалт хийж байж сая орчуулгын ажилдаа орох хэрэгтэй. Өдөр ирэх тусам орчуулга шаардагдаж байгаа энэ цаг үед орчуулгын ажлын цөмийг атгаж, орчуулгын ажлыг зохион бичлэгийн ажилтай хавь төсөөдүүлэн, амьдлаг боловсронгуй болгох тулгам шаардлага тавигдаж байна. Тиймээс орчуулгын мэргэжлийн чадвартныг хүмүүжүүлж дадлагажуулах, орчуулгын мэргэжлийн сургалтыг чангатгах зэрэг тал дээр хүчээ чангатгаж, орчуулгын мэргэжлийг улам нэг алхам өргөтгөж орчуулагчийн эгнээг сайжруулах хэрэгтэй.

Ном зүй

- [1] Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хорооноос орчуулсан. Лү Шүний өгүүллэгийн түүвэр [М]. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо, 1974 он
- [2] Б.Бат. Х. Пэрлээ монголчилсон. А-Кюгийн үнэн түүх [М]. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр, 1952 он
- [3] Лу Синь. Галзуу хүний өдрийн тэмдэглэл [М]. Улаанбаатар: Нэпко хэвлэлийн газар, 2019 он
- [4] Мөнхбуян, Элсэнцэцэг Нийгмийн хэл шинжлэл [М]. Өвөр Монголын Хэвлэлийн Хороо, 2015 он
- [5] Боржгон Ганжууржав. Орчуулгын ёсон [М]. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 1999 он
- [6] Т.Цэнгэлт .Орчин цагийн хэл шинжлэлийн онолын сонгомол [М]. Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн Хороо, 2012 он
- [7] Рашдонров. Орчин цагийн монгол хэлний товч тайлбар толь [М] .Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо, 2000 он
- [8] Зоригт. Өвөр Монголын монгол хэлний хэрэглээний одоох байдлын тухай



Р.Х.БРАЙДЫН ХАЙКУ ШҮЛГИЙН ОРЧУУЛГЫН ТУХАЙ

Д.Будсүрэн⁸³

Abstract: Reginald Horace Blyth's Haiku, published in four volumes from 1949 to 1952, were anthologies of Japanese haiku. His books attracted the attention of many writers, most notably the Beat school poets such as Allen Ginsberg, Gary Snyder and Jack Kerouac mainly because of his assumption that the haiku was the poetic expression of Zen. The purpose of this paper is to examine how R. H. Blyth's translation of haiku was affected by his perception of haiku. First, it provides an overview of translations of haiku before Blyth in order to clarify characteristics of his translation. Next, it discusses his perception of haiku and features of his haiku translation. It concludes that Blyth's perception of haiku affected various aspects of his translation.

Түлхүүр үг: Хайку, найруулга, киго, орчуулгын онцлог, арга барил

Удиртгал

Режиналд Хорас Брайд 1949 – 1952 онд хайку шүлэг судлалын талаар дөрвөн боть бүтээлийг англи хэлээр хэвлүүлжээ. Энэ бүтээлийг нэр алдраа цуурайтуулсан Аллен Гинсберг, Гари Снайдер, Жек Керуак зэрэг яруу найрагч, зохиолчид уншин, хайку шүлгийг өргөн цар хүрээтэйгээр дэлхийд таниулахад томоохон үүрэг гүйцэтгэсэн юм.

Брайд хайку шүлэгт дорнын соёл, амьдралын хэв маяг агуулагдсан байдаг гэж үзээд хайку шүлгийн онцлог шинжийг бүтээлдээ тусгасан. Брайд энэ бүтээлээрээ хайку шүлгийн хэмнэл, бүтэц, киго буюу улирал илэрхийлсэн үгэнд анхаарлаа хандуулсан байдаг.

Тус өгүүллээр Брайдын хайку шүлгийн талаарх үзэл нь хайку шүлгийг англи хэл рүү орчуулахад хэрхэн нөлөөлж байсныг авч үзнэ.

Үндсэн хэсэг

Хайку шүлгийн анхны орчуулга

У.Ж.Астон, Б.Х.Чэмберлэйн нар хайку шүлгийг хамгийн анх орчуулж, өрнөдөд таниулсан байна. 1880 аад оны эхэн үед Астон, Чэмберлэйн нарын хайку шүлгийн орчуулга нь голчлон япон хэлний дүрмийн ном, хэл шинжлэлийн сурах бичигт хэвлэгдсэн байдаг. Астон хайку шүлгийн тухай “Үгийн хувьд маш хязгаарлагдмал арван долоон үетэй, шүлэгт оноосон нэр байдаггүй, хэт богино тул яруу найраг, шүлэг гэж үзэх боломжгүй юм” гэж үзэж байв. (伊東裕起, 2019:3)

Хайку шүлгийн орчуулгын хувьд тухайн бүтээлийн урлаг, уран сайхны үнэ цэнийг харуулахаас илүүтэйгээр үгчлэн орчуулах хандлагатай байжээ.

1902 онд Чэмберлэйн “Башёо ба Японы яруу найргийн эпиграм” гэх өгүүллээ Asiatic Society of Japan сэтгүүлд нийтлүүлсэн. Хожим 1910 онд хэвлэгдсэн “Японы яруу найраг”

⁸³ ҮБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төв

номынхоо нэг бүлэг болгон оруулсан байдаг. Энэ өгүүллийн гол онцлог бол хайкү шүлгийг эпиграм, харин хайкү шүлэгчийг эпиграматист гэж нэрлэсэн.

Чэмберлэйн хайкү шүлгийг урлаг, уран сайхны талаас нь үнэлж байлаа. Тэрээр хайкү шүлгийг бие даасан шүлгийн төрөл гэж үзээгүй байж магадгүй юм.

Учир нь **а.** Чэмберлэйн хайкү шүлгийг орчуулахдаа тухайн хайкү шүлгийн тайлбарыг хаалтанд хийн нэмэлтээр оруулсан байдаг. Жишээ нь: Хаттори Рансэцүгийн хайкүг дараах байдлаар орчуулжээ. (伊東裕起, 2019:7)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга Б.Х.Чэмберлэйн	Монгол орчуулга Д.Будсүрэн
うめいちりん 梅 一輪 いちりん 一輪ほどの あたたかさ	Ү-мэ и-чи-ри-н И-чи-ри-н хо-до-но А-та-та-ка-са	[Slowly] it mildens, as the plum [Ventureth forth,] blossom by blossom.	Чавганы модны цэцэг Нэг нэгээр цэцэглэх нь Урин дулаан

б. Өрнөдийн шүлэг тодорхой хэмжээний шүлгийн мөртэй, шүлэгт тохирсон нэртэй, толгой холбох, сүүл холбох гэх мэт хэмнэлтэй байдаг. Харин хайкү шүлэгт эдгээр нь байхгүй. Хайкү шүлгийн эртний грек хэлнээс гаралтай үг болох эпиграм гэж нэрлэсэн. Хэрэв хайкү шүлгийг бие даасан шүлэг гэж үзсэн бол энэ үгийг ашиглахгүй байсан болов уу.

1930 – аад оны эхэн үеийн хайкү шүлгийн орчуулга

1930 – аад онд Брайдын хайкү шүлгийн орчуулгад нөлөөлсөн хоёр бүтээл хэвлэгдсэн байна.

1. 1930 онд хэвлэгдсэн Миямори Асатарогын “An Anthology of Haiku”
2. 1933 онд Х.Г.Хэндersonы “The Bamboo broom”

Миямори Асатаро бол Кэйо их сургуулийн англи хэл, утга зохиолын профессор бөгөөд японы нэлээд хэдэн уран зохиолыг англи хэл рүү орчуулан хэвлүүлж байжээ.

Хэндerson дайны дараа хайкү шүлгийн талаар хэд хэдэн бүтээл гаргажээ. Харин “The Bamboo broom” нь түүний хамгийн анхны бүрэн хэмжээний ном юм.

1900 –аад оны хайкү шүлгийн орчуулгаар Японы соёл, япон хэлийг түлхүү тайлбарласан байдаг. Харин дээрх хоёр бүтээл нь хайкү шүлэгт тулгуурлан бүтээгдсэн байдаг. Мөн Миямори, Хэндerson нар хайкү шүлэг нь эпиграм гэсэн үзлийг үгүйсгэсэн байдаг. Миямори Асатарогын 841 хуудастай бүтээлд асар олон тооны хайкү шүлэг байдаг.

Миямори бүтээлийнхээ эхний хэсгийг “Хайкү болон Эпиграм” гэж гарчиглан, Европ болон АНУ-д хайкү шүлгийг эпиграм гэж үздэг хэдий ч хайкү шүлэг эпиграмаас ялгаатай, бие даасан шүлэг юм гэдгийг тайлбарлан бичсэн байдаг.

Хэндerson мөн бүтээлдээ хайкү бол шүлгийн нэг төрөл юм. Хайкү шүлгийг эпиграм гэж үзэх буруу ойлголт гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.

Ийнхүү дээрх хоёр бүтээлээр хайкү шүлгийг эпиграмтай адилтган үзсэн Чэмберлэйний үзлийг үгүйсгэн, хайкү шүлэг бол бие даасан шүлгийн нэг төрөл юм гэдгийг онцолсон байдаг билээ.

Р.Х.Брайдын хайкү шүлгийн орчуулга

1. Р.Х.Брайд хайкү шүлгийн тухай

Р.Х.Брайдын “Хайкү” дөрвөн боть, 1300 –аад хуудастай, нэгдүгээр бүлэг “Хайкү шүлгийн оюун санааны үндэс”, хоёрдугаар бүлэг “Эн, Хайкү шүлэг дэх оюун ухааны илрэл”, гуравдугаар бүлэг “Хайкү болон Шүлэг”, дөрөвдүгээр бүлэг “Хайкү шүлгийн дөрвөн их найрагч”, тавдугаар бүлэг “Хайкү шүлгийн арга барил” гэсэн таван бүлгээс бүрддэг.

Брайдын хайкү шүлгийн талаарх үзэл бодол нь түүний “Хайкү” нэгдүгээр ботийн оршил хэсэгт байх “Хайкү шүлэг бол дорнын соёлын цэцэг, амьдралын хэв маяг юм. Хайкү шүлгийг Зэнийн өнцгөөс ойлгож, таних хэрэгтэй” гэсэн байдаг. (Blyth, 1981:3)

Дорнын соёл, мөн Зэн гэх өнцгөөс хайкү шүлгийг ойлгох хэрэгтэй гэсэн санаа нь “Хайкү” дөрвөн ботид удаа дараа дурдагдсан байдаг. Энэ нь Миямори болон Хэндerson нарын бүтээлд дурдагдаагүй Брайдын өөрийнх нь онцлог шинж байсан юм. Тэрээр дорнын соёл болон Зэнийн тухай ойлголтыг “Хайкү” нэгдүгээр ботийн нэгдүгээр бүлэгт дорнын соёл, хоёрдугаар бүлэгт Зэнийн тухай нэлээн дэлгэрэнгүй бичсэн байна.

Эхний боть 393 хуудастай, үүний нэгдүгээр бүлэг нь 154 хуудас буюу номын 40 орчим хувь эзэлсэн байдаг. Хоёрдугаар бүлэг нийт номын дөрөвний нэг буюу 93 хуудаснаас бүрддэг.

Нэгдүгээр бүлэгт дорнын соёлын үндэс болох Буддизм, Зэн, Даосизм, Хятадын яруу найраг, Күнзийн сургаал, Дорнын урлаг, Вака, Рэнкү, Чадвар-Икэбана-Чя но Ю, Шинто гэх дэд бүлгээр хайкү шүлэгтэй холбон тайлбарласан байна.

Хоёрдугаар бүлэгт хайкү шүлгийг Зэнтэй холбон бичсэн байдаг. Зэнийн онцлог шинжийг тодотгосон Амин хувиа хичээхгүй байх, Ганцаардал, Талархах, Үтгүй байх, Зөрчилтэй байдал, Шог хошин байдал, Эрх чөлөө, Эгэл байдал, Хайр, Зориг зэрэг арван гурван сэдвийг дэвшүүлжээ. Брайд эдгээр арван гурван сэдэв тус бүрийн онцлог шинжийг утга зохиолын бүтээлүүдэд шингээсэн юм.

“Хайкү” бүтээлд Зэнийг хоёр утгаар авч үзсэн байдаг. Нэгд. Энэтхэг улсад үүсэн Хятад улсаар дамжин Япон улсад нэвтрэн үр өгөөжөө өгсөн буддын шашны нэгэн сургаал, Хоёрт. Нэгэн төрлийн оюун санаа, сэтгэлгээний байдлыг хэлжээ.

Ийнхүү Зэнийн утгыг харахад, Брайдын хувьд хайкү шүлэг нь юм үзэгдэл, бие хүн бүгд өөр хоорондоо адил, нэг нэгнээсээ хамааралтай, харин хувь хүн болон аливаа зүйл өөрийн гэсэн онцлог шинж, дотоод сэтгэлгээ, янз байдалтай юм гэж үзжээ.

2. Р.Х.Брайдын хайкү шүлгийн орчуулгын онцлог

Брайд хайкү шүлгийн оюунлаг байдлыг эрхэмлэн, нэгдүгээр ботийн талаас илүү хувийг дорнын соёл, сэтгэлгээ болон Зэнийн талаар тайлбарлан бичсэн байдаг. Мөн хайкү шүлгийн бүтэц болон онцлог бүхий кирэжи, киго буюу улирал илэрхийлсэн үг, япон хэлний онцлог зэргийг нэгдүгээр ботийн тавдугаар бүлэгт 36 хуудсанд багтаан тусгасан байна.

Үүнээс үзэхэд, Брайд хайкү шүлгийн арга барил, бүтцийг үл тоомсорлоогүй ч хайкү шүлгийн сэтгэлгээ, оюунлаг байдлыг илүү чухалд авч үзэж байжээ. Брайдын хайкү шүлгийн орчуулгаас хэд хэдэн онцлог шинж ажиглагддаг.

Нэгдүгээрт. Хайкү шүлгийг гурван мөр болгон орчуулдаг. Энэ нь хайкү шүлгийн бүтэц 5 – 7 – 5 үеийг баримталсан байдаг. Ингэж орчуулах нь Брайдын орчуулгын онцлог гэхээс илүүтэйгээр анхлан хайкү шүлгийг орчуулан дэлхийд таниулсан В.Ж.Астон тэргүүтэй орчуулагчдын туршлагаас улбаатай болов уу. Хайкү шүлгийг яагаад гурван мөрт болгон орчуулдаг тухай тодорхой тайлбар байдаггүй.

Брайд бүтээлдээ Миямори Асатарогийн “An Anthology of Haiku” болон Хэндersonы “The Bamboo Broom” гэх хоёр бүтээлийг танилцуулсан байдаг. Энэ хоёр ном нь Брайдад хүчтэй нөлөө үзүүлсэн гэж болно.

Миямори хайкү шүлгийг хоёр мөр болгон орчуулсан байдаг. Харин Хэндerson хайкү шүлгийг гурван мөрт болгон орчуулсан байдлаас харахад, Хэндersonы ном болон орчуулгын арга барил Брайдад илүү хүчтэй нөлөөлж байсныг илтгэж байна.

Хоёрдугаарт. Хайкү шүлгийн орчуулгыг ажиглахад хоёр дахь мөрийг нэг болон гурав дахь мөрнөөс арай олон үгээр орчуулсан байдаг. Мөн хоёр дахь мөрийг нэг болон гурав дахь мөртэй үгийн тоогоор тэнцүү орчуулсан. Ингэж орчуулсан хайкү шүлэг олон байдаг.

Тухайлбал: Рёокан Тагүгийн дараах хайкү шүлгийн хоёр дахь мөр хамгийн богино буюу хоёрхон үгээр орчуулсан байдаг.

(Blyth, 1981:182)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
たふるれは たふるるままの にわ くさ 庭の草	Та-хү-рү-рэ-ва Та-хү-рү-рү-ма-ма-но Ни-ва-но-кү-са	The grasses of the garden,-- They fall, And lie as they fall.	Будран унах Будран бударсаар Цэцэрлэгийн өвс

Мацүо Башёогийн дараах хайкү шүлгийг гурван мөрөөр хоёр үгээр орчуулсан байдаг.
(Blyth, 1981:179)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
うき ^{われ} 我を さび ^{さび} 淋しがらせよ かん ^{どり} こ鳥	Ү-ки-ва-рэ-о Са-би-ши-га-ра-сэ-ё Ка-н-ко-до-ри	Ah, kankodori, Deepen thou My loneliness.	Ганцаардмал намайг Гунигт автуулах Канго шувуу!

Мацүо Башёогын дараах хайкү шүлгийн гурван мөр тус бүрийг гурван үгээр орчуулсан байна. (Blyth, 1981:172)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
こ ^{みち} の道や ゆ ^{ひと} 行く人なしに あき ^{くれ} 秋の暮	Ко-но-ми-чи Юү-кү-хи-то-на-ши-ни А-ки-но-кү-рэ	Along this road Goes no one, This autumn eve	Энэ замаар Явах хүнгүй Намрын үдэш

Чёорагын дараах хайкү шүлгийг гурван мөр тус бүр уртаар орчуулсан байдаг. (Blyth, 1981:102)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
くれ ^{たけ} 呉竹の よよにあふひの まつりかな	Кү-рэ-та-кэ Ё-ё-ни-а-хү-хи-но Ма-цү-ри-ка-на	Today, the Aoi Festival: We greet again the many-jointed bamboos, Generation after generation.	Хулс модны Үеийн үед уулзах өдөр Наадам юм

Энэ мэтчилэн хайкү шүлгийг орчуулахад мөрийн урт богиныг тэнцүүлнэ гэсэн тогтсон ойлголт байхгүй. Хайкү шүлгийн 5 – 7 – 5 гэсэн бүтцийг баримтлан орчуулах нь боломжгүй юм. Энэ нь япон хэлний онцлог, соёл, аж амьдралтай шууд холбоотой.

Гуравдугаарт. Англи яруу найргийн бүтэц, шүлэгт баримтлах арга барил, тогтсон уламжлалт аргыг хайкү шүлгийг орчуулахдаа баримтлаагүй. Үүний нэг жишээ бол хайкү шүлэгт нэр өгөн орчуулаагүй явдал юм.

Японы богино шүлгийн төрөл болох вака шүлэгт оноосон нэр гэж байдаг бол хайкү шүлэгт оноосон нэр гэж байдаггүй. Учир нь хайкү шүлгийн утга санааг оноосон богино үгээр илэрхийлэх боломжгүй гэж үзсэн болов уу.

Брайд “Хайкү шүлэг бол өөрийгөө устгах, үнэний үггүй дуу юм.” гэж хэлсэн байдаг. (Blyth, 1981:117) “Үгээр илэрхийлэх боломжгүй”, “Өөрийгөө устгах” гэх үг нь Зэнийн онцлог шинж болох аливаа зүйлийг үгээр илэрхийлэхгүй сэтгэл, оюун бодлоороо холбогдох, мөн би гэх үзлээс ангижрах гэсэн үзэлтэй холбоотой.

Хайкү шүлгийг орчуулахдаа нэр өгөөгүй нь Зэнийн үзэл баримтлалаас хайкү шүлгийг ойлгох хэрэгтэй гэсэн санаа хүчтэй нөлөөлснийг үзүүлж байна.

3. Киго буюу улирал илэрхийлсэн үг

“Хайкү” дөрвөн ботийн хоёрдугаар боть “Хавар”, гуравдугаар боть “Хавар”, “Зун”, дөрөвдүгээр боть “Намар”, “Өвөл” гэж боть тус бүрт дөрвөн улирлыг тусгасан байдаг.

Хайкү шүлгийн ^{さいじき} 歳時記 буюу улирал илэрхийлсэн түлхүүр үгийг улирлаар дэлгэрэнгүй судалсан анхны гадаад хүн бол Брайд юм.

“Хайкү” номын нэгдүгээр ботийн тавдугаар бүлэг “Хайкү шүлгийн арга барил” –д хайкү шүлгийн улирал илэрхийлсэн үг гэсэн дэд бүлэг байдаг. Энэ дэд бүлэг нь дөрвөн хуудас хагасаас бүрдсэн. Үүнд “Ихэнх хайкү шүлэгт улирал илэрхийлсэн түлхүүр үг байдаг. Хайкү шүлэгт улирал илэрхийлсэн түлхүүр үг чухал үүрэг, ач холбогдолтой. Гэсэн хэдий ч улирал илэрхийлсэн түлхүүр үггүй хайкү шүлэг бас байдаг. Улирал илэрхийлсэн үг нь хайкү шүлэгт заавал тусгагдсан байх шаардлагатай гэсэн үг биш юм.” гэжээ. (Blyth, 1982:351)

Дараах хайкү шүлгүүд киго буюу улирал илэрхийлсэн үггүй хайкү шүлгийн төлөөлөл юм. Улирал илэрхийлсэн үггүй Иссагийн дараах хайкү шүлгийн орчуулга. (Blyth, 1982:336)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
つきはな 月花や よん じゅう きゅう ねん 四 十 九 年 の むだあるき	Цү-ки ха-на-я Ши-жюү-кюү-нэ-н-но Мү-да а-рү-ки	The moon and flowers: Forty nine years Walking about wasting time.	Сар, цэцэг ээ Дөчин есөн жилийн Үр бүтээлгүй алхалт

Мацүо Башёогийн улирал илэрхийлсэн үггүй хайкү шүлгийн орчуулга. (Blyth, 1982:336)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
むさしの 武蔵野や さわるものなき きみ かさ 君の笠	Мү-са-ши-но-я Са-ва-рү мо-но на-ки Ки-ми-но-ка-са	The Great Musashi Plain ; There is nothing To touch your kasa.	Мүсашино Саад болох зүйлгүй Чиний каса

Брайд хайкү шүлгийн кигог улирал илэрхийлсэн үг гэж тайлбарлаагүй. Харин хайкү шүлэг дэх улирлын үгс гэж тайлбарласан байгаа нь кигог хайкү шүлгийн онцлог, мөн чанарыг илэрхийлсэн гол үг гэж тодотгож үзээгүй мэт харагдаж байна.

Брайд англи хэлээр бичсэн хайкү шүлгийн тухайд: Англи хэлээр бичих хайкү шүлэгт кигог тусгаж өгөх шаардлагагүй гэдгийг нь цохон тэмдэглэжээ. (Blyth, 1982:351)

Энэ үгээрээ хайкү шүлгийг англи хэл рүү орчуулахад кигод төдийлөн ач холбогдол өгөөгүй мэт ойлгогдож байгаа ч үнэн хэрэгтээ тийм биш юм. Тэрээр “Хайкү” номынхоо хоёр, гурав, дөрөвдүгээр ботийг дөрвөн улиралд хуваан улирал илэрхийлсэн түлхүүр үгийн ач холбогдол, хайкү шүлэгт киго хэрхэн чухал үүрэгтэйг харуулсан олон хайкү шүлгийг орчуулсан байдаг. Дараах хайкү шүлгүүд нь хаврын улирлыг илтгэсэн байдаг. (Blyth, 1981:361)

Япон эх шүлэг (Мацүо)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
がんちょう 元朝や かみよ 神代のことも おもはるる	Га-н-чө-ү-я Ка-ми-ё-но-ко-то-мо О-мо-ва-рү-рү	It is New Year's morning I think also of the Age Of the God	Шинэ жилийн өглөө Камиёгийн талаар ч Бодох

(Blyth, 1981:572)

Япон эх шүлэг (Рансэцү)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
うめいちりん 梅 一輪 いちりん 一輪ほどの あたたかさ	Ү-мэ и-чи-ри-н И-чи-ри-н хо-до-но А-та-та-ка-са	Another blossom of the plum, And that amount More warmth	Чавганы модны цэцэг Нэг нэгээр цэцэглэх нь Урин дулаан

(Blyth, 1981:570)

Япон эх шүлэг (Бүсон)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
はるさめ 春雨や く 暮れなんとして けふもあり	Ха-рү-са-мэ-я Кү-рэ-на-н-то-ши-тэ Кэ-хү-мо-а-ри	Spring rain; It begins to darken; Today also is over.	Хаврын бороо Харанхуйлж Өнөөдөр ч бас

(Blyth, 1981:578)

Япон эх шүлэг (Оницүра)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
春の水 ところどころに 見ゆるかな	Ха-рү-но-ми-зү То-ко-ро до-ко-ро-ни Ми-юү-рү-ка-на	Here water, And there water, The waters of spring.	Хаврын ус Энд тэнд Харагдана

Дараах хайкү шүлгүүд нь зуны улирлыг илтгэсэн байдаг. (Blyth, 1982:657)

Япон эх шүлэг (Шики)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
すず 涼しさや あおた なか 青田の中に ひと まつ 一つ松	Сү-зү-ши-са-я А-о-та-но-на-ка-ни Хи-то-цү-ма-цү	The coolness of it In the middle of a green rice – field, A single pine-tree!	Сэрүүхэн Ногоорох тариалангийн талбайд Ганц нарс

(Blyth, 1982:669)

Япон эх шүлэг (Исса)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
なに 何もないが こころやす 心 安さよ すず 涼しさよ	На-ни-мо-на-и-га Ко-ко-ро-я-сү-са-ё Сү-зү-ши-са-ё	I have nothing at all, - But this tranquility! This coolness!	Юу ч байхгүй ч Сэтгэлийн амар амгалан Сэрүүхэн

(Blyth, 1982:848)

Япон эх шүлэг (Бүсон)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
あさ まやま 浅間山 けむり なか 煙 の中の わかば 若葉かな	А-са-я-ма Кэ-мү-ри-но-на-ка-но Ва-ка-ба-ка-на	Mount Asama; Through the smoke Young leaves appearing.	Асама уул Утаан дунд Зулзаган навч

(Blyth, 1982:717)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
かねもち 金持も	Ка-нэ-мо-чи-мо Кү-ма-мо ки-тэ-но-мү	Millionaires,	Баян хүн ч Баавгай ч ирээд уух

Орчуулгазүй - IX

くま き 熊も来てのむ しみずかな 清水哉	Ши-ми-зү-ка-на	Come and drink of this clear water, And bears.	Цэнгэг ус
--------------------------------	----------------	---	-----------

Дараах хайкү шүлгүүд нь намрын улирлыг илтгэсэн байдаг. (Blyth, 1981:909)

Япон эх шүлэг (Бүсон)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
ちちはは 父母の ことおもふ 事のみ思ふ あきくれ 秋の暮	Чи-чи-ха-ха-но Ко-то-но-ми-о-мо-хү А-ки-но-кү-рэ	It is evening, autumn; I think only Of my parents.	Аав ээжийн Тухай л бодох Намрын үдэш

(Blyth, 1981:927)

Япон эх шүлэг (Нангай)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
よなか 世の中の ものかげより もの影より つき けふの月	Ё-но-на-ка-но Мо-но-но-ка-гэ-ё-ри Кэ-хү-но-цү-ки	From the shades Of all things on earth, - Today's moon.	Ертөнцийн Юм үзэгдлийн тусгалаас Өнөөдрийн сар

(Blyth, 1981:889)

Япон эх шүлэг (Шики)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
くさばな 草花を えにつか 書がく日課や あきい 秋に入る	Кү-са-ба-на-о Э-га-кү-ни-к-ка-я А-ки-ни-и-рү	Entering autumn, The painting of flowering plants A daily task.	Цэцэгт ургамлыг Зураглах өдрийн хэмнэл Намар болох

(Blyth, 1982:893)

Япон эх шүлэг (Бүсон)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
びんぼう 貧乏に つい 追ひつかれけり あき けさの秋	Би-м-бо-ү-ни О-и-хи-цү-ка-рэ-кэ-ри Кэ-са-но-а-ки	Overtaken By poverty, This autumn morning	Ядуу тарчигт Гүйцэгдэх Намрын өглөө

Дараах хайкү шүлгүүд нь өвлийн улирлыг илтгэсэн байдаг. (Blyth, 1982:1142)

Япон эх шүлэг (Кёкүсүи)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
さむよ 寒き夜や うみおこ 海に落ち込む たきおん 瀧の音	Са-мү-ки-ё-я Ү-ми-ни-о-чи-ко-мү Та-ки-но-о-то	The sound of a waterfall Falling down into the sea The winter night is cold.	Хүйтэн орой Далайд цутгах Хүрхрээний чимээ

(Blyth, 1982:1146)

Япон эх шүлэг (Шики)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
ははふたり 母と二人 いもうと 妹をまつ	Ха-ха-то-хү-та-ри И-мо-то-о-ма-цү Са-мү-са-ка-на	Mother and I Waited for my younger sister; The night was cold.	Ээжтэйгээ Охин дүүгээ хүлээнэ Хүйтэн байна

さむ 寒さかな			
------------	--	--	--

(Blyth, 1982:1155)

Япон эх шүлэг (Эцүжин)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
ゆくとし 行年や おや しらが 親に白髪を かく 隠しけり	Юү-ки-то-ши-я О-я-ни-ши-ра-га-о Ка-кү-ши-кэ-ри	The departing year; I hid my grey hairs From my father.	Улиран өнгөрөх жил Эцгээс буурал үсээ Нууя

(Blyth, 1982:1173)

Япон эх шүлэг (Башёо)	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
たびびと 旅人と わ よ 我がな呼ばれむ はつ しぐれ 初時雨	Та-би-би-то-то Ва-га-на-ё-ба-рэ-н Ха-цү-ши-гү-рэ	The first winter rain, And my name shall be called, “Traveller.”	Аянчин гэж Намайг дуудах Өвлийн анхны бороо

Брайд англи хэлээр бичсэн хайкү шүлэгт киго зайлшгүй шаардлагатай биш гэж үзсэн ч япон хэлээр бичсэн хайкү шүлэгт кигогийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн нь дээрх хайкү шүлгийг сонгон орчуулснаас харагдаж байна.

4.Шүлгийн утга, найруулгад анхаарсан байдал

Брайд 5 – 7 – 5 гэсэн бүтэцтэй хайкү шүлгийг гурван мөрт болгон орчуулжээ. Мөн хайкү шүлгийн чухал онцлог шинж болох киго нь хайкү шүлгийн утга санааг улам гүн гүнзгий болгодог арга барил, ухаан гэж үзсэн.

Эх хайкү шүлэгт аж амьдралын хэв маяг, соёл, уламжлал нэвт шингэсэн байдаг. Шүлгийн санааг орчуулгад тусган өгөх нь хамгийн чухал зүйл ч соёлын ялгаа, амьдралын хэв маягаас шалтгаалан бүрэн гүйцэд ойлгогдохгүй, нэмэлт тайлбар шаардсан хайкү шүлэг олон юм.

Брайд эх хайкү шүлгийн юуг чухалчилж, орчуулгадаа юуг тусгахыг зорьсон бол?. Брайд эх хайкү шүлгийн эхний таван үе, дунд долоон үе, сүүл таван үеийг гурван мөр болгон, эх шүлгийн бичлэгийн дэс дарааллыг зургаан янзаар өөрчлөн англи хэлээр уншихад илүү ойлгомжтой болгон орчуулсан байдаг.

Дараах зургаан янзын орчуулгын бүтцээр ангилжээ.

1. Дээд тав, дунд долоо, доод тав гэсэн эх хайкү шүлгийн бүтцээр орчуулах.
2. Дээд тав, доод тав, дунд долоо гэсэн эх хайкү шүлгийн бүтцээр орчуулах.
3. Доод тав, дунд долоо, дээд тав гэсэн эх хайкү шүлгийн бүтцээр орчуулах.
4. Доод тав, дээд тав, дунд долоо гэсэн эх хайкү шүлгийн бүтцээр орчуулах.
5. Дунд долоо, доод тав, дээд тав гэсэн эх хайкү шүлгийн бүтцээр орчуулах.
6. Дунд долоо, дээд тав, доод тав гэсэн эх хайкү шүлгийн бүтцээр орчуулах.

Тухайлбал Мацүо Башёогийн дараах хайкү шүлгийг дээд тав, доод тав, дунд долоо гэсэн бүтцээр орчуулжээ. . (Blyth, 1982:57)

Япон эх шүлэг	Монгол галиг	Англи орчуулга (Р.Х.Брайд)	Монгол орчуулга (Д.Будсүрэн)
しず 静けさや いわ 岩にしみいる	Ши-зү-кэ-са-я И-ва-ни-ши-ми-и-рү Сэ-ми-но-ко-э	The silence; しず 静けさや	Нам гүм байдал Хадан цохионд шингэн Царцаа дуугарах

せみ こえ 蟬の声		The voice of the cicadas せみ こえ 蟬の声	
		Penetrates the rocks. いわ 岩にしみいる	

Брайд хайкү шүлгийг ингэж орчуулснаар англи хэлээр унших уншигчдад илүү ойлгомжтой болгож өгчээ. Энэ нь эх хайкү шүлгийн утга санааг бүрэн гүйцэд гаргахыг зорьсонтой холбоотой юм. Шүлгийн утга санааг тодруулж өгөхийн тулд эх шүлгийн бүтцийг өөрчлөн орчуулах нь дорнын болон өрнийн хэл, өгүүлбэрийн бүтэцтэй шууд хамааралтай юм.

Дүгнэлт

Өрнөдийн ихэнх судлаачид 1900 оноос өмнө хайкү шүлгийг хэт богино, шүлэгт оноосон нэр гэж үгүй, бие даасан яруу найраг, шүлгийн нэгэн төрөл гэж хүлээн зөвшөөрдөггүй байсан юм.

1930–аад оны үеэс хайкү шүлэг нь дорнын яруу найргийн нэгэн төрөл юм гэдгийг онцлон тэмдэглэж, чухалчилж үзсэн байдаг.



Брайд хайкү шүлгийг “шүлэг” гэсэн утгаар бус “Хайкү шүлэг бол дорнын соёлын цэцэг, амьдралын хэв маяг юм. Хайкү шүлгийг Зэнийн өнцгөөс ойлгож, таних хэрэгтэй.” гэсэн байдаг. (Blyth, 1981:3) Брайд “Хайкү” номондоо хайкү шүлэг болон Зэн хоёр нь харилцан холбоотой салшгүй зүйл гэдгийг харуулахыг зорьсон.

“Хайкү” номын “Хайкү ба Шүлэг” гэх гуравдугаар бүлэгт “Хайкү бол шүлэг биш. Утга зохиол ч биш.” гэж бичсэн билээ. Хайкү шүлгийг дорнын соёлын цэцэг гэж үздэг Брайд хайкү шүлгийн орчуулгад өрнийн яруу найргийн онцлог хэв шинжийг тусгаагүй. Тухайлбал: Орчуулсан хайкү шүлэгтээ нэр өгөөгүй.



Брайд хайкү шүлгийн 5 – 7 – 5 бүтцийг гурван мөр болгон, англи хэлээр ойлгоход илүү хялбар болгох үүднээс мөрийн дэс дарааллыг өөрчлөн орчуулсан байдаг. Ингэснээр хайкү шүлгийг орчуулахад шүлгийн утга санааг бүрэн тод гаргах үүднээс тав, долоо, тав гэсэн үндсэн бүтцийг өөрчлөн орчуулж болдог байна.

Ном зүй

1. 伊東裕起. (2019), 英語圏における俳句の受容史の概観, 東京. 城西大学語学教育センター研究年報
2. 松本隆志. (2017), ロシア象徴派と日本短詩型文学, 東京. 早稲田大学多元文化学会
3. Blyth, R. H. (1981). Haiku. Volume I. Tokyo: The Hokuseido Press.
4. Blyth, R. H. (1981). Haiku. Volume II. Tokyo: The Hokuseido Press.
5. Blyth, R. H. (1982). Haiku. Volume III. Tokyo: The Hokuseido Press.
6. Blyth, R. H. (1982). Haiku. Volume IV. Tokyo: The Hokuseido Press.



ОРЧУУЛГЫН САН ХӨМРӨГ





ЧОСӨНЬ-ИЙ ХЭВЛЭЛ МЭДЛЭГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ МОНОПОЛЬЧИЛСОН НЬ

Солонгос хэлнээс орчуулсан Г.Эрдэнэчимэг⁸⁴

Хорвоо ертөнцийн тухай хүн төрөлхтний мэдлэг нь хэл яриагаар биежиж байж, сая утга учиртай болно. Гэхдээ хэл яриа замхран алга болдог. Түүнээс сэргийлэхийн тулд мэдлэгийг хадгалж болохоор биет хэлбэрт оруулах хэрэгтэй. Тэр нь мод, чулуу, төмрийн алинаар ч хийсэн зүйл байж болно. Компьютерийн диск ч байж болно. Гэхдээ хүн төрөлхтний зохион бүтээсэн хамгийн авсаархан, хэрэглэхэд амар, мэдлэгийн биет хэлбэр бол цаасан ном юм. Түүнийг дуурайлган цахим ном хийсэн ч цаасан номтой адил хэрэглэхэд амар хялбар бус.

Цаасан номыг зохион бүтээснээр мэдлэгийг биет хэлбэрт оруулж, хадгалах боломжтой болгосон бөгөөд эргэлтэнд оруулахад ч хялбар болжээ. Номыг зохион бүтээснээс хойш мэдлэгийн ихэнхи хэсгийг цаасан ном болгоод эргэлтэнд оруулсан юм. Цаасан номын доторхи мэдлэгийг хүний тархинд хувилаад адилхан мэдлэгтэнгүүдийг бий болгов. Нэн шинэ түүхээс өмнөх үед чухамдаа гагцхүү ном л хүн төрөлхтнийг мэдлэгжүүлэх цор ганц хэрэгсэл байлаа.

Одоо Чосөнь-ий ном хэвлэл болон мэдлэгийг хэрхэн эргэлтэнд оруулдаг байсан талаар товч өгүүлбэр. Юуны өмнө Чосөнь-ий үед өргөн хэрэглэх болсон хорголжин хэвлэлийн талаар авч үзнэ.

Хорголжин хэвлэл ба сэдэв⁸⁵

Бүр Корйө-гийн үед цутгамал үсэг бүтээчихсэн байлаа. Гэхдээ түүнийг хэр өргөн хэрэглэсэн, түүгээр ямар ном судар хэвлэсэн зэргийг мэдэх баримт баталгаа төдий их бус. Чосөнь-ий үед өргөн хэрэглэх болсон гэдэг нэг зүйл л тодорхой байна. Мөн бидний бодсоноос эсрэгээр, өөрөөр хэлбэл, нэг номыг цөөн тоогоор хурдан хэвлэхэд сайн гэж үзээд сонгосон арга байжээ. Хачирхалтай хэдий ч бичиг номыг олон тоогоор олшруулах арга нь модон бар байлаа.

1234-1241 оны хооронд, анх удаа цутгамал үсэг ашиглан “Эрт эдүгээгийн хэв ёсны бичиг”-ийг ердөө 28 хувь хэвлэсэн нь үүнийг батлана. Бидний үед уламжлагдан ирсэн, хорголжин хэвлэлийн хамгийн эртний судар болох “Чигжи шимгйөн”⁸⁶-ийг мөн л буддын сүмд цөөн тоогоор хэвлэсэн байна. Энэ хоёр жишээнээс харахад хорголжин хэвлэлийг вант төр, эсвэл сүм хийд эзэмшиж байжээ. Хожим Чосөнь-ий үед ч эгэл жирийн хүн түүнийг өмчлөх нь тун ховор байсан бөгөөд төр улсаас, бүр тодруулбал ямар нэг албан газраас цутгамал үсгээр ном судар хэвлэдэг байжээ.

⁸⁴ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, доктор

⁸⁵ (士大夫) Корйө, Чосөнь-ийн үеийн бичгийн түшмэдийг нэрлэх ерөнхий нэр.(орч.)

⁸⁶Цутгамал хэв ашиглаж хэвлэсэн ном бөгөөд Гүтенбэргийн үсэг өрөх аргаар хэвлэсэн хэвлэлээс наян жилээр түрүүлнэ. Уг судар эдүгэ Францын Үндэсний Музейд хадгалагдаж буй. (орч.)

Корйөгийн үед бүтээсэн цутгамал үсгийг Чосөнь-ий эхэн үед амьдарч байсан хувьсгалч үзэлтэй Чөн До жөнъ ихэд сонирхжээ. Тэрбээр *Сөжсөгноши*⁸⁷-д күнзийн суртлын ном судрыг хорголжин хэвлэлийн аргаар хэвлэж, түгээх замаар бүддийн шашинтэй хийх үзэл суртлын тэмцэлд ялалт байгуулна хэмээн шийджээ. Энэ шийдвэр нь тэр дороо *садэбү* нарын талархлыг хүлээв. Тайзуны үед “харагчин хонь жилийн үсэг”-ийг хийсэн бол Сэжон вангийн үед түүнийг сайжруулаад “цагаан хулгана жилийн үсэг”, “хөх бар жилийн үсэг” хийжээ. Сөнжон вангийн үеийг хүртэл цутгамал үсгийн өөр төрлүүдийг нэмж хийсэн бөгөөд хэвлэлийн арга ажиллагаа сайжирснаар Чосөнь-ий эхэн үед маш олон төрлийн ном судрыг хорголжин хэвлэлээр хэвлэсэн байна.

Ингэж төрийн бодлогоор цутгамал үсэг хийж, түүгээрээ их хэмжээний ном судар хэвлэсэн нь Корйөгийн үеэс тод ялгарах үзэгдэл байлаа. Энэ бол Чосөнь хэмээх төр улсыг төвхнүүлсэн гол хүчин, *садэбү* нартай холбоотой. Күнзийн суртлын шинэ урсгал (Неоконфуцизм)-ыг төр засах үндсэн үзэл суртлаа болгосон энэ улс 1392 онд байгуулагдсан юм. Неоконфуцизмын үндсэн зарчмаар төр улс, нийгмийг сэхээтнүүд удирдах ёстой. “Бичиг уншвал *са* (士) хэмээмүй. Төрд зүтгэвэл *тэбү* (大夫) хэмээмүй” гэсэнчлэн *садэбү* нар нь үндсэндээ уншигчид байлаа. Эдгээр уншигчид “орогсдын шалгалт”⁸⁸-д тэнцсэнээр түшмэл болж, засаг захиргааны ажилд зүтгэнэ.

Төрсөн цагаасаа л ямбатан болдог онцгой эрх дархтай язгууртнаас *садэбү* хүний ялгарах тал нь неоконфуцизм болоод утга зохиолын өндөр мэдлэгтэй байх явдал юм. Чосөнь улсыг төвхнөмөгц тэр даруй *садэбү* давхарга бий болчхоогүй. Тийм учраас күнзийн суртлын боловсролтой *садэбү* нарыг бэлтгэн гаргах нь нэн тэргүүний зорилт болсон бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд их хэмжээний ном судар хэвлэх шаардлагатай байлаа. Үүний үндэс суурь Корйөгийн сүүл үед тавигдсан бөгөөд тэр үеэс л *садэбү* нар ном судар хэвлэж эхлэсэн нь Корйө хэмээх бүддийн шашинтай төрт улсын хувьд хүлээн зөвшөөрөхүйц ном биш байлаа. Жишээлбэл, “Шинэ үзлийн тэмдэглэл (近思錄)”, “Дөрвөн бичгийн тайлбар (四書集注)” зэрэг нь күнзийн суртлын шинэ урсгалыг үнэн хэмээн итгэсэн *садэбү* нарын санаа бодол, явдал үйлийн чиг баримжаа болсон ном судар юм. Чосөнь-ий төр төвхнөмөгц улсаас цутгамал үсэг үйлдэж, ийм төрлийн ном судрыг ихээр хэвлэж эхлэв. Тэдгээр номыг уншсаар *садэбү* нарын бүхэл бүтэн давхарга бий боллоо.

Төр улс ба ном хэвлэл

Чосөнь-ий үед олон тооны ном судар хэвлэж, түгээсэн бөгөөд энэ ажлыг төр улсаас эрхэлдэг байв. Энгийн хүн ашиг олох зорилгоор ном хэвлэн худалдах үзэгдэл Чосөнь-ий сүүл үеэс буюу 18-р зууны сүүлээс л гарах болсон юм. Тийм номыг *пангагбонь* (坊刻本) гэж нэрлэдэг. Эгэл иргэн цөөн хувиар ном хэвлэх нь тун ховор үзэгдэл байсан бөгөөд ном дагнаж худалдах орон зай буюу номын дэлгүүр ч бас 18-р зууны сүүлээр л бий болжээ. Эхэн үеийн номыг зуучлан худалдах ажлыг эрхэлдэг *сөкүэ* (書僮) нарын гараар дамжин цөөн ном эргэлтэд ордог байжээ. Чосөнь-ий дунд үед үүссэн номын худалдаачдын үйл ажиллагаа цаг хугацаа өнгөрөх тусам улам бүр идэвхжив.

Иргэдийн дунд ном хэвлэж, худалдах ажил төдийлөн газар аваагүй нь үндсэндээ тухайн үед мэдлэгийн зах зээл гэхимээр зүйл бүрэлдээгүй, мөн ном хэвлэж түгээх ажлыг төр улсаас эрхлэн явуулж байсантай холбоотой. Ном хэвлэж, эргэлтэд оруулах ажлыг Сөүл хотод Үсэг

⁸⁷ Анх 1101 онд Төрийн Хөвгүүдийн Суруулийн (國子監) харьяанд харьяалуулан улсаас байгуулсан хэвлэлийн газар. (орч.)

⁸⁸ Төрийн албан хаах түшмэдийг шалгаруулах шалгалт. (орч.)

үйлдэх газар (鑄字所) ба Ном Үйлдэх Газар (校書館) хариуцдаг, орон нутагт бол мужаас эхлээд *хийөнъ*⁸⁹ хүртэлх шатны тамгын газар хариуцдаг байв. Орон нутагт үйлдсэн модон барыг тухайн орон нутгийн тамгын газар хариуцан хадгална.

Сөүл хотын хэвлэлийн газар болох Үсэг үйлдэх газар, Ном үйлдэх газрууд цутгамал үсэг эзэмшихийн зэрэгцээ модон бар хийнэ. Гэхдээ илүү олон төрлийн ном хэвлэхэд цутгамал үсэг үнэмлэхүй давуу талтай тул нийслэл хотод голцуу түүнийг ашиглан ном хэвлэдэг байв. Ингэж хэвлэсэн номыг голцуу вангийн угсааныхан болоод яам тамгын газар, дээд зэргийн түшмэдэд хишиг болгон түгээнэ. Тэдгээрээс хэрэглээ ихтэй номын хорголжин хэвлэлийг ашиглан модон бар хийх ба уг барыг Ном үйлдэх газарт хадгална.

О Сүг квөнъ-ий “Эртний хэргийн товчоон (攷事撮要)”-ы “Номын, зах зээлийн үнэ (書冊視準)”-д Ном үйлдэх газраас гаргадаг номын төрөл зүйл, цаас, зардал сүйтгэл зэргийг нарийвчлан тэмдэглэсэн буй. Ном хэрэглэх хүн хэвлэлд шаардлагатай цаас, зардал зэргийг Ном үйлдэх газарт тушаагаад хэвлүүлж авдаг байсан бололтой. “Дөрвөн бичиг, таван ном” мэтийн күнзийн суртлын судар ном, “Эртний яруу найргийн дээж (古文眞寶)” мэтийн сурах бичиг, “Бага суртахуй” мэтийн ёс суртахууны ном, “Нутгийн эмийн жорын эмхэтгэл (鄉藥集成方)” мэтийн анагаах ухааны ном голлоно. Өөрөөр хэлбэл *садэбу* нарын эрдэм мэдлэг, соёл боловсролын үндэс болсон ном судар байв.

Сөүл хотын Үсэг үйлдэх газар болоод Ном үйлдэх газарт л цутгамал үсэг байдаг байв. Төрийн албан ёсны бичиг нь ханз бичиг болохоор номыг ханз үсгээр бичих нь тодорхой. Тэгэхээр цутгамал үсэг ч ханз үсэг байх нь аргагүй. Гэхдээ нэг удаад зуун мянгаас доошгүй цутгамал үсэг үйлдэх ёстой тул түүнийг хийж хадгалахад их зардал орно. Орон нутагт цөөн ном судар хэвлэх тул заавал цутгамал үсэг хийх шаардлагагүй. Тэгэхээр модон бараар хэвлэхийг илүүд үзэх нь аргагүй.

Орон нутагт засаг захиргааны шат шатны нэгжийн захирагч нар тус тусын тамгын газарт хэвлэх ном судрыг сонгох ба заримдаа Төв Засаг Газрын захирамжаар модон бар хийгээд ном хэвлэдэг байв. Төв Засаг Газар нь хэрэглээ ихтэй ном, улс орон даяар түгээх хэрэгтэй номын модон барыг хийх, барлах ажлыг орон нутгийн тамгын газруудад зарлиг буулган хийлгэх бөгөөд заримдаа нийслэлд хэвлэсэн хорголжин хэвлэлийн эхээр модон бар хийгээд ном барлахыг тушаана. Нутгийн түшмэл хааяа өөрийн болон найз нөхдийнхөө хэрэгцээнд зориулж модон бар хийлгэсэн нь илрээд хүнд байдалд орох явдал бас гардаг байжээ.

Орон нутгийн тамгын газарт бүтээсэн модон бар, ном судрыг тэндээ хадгалах бөгөөд өмнө дурдсан “Эртний хэргийн товчоон” хэмээх номын “Найман мужийн номын жагсаалт”-аас 16-р зууныг хүртэл орон нутагт хэвлэсэн номын төрөл зүйл, тоо хэмжээг багцаагаар мэдэх боломжтой. Хамгийн их хэрэглээтэй ном нь ямар ном байж вэ гэдгийг уг жагсаалтаас олж чадвал Чосөнъ-ий эхэн үеийн *садэбу* нарын нийгэмд нийлүүлсэн мэдлэгийн төрөл зүйлийг таамаглах боломжтой.

Хувь хүн хүсэх аваас орон нутгийн тамгын газрууд эзэмшиж буй модон бараараа ном барлаж өгдөг байжээ. Тодорхой дурдах баримт их биш хэдий ч бас цөөн гэхээргүй. Тухайлбал 16-р зууны сүүл үеийн эрдэмтэн, ном цуглуулагч Юү Хыи цүнъ байна. Тэрбээр аль орон нутгийн ямар тамгын газарт ямар модон бар байгааг мэдэж авсныхаа дараа танил түшмэлдээ захидал бичиж, хэрэгтэй номоо барлаж өгөхийг хүснэ. Магадгүй тухайн үеийн ямбатнууд иймэрхүү аргаар л хэрэгтэй номоо олж авдаг байсан болов уу. Үндсэндээ ийм аргаар мэдлэгийг буюу ном хэвлэлийг эргэлтэнд оруулдаг байжээ.

⁸⁹Засаг захиргааны доод шатны нэгж.

Сайхан барлаж, хэвлэсэн ном олж авах нь мэдлэг эзэмших хамгийн сайн арга мөн хэдий ч, тэр нь элбэг зүйл биш байлаа. Ном олдохгүй бол баян ядуугүй хуулж авцгаадаг байжээ. Хэрэгтэй номоо хуулаад бичиж авах нь энгийн хэрэг байсан ба (хуулж бичих нь бас нэг хичээл болно) чинээлэг хүн бол гоё бичигтэй хүнд хөлс мөнгийг нь өгч бичүүлээд сайхан хуулбартай болно. Юу Хыи цүнх ийм маягаар тун олон номтой болсон байна.

Хамгийн чухал мэдлэг - “Дөрвөн бичиг, таван ном - Их судар” ба “Жүзы - Их судар”

Чосөнь-ий үед номыг хэвлэх болон эргэлтэд оруулах эрхийг төр улс эзэмшиж байлаа. Төр улсаас гадна Бичгийн хүрээлэн, сүм хийдийг дурдаж болно. Гэхдээ Бичгийн хүрээлэнг төрийн эрх баригч *сэдэбү* нар эзэгнэж байсан тул Бичгийн хүрээлэнгийн ном хэвлэлийг төр улсынхаас тусад нь ялгах аргагүй. Сүм хийдэд мэдээжээр бүддийн шашны ном судар барлаж, хэвлэх хэдий ч энэ үед (төрөөс ивээн тэтгэхээ больсны улмаас орч.) бүддийн шашин нэгэнт сулран доройтсон цаг. Тэгэхээр нэг их нөлөөтэй байж чадахгүй.

Төр улсаас олон тооны ном хэвлэн түгээж байлаа. Гэхдээ ном бүрийг тэгэхгүй. Хамгийн ихээр түгээх гэсэн ном бол “Дөрвөн бичиг - Их судар”, “Таван ном - Их судар”, “*Сөнри* - Их судар” байлаа. Эдгээр Их судруудыг Мин улсын Юнлө хуандигийн үед эмхтгэсэн бөгөөд төр улсаас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн, күнзийн суртлын ном судрын уламжлалт тайлбар юм. Тийм учраас Мингийн үеийн “Орогсдын шалгалт”-ын асуултыг бүгдийг нь “Дөрвөн бичиг - Их судар”-ын агуулгаар бэлддэг байж. Чосөнь-ий үед Юнлө хуанди бээр Сэжон ванд хоёр удаа их судар хайрласан ба Сэжон ван тэр даруйд зарлиг буулган Кйөнсан, Цүнцөн, Чөлла мужид хэвлүүлжээ. Чосөнь-ий вант улсыг мөхөх хүртэл “Их судар”-ууд нь “Дөрвөн бичиг”, “Таван ном”-ын албан ёсны тайлбар, гол сурах бичиг болж байлаа. “Хөх бар жилийн үсэг”-ээр хэвлэсэн “Их судар”-ыг Йөнжо⁹⁰-гийн үе хүртэл хэд хэдэн удаа хэвлэсэн бөгөөд одоо хүртэл ханз бичиг сурах болбол Йөнжо-гийн адаг онд хэвлэсэн Их судрын “Дөрвөн бичиг”-ийг ашигладаг.

Гэхдээ цуврал “Их судар” дундаас Күнзийн суртлын шинэ урсгалын үндсэн ухагдахууныг тайлбарласан “*Сөнри* -Их судар”-ыг тийм ч амархан ойлгож чадсангүй. Энэ номын тун багахан хэсгийг Сөнжон-ы үед ордны мэтгэлцээний текст болгон ашиглаж байв. Йөнъсаньгүнх төр барьсны дараа Чүнжон вангийн үед дахиад ордны мэтгэлцээнд ашиглах гэтэл түүний учир утгыг ойлгох ганц ч хүн байгаагүй гэдэг. Өөрөөр хэлбэл, Чүнжон-гийн үеийг хүртэл Күнзийн суртлын шинэ урсгалын гүн утга учрыг ойлгоогүй байжээ.

Энэ үед Күнзийн суртлын шинэ урсгалын талаархи мэдлэгийг сайжруулахын тулд Мин улсаас холбогдох ном судрыг их хэмжээгээр худалдан авчирсан хэдий ч асуудал шийдэгдсэнгүй. Хэргийн учир нь Жүзы-гийн зохиолд оршиж байлаа. “Дөрвөн бичиг - их судар”-ын гол үндэс болсон “Дөрвөн бичгийн тайлбар”-ыг ойлгоё гэвэл “Дөрвөн бичгийн тайлбар”-ыг зохиох болсон учир шалтгаан буюу Жүзы-гийн зохиолыг эхлээд мэдэх ёстой. Харин Жүзы-гийн зохиолын эмхтгэл буюу “Жүзы – Их судар”-ыг Чосөнь-д 1543 онд хэвлэсэн юм. И Хван⁹¹ энэ номыг олж авсныхаа дараа төрсөн нутаг Түэге-дээ очиж суугаад шимтэн судалсан байна.

Анх удаа “Жүзы – Их судар”-ыг бүрэн уншиж судлан утга учрыг нь олсон учраас түүнийг Чосөнь-ий күнзийн суртлын шинэ урсгалын билэг тэмдэг гэж үздэг. “Жүзы – Их судар”-аас Жүзы-гийн захидлууд эрдэм судлалын хувьд онцгой ач холбогдолтой гэж үзсэн И Хван чухал захидлуудыг нь түүвэрлэн “Жүзы бичгийн товчоон” гэдэг номынхоо эхийг эмтгэжээ. Тэгээд нутгийн түшмэлийг гуйж, модон бар хийлгээд хэвлүүлсэн байна. И Хваны хувьд эн тэргүүний зорилт нь Күнзийн суртлын шинэ урсгалыг илүү сайтар ухаж ойлгох явдал байсан ба хараахан түгэж дэлгэрээгүй энэхүү сурталтай холбоотой нэлээд хэдэн номыг хэвлүүлжээ. Ийнхүү *сөнри*

⁹⁰ Чосөнь-ий 21-р ван. (Орч)

⁹¹ Түэге хэмээх И Хван (1501-1570). Их эрдэмтэн, бичгийн түшмэл.(Орч)

суртлыг зөв зүйтэй ухаж ойлгох эх суурь тавигдав. Түүнээс хойш “Жүзы – Их судар”, Жүзы-гийн хэлж ярьсан зүйлсийг эмхэтгэн бичсэн “*Жүзы өрйюү*”-г унших, дахин эмхтгэх болсноор Жүзы судлал гүнзгийрлээ. Энэ нь 18-р зууныг хүртэл үргэлжилсэн юм. 1543 онд “Жүзы – Их судар”-ыг хэвлэсний үр дүн гэж хэлж болно. 18-р зууны эцэс гэхэд Жүзы-гийн учир утгыг бүрэн оллоо.

“Дөрвөн бичиг - их судар”, “Таван ном - их судар”, “*Сөнри* - их судар” нь *садэбү* нарын ертөнцийг үзэх үзлийг бүрдүүлсэн юм. Эдгээр ном хамгийн чухал, бүх мэдлэгийн цөм байв. Түүнээс л бусад мэдлэг салаалж салбарлана. Хувь хүн, нийгэм, төр улс бүгд эдгээр номоос ангид байх аргагүй байв.

Гаднаас авчирсан гайхширмаар зүйл - Бээжингээс авчирсан шинэ ном

Чосөнь-ий үед хэвлэлийг төр улс монополичлон эзэмшсэн учраас бичгийн хүмүүс амьд сэрүүндээ зохиол бүтээлээ хэвлүүлэх удаа бараг байсангүй. Байсан гэвэл тун ховор, онцгой тохиолдол болох буй за. Иргэн хүн хувиараа хэвлэлийн газар ажиллуулж болохгүй нөхцөлд хувь хүн өөрийн уран зохиол, үзэл суртлаа ном болгоод түгээх боломжгүй. Энэ нь мэдлэгийг үйлдвэрлэхэд саад тогтор болж байлаа.

Тиймээс дотроос бус, харин гаднаас авчирсан гайхширмаар зүйл чосөньчуудыг шинэ мэдлэгийн шоконд оруулсан юм. Гадна гэдэг нь даруй Хятад, бүр тодруулбал Бээжинг хэлнэ. Чосөнь-ий сэхээтнүүд хэрэгтэй номоо Бээжингээс захиж авчруулна. Хааяа Ёслолын яаманд бичиг өргөж, гадаад харилцааны албан шугамаар ном худалдаж авна. Ер нь бол жилд хэдхэн удаа Бээжин рүү илгээдэг элч нарын багийнхан хувиараа ном худалдаж авчрах бөгөөд энэ багт багтах боломжгүй хүн элч нарт хэрэгтэй номоо захиж авчруулдаг байжээ. Голдуу ийм маягаар ном олж авдаг байсныг “*Миам*”⁹²-ын өдрийн тэмдэглэл”-ээс үзэхэд тодорхой байна. Юү Хьи цүнх Бээжин явах элчид ном захиад, ирэх өдрийг нь хоног тоолон хүлээдэг байжээ.

Элч нар Бээжингийн ном худалддаг гудамжинд очиж ном авдаг байсан уу гэвэл, үгүй л болов уу. Тэдний дунд ном худалдаж авч чадах чинээний бэл бэнчинтэй хүн гэвэл элч нарын ахлагч, дэс зарагсад, бичээч түшмэл нар байлаа. Элч нарын баг Ёслолын яамнаас зааж өгсөн дэн буудалд голдуу хоноглоно. Ёслолын яамнаас “*сөбань*” гэдэг доод тушаалын түшмэлийг томилж, элч нарын аар саар ажилд туслуулна. Энэ түшмэл тэдний хэрэгцээт ном, уран зураг зэргийг худалдаж авах ажлыг хариуцдаг байжээ. Мэдээж нөхцөл бололцооноос шалтгаалан элч нарын багийн зарим түшмэл Бээжингийн номын худалдааны гудамжийг зорьж очдог байсан байх боломжтой. Гэвч энэ талаар нарийн тодорхой бичиж тэмдэглэсэн зүйл үгүй тул хэлэх юм алга.

Хар луу жилээс эхлэн Японтой дайтсан, мөн улаан хулгана жил Чин улстай дайтаж ялагдсанаар Чосөнь нь Мин бус, Чин гүрний түшмэг хараат улс болов. Чингийн Засаг газар нь өмнөд хэсэгтээ гарсан Гурван феодалын бослогыг дарж, улс орноо тогтворжуулах хүртлээ Чосөнь-ий элч нарт итгээгүй тул Бээжинд ирсэн хойно нь дэн буудлаасаа гарч явахыг хориглодог байв. Харин 18-р зууны эхний хагасаас эхлэн Гурван элч⁹³-ийн үр хүүхэд, төрөл садан гэх мэт онцын ажил үүрэггүй, зүгээр л юм үзэж сонирхохоор дагаж явсан хүмүүс Бээжингийн гудамжаар чөлөөтэй зорчих болжээ. Эдгээр хүмүүс ном худалдаж авдаг байсныг дурдах нь илүүц биз. Мингийн үеэс Бээжингийн Боличуанг (琉璃廠)-д ном, уран зураг, эртний үнэт эдлэл зардаг гудамжууд бий болсон бөгөөд Чингийн төрийг тогтворжоод ирмэгц ихэд хөгжив. Улмаар Жаннань (江南)-ий эртний бичиг судлаачид “Дөрвөн төрлийн номын цогц сангийн ордон (The Siku Quanshu; “四庫全書館”)-г байгуулж, “Дөрвөн төрлийн номын цогц бичиг”-ийг эмхтгэж

⁹² Юү Хьи цүнх-ий бичгийн нэр. (Орч)

⁹³ Ахлагч, дэс зарагсад, бичээч түшмэл гурвыг *Самса* буюу Гурван элч гэнэ. (Орч)

дуусмагц, Хятадын өнцөг булан бүрээс Бээжин рүү ном судар урсах болжээ. Ийнхүү Боличуанг-ийн номын худалдааны гудамж 18-р зууны сүүлийн хагаст цэцэглэн хөгжжээ.

“Турван элч” дэн буудлаасаа гарч чаддаггүй бол хэлмэрч түшмэл болон дагалтууд нь Боличуанг-аар хэрэн явж ном судар худалдан авахаас гадна Хятадын эрдэмтэн мэргэдтэй уулзаж учрах боломжтой байлаа. 1765 онд Бээжинд очсон Хон Дэ ёноос эхлээд Паг Жэ га, И Дөг мү, Паг Жи вөнъ, Хон Ян хо зэрэг 18-р зууны сүүлийн хагаст амьдарч асан Чосөнъ-ий эрдэмтэн мэргэд Боличуанг-ийн гудамжаар алхалж, ном судар худалдан авч байжээ. Энэ үеэс л Бээжингээс их хэмжээний ном судар Сөүл хот руу ачигдах болсон байна.

Тэдгээрийг нийслэл хотод үе улиран сууж ирсэн өндөр дээд угсаа гаралтай, язгууртан гэр бүлүүд эзэмшдэг байв. Ийм гэр бүлээс гаралтай хүн л төрийн алба хаших өндөр магадлалтай. Тухайн үеийн Чосөнъ-д төрийн эрхийн төлөө анги бүлэг болон тэмцэлдэх явдал гаарч, янбань⁹⁴ нар хот, хөдөөгөөрөө хуваагдаад байлаа. Нийслэлийн язгуурлаг гэр бүлүүд улс төр, эдийн засгийн эрх мэдэлдээ тулгуурлан хээнцэр тансаг, боловсронгуй соёлд тэмүүлэхийн хэрээрээ Бээжингээс тансаг хэрэглээний эд зүйл, эртний үнэт эдлэл, уран зураг болоод уран бичиг, тэрчлэн их хэмжээний ном судар худалдан авчирдаг байлаа. Тэд бол их хэмжээний урлагийн бүтээл болоод ном судар цуглуулагчид байв.

Бээжингээс ирсэн ном урьд өмнөхөөс тун их ялгаатай болсон байлаа. Алдарт дөрвөн зохиол⁹⁵ тэргүүтэй романаас авахуулаад *шяопинвень*⁹⁶ төрлийн хөнгөн, богино өгүүллэгүүд нь нийслэлийн язгууртнуудын дурлан уншдаг зохиол болов. Нөгөө талаар Жүзы-гийн ном судрын тайлбарыг эртний бичиг судлалын аргаар шүүмжлэн судалдаг *кйөнхаг* ухаан (гол төлөөлөгч нь Ко Йөн мү, Йөм Яг гө, Мо Ги рйөн нар), Янминий зүүн⁹⁷ урсгалд үндэслэсэн кон анъ⁹⁸ урсгалынхны утга зохиолын шүүмж ихэд хөгжив. Дээр нь энэ үеийг хүртэл огтоос дуулдаагүй байсан католик шашин болоод өрнийн шинжлэх ухаан, газарзүйн ухааны ном бөөн бөөнөөрөө орж ирэв. Эдгээр шинэ ном бүгдээрээ төрийн үзэл суртал болох Күнзийн шинэ суртлыг цор ганц үнэн хэмээх итгэлийг ганхууллаа. Аюулыг мэдэрсэн Жөнжо⁹⁹ Бээжингээс ном оруулахыг хориглож, албат түшмэдийнхээ унших ном, туурвих бүтээлийг хянан шалгах болсон ба тэрс үзэлтнийг хөөн зайлуулахаа зарлав. Үүнийг Жөнжо вангийн Бичиг Зохиолын Шинэчлэлт (文體反正) гэж нэрлэдэг. Мөн тэрбээр *Кюүжангаг* (Вангийн Номын Сан)-ыг байгуулаад түүнд Ном үйлдэх газрыг харьяалуулжээ. Ингээд Күнзийн шинэ суртлын холбогдолтой ном судрыг гэм хоргүй, бас зөв зүйтэй гэж үзээд олон тоогоор хэвлэж, түгээхийг зорьсон байна. Энэ нь амжилт, алдаа аль алиныг дагуулав.

Зөвхөн *садэбү* нарт зориулсан ном болоод мэдлэг

Чосөнъ-ий үед ном болоод мэдлэг нь зөвхөн *садэбү* нарт зориулагдсан зүйл байлаа. Цутгамал үсэг, модон бар хийх нь тун их зардал чирэгдэлтэй ажил учраас энгийн хүн ном худалдан авч чадахгүй. Зөвхөн *садэбү* нар л ном худалдаж авах хэрэгцээ шаардлагатай, бас бэл бэнчинтэй байлаа. Энгийн иргэн ном олж авах аргагүй тул үнэн хэрэгтээ мэдлэгийн эргэлтэд оролцож чадахгүй. Хэдийгээр солонгос авианы үсэг буюу “Иргэнийг сургах зөв аялгуу”-г ард иргэдийн төлөө зохиосон гэх ч иргэнд зориулан модон бараар, эсвэл хорголжин хэвлэлээр ном

⁹⁴ Хоёр анги гэсэн утгатай үг бөгөөд бичиг, цэргийн түшмэдийн ерөнхий нэр. (Орч.)

⁹⁵ Юаний үеийн “Усан хөвөө”, “Турван улсын түүх”, Мингийн үеийн “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”, “Улаан асрын тэмдэглэл”-ийг ингэж нэрлэдэг.(Орч.)

⁹⁶ 小品文, Хятадын богино өгүүллэгийн төрөл. (Орч.)

⁹⁷ Сүнгийн үед үүссэн күнзийн суртлын бас нэгэн урсгал.(Орч.)

⁹⁸ Мингийн сүүл үед дэлгэрсэн утга зохиолын урсгал.(Орч.)

⁹⁹ Чосөнъ-ий 22-р ван. (1776~1800)(Орч.)

хэвлэж байсангүй. Сэжон¹⁰⁰ солонгос үсэг зохиож, цутгамал үсгийг боловсронгуй болгосон ч энэ хоёрыг нэгтгээд иргэнд зориулан ном бүтээгээгүй юм. 18-р зууны сүүлээр л арай гэж иргэн хүний гар дээр уран зохиолын ном тавигдсан ба тэр үед ч бас л дийлэнх нь ном гэхэд хэцүүхэн, зүс муутай хуулбарууд байлаа.

Чосөнъ бол сэхээтэн буюу бичгийн хүмүүс нийгмийг нь ноёлсон, хорвоод ховорхон төрт улс байлаа. Сэхээтэн буюу *садэбү* нарын мэдлэг боловсролын эх булаг нь күнзийн суртал болно. Күнзийн суртлаар нийгэм болоод төр улсыг удирдана. Күнзийн суртал ингэж төгс үйлчилдэг нийгэм, төрт улс энэ дэлхийд ховорхон. Япон, Вьетнам төдийгүй эх орон нь болох Хятад хүртэл Чосөнъ шиг энэхүү сурталд автаагүй. Түүний шалгаан ганц нэгээр тогтохгүй. Гагцхүү ном хэвлэл, түүний эргэлт, мөн түүнийг дагасан мэдлэгийн үйлдвэрлэл болоод эргэлтийг зөвхөн *садэбү* нар болоод тэдний байгуулсан төрт улс дангаар эзэмшсэнд гол учир орших буй за.

¹⁰⁰Чосөнъ-ий 4-р ван. (Орч.)